



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-118</i>

Өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг танилцуулах	6-7
1.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах	7-7
2.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	7-118

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 15-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Ч.Анар, Т.Аубакир, Х.Баасанжаргал, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Б.Баярбаатар, Ж.Баясгалан, Д.Бум-Очир, С.Бямбацогт, А.Ганбаатар, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, С.Замира, М.Мандхай, Ц.Мөнхбат, Ц.Мөнхтуяа, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Б.Тулга, А.Ундраа, Ч.Ундром, Н.Учрал, Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Б.Хэрлэн, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, Д.Энхтуяа, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, З.Мэндсайхан;

Хоцорсон: М.Бадамсүрэн-05 минут, Б.Батбаатар-19 минут, О.Батнайрамдал-11 минут, Б.Бейсен-04 минут, Д.Ганбат-11 минут, Л.Гантөмөр-02 минут, Ц.Даваасүрэн-16 минут, Б.Жавхлан-3 цаг 44 минут, Б.Жаргалан-16 минут, Д.Жаргалсайхан-18 минут, Ч.Лодойсамбуу-01 минут, П.Мөнхтулга-04 минут, Ц.Туваан-4 цаг 22 минут, Б.Түвшин-11 минут, Г.Тэмүүлэн-03 минут, Б.Чойжилсүрэн-4 цаг 28 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.05.08-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүнээс 2025.05.08-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Нэг.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн

албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /10:12/

Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Нийслэлийн Засаг даргын орлогч нэгдүгээр Т.Даваадалай, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Өнөржаргал, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлуvsан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга

Ж.Дэлгэржаргал, Батлан хамгаалах яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Эрхэмбаяр, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 14 цаг 01 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Бат-Эрдэнэ, Б.Найдалаа, С.Эрдэнэболд, Ж.Чинбүрэн, Э.Батшугар, Б.Мөнхсоёл, А.Ариунзаяа, Да.Цогтбаатар, Ж.Ганбаатар, Г.Лувсанжамц, П.Сайнзориг, Ц.Идэрбат, Ж.Батжаргал, Ө.Шижир, Г.Хосбаяр, Х.Булгантуяа, Д.Энхтүвшин, Л.Соронзонболд, Ж.Баярмаа, Г.Очирбат, М.Ганхүлэг, Ц.Сандаг-Очир, Ж.Галбадрах, Н.Алтаншагай, Б.Бейсен, П.Мөнхтулга, Д.Ганбат, Б.Жаргалан, Э.Болормаа, Д.Жаргалсайхан, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Эдийн засаг хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 15 цаг 18 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, А.Ариунзаяа, П.Сайнзориг, Л.Мөнхбаясгалан, М.Ганхүлэг, Г.Уянгахишиг, Б.Бейсен, Д.Ганбат нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний

удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т заасан шаардлагыг хангасан байна гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 38
Бүгд: 86
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, Ж.Бат-Эрдэнэ, М.Сарнай нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 59.3 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 49 минут үргэлжилж, 126 гишүүнээс 86 гишүүн хүрэлцэн ирж, 68.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая 66 гишүүн ирцэд бүртгэгдэж ирц 52,4 хувь хүрсэн байна.

2025 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн чуулган нээснийг мэдэгдье. Олон улсын парламентын үйл ажиллагаанууд идэвхжээд бас 10 гаруй гишүүд гадаадад Улсын Их Хурлын шугамаар томилолттой явж байгаа. говийн бүсийн Засгийн газрын арга хэмжээ болсонтой холбогдуулаад говийн бүсийн гишүүд өчигдөр Гашуун сухайт Ганц мод боомт дээр ажилласан. Бас хил гарч энэ нүүрсний холболт төмөр замын холболтын байгууламжийн бүтээн байгуулалтын нээлтийн ажиллагаа явагдсан байна. Өнөөдөртөө хараахан ирж амжаагүй байна. Тэгээд өнөөдөр бол бас 20 гаруй гишүүд томилолттой явж байгаа учраас гишүүдийг чуулгандаа идэвхтэй оролцож асуудлуудаа идэвхтэй хэлэлцэж явахыг бас хэлэхийг хүсэж байна. Сануулж хэлж байна. Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт хуулийн төслүүдийг эцэслэн батална. Гаалийн албан татварын хуульд өөрчлөлт орж байгаа. Хуулийн төслийг эцэслэн батлах. Зээлийн мэдээллийн сан хуульд нэмэлт орсон асуудлыг эцэслэн батлах асуудал, мөн “Хууль батлагдсантай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” гарч байгаа тогтоолыг эцэслэн батална.

2 дугаарт “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулахаар байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороо хэрэв тухайн төсөлд хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамрагдахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох байнгын хороод хуваарилсан талаар танилцуулъя.

1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоолын төслүүдийг Засгийн газраас 5 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд

2.“Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Казакстан Ард Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр” -ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд

3.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин нарын 41 гишүүн санаачилж 5 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлснийг Нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах хувилбарыг Байнгын хороод бэлтгэн гишүүдэд тараасан байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байдаг.

Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэл санал хураалт. Гишүүд суудалдаа суучих. Ирц бүртгэлийн санал хураалт дахиж явуулаадахъя. Чинбүрэн гишүүн санал хураалтад орж амжаагүй гишүүн байна уу. Батшугар уу. Дараагийн асуудал руу оръё. Томилолттой гишүүд иртэл санал хураалтыг түр хойшлуулъя.

10.12 цаг.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннямын Гантөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Гантөмөр: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1, 6.10.2 дахь заалтад заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Мөн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт, шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтын шалгуур, үзүүлэлтүүдтэй уялдууллаа. Төлөвлөгөөний төслийг боловсруулах явцад буюу 2025 онд гадаад эрсдэлээс үүдэлтэй эдийн засаг дахь тогтворгүй, тодорхойгүй байдал бий болж байна. Тухайлбал, худалдааны дайн, геополитикийн хурцадмал

байдал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал зэрэг эрсдэлд нөлөөлөл үүсэж байна.

Монгол Улсын экспортын орлогыг бүрдүүлдэг гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 40 орчим хувиар унаж, нийт экспортын орлогын 17 хувиар, улсын нэгдсэн төсвийн нийт орлого 16 хувиар буурлаа. Энэхүү нөхцөл байдал 2025, 2026 он дамжин үргэлжлэх төлөвтэй байна.

Эрхэм гишүүд ээ,

Гадаад таагүй нөхцөл байдал үргэлжилж байгаа хэдий ч Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон төслүүдийг эдийн засгийн эрх чөлөөний реформ хийж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах замаар оновчтой төлөвлөж, тэдгээрийг үе шаттай хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш түвшинд хадгалах боломжтой гэж тооцооллоо.

Бидний өмнөө тавьж байгаа том зорилт нь экспортыг өсгөж, инфляцыг тогтвортой түвшинд барьж, валютын нөөцийг нэмэгдүүлж, иргэн, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор томоохон бүтээн байгуулалтыг хэрэгжүүлж, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар баялгийн санг арвижуулж, ядуурлын 5 хувиар бууруулах зорилт байна.

Засгийн газраас түүхий эдийн үнийн уналт, ган, зуд зэрэг байгаль цаг уурын эрсдэл нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт, эрчим хүчний хязгаарлагдмал нөөц хилийн боомтууд дахь тээвэрлэлт, логистикийн саатал зэрэг болзошгүй эрсдэлийн нөлөөллийг урьдчилан тооцож, эрсдэлт нөхцөл гарах нөлөөллийг бууруулах бодлогыг хэрэгжүүлж байгаа. Тухайлбал, хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний хувьсгал хөдөлгөөн, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг тус тус эрчимтэй хэрэгжүүлж байна.

Эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрчим хүчний нийлүүлэлтийг сайжруулж байна. Төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа уул уурхайн гол бараа бүтээгдэхүүний үнэ унах эрсдэлийг тооцсон бөгөөд сөрөг нөлөөллийг харьцангуй бага байлгахын тулд хил, гаалийн нэвтрүүлэх чадварыг сайжруулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх, тухайлбал уул уурхайн салбарт нүүрс баяжуулах, зэс, гангийн үйлдвэрлэл зэрэг боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нэмүү үнэ цэнийг өсгөж, экспортыг төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхойлсон бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг үргэлжлүүлнэ.

2026 онд хүн төвтэй хөгжлийн үзэл санаанд нийцсэн эдийн засгийн эрх чөлөөг цогцлоохыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ,

төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлнэ.

2026 оныг бид реформ өрнөсөн жил байна гэж төлөвлөж байна. Нэн шаардлагатай хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлнэ. Макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгаж, эдийн засгийн эрх чөлөөний реформыг хэрэгжүүлж, ядуурлын бууруулах зорилгодоо хүрнэ. Эдийн засгийн эрх чөлөөний реформын хүрээнд бизнесийн үйл ажиллагаагаа зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, татварын орчны шинэчлэлийг хийж, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтыг хязгаарласан, хаасан зохицуулалтыг багасган ялгамжтай байдлыг арилгаж, бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, шинжлэх ухаан, гарааны бизнес, өндөр технологи, хиймэл оюун, инновацыг дэмжих бодлого хөшүүргийг тодорхойлох замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Стратегийн түнш болон томоохон зах зээлтэй улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаа, түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг дотоодын бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлэн байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

Төсвийн зардлын реформын хүрээнд төсвийн урсгал зардлыг ДНБ-ий 24 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, процессын дахин инженерчлэлийг хийж, төрийн үйлчилгээг хялбар, хүн төвтэй проактив хандлагаар эрчимжүүлэх юм.

Төрийн албаны реформын хүрээнд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог багш, эмч нарыг оруулахгүйгээр 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх ажлыг эхлүүлнэ. Төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлж, төрийн худалдан авалтад хиймэл оюуныг ашиглан ил тод байдлыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлж, авлига, хээл хахуулийг цэглэнэ.

Үндэсний Баялгийн Сан төрийн өмчит компанийн засаглалын реформын хүрээнд төрийн өмчит компаниудын реформыг эрчимжүүлж, зардлыг 15 хувиар бууруулж, бүтээмжийг 30 хувиар нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлж байна. Төрийн өмчит компаниудын хөрөнгийн удирдлагыг сайжруулж, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын коэффициентыг нэмэгдүүлж, өгөөж, үр ашгийг сайжруулах зорилтыг дэвшүүлж байна. Геологи хайгуул болон ашиглалтын түвшнийг нэмэгдүүлэх, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар баялгийн сангаа арвижуулцгаана.

Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд нийт 300 төсөл, арга хэмжээг 17,5 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгалаа. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 3,5 их наяд төгрөг, орон нутгийн төсвөөр 1,5 их наяд төгрөг, гадаадын зээл тусламжаар 3,6 их наяд төгрөг, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 4,5 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4,4 их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөлөө.

2026 онд баримтлах бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг танилцуулъя.

1.Эдийн засгийн эрх чөлөөг бүсийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлнэ. Бүс нутгийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлж, бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлж, дэд бүтцийг хүртээмжтэй болгож, бүсчилсэн хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, тогтолцоог сайжруулна. Шинэ суурьшлын бүс байгуулах ажлыг эрчимжүүлж, дагуул хотуудын хатуу, зөөлөн дэд бүтцийн бүтээн байгуулалт эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжинэ. Хөдөө аж ахуй, мал аж ахуй, аялал жуулчлал, аж үйлдвэр, хүнс, худалдаа, эрчим хүч, үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг кластер хэлбэрээр хөгжүүлж, хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан экспортыг дэмжсэн үйлдвэрлэл технологийн паркийг байгуулах замаар бүсийн онцлог, давуу тал, нөөц боломж, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлнэ. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд дээрх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр иргэдийг хөдөө, орон нутгийн инженерийн дэд бүтцийн шийдэл бүхий орон сууцад хамруулах юм.

2.Ядуурал тэгш бус байдлыг бууруулж, эрдэм боловсролтой эрүүл монгол хүнийг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж байна. Аливаа улсын хөгжлийн тулгуур багана нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийн суурь хүчин зүйл улсын үнэт баялаг нь хүн өөрөө байдаг. Иргэд төрийн үйлчилгээг төрийн байгууллагад ирж бус төр иргэдийн хэрэгцээнд тулгуурлан хүрч үйлчлэх зарчимд шилжихийг зорьж байна. Бид 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарлаж, боловсролын чанар, хүртээмж дээшлүүлж, хөрөнгө оруулалтыг өсгөж, 108 сургууль, 95 цэцэрлэгээр нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг стандарт түвшинд хүргэж, хамгийн сайн цэцэрлэг, сургууль, гэрт ойр хөтөлбөрийг хэрэгжүүлж, хот хөдөөгийн боловсролын чанарын ялгааг арилгана. Дотоодын болон олон улсын их, дээд сургуулиудын хооронд кредит шилжүүлгийн тогтолцоог боловсронгуй болгож, дотоод гадаадад докторын түвшинд суралцаж байгаа оюутнуудад зориулсан тэтгэлгийн тогтолцоог бүрдүүлж, дэлхийн шилдэг багш, профессоруудыг Монголд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын чанар, багшийн ур чадвар, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт зэрэг үзүүлэлттэй уялдуулан үнэлгээний системийг сайжруулна.

Эрүүл монгол хүн хөтөлбөрийг хөгжүүлж, хавдар, зүрх судасны өвчлөлийн эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлж, эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг хийж, хиймэл оюун ашиглан боловсронгуй болгоно. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээний давхардлыг бууруулж үр ашгийг дээшлүүлнэ. Хүн төвтэй нийгмийн үйлчилгээг нэвтрүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хөгжлийн цогц үйлчилгээний төвийг аймгуудад байгуулж, зорилтот өрх, хүнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлнэ.

Өндөр технологийн хурдтай, хөгжилтэй уялдуулан ур чадварын шилжилтийг хийж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн ур чадварт сургах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын бууруулна. Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлс, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхийг зорьж байгаа.

Иргэдийн нийгмийн баталгааг хангаж Чингис хаан үндэсний баялгийн сангаар дамжуулан ирээдүйд хөрөнгө оруулалт хийх, эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлж, миний түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Миний сонголт орон нутаг, миний амины орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, 150 мянган айлын орон сууцын хөтөлбөрийг баталж, орон нутагт хүртээмжтэйгээр ажлыг зохион байгуулна. Энэ хөтөлбөрийг гүйцэтгэгчид нь

дотоодын аж ахуйн нэгжүүд, Монгол хүн байх бөгөөд ядуурлын бууруулах гол хэрэгсэл болгож, ирэх жилийн зорилттойгоо уяж байгаа юм.

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд дээрх зорилт арга хэмжээний үр дүн, ажиллах хүчний оролцооны түвшнийг 63 хувьд, Писа олон улсын үнэлгээний эрэмбийг 52-т тус тус хүргэж, ядуурлын түвшнийг 5 хувиар бууруулахыг зорилт болгож байна.

3.Хүн төвтэй хөгжлийн үзэл санаанд нийцүүлэн бизнесийн орчны реформ ба чөлөөт эдийн засгийг цогцлоохыг зорьж байна. Шинжлэх ухаан, инновац, хиймэл оюун, дэвшилтэт технологид суурилсан мэдлэг, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогоор дэмжиж оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийн зорилго зорилтуудыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана. Шинжлэх ухаан технологийн арга хэмжээний зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ДНБ-ий 0,5 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлж шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ.

Санхүүгийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлж, цахим эдийн засгийг эзлэх хувийг нэмэгдүүлснээр ДНБ-д хиймэл оюуны хувь нэмрийг бодитойгоор өсгөж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах юм. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж үйлдвэрлэлийн салбарт санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, шинэ эх үүсвэрүүдийг бүрдүүлж, банк, санхүү, даатгалын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, эрсдэлийн удирдлагыг шинэчилж, гадаадын банкны салбар нэгж байгуулах нөхцөл боломжийг бий болгохыг зорьж байна. Эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, дамжин өнгөрөх худалдаа, тээвэр логистик, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлж, хил холболтын төмөр зам, боомт, чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж экспортыг өсгөнө.

Жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих, урт хугацаатай, хүү багатай зээлийн бүтээгдэхүүний төрөл хүртээмжийг нэмэгдүүлнэ. Эдийн засгийн бодлогын хүрээнд дээрх зорилт арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хадгалж, инфляцыг 7 хувьд барихыг зорьж байна.

4.Хиймэл оюуныг төрийн бүх шатад нэвтрүүлж, хүн төвтэй төрийн үйлчилгээг бий болгох зорилт. Хүн төрөлхтөн хиймэл оюуны эринд эргэлт буцалтгүй шилжин орлоо. Дэвшилтэт технологи процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, авлигагүй, хүн төвтэй төрийн үйлчилгээ болгон өөрчилнө. Хүний эрхийн хөтөлбөр 2-ыг хэрэгжүүлж үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, улсын батлан хамгаалах бодлого, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бататгаж, гадаад харилцааны 1 цонхны бодлого баримтлан энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, хиймэл оюун, орчин үеийн техник технологиор зэвсэгт хүчнийг бэхжүүлж, цэргийн аж үйлдвэр, дэд бүтцийг хөгжүүлж, батлан хамгаалах бие даасан байдлыг хангаж, иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг эрчимтэйгээр зохион байгуулна.

Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр процессын дахин инженерчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний хурд, чанарыг сайжруулж, үр ашиггүй давхардсан үйлчилгээг халж, цахим шийдлийг нэвтрүүлэх замаар зардлыг бууруулж, зорилтот хүн, хуулийн этгээдэд проактив хэлбэрээр хүргэнэ.

Төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээний уялдаа холбоог сайжруулах ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх нөөцийн оновчтой зарцуулалтыг сайжруулах, мэдээллийн давхардал, зөрүүг багасгах зорилгоор төлөвлөлт, төсөвлөлт, хяналт үнэлгээний платформыг хөгжүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн сан, тогтолцоо, процесс, санхүүжилтийн орчныг сайжруулах юм.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд дээрх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийг 103-д, авлигын индексийг 112-т, шүүхийн индексийг 57-д, шударга байдлын үнэлгээг 77-д тус тус хүргэж, сайжруулахыг зорьж байна.

Эрхэм гишүүд ээ,

Бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг амжилттай хэрэгжүүлснээр 2026 онд 1 хүнд ноогдох ДНБ-ийг 8090 ам.доллар-т хүргэж ядуурлын түвшнийг 5 хувиар бууруулна. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төсөл санаачлагч “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалтад Монгол Улсын хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх гэж, мөн зүйлийн 6.12 дахь заалтад санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх гэж заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан гэжээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг эдийн засаг, бүсчилсэн хөгжил, хүний хөгжил, хүний эрхийг дээдэлсэн засаглал гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хүн төвтэй хөгжлийн үзэл санаанд нийцсэн эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох зорилгыг тодорхойлж, төсвийн зардлын шинэчлэл, төрийн албаны

шинэчлэл, Үндэсний баялгийн сан төрийн өмчит компанийн засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах замаар эдийн засгийн эрх чөлөөний шинэчлэлийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тогтоолын төслийг D-parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Найдалаа 14 мега төсөлд үр ашгийн ач холбогдлын тооцоо судалгаа хийж, төслүүдийг эрэмбэлсэн эсэх, боловсролын салбарын хөрөнгө оруулалт болон төрийн албаны шинэчлэлийн талаар алдагдалгүй төсвийн бодлого хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд Хөгжлийн төлөвлөгөөнд макро тогтвортой орчныг бүрдүүлж, тодорхой хэмжээнд хэмждэг төлөвлөгөөтэй болох, төрийн өмчит компанийн ажилчдын цалин, тоо, бүтээмж, ноолуурын бэлтгэлийн эх үүсвэр, аж ахуйн нэгжүүдийг хэрхэн дэмжих талаар, Нүүрсний экспортын орлогын бууралтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батшугар Иргэдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авах, хүртээмжтэй өсөлтийг хэрхэн бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогын талаар, Төрийн өмчит компаниудын шинэчлэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар биржээр нүүрс арилжаалах үйл ажиллагааны талаар, урсгал зардал өндөртэй оновчгүй хөрөнгө оруулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС, Сэлбэ төвийн бүтээн байгуулалтын явцын талаар хөрөнгө оруулалтын төлөвлөлт улсын төсөвтэй нийцэлтэй эсэх, төслийн гадаад зээл тусламжтай холбоотой зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц Иргэдийн төлбөрийн чадвартай нийцсэн инженерийн бүрэн хангамжтай, эрүүл аюулгүй орчин бүхий 150 мянган айлын орон сууцыг барихаар төлөвлөгөөнд тусгагдсан нь бодитой эсэх, төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүдээрээ зөв тогтоох талаар, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлж, авлигын төсөөллийн индексийн оноог сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх талаар, төслийн хавсралтууд хоорондын уялдааг хэрхэн хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл 2026-2030 оны дунд хугацааны хөгжлийн бодлогоо хэзээ гаргах, 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг дунд хугацааны бодлогод хэрхэн нийцүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд төсөв санхүүгийн нарийн тооцоо хийсэн эсэх, Нийгмийн салбарын бодлогын зээлээр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд 333 тэрбум төгрөгөөр спорт заалыг барих нь үр дүнтэй эсэх, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих, шинжлэх ухаан технологийн паркийг байгуулах нь тохиромжтой эсэх, үүнийг хөгжлийн төлөвлөгөөнд тусгахгүйгээр хувийн хэвшлийн оролцоогоо дор барих талаар, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд төлөвлөгөөнд туссан төсөл арга хэмжээтэй хэр уялдаж байгаа талаар, олон улсын өрсөлдөхүйц чанартай, тэгш, хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлнэ гэж зорилтод үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь писа болон олон улсын үнэлгээ хэрхэн хүрэх, үр дүнд шууд нөлөөлөх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн үнийн өсөлтийг хязгаарлах талаар Эдийн засаг, хөгжлийн яам болон бусад яамд хэрхэн хамтран ажиллах талаар, Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, өрх айл, бичил бизнесийг дэмжих, хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний талаар, Төсвийн урсгал зардлыг бууруулахаар авч хэрэгжүүлж байгаа ажлын явц., төрийн албан хаагчдын тоог бууруулахдаа ажиллаж байгаа төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр ямар хувилбар, ямар сонголт өгч байгаа талаар,

Ашигт малтмалын нөөц тогтоох хөрөнгө, санхүүжилтийг хэрхэн нэмэгдүүлэх, АМНАТ, Газрын тосны нөөц, Засгийн газрын төлбөрийн 30-аас доошгүй хувийг орон нутагт хуваарилах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал хиймэл оюуныг төрийн бүх шатад нэвтрүүлж, бүтээмжийг сайжруулах хиймэл оюуны бэлэн байдлыг хангах ажлын явц Монгол Улсын хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ хийлгэж үндэсний стратегиа тодорхойлж дууссан эсэх, 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан эсэх төрийн өмчит компанийн бүтээмжийг 30 хувиар сайжруулах асуудал шийдлийн талаар, Оюутолгой төслийн ажиллах хүчний стратеги төлөвлөгөөг 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан Сангийн яамнаас татварын бодлогын шинэчлэлийг хэдий хугацаанд хийх, бүсийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийг ТЭЗҮ болон өөдөө тэмүүлэх ган татлагат гүүр, Хөшигтийн хөндийн туннел төсөл, Шинэ их тойруу хурдны зам гэх мэтчилэн өндөр санхүүжилттэй төслүүд Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд тусгасныг тодруулж, 14 мега төсөлд Тавантолгой цахилгаан станцын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд макро тогтвортой орчныг бүрдүүлж, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн Урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийг 10-20 дахин нэмэгдүүлэх гэсэн саналыг тодорхой тусгах, АМНАТ, Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бүс, аймаг, сум орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэлийг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх, Төрийн өмчит компанийн болон төсвийн зардлыг бууруулах реформыг яаралтай эхлүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3-д олон улсад өрсөлдөхүйц, чанартай, тэгш, хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлэх гэснийг олон улсад өрсөлдөхүйц гэснийг хасах талаар үндэсний баялгийн сангаар дамжуулан хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж эргэн төлөвлөгөөндөө тусгах нь тохиромжтой эсэх талаар, санхүүжилтийн эх үүсвэргүй төсөл, арга хэмжээг төсөлд тусгахгүй байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Найдалаа мега заслудын хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар Эдийн засаг, хөгжлийн яам болон бусад яамд хөгжлийн төлөвлөгөөний боловсруулалтад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Батболд гадаад зээлээр хэрэгжиж байгаа төсөлд хариуцсан яамд хяналтаа сайжруулж, хариуцлагатай ажиллах талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Эрдэнэбилигийн Одбаяр Монгол Улсын сайд,

Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Чинбатын Номин Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Жамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндийн Баатархүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лханаажав Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Довчинбуугийн Бямбадорж Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батсайханы Өнөмөнх Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Цэцэгмаагийн Уртнасан Байгаль, орчин уур, амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пуушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Доржготовын Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Жигжидсүрэнгийн Өнөржаргал Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Баасангийн Эрхэмбаяр Батлан хамгаалах яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, хурандаа, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Очиржанцаны Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Түмэндалайн Даваадалай Нийслэлийн Засаг даргын орлогч, Пагмажавын Хадбаатар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Болдбаатарын Гантулга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Даваасамбуугийн Дэлгэрмаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Нийт 31 гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Тэгээд жил болгоны төсвийн төсөөлөл орж ирдэг. Даанч харамсалтай нь их аймаг гоё юм ярьж байгаа биз. Ёо ёстой нээрээ энэ яриа янзын. Тэгээд жилд дунджаар 2 солино. 2021 онд бол жишээ нь 4 удаа сольсон шүү дээ. Төсөв тодотгох болгондоо солиод. Тэгээд нөгөө төсөвт тодотгох болгондоо нөгөө гоё юмнууд нь алга болоод байна. Тэгээд сайд нарынх болж хувирна даа. Тэгээд л тэд нар сайхан ийм семинар хийсэн шиг, гадна, дотно зугаалсан шиг, онгоцоор нисдэг тэргээр ниссэн шиг тэгээд л нөгөө семинарт ирсэн хүмүүс нь бүгдээрээ л сайддаа алга ташсан шиг тэгээд л нөгөө хамаг төсөв чинь бүгдээрээ байхгүй болдог байхгүй юу даа.

Тэгээд энэ жил дахиад л тэгэх гэж байна. Яагаад гэвэл ирэх жил нүүрсний үнэ чинь тийм аймаг өндөр байхгүй. Тэгээд өнөөдөр яг энд ингээд төсөв бид нар ийм төсвийн төсөөлөл энэ тэр гээд, ирэх жил 33 их наяд энэ тэрийг хуваарилах гээд л яриад сууж байх хооронд чинь хамгийн гол том хулгай хаана явж байна вэ гэхээр “Эрдэнэс Тавантолгой” дээр чинь явж байдаг байхгүй юу даа. Нүүрсээ өндөр тавьж байгаад л их орлого олно гэдэг. Тэнд нүүрснээс чинь хулгайлдаг хүмүүс нь Эрдэнэс Таван толгойнхон болчихсон. Яагаад. Би жишээ нь ганцхан жишээг хэлээд өгье. “Адмирал”, “Энержи ресурс” компаниуд яг уурхай дотроо баяжуулах үйлдвэр барьж байхад нөгөө “Эрдэнэс Тавантолгой” 14км-ийн цаана 30 сая тонн нүүрс баяжуулна гэж үйлдвэр барьчихаад, яг ашиглаад явна гэхээр ойролцоогоор 10 саяыг л баяжуулах үйлдвэр барьчихсан. Тэрийгээ 1 их наяд төгрөгөөр барьсан байгаа шүү дээ. Тэгээд яаж байна вэ гэхээр тэр дарга нар нь яаж байна вэ гэхээр дахиад тендер зарлана. Тийшээ нөгөө конвер явуулна. Конвероосоо бас жоохон мөнгө хусна гээд ингээд байж байгаа шүү дээ. Ийм байдлаар ерөөсөө хулгай зэлгий чинь бүр хаа сайгүй, шат шатандаа явчихсан. Одоо тэгээд л 7 их наядын төсөвтэй “Эрдэнэс Тавантолгой” чинь 7 их наядын төсөвтэй. 7 их наяд шүү. Юун тэнд чинь тэгээд гав ганцхан захирал нь, тэгээд нөгөө гол юмыг нь тэр худалдан авах ажиллагааных нь дарга нь мэддэг гэж байгаа юм. Тэр нь бол жинхэнэ хулгайч гэж байгаа юм. Тэгээд тэд нар нь бол ерөөсөө юун энд сууж байгаа Их Хурлын гишүүд, сайд нар бол сураг байхгүй. Одоо та нарыг шинэхэндүү гишүүд очоод, Лувсанжамц чамайг очих юм бол гөлөг ч гэж тоохгүй нээрээ шүү. Бүр тийм дампуурчихсан, даварчихсан газрууд бий болчихсон. Тэрийгээ цэгцлэхгүйгээр та нар лаг лаг төсөв бариад, ийм гоё бүтээн байгуулалт, энэ Монгол орон даяар хийнэ гэж яриад ямар нэмэр байгаа юм бэ. Ямар ч нэмэр байхгүй шүү дээ. Дунд шатанд чинь ерөөсөө хулгай зэлгий хэрээс хэтэрчихсэн. Энэ асуудлаа цэгцэл л дээ. Авлига, хээл хахууль хэрээс хэтэрчихсэн. Хөдлөх болгонд мөнгө болчихсон. Энэ дээрээ эн Их Хурал, Засгийн газар манлайллаа үзүүл л дээ. Авлигатай тэмцээд л байна, тэмцээд л байна гэх юм. Яагаад ард иргэд зүгээр л өчигдөр өөрсдөө ингээд ямарваа нэгэн шахалтгүйгээр ингээд гарч ирж жагсаж байна. Дургүйцэж байна гэдэг чинь юунаас шалтгаалж байгаа юм. Ерөөсөө л тэр татвар нь өндөр. Авдаг татвар нь өндөр. Бизнес ерөөсөө явж байгаа юм байхгүй. Тэгээд бүх шатанд бүгдээрээ авлига, хээл хахууль болчихсон. Тэр мөрөнд нь бүгдээрээ дарагдсан тэр ард түмэн чинь дургүйцээд,

ялангуяа бизнесменүүд хэдэн сайн хүнийхээ цалинг арай чүү тавиад л, тэгээд амьдралаа урагшаа явуулж байхад сайд нар тэр саяхан автобуснаас бууж ирж байна лээ л дээ. Яг худлаа л даа. Автобусаар юу гэж очих вэ дээ. Том том машинаар оччихоод автобуснаас бууж юм л үзүүлж байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” гээд Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Бүсчилсэн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Тэгээд сая Гантөмөр сайд бүсчилсэн хөгжилтэй холбоотой нэлээн чухал зүйлүүдийг дурдаж байна. Хэрэгжүүлсэн. Гэхдээ өнөөдөр яг бодит зүйлээ л хэдүүлээ бас яримаар байгаа юм. Яг энэ бүсчилсэн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд бид нар орон нутаг маань ямар байгаа билээ. Хэчнээн үйлдвэр баригдах юм бэ. Хэчнээн ажлын байр бий болох юм бэ. Ажлын байргүйгээс улбаатай орлогогүй иргэд дүүрэн, архидалт дүүрэн, архидалтаа дагаад хүчирхийлэл дүүрэн ийм л түвшинд өнөөдөр яг сумууд маань байна.

Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжил гээд бид нар яриад байдаг. Бүсчилсэн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэе гээд яваад байгаа маань зөв. Мэдээж 27 жилийн хугацаанд хэрэгжээгүй ураны төсөл хөдөллөө. 10 бараг 20-иод жилийн хугацаанд хөдлөөгүй төмөр замын хил холболтын төслүүд маань хөдөллөө. Сайн байна. Сайн ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Том төслүүд хөдөлж байж эдийн засаг тэлэх ёстой гэж ойлгож байгаа.

Гэхдээ бид нар өнөөдөр орон нутагт, ялангуяа бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд ч тэр маш олон цааснуудыг л бид нар үйлдвэрлэж байна. Яг бүс нутгийн хэмжээнд бид нар хэдэн үйлдвэрийг барьж байгуулж, хэдэн ажлын байр бий болгохоор энэ хөгжлийн төлөвлөгөөнд орж ирж байгаа юм бэ. Иргэдийн орлого хэрхэн нэмэгдэх юм бэ. Яг энэ бодит дүнгүүдийг л бид нар гаргаж тавимаар байна.

Цаашдаа бид нар энэ гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай асуудал хөндөөд байгаа юм. Яг яаж өнөөдрийн байгаа эрх зүйн орчин дээр гадаадын хөрөнгө оруулалт орох юм уу. Ямар боломжоор бид нар хангагдах ёстой юм. Энэ дээр би хариулт авмаар байна.

Хүний хөгжлийн бодлоготой холбоотой асуудлууд байна. Бас л гоё гоё зүйл биччихсэн л байна. Өнөөдөр Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум Мөрөн хотоос 170км зайтай байдаг. Өвчтөний хяналтын монитор байхгүйгээс болоод нярай хүүхдүүдээ Мөрөн хотод мониторт үзүүлэх гээд, харуулах гээд 6 цаг явж байгаа. Дунджаар шүү. Тэгээд бид нар өнөөдөр энэ сум орон нутагт байгаа иргэдийнхээ асуудлыг өнөөдөр байгаа түвшинд нь шийдэж чадаагүй байж байж энийгээ шийдэх тухай өнөөдөр хөндөж яриагүй байж байж, дахиад шинэ шинэ юм хийх тухай асуудлуудыг хөндөөд байгаа юм. Шинэ суурьшлын бүс байгуулна гээд л биччихсэн л байна л даа. Бүсчилсэн хөгжлийн хүрээнд шинэ суурьшлын бүс байгуулах ажлыг эрчимжүүлнэ. Дагуул хотуудын хатуу, зөөлөн дэд бүтцийн байгуулалт, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжинэ гээд. Шинэ суурьшлын бүс байтугай өнөөдөр байгаа суурьшлын бүсүүдээ бид нар өнөөдөр яаж дэмжих гээд байгаа юм. Яаж ажлын байраар хангах гээд байгаа юм. Яаж тэнд хүн амаа орлоготой болгох гээд байгаа юм. Энэ дээрээ төвлөрсөн бодлогоо бид нар ядаж 2026 ондоо бататгаад, энийгээ илүү сайжруулах тал дээр эхлээд байгаа суурьшлын бүс дээрээ асуудлаа шийдчихээд, дараагаар нь хэдүүлээ шинэ суурьшлын бүсийг ярихгүй юм уу. Бодит тоо л авмаар байна. Тэгнэ,

ингэнэ, тэгмээр байна, ингэмээр байна гэсэн мөрөөдлийн жагсаалт сонсоод баймааргүй байна. Яг бодит тоог л хэлж өгөөч ээ л гэдгийг хүсэж байгаа юм. Асуултдаа хариултаа авъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лувсаннямын Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ер нь бүсчилсэн хөгжлийн бодлого бол өөрөө ядуурлыг арилгах, ажлын байр нэмэгдүүлэх зорилготой эдийн засгийн бодлого. Яг энэ дээр тантай төсөөлж байгаа төсөөлөлтэй бол санал нэг байгаа. Бид нар энэ бодлогоо яг эцэслэж гаргасан уу гэвэл бас хагас дутуу юм байна. Одоо ний нуугүй хэлэхэд. Яагаад гэвэл бүсчилсэн хөгжлийнх нь тухайн бүсүүдийнх нь өөрийн нөөцийн судалгаа дутуу байна. Дата өгөгдөл нь дутуу байна. Ерөнхий төсөөлөл байна. Ерөнхий төсөөлөл дээр бодитой хөрөнгө оруулалтуудыг татъя гэж байгаа юм. Бодитой хөрөнгө оруулалтуудыг татахад жишээлбэл таны сонгогдсон хойд бүс дээр бол яалт ч үгүй зэсийн смелтрийн үйлдвэр бол тэргүүн эгнээнд орж ирэх учиртай. Тэрийг залгаад Эрдэнэт дээрээ зэсийн баяжуулах смелтрийн үйлдвэрээ дагасан аж үйлдвэрийн цогцолбороо бид нар хийх хэрэгтэй. Энэ дээр бол 2025 оны сүүлийн хагас, 2026 ондоо бол хэдүүлээ бүтэн алхана. Ингэж чадах юм бол 3-4 мянган ажлын байр бол тэнд бүрэн дүүрэн гарч ирэх ийм бололцоо бол 1 дүгээрт байна.

2 дугаарт хойд бүсийн тухайд бол аялал жуулчлалын бүс болгоно гэдэг нь бол маш ойлгомжтой байгаа. Тэгэхээр аялал жуулчлалын бүсээ ер нь хэрхэн дэмжих вэ гэдэг бодлогоо бол бид нар бодитойгоор гаргаж байгаа юм. Бодитойгоор бодлого гаргахад эхний ээлжид бол 4 улирлын аялал жуулчлал авах чадавхыг хэдүүлээ нэмэгдүүлэх юм байна лээ. Өнөөдөр байгаа аялал жуулчлалын нөгөө хүлээж авдаг төвүүд нь зөвхөн зун, намар тэгээд хавар дулаарахаар үйлчилдэг. Ингээд өвлийн улирал намар хүйтрэхээр бол үйлчилгээ явдаггүй ийм зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар бол бүсчилсэн хөгжлийн хүрээнд яг хойд бүс дээр аялал жуулчлалыг хэрхэн дэмжих вэ. Жишээлбэл, аялал жуулчлалын орон байрууд байна шүү дээ. Тэрний газрын татварыг яах вэ гэдэг асуудал цоо шинээр хөндөгдөнө. Аялал жуулчлалын компаниудыг татварт хамруулах уу, үгүй юу гэдэг асуудал хөндөгдөнө. Яг энэ утгаараа бол яг бүсчилсэн хөгжил өөрийнхөө бүсийн нөөц, боломж тэр дээр тулгуурласан асуудлуудаа шийдээд явна.

Шинэ суурьшлын бүс гэдэг нь бол Хархориноо хэдүүлээ босгож ирнэ. Хүннү хотоо босгож ирнэ. Үүний төлөвлөлтийг хийхээс өөр аргагүй. Өнөөдөр байгаа суурьшлын бүсүүдийг сайжруулахыг бас шинэчилж байгаа гэж ойлгох хэрэгтэй. Бид нар 150 мянган айлын орон сууцын үндэсний хөтөлбөрөө зарлаад явах юм бол жишээлбэл өчигдөр бид нарын ажилласан Цогтцэций сум, Ханбогд сум, тэр Гашуунсухайт гээд энэ газрууд дээр бид нар хот төлөвлөлтийг шинээр хийх боломж байна. Тэгээд энэ хүрээндээ ажлуудаа төлөвлөөд явж байгаа шүү гишүүн ээ. Тэгэхээр бид нар бол 6 хувийн эдийн засгийн өсөлт гэдэг бол яг тэр хэмжээгээр ажлын байраа нэмэгдүүлэх ийм л тооцоо. Эдийн засаг өсөх хэмжээгээр ажлын байр бий болдог. Эдийн засаг өсөх хэмжээгээр 6 хувиар эдийн засаг өсөж байхад хүмүүсийн орлого 5 хувиар нэмэгдэж байдаг. Энэ бол өөрөө уялдаатай эдийн засаг өсөөд яг орлого нь .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм Гантөмөр сайд аа, ойлгож байгаа. Ингээд л ерөнхий л хариулаад байгаа байхгүй юу. Яг ний нуугүй хэлэхэд аялал жуулчлал дээр, хойд бүс дээр газрын татвараас тодорхой хэмжээнд хөнгөлөх нь нэг их чухал асуудал биш. Хамгийн чухал асуудал бол эрчим хүч. Тэнд 4 улирлын аялал жуулчлалтай болохын тулд өвөл ажилладаг системийг дэмжихийн тулд зун тогтвортой ажиллуулахын тулд эрчим хүч л хэрэгтэй байгаа юм. Бороо ороход бүх баазуудын цахилгаан тасарч байна шүү дээ. Би сайд байхдаа энэ асуудлыг хөндөж байсан. Эрчим хүчний яам маань юу гэж хариулдаг вэ гэхээр эрчим хүчний хангалт дутуу л гэдэг. Үнэн. Тэгэхдээ тэнд өнөөдөр ний нуугүй хэлэхэд газрын төлбөрөөс илүүтэй эрчим хүчний хангалтыг тогтвортой байдал дээр барьж өгвөл 4 улирлын аялал жуулчлал хөгжихөд бэлэн байгаа. Аж ахуйн нэгжүүд өөрсдөө бэлэн байна.

2 дугаарт, Хөвсгөл аймаг, Булган аймаг мал аж ахуй ихтэй. Яг энэ чиглэл дээр мал аж ахуйд суурилсан, малын бүтээгдэхүүнд суурилсан хэдэн үйлдвэр баригдах юм бэ. Боломж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Тийм. Тэгэхээр бид нар эрчим хүчнийхээ чадлыг нэмэгдүүлэхээр маш тодорхой ажлууд хийж байгаа. Энэ жилдээ багтаагаад 300мвт-аар бид нар хүчин чадлаа нэмэгдүүлнэ. Тэгээд ирэх 7 хоногт Засгийн газрын хурлаар 1 чухал зүйл яригдах гээд байна. Тэр бол тархмал эх үүсвэрийн боломжийг гаргаж өгөх, ялангуяа говийн бүс, баруун бүс гээд энэ 2 бүс дээр тархмал эх үүсвэрийнх нь боломжийг гаргаж өгөхгүй бол эдийн засгийн нөгөө бид эрчим хүчийг хэдүүлээ либералчилна гэж яриад байгаа нь тэр тодорхой хэмжээг хүртэл эрчим хүчний станцуудыг өөрөө өөрийгөө хангах зориулалтаар барьж байгуулах тэр бололцоог, тэр эрхийг нь олгох чиглэлийн бодлого 1 дүгээрт гаргана.

2 дахь асуулт нь юу байлаа. Хөдөө аж ахуй дээр тэр малын эзэн үйлдвэрийн эзэн гэдэг ТЭЗҮ-г хийж байна. ТЭЗҮ-ийг яг малчид үйлдвэртэйгээ хэрхэн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: Одоо манайд байгаа гол дутагдал юу вэ гэвэл малчид, үйлдвэр 2 нь хоорондоо бүрэн салчихсан учраас дунд нь худалдааны систем байгаад байдаг. Гэтэл үйлдвэрлээд гарсан бүтээгдэхүүнээс ашиг олдоггүй гэдэг ийм зүйл байгаад байгаа юм. Тэгээд хамгийн сүүлд Энхбаяр сайд бид 2 ноолуур үйлдвэрлэгчидтэй уулзалт дээр юу ярьсан бэ гэхээр ноолуур үйлдвэрлэлийг эцсийн бүтээгдэхүүн рүү нь алхъя. Ингэж чадах юм бол ноолуур үйлдвэрлэгчид маань эргээд малчдынхаа орлогыг тогтвортой байлгах бодлого дээрээ Засгийн газартайгаа 3 талтай ийм харилцааг бий болгоод явъя гэж байгаа юм. Малыг эзэн, үйлдвэрийн эзэн гэдэг хөтөлбөрийг хэрэгжүүлж чадвал бид нар бүсүүд дээрээ үйлдвэрүүдээ байгуулна. Байгуулахдаа хувийн хэвшил үйлдвэрээ авч явна. Тэнд нь Засгийн газар хөрөнгө оруулна. Хөрөнгө оруулсан хэмжээгээрээ малчдадаа хувийг нь эзэмшүүлнэ. Хувь эзэмшиж байгаа малчид маань өөрийнхөө түүхий эдийг үйлдвэр лүүгээ нийлүүлнэ гэдэг .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Тодорхой 3 асуулт асууя. Энэ төлөвлөгөөнд төрийн албан хаагчийн тоог эмч, багш нараас бусад төрийн албан хаагчийн тоог 9 хувиар бууруулна гэсэн байна л даа. Сайн тоо байна. Тодорхой төлөвлөгөө байна. Энэ зүгээр яг одоо төрийн албан хаагчийн тоо эмч, багш нараас бусад нь хэд байгаа юм бол. Тэгээд 2026 оны сүүл гэхэд 9 хувиар буурах нь л дээ. Энэ зүгээр аль хэсгээс, ямар аргаар цахимжуулаад юм уу, эсвэл цомхотгоод юм уу, ямар төлөвлөгөөтэй байгаа юм бол энийг тодруулж өгөөч. 2025 онд одоо энэ жилийн төлөвлөгөөнд тэр бас яг төрийн албан хаагчийн тоог бууруулна гэсэн ажил байгаа билүү. Тэр нь хэд байгаа билээ. Энийг ажлын хэсгээс тодруулж өгвөл их сайн байна.

2 дахь нь мега төсөл гээд 14 төсөл ноднин баталсан. Тэгээд өнгөрсөн жилийг бодвол жил орчим боллоо. Гадаад орчин, дотоод орчин, эдийн засгийн нөхцөл байдал өөр болж байна. Тэгээд энэ дээр ямар нэгэн эрэмбэлсэн зүйл эрэмбэлэх төлөвлөгөө байгаа юу. Өчигдөр Байнгын хороо дээр асуухад эрэмбэлээгүй л гэж байна лээ л дээ. Бүгдээрээ хийх гэж байгаа гээд. Жишээлбэл, нөгөө хиймэл дагуул маань хийх хэвээрээ юу гээд. Тэгээд ийм нөхцөл байдалд энэ том мега төслийг хэт ингээд шүтээд явах нь өөрөө эдийн засгийн макро орчныхоо нөхцөл байдлыг нөгөө ханшийн тогтвортой байдал, инфляцыг бас буруу тийш нь залах аюултай. Тэгэхээр ямар нэгэн байдлаар эрэмбэлэх тэмүүлэл процесс ажиллагаа байх ёстой гэж санагдаад байгаа юм. Тэгээд хиймэл дагуул хэвээрээ юу. Мөн Богд уулыг нүхлэх хэвээрээ юу. Аль ч талаасаа бодсон энэ бол бас л сайн бодохгүй бол оновчгүй төсөл байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр хариулж өгнө үү.

3 дахь нь бизнесийн орчныг сайжруулах бол жил жилийн ер нь жил болгон л ярьж байдаг, байнга төлөвлөгөөнд ордог. Гэхдээ хэзээ ч бодитой үр дүн гардаггүй нэг ажил байгаа. Энэ төлөвлөгөө дээр харах юм бол эдийн засгийн эрх чөлөө гээд маш ерөнхий нэрээр орчихсон байна. Тэгээд яг бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр татварын шинэчлэл гээд орчихсон байна. Яг аль чиглэлээр нь татвар дээр ямар шинэчлэл хийх гэж байгаа юм. Ер нь бизнес эрхэлж байгаа хүмүүст тэр эрх чөлөө гээд байгаа бизнесийн орчин нь яг юун дээр мэдрэгдэхүйц тийм ажил 2026 онд төлөвлөж байна вэ. Энийг яг тодорхой хэлж өгөөч гэж.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Бизнесийн орчин дээр маш ойлгомжтой юм билээ. Барилга б эхлүүлэх зөвшөөрлийн хүнд суртлын бүрэн арилгана гэдэг 1 дэх асуудал байгаа. 2 дахь асуудал бол эрчим хүчтэй холбогдох хүнд суртлыг бүрэн арилгах юм билээ. 3 дахь нь бүртгэлийг хялбаршуулах юм билээ. Хоног хугацааг нь наашлуулах. 4 дүгээрт нь шүүхийн маргааныг шийдвэрлэх эрх зүйн орчин. Яг өнөөдөр монголын бизнесийн орчинд юу байна вэ гэхлээр шүүхийн маргаан, өмчийн маргаан 3 шатын шүүхээр явдаг, буцдаг ийм маргаантай байгаа тохиолдолд заримдаа 2 хөрөнгө оруулагч хоорондоо шүүхдээд 15 жил болж байгаа түүх байна. Асуудал шийдэгддэггүй. Хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалт нь хамгаалалтгүй. Тэгээд эцэст нь мэдээж хөрөнгө оруулалтын хуулиа хэдүүлээ энэ чуулганаараа хэлэлцүүлнэ. Хөрөнгө оруулалтын хуулиар хөрөнгө оруулахад хаасан зарим салбаруудыг нээнэ гэсэн ийм бодитой ажлууд байгаа. Нэг үгээр хэлбэл бизнесийн орчныг үнэлдэг үнэлгээнийхээ юуг үнэлээд байна вэ гэдгийг бид нар бол харчихсан. Тэр үнэлгээ дээр яагаад алдаад байна вэ гэдгийг судлаад гаргачихсан. Одоо бол хуулиуд дээрээ ажиллах ийм зүйл бол 1 дүгээрт байгаа.

2 дугаарт ер нь энэ бизнес, хөрөнгө оруулалт хийхэд хамгийн чухал зүйл бол яалт ч үгүй эрчим хүчний асуудал байгаа. Түрүүн Бат-Эрдэнэ гишүүний хэлдэг. Тэгэхээр эрчим хүчнийхээ тархмал эх үүсвэр дээр бид нар зөв бодлого гаргаж чадах юм бол холболт дээр нь нийлүүлэлтээ нэмэгдүүлж чадах юм бол холболтынх нь асуудал шийдэгдээд явах ийм бололцоо бол байгаа.

Мега төслүүд бол мэдээж эрэмбэлэгдэнэ. Жишээлбэл, мега төсөл яаж эрэмбэлэгдэх вэ гэхээр урт хугацаандаа Монголын хожлыг аль нь авчрах вэ гэдэг дээр эрэмбэлэгдэнэ. Урт хугацаандаа. Тэгэхээр өнөөдөр бол эрэмбийн 1 дүгээрт хэл холболтын төсөл байсан. Энэ эрэмбийн 1-д байгаа төслөө бид нар урагшлуулж чадсан. Юу вэ гэвэл, бид ямар байхаас, бидний араншин ямар байхаас үл хамаараад эдийн засаг өөрөө тогтвортойгоор өсөж байдаг. Эдийн засаг өөрөө тогтвортой байдаг тэр суурийг хил холболт гэж байгаа юм. Нэг үгээр хэлбэл байгаа салбараа интеграцад оруулж байгаа гэж цөмөөрөө ойлгож байгаа.

Дараагийнх нь бол мэдээж эрчим хүчний асуудал байгаа. Хил холболтын дараа эрчим хүч. Дараагийнх нь усны асуудал байгаа. Усныхаа асуудлыг хэдүүлээ бодитойгоор шийдэхгүй бол байгаль орчны доройтол бол ирээдүйн эдийн засагт хамгийн том цохилт өгөх юм байна лээ. Тийм учраас үүнээс урьдчилан сэргийлж байгаа гэж ойлгох хэрэгтэй.

Дараагийнх нь энэ зун, ирэх жил 2 хамгийн их хүч гаргаж хийх ажил бол аж үйлдвэржилт. Эрчим хүчний шийдлүүдээ гаргаад, эрчим хүчний хөрөнгө оруулалтууд орж ирж байна. Энийгээ дагасан үйлдвэржилтийн хөрөнгө оруулалтыг татах тэр орчны төслийн санхүүжилтийнхээ схемүүдийг гаргаж байна. Одоо миний хэлээд байгаа тэр зэсийн үйлдвэр дээр нь Кокс химийн үйлдвэр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: Төрийн албан дээр яалт ч үгүй давхардал байна. Төрийн албаны судалгааг сүүлийн 1 жилийн хугацаанд Амарбаясгалан дарга Хэрэг эрхлэх газрын дарга байхаасаа эхлүүлээд, захиалга өгөөд судалгаанууд хийсэн. Судалгааг 2, 3 газраар хийж байна. Энэ давхардлыг 1 дүгээрт арилгана. Жишээлбэл, татварын алба хотод байх ёстой юу, байх ёсгүй гэж хотын татварын алба байхгүй. Дүүрэг дээрээ л тэр татварын асуудлаа шийд. Нийгмийн даатгал адилхан дүүрэг дээрээ л шийд гэх мэтчилэн дунд байгаа албуудаа хэдүүлээ цөөлөе.

2 дугаарт үйлчилгээгээ цахим руугаа шилжүүлье. Цахим руугаа шилжүүлье. Тэгэхээр цахим технологийн хөрөнгө оруулалтын асуудал яригдаж байгаа. Өнөөдөр Баатархүү сайдаас авч байгаа мэдээлэл 5 жи бол өөрөө манай интернэтийн сүлжээ рүү нэвтрэх суурь нөхцөлүүдийг боломжуудыг бид нар гаргаад компаниудад нь боломжийг нь өгөөд явж байгаа гэж байгаа. 5 жи нэвтрээд явах юм бол манай платформ өөрөө маш сайн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Алив ажлын хэсгийн микрофоны дугаар хаачсан юм. 11 номерын микрофон өгье. Ажлын хэсэг, дараад нь Баатархүү сайд нэмж хариулна.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Найдалаа. Гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны цомхотгол төрийн албаны албан хаагчдын тоон өсөлт нь сүүлийн 10 жилийн байдлаар нийт 39,3%-аар өссөн юм байна лээ. Төрөн дотроо улс төрийн алба нь 36,6 төрийн захиргааны алба нь 31,9 төрийн тусгай алба

нь 70,5 төрийн үйлчилгээний алба нь 32,7% хувиар ингээд өсөлттэй явж байгаа юм байна лээ. Эндээсээ бид саяын өсөлтийг нь томъёололд оруулаад тодорхой яг саяын салбаруудаар нь ингэж ангилж бууруулахаар эхний тооцоо гарсан 2 дахь яг энэ эцсийн тооцоо маань төрийн албаны чиг үүргийн бүрэн шинжилгээ хийх процессыг нь дахин инженерчлэл хийсний дараа тоо нарийвчилж эцэслэгдэж гарах юм.

Д.Амарбаясгалан: Баатархүү сайд нэмж хариулъя.

Ц.Баатархүү: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Үндэсний хиймэл дагуултай холбоотой асуудлыг тавьж асуусан байна. Үндэсний хиймэл дагуул төсөл бол судалгааны шатад явж байгаа. Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд Франц улсад үндэсний хиймэл дагуул төслийг тэр үйлдвэрлэгчтэй уулзаж ярилцаж, үнэ өртөг, хүчин чадал, Монгол Улсын яг өнөөгийн нөхцөл байдалд ямар үр ашиг өгөх юм бэ гэдэг ийм судалгааны үе шат явж байна. Одоогийн байдлаар яг өнөөдөр бас Франц Улсад Засгийн газрын гишүүд бөгөөд ажлын хэсгийн гишүүд бол ажиллаж байгаа гэдгийг хэлье.

2 дугаарт нь үндэсний хиймэл дагуул төсөл маань бол эдийн засгийн хувьд гэхээсээ илүү технологийн хувьд, харилцаа холбооны, бие даасан байдлын хувьд үр ашигтай төсөл юм гэж би албан ёсоор хэлмээр байна. Учир юу юм бэ гэхээр дэлхийн 100 гаруй улс ямар нэгэн байдлаар энэ сансрын орон зайд өөрсдийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Манай хариулт өгч байгаа талын хүмүүс бас их товч тодорхой хариулт өгнө шүү. Тэгэхгүй бол Улсын Их Хурлын гишүүд 5 минутад асуучихдаг. Хариулт нь 10 минутаар яваад байвал бид 30 хэдэн хүн хэдэн цаг, хэдэн өдөр хэлэлцээд дуусахгүй юм руу явах нь байна шүү дээ. Тэгээд хариултаа маш тодорхой өгөөд явчихъя. Бадрахын найдлаа гишүүн тодруулъя.

Б.Найдалаа: Тэр төрийн албан хаагчийн тоог бууруулахтай холбоотой би зориуд асуусан юм. Энийг зүгээр ингээд товч тодорхой 9 хувь гээд оруулчихсан байгаа байхгүй юу. Энэ маш сайн. Гэхдээ одоо яг хэд байгаа тоог хэлэхгүй байна шүү дээ. Хэлэхгүй байна уу, эсвэл тооцоо нь байхгүй байгаа юм уу. Зүгээр олон нийтэд дуулгачихмаар байгаа байхгүй юу. Ирэх оны төлөвлөгөөнд ийм төлөвлөгөө орох юм байна. Төрийн албан хаагчийн тоо ийм байгаа юм байна. 9 хувь бууруулна гээд төлөвлөгөө батлуулж байгаа юм байна. Тэгээд ирэх жил 9 хувь буурсан уу, 30 хувь өссөн үү, 2 хувь буурсан уу гээд яг нягталмаар байгаа байхгүй юу. Жоохон тодорхой байхгүй бол болохгүй байна. Тэгэхээр энэ дээр тодорхой тоо байхгүй бол байхгүй гээд хэлээд өгөөч. Байвал тоогоо тодруулаад өгөөч гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Захиргааны албан хаагчдыг бид нар 10 хувиар бууруулахад 2153 хүнийг чөлөөлнө. Тусгай албыг 25 хувиар бууруулахад 12270 хүнийг чөлөөлнө. Үйлчилгээний албыг 9 хувиар бууруулахад 3658 хүнийг чөлөөлнө. Улс төрийн албыг 9 хувиар бууруулахад 340 хүнийг чөлөөлнө гэсэн ийм тоо байгаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Монгол Улсын Засгийн газар 2024-2028 онд 578 зүйл заалт бүхий мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн. Энэ мөрийн хөтөлбөрөө 11 хэмжих нэгжээр хэмжихээр тодорхойлсон байгаа. Жишээлбэл, ядуурлыг тэдэн хувьд хүргэнэ. Авлигын индексийг тэдэн хувьд хүргэнэ. Хүний хөгжлийн индексийг тэдэн хувьд хүргэнэ. Өрсөлдөх чадварыг тэдэн хувьд хүргэнэ гэх маягаар 11 хэмжих нэгжийг тодорхойлсон байгаа юм. Одоогийн байдлаар 48 сараас 11 сар буюу бараг 4-ний 1 нь өнгөрч байна. 4-ний 1 нь өнгөрч байхад 4-ний 1 хэрэгжилт бий болсон байх ёстой логикийн дагуу. Тэгэхээр энэ логикоор хараад үзэхэд өнөөдрийн байдлаар дараагийн 2026 оны хөтөлбөр орж ирж байгаатай зэрэгцээд мониторинг үнэлгээ хэдэн хувьтай байгаа вэ. Энэ 11 хэмжих нэгжээр Засгийн газрын хөтөлбөр яаж хэрэгжиж байгаа вэ. Энэ дээр хариулт авъя.

2 дугаарт нь 2026 оны тэргүүлэх чиглэл маань 4 бүлэг 104 зүйл заалттайгаар орж ирж байна. 4 бүлэг, 104 заалт маань 1 дүгээрт бүсчилсэн хөгжил, 2 дугаарт хүний хөгжлийн бодлого, 3 дугаарт эдийн засгийн бодлого, 4 дүгээрт хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн ийм загварчлалтайгаар орж ирж байгаа. Энэ загварчлалыг буруу байна гэж үзэж байгаа. Энэ дээр өөрчлөх боломж байна уу. Ер нь бид нарын хамгийн чухал зүйл чинь энэ хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого нэгд байх ёстой. Эндээс чинь авлигыг бууруулна. Эндээс чинь тэр засаглал ил тод, нээлттэй, цомхон, чадварлаг байх боломжууд бүрдэнэ.

Ингэснээрээ нийгэмд өгөөж нь, эдийн засагт өсөлт нь, иргэдийн амьжиргаанд хүртээмж нь очно. Тэгэхгүй шууд бүсчилсэн хөгжил гэж байгаа юм. Тэгэхээр энэ загварчлалын хувьд бол эрэмбийн 1 дүгээрт нь энэ хүний эрхийг дээдэлсэн энэ засаглалын бодлогоо н1-д оруулж байж 2 дугаарт нь хүний хөгжлийн бодлогоо тавих ёстой. Энэ бүсчилсэн хөгжил юуны төлөө юм. Хүний хөгжлийн төлөө. Энэ эдийн засгийн бодлого юуны төлөө юм. Хүний хөгжлийн төлөө хүний эрхийг хангасан тогтолцооны төлөө байхгүй юу. Тэгэхээр Улсын Их Хурал чинь өнгөрсөн 11 сард хүн төвтэй бодлого хэрэгжүүлнэ гээд стратегия гаргаад, Их Хурлаас гаргаж байгаа бодлогын шийдвэр болгон хүний эрхийн мэдрэмжтэй энэ шалгуурыг хангасан байна гэчихсэн шийдэл гарчихсан байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 4 зүйл 1 дүгээрт нь энэ эрэмбээ зохицуулаач. Засаглалын бодлогоо нэгтгэн тавиац Хүний эрхийг дээдэлсэн. 2-т нь хүний хөгжлийн бодлого. 3-д нь эдийн засгийн бодлого 4-д нь бүсчилсэн хөгжил гэж загварчлах боломж байна уу. Өөрөөр хэлбэл логиктой байх ёстой шүү дээ. Тэгэхгүй эхэндээ бол эдийн засаг, бүсчилсэн хөгжил гээд байдаг баахан тоо мега төсөл хөтөлбөр яриад байдаг. Гэтэл үүний чинь эцсийн эцэст зориулалт нь хаашаа чиглэх ёстой юм бэ гэхлээрээ иргэний амьжиргаа сайжрах ёстой. Тэгж байж бид нар хэдэн мянган залуучуудаа хилийн дээс алхуулж хүний нөөцийн хохирол авч тархины гоожилтод өртөхгүй байх ёстой юм л даа. Тэгэхээр Засгийн газрын энэ хөтөлбөрийг харахаар процессыг нь дахин инженерчлэл эд нар гэсэн ийм үг хэллэгүүд ашиглаад байгаа юм. Ойлгож байгаа.

Гэхдээ Засгийн газрын хөтөлбөр энгийн иргэдэд ойлгомжтой байх ёстой. Тангад ном уншаад байгаа юм шиг сонсогдож болохгүй баймаар байгаа юм. Хээнцэр ганган биш, яг оновчлолтой хэмжих нэгжтэй тэр томъёолол байх ёстой Нэхэж байгаа зүйл бол Зам, тээврийн ослоор зөвхөн Улаанбаатар хотод гэхэд 2024 онд 131 хүн нас барж байна. 2022, 2023, 2024 онд 318 хүний эрдэнэт амь нас эрсэдсэн. Тэгвэл Засгийн газар үүнийг яаж байхгүй болгох юм. Иргэд нь амь насаа алддаггүй, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй орчныг яаж бүрдүүлэх юм гэдэг дээр зорилго тавимаар байгаа юм.

Хүчирхийллийн асуудал 2017-2024 онд 9610 хүн хүчирхийлэлд өртсөн, хохирогчоор тодорхойлогдсон. Гэхдээ энэ нь Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хэлж байгаагаар дөнгөж 10,1 нь л мэдэгдэж байгаа. Насанд хүрээгүй хүүхдийн хүчирхийлэл сүүлийн 4 жилд 2,5 дахин өссөн. 598 хүүхэд хохирсон, зөвхөн 2024 онд. Сүүлийн 3 жил 2207 хүүхэд хохирчихсон байгаа. Засгийн газар энэ зүйлээ бууруулна гэдэг зорилгыг тавиач ээ.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Ер нь Эрдэнэболд гишүүний ярьж байгаа саналтай бол санал 1 байгаа. Авлига буурч байж юм явна гэж. Гэхдээ бид нар асуудлыг арай нөгөө талаас нь бас давхар харж байгаа юм. Юу вэ гэвэл ядуурал байгаа үед бол энэ авлига, хээл хахууль буурахгүй юм байна. Тийм учраас ядуурлаас гаръя гэдэг нь бол энэ хамтарсан Засгийн газрын тэргүүн чиглэл гэж би хувьдаа дүгнэж, энэ эрэмбэ дараалал гаргасан байгаа. Тэгэхдээ энэ бол өнөөдөр зохиож байгаа зүйл биш. Хэдүүлээ Засгийн газрынхаа 4 жилийн мөрийн хөтөлбөр батлахдаа яг энэ эрэмбээр гаргаж зохиосон, гаргаж баталсан. Бид бол нэг тодорхой зорилт дэвшүүлээд, 4 жилийн зорилтоо дэвшүүлчихсэн бол яг тэрнийхээ араас явна гэсэн ийм тодорхой байр суурьтай байгаа шүү гишүүн ээ. Тэр 4 жилийн хөтөлбөрөө л хэрэгжүүлье. Тэгэхгүй бол дундуур нь ингээд шинэ юм бодож олоод, дундуур нь шинэ санаачилга гаргаад, дундуур нь өөр зүйл рүү ингээд самуураад байх шаардлага бидэнд алга гэж ингэж үзэж байгаа юм. Тийм учраас ер нь Их Хурал хэрвээ бодлогоо өөрчилье гэвэл та бүхэн Байнгын хороон дээрээ энийгээ яриад эрэмбэ дараагаа сольж болно. Энэ бол Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Засгийн газар энэ бүсчилсэн хөгжил нь өөрөө Монгол Улсын энэ тархай бутархай том газар нутагтай улс орны хувьд бүсчилсэн хөгжлийн бодлого нь өөрөө ядуурлыг арилгах чухал бодлого байна. Энийг л хэдүүлээ 4 жилийн хугацаанд суурийг нь хийгээд бодлогынх нь чиглэлийг гаргаад, тодорхой төслүүдийг нь хэрэгжүүлээд ард нь гаръя гэдэг ийм зорилттой байгаа.

Тэгэхдээ энэ бол их амархан хийх ажил бол биш. Бид нар Японы Засгийн газартай ярилцаж байгаа. Яг энэ бүсчилсэн хөгжлийнхөө бодлого, төлөвлөлтийг жишээлбэл говийн бүсийн хөгжлийг тэр хийж чадаж байгаа, олон улсад хэрэглэчихсэн хүмүүс нь яаж хийсэн бэ, тэр хүмүүсээр нь судалгаа хийлгэх ажил явж байна. Тэгээд та бол мэдээж судалгаанд ямар хугацаа ордгийг мэдэж байгаа. Тэгэхдээ ерөнхий өгөгдлөө бол бид нар харж байгаа учраас тийм худлаа юм бол хийхгүй байгаа. Зүгээр энийг төгс байдлаар нь хэрэгжүүлэхэд яалт ч үгүй эрдэмтэн мэргэдийн оролцоо хэрэгтэй байна. Энийг хийсэн хүмүүсийнх нь оролцоо хэрэгтэй байна гэж үзэж байгаа учраас хөгжлийн шинэ хандлага гаргаж ирж байж ядуурлаас салъя. Ядуурлаас салахад бол дарга нар нь тэр авлига авдаг, бизнес хийж байгаа хүмүүс нь авлига тушаадаг энэ хандлага алга болно гэсэн ерөнхий зураг байгаа. Тэгэхдээ мэдээж таны хэлж байгаа сайн засаглалыг бид өдөр болгон араас нь явах ёстой. Өдөр болгон араас нь явахад хамгийн бидэнд байгаа том хэрэгсэл бол яалт ч үгүй цахим засаглал. Цахим гэдэг бид нар энийг технологийн шинэчлэлээ хийж чадах юм бол хэн нэгэн хүн зам зуур ямар нэгэн луйвар хийх ямар ч боломжгүй болж байгаа. Тийм учраас энэ цахим засаглалаа би Их хурал, Засгийн газар бүх түвшинд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Гантөмөр сайд аа, таны логиктой санал нийлэхгүй байгаа юм. Ядуурал буурч байж авлига буурна гэдэг логик байж болохгүй ээ. Засаглал чинь сайжирч байж иргэдийн тэр боломжийг хулгайлаад байгаа тэр авлига чинь буурч, үгүй болж байж ядуурал буурч тэгш хүртээмжтэй эдийн засаг чинь өснө. Энэ дээр хэдүүлээ маргаад ч юм уу олон тал болоод байх хэрэггүй. Өөр өнцөг гэж байхгүй. Ямар ч хоёрдмол утгагүй ойлгомжтой зүйл байхгүй юу. Засаглал сайжирч байж дарга нарын энэ данхайсан бүтэц, авлига авдаг тогтолцоог нурааж байж энэ авлигыг устгаж байж ядуурал чинь буурах нийгмийн эко систем чинь гарна.

2 дугаарт эрдэмтэн мэргэдийн судлаачдыг ойлгож байна, хүлээж байна. Гэхдээ энийг чинь хүлээгээд бид нар их ухаантай юм ярьж байх хугацаанд чинь зам тээвэр гээд янз бүрийн ийм байдлаар утаа тортог гээд иргэд амь насаа алдсаар байгаа. Энэ дээр Засгийн газар нэг тийм шийдэмгий алхаад явчих бүрэн боломж байгаа юм. Ерөнхий зургаар харахгүй тодорхой зарчмаар хэдүүлээ асуудалд хандъя.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Үгүй ээ, тэгээд Эрдэнэболд гишүүн ээ, өөрөө яг энэ эрэмбээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлаад 7 сар болж байгаа шүү дээ. Тэгээд 7 сарын хооронд та гэнэт ухаан ороод л байрлалыг нь сольё гэдэг юм уу ямар учиртай юм. Тэр 7 сарын өмнө өөрөө саналаа гаргахгүй яасан юм. Наад засаглалын бодлогыг чинь 1-д тавья гээд 7 сарын өмнө батлахад саналаа оруулаад батлахгүй яасан юм. Тэгээд бид нар ингээд 7 сар, 6 сар, 5 сар, 3 сараар ингэж бодол санаагаа өөрчилдөг юмаа одоо больё л доо. Засгийн газрын хөтөлбөрийг Их Хурлын гишүүн болгон ширээн дээрээ тавиад, яг тэр ажлынхаа араас бүгдээрээ явъя л даа. Тэгэхгүй тэгээд 1 өдөр сэрээд 1 юм ярьдаг. Маргааш нь н1 ном уншихаараа өөр юм ярьдаг. Бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Эдийн засаг нь гайгүй болсон орон болгон тэр хугацаандаа авлигаасаа холдсон шүү дээ. Тэгээд энийг мэдэн будилаад ядуу мөртөө шударга ёстой улс гэж хаана байгаа юм.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүн дахиж тодруулна.

С.Эрдэнэболд: Төсөв хэлэлцэж байхад, хөтөлбөр хэлэлцэж байхад энийг удаа дараа хэлж, горимын санал хүртэл гаргаж байсан юмаа. Тэр бичлэг нь интернэт дээр байгаа. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төсөв нийцэж байгаа эсэх дээр аудит бүрэн нягталж чадахгүй байна. Нийцүүлж дүгнэлт хийж чадахгүй байна. Ингээд өгөөч ээ гэж Байнгын хорооны хурал, Их Хурлын чуулган дээр 3 удаа мэдэгдсэн. Гэнэт зүүдэлж сэрээд байгаа юм биш. Хэрвээ тэр бичлэгийг та үзэж чадахгүй бол миний өнгөрсөн 7, 8 сарын цалинг бүгдийг нь хурааж авч болно. Ажлаа хийгээд явж байгаа. Зарчмын шаардлагууд тавьж байгаа. Зарчмын шаардлага тавихаар азаргалаад, субъектив гомдоод, хандаад байх шаардлага байхгүй. Авлига гэдэг зүйлийг өөрийг нь устгаж байж ядуурал буурдаг юм. Эдийн засгаа нэмэгдүүлэхээр ядуурал сайжирдаг гээд байдаг. Гол нь өнөөдөр бид нарт мөнгө байхгүй биш, байгаа байхгүй юу. Тэр байгаа мөнгө дарга нарын тансаглалд яваад байгаа учраас энэ дээр та энэ Ардчилсан намын удирдаж байгаа баруун төвийн энэ чиг баримжаа, үзэл санаатай хүн учраас энэ дээр зоригтой дуугараач ээ. Цахим засаглал бол 70 хувь нэмэгдүүлнэ гэж байгаа. Эхлээд энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дахиад хэрэлдэх үү. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Их Хурлын дарга, гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Чухал асуудал хэлэлцэж байна. Бид ингээд л жил болгон хэлэлцээд л, дараа нь тайланг нь аваад л, хэрэгжилтийг нь үнэлээд л, тэгээд л муу дүн тавиад л гардаг. Одоо жишээлбэл оршил хэсэгтээ нийгмийн өнөөгийн байдал яаж байна вэ гэхээр эрэгтэй, эмэгтэй хүний нас баралтын харьцаа 9 насаар зөрүүтэй, 50,2 хувь нь ид хөдөлмөрийн насандаа буюу 30-60 насандаа нас барж байна гэсэн ийм чухал тоо тавьчихаад, яг үүнийхээ эсрэг ямар үйл ажиллагаа явуулж байгаа юм бэ. Тэрийгээ хэлээд өгөөч ээ. Би энэ төслүүдээс нь хайгаад олж харсангүй.

2 дахь асуудал нь бид саяхан бас утааны сонсгол хийсэн. Одонтуяа сайд бас өөрөө бүрэн сууж, энэ асуудал дээр анхааралтай оролцсон хүний хувьд яг намраар ид хүйтрээд, өвөл болоход Улаанбаатар хот утаагүй байхад 2026 оны төсөвт бид юу юу суулгаад, ямар ажил хийнэ гэж төлөвлөсөн юм бэ. Төлөвлөөд тавьсан зүйлүүдийг харахлаар дэндүү өчүүхэн харагдаад байна. Энэ дээр нэг тайлбар өгөөч.

Дараагийнх нь эмийн түр хороо, эмийн сонсгол хийгээд бид чухал Их Хурлаас тогтоол гаргасан. Энэ бол хүнс, эм лавлагаа, лаборатори нь нэгтгэ гэсэн үүрэг даалгавар өгсөн. Ямар ч байсан одоо ингээд нэгтгэх гэж байгаа юм байна. Тэгээд Шадар сайдын ажлын алба дээр хариуцуулна. Төсөв нь ердөө 485 сая байна. Энэ зах зээл дээр байгаа сери дугаар нь эмийн чанарыг шалгахад санамсаргүй түүвэрлэлтээр аваад үзэхэд зөвхөн эмийн лавлагаа лаборатори 1,2 тэрбум төгрөг хэрэгтэй байгаа гэсэн шүү дээ. Гантөмөр Шадар сайд аа, тэгээд 450 сая төгрөг тавьчихаар хүнстэйгээ нэгдчихсэн. Нөгөө төсөв мөнгө нь хүрэхгүй ахиад л хийж чадахгүй болох юм биш биз. Энэ дээр танд мэдээлэл байна уу.Энийг надад нэг тайлбарлаж өгөөч.

Дараагийн нэг чухал Эрүүл мэндийн сайдаас асуумаар байна. Эд эс, эрхтэн шилжүүлэн суулгах барилгын асуудал дээр би асуулга асуусан. Надад хариу өгөхдөө давхрын өөрчлөөгүй байгаа гэсэн хариу өглөө. Төсөв нь хэвээрээ байгаа юм шиг байна. Энэ яг бодитой юу. Энэ яг 7 давхар хэвээрээ байгаа юу гэдгийг надад хариулаад өгөөрэй.

Дараагийн асуудал энэ их чухал сэдэв. Ашгүй нэг үглэсээр байгаад ямар ч байсан эхийн эндэгдэл, амьд төрөлт, нярайн эндэгдэл энэ тэр гээд тоонууд бас овоо тавьчихаж. Энэ чинь өнгөрсөн Засгийн газарт энэ ерөөсөө ороогүй байсан. Овоо нэг хэмжих хэмжүүртэй боллоо. Энэ дотор сүрьеэгийн тохиолдлын түвшин 10 мянгад. Тэгсэн энэ дээр хараа ингэчихсэн байгаа юм. 69,7 байсан суурь түвшнийг 69,3 болгоно гэчихсэн байгаа юм. Үгүй ээ, үгүй. Хийхгүй байхад л ингээд буурчихна шүү дээ. Илрүүлэхгүй юм чинь тохиолдол чинь олдохгүй шүү дээ. Тэгээд хийхгүй гээд байгаа юм уу. Эрүүл мэндийн яам Шадар сайд танд ийм тоо өгсөн юм уу. Уг нь өвчлөл нь ихсээд, нөгөө олон эмд дасалтай сүрьеэгийн тоо цөөрөөд, далд сүрьеэг илүү их оношлоод, тохиолдол ихсэх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ чинь оношлохгүй гэж хэлээд байгаа юм уу. Энэ дээр надад нэг тайлбар өгөөч.

Үгүй ээ, нөгөө бид нарын хамгийн сайн явж байгаа нөгөө “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр чинь байхгүй болчихож. Би олж харсангүй. Хараагүй байж магадгүй шүү. “Д” вирусийн эмчилгээ маань яав аа. Байхгүй болчихож. Энд хариулт өгөөрэй.

Дээрээс нь төвлөрлийг сааруулна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон нутагт нь сайжруулах гээд бас чухал сэдэв яриад байгаа ялангуяа энэ ха харвалт, шигдээстэй холбоотой асуудал дээр бид бас онцгой анхаарч байхгүй бол болохгүй. Тэгээд үүнтэй холбоотой 5 аймаг ердөө 7 аймгаар л нэмэгдэнэ гэж байгаа юм. 5 дээр нэмэх нь 2, 7 болох юм уу. Энийг тайлбарлаад өгчхөөрэй. Тэгээд дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Утааг бууруулах төслүүдээ Улаанбаатар хотоос хүн байвал дэлгэрэнгүй ярих нь зөв гэж бодож байна. Ер нь 2027 оны өвлийг л утаагүй угтана гэдэг ийм зорилттой байгаа. 2026 онд бид нар юу юугүй утаа алга болно гэж айхтар амлаж чадахгүй. 2027 оны өвлийг бид нар Улаанбаатар хот бол утаагүй угтана. Бидэнд бас нэг ийм хаана очоод, юу алга болох юм бэ, хаана очоод юу бий болох юм бэ гэдэг тодорхой хугацаа хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр энийгээ бид нар 2027 он гэж үзэж байгаа шүү Чинбүрэн гишүүн ээ.

Мэдээж Эрүүл мэндийн сайд маань эрүүл мэндийн салбарынхаа төлөвлөж байгаа асуудлуудыг ярина. Тэгэхдээ ер нь бид энэ Засгийн газрын хийж байгаа бүх ажлыг төлөвлөлтдөө оруулахгүй байгаа юм. Аль болохоор цөөхнийг оруулаад, цөөхнийг оруулж байгаа гэдэг нь бол төлөвлөлтийн бүтэн зургаа бид нар нөгөө интеграцуудаа хараад байгаа юм. Тэгээд таны нөгөө шаардаж байгаа хүрч болох түвшнээ аль болохоор тодорхой болгоё гэсэн оролдлого энд явж байгаа. Ер нь бол урьдчилан сэргийлэх бол өөрөө эрүүл мэндийн салбарын хамгийн чухал ажил мөн гэдэгтээ бол Засгийн газар эргэлзэхгүй байгаа.

Урьдчилан сэргийлэхэд өрхийн эмнэлгийн оролцоог хэрхэн бий болгох вэ гэдэг энэ зүйл бол Эрүүл мэндийн яам дээр ажил хэрэг болоод явдаг. Өрхийн эмнэлгийн хөгжил ямар байх вэ. Бид нар нөгөө төрийн үйлчилгээг очиж үйлчилдэг болно гэдэг нь энэ юм. Юу вэ гэвэл яг өрхийн эмнэлэг нь нөгөө Монгол хүн чинь цөөхүүлээ учраас нэг өрхийн эмчид оногдож байгаа хүнтэйгээ өрхийн эмч нь хэрхэн ажиллах вэ. Үүний санхүүжилт яах вэ гэдэг энэ зүйлс дээрээ шийдлээ гаргачих юм бол урьдчилан сэргийлэх гэдэг зүйл рүүгээ бид нар алхаад байж болно гэж ингэж харж байгаа. Лабораторийн зардал бол яг Стандарт хэмжил зүйн газар болоод Шадар сайдын албанаас ирж тавьж байгаа санхүүжилтээр л орж ирж байгаа. Ер нь бол энэ эм, хүнсний олон улсын байгууллагыг Монголд ингээд байгуулаад явах нь бол зөв. Ингэж байж бид нар гарал үүсэл нь тодорхой болно. Хяналт шалгалт нь тодорхой болно. Зүгээр эм, хүнсний байгууллага дэлхий дээр ажиллахдаа үйлчилгээгээ тодорхой хэмжээгээр төлбөртэй явуулж байгаа. Энэ зүйл рүү орох юм бол өөрөө бид нарын хүнсний аюулгүй байдал гэдэг зүйл, мөн хүнсний экспорт гэдэг зүйл энэ рүүгээ бол бид нар бүтэн алхах боломж байна гэж харж байгаа. Тэгээд энэ удаа Эрүүл мэндийн сайд 1 шинэлэг санаачилга гаргаж байгаа нь бол ер нь энэ хүнд өвчнүүдээ эмчлэх энэ зүйл рүүгээ хэдүүлээ алхъя гэдэг ийм зүйл яриад байгаа юм. Ялангуяа хавдар дээр. Хавдрын эмчилгээ рүү бид нар яг орчин үеийн эмчилгээ рүү нь шилжих шилжилтийг энэ 4 жилийн хугацаанд хэдүүлээ хиймээр байна гэж байгаа юм. Яг энд зориулсан бид нар эрдэм шинжилгээ болоод бусад төсөв санхүүг бол шийдээд, олон улсын тэр судалгаа хийж байгаа байгууллагууд ажиллаж байгаа эрүүл мэндийн ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхсайхан сайд нэмж хариулт өгье.

Т.Мөнхсайхан: Гишүүний асуултад хариулъя. Энэ гэхдээ 1 минут маань арай хүрэхгүй л байх даа. Бид нарын гол бодлого бол дундаж наслалтыг нэмэгдүүлэх. Ингэхдээ эрүүл насжилтыг бий болгож, дундаж наслалтыг нэмэгдүүлэх нь бид нарын гол зорилго. Үүний тулд бид нар аливаа өвчнийг үүсгэж байгаа эрсдэл, хүчин зүйл, шалтгааныг арилгах бодлого 1 дүгээрт чухал.

2 дугаарт бид нар эрт илрүүлгийнхээ тогтолцоог оновчтой зөв, бага зардлаар их өвчлөлийг илрүүлдэг тогтолцоогоо бий болгох нь чухал. Энэ рүү чиглэсэн ажлууд их хийгдэж байгаа.

3 дугаарт бид нар эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжээсээ сайжруулж байж энэ дундаж наслалтаа нэмэгдүүлнэ. Тэрний тулд бид нар аймаг, дүүргийн эмнэлгүүдийн чадавхыг маш сайн нэмэгдүүлж байж энэ төвлөрлийг задалж байж, тусламж үйлчилгээгээ ямар нэгэн цаг алдалгүй хүргэдэг энэ тогтолцоог бий болгох. Түрүүний ярьсан таны тоонууд бол залуудаа хөдөлмөрийн насандаа амь нас ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхсайхан сайд гүйцээж хариулъя..

Т.Мөнхсайхан: Амь нас эрсдэж байгаа тохиолдлуудын дийлэнх хувь. Сүүлийн 5 жилийг аваад үзэхэд бараг 94 мянган хүн яаралтай тусламж авч эмнэлэгт хүргэгдэж амжилгүйгээр нас барсан. 12 мянган хүүхэд амь нас эрсэдсэн гэдэг ийм тоо баримтууд байгаа. Энэ бол бид нар үндэсний хэмжээний яаралтай тусламжийн тогтолцоогоо бий болгохгүй бол эмнэлэг хүрч амжихгүйгээр амь нас эрсдэх ийм тохиолдлууд өндөр байгааг харж байгаа.

Тийм учраас энэ тогтолцоог бий болгох тал дээр бид нар маш их ажлуудыг хийж санаачилж хэрэгжүүлж байгаа. Энэ дээр нэлээдгүй санхүү мөнгөний асуудал хэрэгтэй байгаа юм.

Тэр Эм, хүнсний агентлагийн хувьд эмээ шинжилдэггүй, эмийнхээ бодлогыг хийж чаддаггүй тийм яам байж болохгүй ээ. Тийм учраас Эрүүл мэндийн яам эмийнхээ бодлогыг авч явна. Эмийнхээ лабораторийг авч явна. Эм, хүнсний хяналтаа хийдэг лабораториуд нь харин хяналтыг нь тусдаа гаргах асуудал бол зөв байх гэж үзэж байгаа.

Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн хувьд барилгын зураг бол маш олон жил.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн тодруулж асууя. Индэр дээрээс Нийслэлийн Засаг даргын орлогч. 4 дүгээр индрийн микрофон өгье.

Т.Даваадалай: Их Хурлын гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтэц хариуцсан 1 дүгээр орлогч Даваадалай байна.

2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийт нийслэлээс 19 төсөл, арга хэмжээ тусгагдсан. Үүнээс 2026 оны агаарын бохирдолтой шууд болон шууд бус урт хугацаанд холбогдолтой 6 төсөл, арга хэмжээ байна.

1 дүгээрт Сэлбэ дэд төв орчмын гэр хорооллыг орон сууцжуулах “Сэлбэ 20 минутын хот” байгуулах төсөл. Төслийн ажил үргэлжлээд явж байгаа. Газар чөлөөлөлт болон бусад нөлөөллөөрөө агаарын бохирдолд бол шууд нөлөөлж байгаа.

2 дугаар төсөл гэр хорооллын газрыг дахин барилгажуулах төслийн хүрээнд нийт багтсан төслийн хэмжээнд 16 байршилд 41 хэсэгчилсэн талбайд 38 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллын газрыг дахин төлөвлөх төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

3 дугаар төсөл арга хэмжээ нь дулааны тархмал эх үүсвэрүүдийг 11 байрлал дээр барьж байгуулах төсөл бол нийслэл 2026 онд эхлүүлэхээр бол төлөвлөлтөд орж байгаа мөн..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Т.Даваадалай: Мөн Дэнжийн мянга дэд төвийн хийн станц барих, Дамбадаржаа дэд төвийн 63 мегабайтын ДЦС-ыг барьж эхлүүлэх. Мөн төрийн байгууллагуудын уурын болон усан халаалтын зуухнуудын технологийг шинэчлэх. Энэ нь болохоор 27 зуухны технологийг 2026 онд шинэчлэхээр төлөвлөгдсөн. 6 төсөл, арга хэмжээ нь болохоор агаарын бохирдолтой шууд болон урт хугацаанд нөлөөлөхөөр ийм 6 төсөл арга хэмжээг бол улсын төсөвт болон гадаадын зээл тусламжид оруулж 2026 онд төлөвлөсөн байна.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: 2026 оны төлөвлөгөөндөө бас энэ угаартаж нас барж байгаа иргэдийн тоог огцом бууруулах, тэр хяналтын тогтолцоог хийх асуудал, түүнийгээ хянадаг албан тушаалтнуудын тоог нэмэх, хороодын оролцоог нэмэгдүүлэх тал дээрээ анхааралтай ажиллаарай. Энэ бол утааны сонсгол дээр яригдсан хамгийн чухал асуудал шүү. Энийг мартаж болохгүй. Мөн бодлого яриад яах вэ. Бид мэдэж байгаа шүү дээ. Бодлого ярьж байна. Гол нь тэрийг хэрэгжүүлдэг төсөв мөнгө байхгүй бол энэ ажил чинь явахгүй шүү дээ. Ялангуяа 30-60 настай нас баралтын шалтгаан. Яаралтай тусламж гээд ярьж байна. Яаралтай тусламжийг орон нутагт нь авчихдаг. Харвалт, шигдээс гол шалтгаан. Тэр харвалт шигдээсний болсон хүмүүст, харвасан хүмүүст яаралтай тусламж үзүүлэх энэ тогтолцоог хурдан сайн болгох асуудал дээрээ энэ төсөв дээр чинь мөнгө нь харагдахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд асуугаад байгаа шүү дээ. Тийм юм хийх гэж байгаа ингэх гэж байгаа яах вэ. Яг бодитой мөнгө төсөвлөөрэй гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Чинбүрэн гишүүн энэ утааны сонсгол хийсэнтэй холбоотой ажлын хэсгийн дүгнэлт Байнгын хороогоор орчихсон. Тийм ээ. Одоо Улсын Их Хурлаар орох гээд хүлээж байгаа. Тэгээд бас Улсын Их Хурлын гишүүд бас тэр Байнгын хороогоор орсон дүгнэлт дээр энэ агаарын бохирдлыг бууруулах чиглэл дээр ажил хэрэгч саналууд дэвшүүлмээр байна гэдэг асуудал хөндөгдөж байгаа юм. Хэрвээ боломжтой бол дэгийн зохицуулалтаараа болж байвал чуулганаар орохоосоо өмнө дахиж Байнгын хороогоор оруулаад, гишүүдийн саналыг бас тусгаж болно шүү. Утаатай холбоотой, агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой асуудал дээр тодорхой ажил хэрэгч саналууд гарч байгаа зүйл бас байгаа.

Одоо Энхбаярын Батшугар гишүүн асуулт асууя.

Э.Батшугар: Баярлалаа. Ер нь Монголд баялгийн болон орлогын тэгш бус хуваарилалт үүсчихсэн байгаа. Төсөв өсөөд байдаг. Талхны үнэ өсөөд байдаг. Гэвч ард иргэдийн орлого, цалин нь өсөхгүй байгаад байгаа. Энэ юугаар илэрхийлж байна гэхээр Жени коэффициент гэж байдаг. Энэ нь олон улсын эдийн засагч нарыг баялгийн хуваарилалтыг тодорхойлдог энэ нь Монголд 0,39 байгаад байгаа юм. Тэгэхээр яаж энэ статистикийн өсөлтийг ард иргэддээ, ялангуяа өрхийн орлогыг нэмэгдүүлэхээр хуваарилах вэ. Яг дотоодын бүтээгдэхүүнийг харахад бол өсөж байна. Өнөөдөр 1 хүнд ноогдох дотоодын бүтээгдэхүүн бол 6800 доллар. Ирэх жил 8 мянган доллар болно гэсэн тийм таамаглал төсөөлөл тавьсан. Тэгэхээр энэ дотоодын нийт бүтээгдэхүүнийг боддог аргачлал байдаг юм. Томьёолол. Энэ нь бол 1 дүгээрт бол хэрэглээ, хөрөнгө оруулалт, нэмэх нь Засгийн газрын зарлага, нэмэх нь цэвэр экспорт. Монгол Улсад яагаад GDP буюу дотоодын нийт бүтээгдэхүүн өсөөд байна вэ гэхээр манай цэвэр экспорт өсөөд байгаа. Энэ нь бол цэвэр Оюутолгойн зэсийн уурхайн олборлолттой хамааралтай. Нөгөөдөх нь улсын төсөв өсөөд байгаа юм. Тэгэхээр энэ статистикийн тоог яаж яг ард иргэдийн өрхийн орлогод буулгах вэ. Ямар механизм ашиглах вэ гэж асууя.

2-т нь өнгөрсөн жил бид нар цахим хөгжүүлэх 109 хуулийг баталсан. Энэ нь ямар холбоотой вэ гэхээр өнөөдөр бол И-монголиа гэсэн платформ гараад, 1002-аад үйлчилгээг цахимаар ард иргэддээ олгож байгаа юм. Яг үүнтэй адилхан и-бизнес гэсэн платформ байгаа юм. Энэ нь ямар зорилгоор энэ 109 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бэ гэхээр бизнес эрхлэгчид зориулсан и-монголиа л гэж ойлгож болох юм. Нэг ёсондоо гэртээ компьютер дээрээ сууж байгаад, тэгээд шинээр аж ахуйн нэгж үүсгэн байгуулах бүрэн хуулийн зохицуулалтыг нь хийж өгсөн юм. Тэгээд энэ нь яг хэрэгжиж байгаа юу. Хэдэн үйлчилгээ и-бизнесээр олгож байгаа вэ. Яг Эстони улсад бол тухайн иргэн гар утсаараа вагонд сууж байгаад 30 минутын дотор шинээр аж ахуйн нэгж бий болгочхож байгаа юм. Тэгээд нэг ёсны эдийн засгийг илүү либералчилж байгаа л гэсэн. Хүнд суртлыг алга болгож байгаа зүйлүүдийн нэг нь л дээ. Тэгэхээр яг бид нарын хүссэн тэр зорилгодоо хүрч чадсан уу. И-бизнес платформ гэж асууя.

Хөрөнгийн бирж, капитал маркетинг гэж ярьдаг. Хөрөнгийн зах зээлээ яаж хөгжүүлэх вэ. Энэ чинь бол эдийн засгийн бас бүтцийн нэлээн том институт, багана гэж ойлгож болох юм. Хөгжиж байгаа улс орнуудын хөрөнгийн биржийнх нь ДНБ-тэй харьцуулах коэффициент нь харахад бол Вьетнам улс 45, Индонез 40, Казахстан 33 байгаа юм. Монгол Улсад 7 хувь байгаад байгаа юм. Нэг ёсны хөрөнгийн зах зээл юу вэ гэхээр үнэхээр шинээр гоё санаа зохион бүтээчихсэн, инновацлаг бүтээгдэхүүн гаргачихсан иргэд юу дутагддаг вэ гэхээр хөрөнгө дутагддаг. Тэгэхээр тэр санаагаа үнэлээд Хөрөнгийн бирждээ гараад, эх үүсвэр татаад, хөрөнгө оруулалт татаад, бизнесээ хөгжүүлээд, орлогоо нэмэгдүүлээд, улсын төсөвт татвараа төлөөд явах эдийн засгийн бүтцийн л асуудал л даа. Тэгэхээр энийг ямар байдлаар хөгжүүлэх тийм бодлогыг ирэх жил баримтлах вэ. гэж асууя.

Төлбөрийн тэнцлийн хямрал Монгол Улсад ирчхээд байгаа юм л даа яг үнэндээ. Тэгэхээр энийг хамгийн амархан аргаар яаж гаргах вэ. Хамгийн түргэн гэвэл гадаадын хөрөнгө оруулалтыг татах. Яах вэ мэдээж боомтын сэргэлтийн хүрээнд төмөр замын холболт явж байгаа. Гэхдээ энэ бол 22 сарын дараа ашиглалтад орно гэж байгаа юм. Тэгэхээр яаж урсгал дансаа нэмэгдүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалтыг татахаар ирэх жил ямар бодлого баримтлах вэ.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Батшугар гишүүний асуултад хариулъя. Хөрөнгийн зах зээлийг хэрхэн босгож ирэх вэ гэдэг дээр Сангийн яам биржийн хөгжлийн төлөвлөлтөө тодорхой тайлбарлах нь зөв байх. Батшугар гишүүнтэй санал 1 байна. Санхүүгийн зах зээл босож ирэхгүй бол зөвхөн банкаар яваад байхаар энэ улс чинь мөнгөө эргүүлж чадахгүй байна. Нэг эргээд мөнгө ингээд алга болчихоод байна. Тэгэхээр мөнгө ядаж 3, 4 эргэдэг байж байж өөрөө өгөөж нь сайжирдаг гэдгийг бүгдээрээ мэднэ. Валют болж хувирах хүртлээ хугацаа ордог гэдгийг бүгдээрээ мэднэ. Тэгэхээр бол одоо бол хадгаламжаас өөр бидэнд хэрэгсэл байхгүй байгаа гэдэг таны саналтай санал нэг байна. Тэгэхээр Хөрөнгийн биржийн хөгжлийн төлөвлөлт, хөрөнгийн захыг босгох тухай дээр Ганбат дарга хариулаарай. Цахим бизнес бол яалт ч үгүй энэ цахим хөгжил өөрөө бид нарын асуудлыг шийдэх хамгийн том шийдэл болж байна. Тэр зөвхөн Монголын биш, дэлхий даяараа. Тийм учраас энэ дээр Баатархүү сайд тодорхой тэр и-бизнесийг хэрхэн хөгжүүлэх вэ. Одоо бид нар и-монголиа гэдэг дээрээ и-бизнесээ холбомоор байгаа юм. Энэ холболтыг гүйцэд хийж чадах юм бол бизнесийн үйлчилгээнүүд орж ирмээр байгаа юм. Жишээлбэл нотариат энэ тэр нь яг и-монголиа руу ороод ирэх юм бол хүмүүсийн хөл хөдөлгөөн багасаад, тэр нөгөө түгжрэлийн дарамтууд, тэндээс авч байгаа стресс нь алга болно гэж харж байгаа. Тэгэхээр энэ платформыг яг бизнесийн чиглэл рүү нь яаж холбох вэ гэдэг дээр Баатархүү сайд хариулах нь зөв.

Ер нь орлого нэмэгдүүлэхийг, орлогын хуваарилалтыг Засгийн газар хийгээд байгаа юм бол байхгүй шүү дээ. Тэрийг Батшугар гишүүн сайн мэдэж байгаа. Хэн хөдөлж чадсан нь түрүүлж юм аваад байна л гэдэг асуудал байгаа. Тэрнээс цааших урсгалыг нь яах вэ гэдэг дээр яалт ч үгүй Хөрөнгийн биржийг босгож ирнэ. Дээр нь үйлдвэрлэлийг бий болгох. Үйлдвэрлэл бий болж байж тэр лүү хүмүүс ордог. Тэгээд инновацын эко системийг угсрах гэдэг ийм асуудал байгаа юм. Энэ болгоныг шийдэхийн тулд хамгийн түрүүлж хийх алхам бол эрчим хүч юм байна. Эрчим хүч юм байна гэдэг дээр санал нэгдээд Засгийн газар бол энэ эрчим хүч рүү хөрөнгө оруулна. Таны хэлдгээр мэдээж хэрэг эдийн засаг өсөхөд хамгийн чухал зүйл бол гаднын хөрөнгө оруулалт. Гаднын хөрөнгө оруулалт бүх түвшиндээ татарч байна. Одоо Хятад бол бүр дөнгөж 4 тэрбум долларын хөрөнгө оруулалт эхний хэдэн сарын байдлаар авч байна шүү дээ. Энэ юу гэсэн үг вэ гэхээр хэдэн 100 тэрбумыг татдаг улс ингэж орж ирнэ гэдэг бол өөрөө хөрөнгө оруулалтын урсгал бол Трамп тарифтай холбоотойгоор алсарч байна. Ер нь сүүлийн хэдэн жил бол энэ алсарсан. Одоо юу руу явж байна вэ гэхээр яг ногоон эдийн засаг руу, тодорхой засгийн оролцоотой төсөл рүү, тодорхой том бүтээн байгуулалт руу гэдэг ийм хөрөнгө оруулагчид хамгийн баталгаатай тэр зүйл рүүгээ хөрөнгөө тавьж байна. Тэгэхээр яалт ч үгүй Засгийн газар оролцоод явах төслүүд бол түрүүлээд санхүүжүүлэгдэх нь бол тодорхой байна. Тэгэхээр Засгийн газар ирэх 4 жилд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баатархүү сайд нэмж хариулъя. Өөр албаны хүмүүс нэмж хариулахаар бол 4 дүгээр индэр дээрээс хариулт өгнө шүү. Индэр дээр очоорой. Баатархүү сайд.

Ц.Баатархүү: Маш чухал асуудлыг хөндлөө. И-монгол төрийн үйлчилгээний нэгдсэн цахим хуудас гарснаар одоогийн байдлаар 1264 үйлчилгээг бол тогтмол үзүүлж байна. И-бизнес цонхыг тусад нь гарч, аж ахуйн нэгжүүдэд бизнест ээлтэй болгох, түргэн шуурхай байлгах чиглэлээр үйлчилгээний цонхыг тусад нь гаргасан. Үүнээс хойш 312 мянган аж ахуйн нэгж үйлчилгээ авсан байна. Одоогийн байдлаар

832 үйлчилгээг и-бизнест оруулсан байна. Цаашдаа бол и-бизнес үйлчилгээ бол мэргэжлийн холбоод, Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, төрөөс үзүүлж байгаа бизнес үзүүлж байгаа бүх үйлчилгээний нэгдсэн цонх байдлаар хөгжүүлээд явж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат 3 дугаар индрээс хариулт өгье.

Ж.Ганбат: Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх асуудал дээр Сангийн яамнаас болон Засгийн газраас хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хамгийн гол үндсэн ажлуудын 1 бол дэд бүтцийн найдвартай асуудал байгаа. Энэ дээр хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системийн уялдаа холбоог хангах, цогц шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээг 2024 оноос авч хэрэгжүүлээд байна. Энэ хүрээндээ бол хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн хүрээнд дэд бүтцийн байгууллагуудын систем, засаглал, хүний нөөцийн чадавхжуулах зэрэг асуудлыг цогцоор хийх арга хэмжээнүүдийг мөн авч хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд ажиллаж байна. Мөн түүнчлэн хөрөнгийн зах зээлийг дэмжих чиглэлээр татвар дээр нэлээн хэд хэдэн арга хэмжээ татварын бодлогоор дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Энэ хүрээндээ бол Монгол Улсад байрладаггүй татвар төлөгчийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл борлуулсны орлогод албан татвар ноогдуулахад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ж.Ганбат: Нийт үнийн дүнгээс худалдаж авсан үнэ болон шимтгэлийн дүнг хасаж тооцдог болсон. Мөн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл борлуулсны орлогод ноогдуулах татварыг 2024-2026 онд 90 хувь, 2027-2029 онд 50 хувь хөнгөлдөг байхаар болгосон.

3 дахь нь нээлттэй компанийн хувьцааны ноогдол ашгийн татварыг дотоодын 10, гадаадын 20 хувь гэж тооцдог байсныг нийтэд нь 5 хувь болгож бууруулсан. Мөн Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгон нээлттэй арилжаалагдах үнэт цаас гаргасан тохиолдолд үнэт цаас гаргах үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан зардлыг 20 хувиар нэмэгдүүлж, албан татвар ногдох орлогоос хасаж тооцдог болсон зэрэг энэ дэмжлэгүүдийг татварын бодлогоор бол дэмжсэн байгаа. Мөн хөрөнгийн биржийн нийт арилжаа 2023 онд 725 тэрбум байсан бол 2024 онд 1,4 их наяд болж 2 дахин нэмэгдсэн байгаа.

Мөн Сангийн яамнаас Засгийн газрын хөрөнгийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Товчхон хариулъя. Больё доо. Батшугар гишүүн тодруулж асуух уу.

Э.Батшугар: Хөрөнгийн биржийг амжилттай эдийн засгийн бүтэц болохын тулд дэд бүтэц гэхээсээ илүү эрх зүйн байдалдаа 1920 онд АНУ-ын хөрөнгийн биржийн дотоодын бүтээгдэхүүнийхээ 100 хувьтай тэмцдэг байсан юм. Тэгэхээр чинь манай Монгол Улсын дэд бүтэц чинь мэдээж тэрнээс 100 жилийн дараа хамаагүй л илүү болчихсон байгаа. Гол нь эрх зүйн байдал нь байгаад байгаа юм. Сайжруулах. Сеттлемент бол клиринг хийхдээ өдөрт нь хийх. Дээрээс нь нэмээд жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, мөн чөлөөтэй ажиллаж байгаа

нийт хувьцааны хамгийн багадаа 15-20 хувь руу болох, өнөөдөр чинь бараг 97 хувь нь 1 гэр бүлд байдаг. 3 хувь нь хаана байгаа нь мэдэгдэхгүй тийм компаниуд Хөрөнгийн бирж дээр арилжаад байгаа байхгүй юу. Байгаад байгаа юм. Арилжихгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ бүхнийг та бүхэн бас нэлээн харж үзэж, илүү боловсронгуй болгохыг анхаарч ажиллаарай гэж хэлье. Яагаад гэвэл Хөрөнгийн бирж гэдэг чинь бол эдийн засгийн үндсэн суурь нь байдаг юм.

Д.Амарбаясгалан: Одоо тэгээд хэдүүлээ бас ганц энэ асуудал дээр ч биш ер нь Улсын Их Хурлын гишүүд маань асууж байгаа асуулт нь маш тодорхой товчхон, хариулт өгч байгаа албан хаагчид, албан тушаалтнууд маань бас давтаад байхгүй. Зарим тохиолдолд асуусан асуултыг нь давтаж байгаад хариулт өгөхөөр хариултдаа 10 секунд үлдээхээд байх юм. Энэ эсвэл зарим төрлийн арга тактик байгаад байдаг юм уу. Тэгэхээр ерөөсөө элдэв янзын оршилгүй, асуудалд маш тодорхой ханд. Ард иргэдэд ойлгомжтой энгийн ухамсрын түвшинд шууд ойлгогдох түвшинд л хариулт өгч сурцгаа. Тэр лүүгээ бүгдээрээ анхаарлаа хандуулъя. Батшугар гишүүн үг хэллээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Бүгдийнх нь өглөөний амрыг айлтгая. Тэгээд өчигдөр Эдийн засгийн байнгын хорооны гишүүн учраас асуултууд асуусан. Ялангуяа бас тодорхой төсөл, арга хэмжээнүүд дээр асуулт ч асууж, саналаа ч хэлсэн байгаа. Тэгэхээр одоо илүүтэй үг хэлчихье гэж бодож байна. Тэгэхээр ийм байна. 2026 оны энэ хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2026-2030 оны 5 жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр суурилж чадсан уу гэж асуухад тодорхой хариулт аваагүй. Энэ дээр анхаарах.

2 дугаарт нь 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт ямар байгаа юм. Ямар амжилттай байсан юм. Сургамж нь юу байсан ю. 2026 оныхоо төлөвлөгөөнд алийг нь оруулах юм бэ. Энэ дээр асуулт асуусан тодорхойгүй байсан. Бас нэг чухал асуудал бол мэдээж энэ хөгжлийн төлөвлөгөөнд тухайн тусгагдсан төсөл хөтөлбөр, үйл ажиллагаанууд биеллээ олохын тулд санхүүгийн эх үүсвэр, нөөц хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр энэ нь өөрөө уялдаа холбоотой байж чадахгүй байна. Энийг бас хөгжлийн төлөвлөгөө дээр ажилласан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан дүгнэлт нь өнөөдөр л би харж таарлаа. Өчигдөр миний хэлсэн бас саналуудтай санаа нэг байна. Үүнийг бас цаашид анхаарах ёстой гэж хэлмээр байна. Тухайлбал, энэ жилийн хувьд оны эхний 3 сарын байдлаар төсвийн орлого 1,2 их наяд төгрөгөөр дутсан байгаа. 2026 онд мөн эрдэс баялгийн үнэ хэрхэн өсөх, борлуулалтын хэмжээ ямар байхыг бид мэдэхгүй. Алтны үнэ одоогийн байгаагаас унах магадлалтай байгаа. Тухайлбал нэг жишээ. Тэгэхээр тооцсоноор нөгөө 33 их наяд чинь орж ирэхгүй бол жишээлбэл яах вэ. Нөгөө олон тусгасан төсөл үйл ажиллагаанууд чинь хэрэгжихгүй шүү. Бид нар олон жилийн туршид хөрөнгө оруулалтын тусгасан төслүүд яагаад хэрэгждэггүй вэ. Гүйцэтгэл муу байна. Энийг сайжруулъя. Төсвийн сахилга баттай больё гэж ярьсан. Үүний чинь яг ингээд тухай тухай үед яриад өнгөрөөгөөд байх биш, хөгжлийн төлөвлөгөөндөө орж байж бид нарын энэ олон жил ярьж байгаа урхагшсан асуудлууд шийдэгдэх юм гэдгийг хэлмээр байгаа юм.

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороонд бас байгаа, ахалж байгаа энэ хүний хувьд хэлэхэд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч гэсэн дүгнэж хэлсэн байна. Тухайлбал хүний хөгжил, ядуурлыг бууруулах ч гэдэг юм уу, эрүүл мэнд, боловсрол, дэд бүтцийн асуудлууд тусгагдсан боловч үйл ажиллагаанууд шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй байна. Тэр олон улсын түвшинд гаргачихсан тогтвортой

хөгжлийн зорилгын үзүүлэлтүүд байгаа шүү дээ. 2030 онд энэ чинь дүгнэгдэх гээд байна. Тэгэхээр энэ байдал бид нар зорилтот хэмжээндээ хүрэх хаа байсан юм байгаа. Тэр олон үзүүлэлт дотор 17 зорилго дотроо. Тэгэхээр энийг үр дүнтэй болгохын тулд одоогоос бараг өнөөдрөөс хоцрогдсон байгаа ингэж анхаарч ажиллах ёстой байтал 2026 оныхоо төлөвлөгөөнд ийм дутуу, хуумгай хандсан нь бас их асуудал дагуулахаар байна шүү. Энэ дээр гүн ач холбогдол өгөөрэй гэж бас давхар хэлмээр байгаа юм.

Тэгээд өчигдрийн хэлсэн яг тодорхой төсөл, хөтөлбөр үйл ажиллагаатай холбоотой саналуудаа хэлсэн. Тэр маань хэрхэн тусгагдахыг бас цаашид хараад, хянаад явна. Тэгээд бид нар бас өмнөх онуудын төлөвлөгөө, бодлогын хэрэгжилт дээр үнэлгээний асуудал дээр нэлээн олон хурцадмал асуудлууд хөндөгдсөн. Төлөвлөгөө өөрөө муу байвал үнэлэх боломжгүй гэдгийг бүх талууд, түвшин түвшиндээ харилцан хүлээн зөвшөөрсөн гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ төлөвлөгөөнд маш их өндөр ач холбогдол өгч ажиллаарай гэж хүсмээр байгаа.

Тэгээд хүний нөөц, чадамжийн асуудал маш их нөлөөлж байгаа гэдгийг бол хувь хүний хувьд ойлгож байгаа. Энэ дээр бас маш их сайн төлөвлөгөө орох ёстой шүү гэж давтан хэлье. Баярлалаа.

Д.Амарсайхан: Мөнхсоёл гишүүн үг хэллээ. Өнөөдөр олон гишүүд асуулт асууж, хариулт авахаар байгаа тул үдийн завсарлагагүй үргэлжилнэ. Гишүүдэд эртхэн мэдээлэл өгье. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Өнөөдөр олон улсын гэр бүлийн өдөр. Тэгээд 1 дүгээрт гэр бүлийн талаар бас онцолж цөөхөн хэдэн үг хэлье гэж бодсон юм. Монгол Улсад 3,5 сая иргэн байгаа. 997 орчим өрхөд хуваагдаж байгаа. 167,6 мянган өрх яг бол хүүхэдтэй өрхүүд байдаг. Жилд өнгөрсөн оны хувьд 14, 15 мянган гэр бүл шинээр гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4,5 мянга орчим гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Дийлэнх нь буюу 3 мянга орчим нь 10-аас дээш жил ханилсан гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, гэр бүлд учирч байгаа стрессийг нь бууруулах нь бас төрийн нэг талын хариуцах асуудал мөнөөс мөн. Гэр бүлийн тогтвортой байдлыг нөгөө талдаа бас хөшүүрэг болгох үүднээс хамтын тэтгэврийн асуудлыг Нийгмийн даатгалын тухай хуулиар бас оруулсан. 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж байгаа. Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар гэрлэлтээ бүртгүүлсэн. 20-оос дээш жил хамт амьдарсан бол 2 өндөр насны тэтгэвэр авагчийн аль нэг нь тэнгэрт дэвшсэн тохиолдолд үлдэж байгаа хүн нь тухайн бурхны оронд дэвшсэн хүнийхээ тэтгэврийн 20 хувийг өөрийнхөө тэтгэвэр дээр нэмэлтээр авах ийм хуулийн зохицуулалт хэрэгжиж байгаа. 2024 оны 1 сарын 1-ээс. Тэгэхээр бас 1 талдаа нийгмийн даатгал ч гэсэн өөрөө нэг талдаа бас гэр бүлийн харилцаа болон энэ хамтын тэтгэврийн асуудлыг дэвшүүлсэн нь өөрөө бас сайн юм гэж. Нэгэнтээ үүнийг бас хүмүүс мэдээсэй, энэ хуулийн хэрэгжилтийг Улсын Их Хурлын гишүүд бас сурталчлах ёстой учраас энийг хэлж байна. Нийгмийн даатгалын харилцаатай холбоотой энэ хөгжлийн төлөвлөгөөнд орсон 2.12.1.1 дээр үндэсний баялгийн сангаар дамжуулж, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрд хуримтлалын нэрийн дансанд хөрөнгө хуримтлуулна гээд нийгмийн даатгалтай холбоотой биччихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр яг одоо Үндэсний баялгийн сангийн хуримтлалын зарцуулалт нь зөвхөн орон сууц, эрүүл мэнд, боловсролд л зарцуулах ийм боломжтой байгаад байдаг. Гэтэл эдгээрт зарцуулах шаардлагагүй эдгээр харилцаа нь хангагдсан байгаа иргэдийн хувьд яах вэ гэдэг ийм том асуулт үлдэж байгаа. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар

зүйлийн 10.4.1 дээр тэтгэврийн насанд хүрсэн иргэн хуримтлалын нэрийн данс дахь мөнгөн хөрөнгөө нэг удаа нийт дүнгээр нь бэлнээр нь авч болно. Тэтгэврийн насанд хүрэхээрээ. Эсвэл нэгэнтээ л тухайн хүний нэр дээр нь хуримтлал үүсээд байгаа л юм бол түүнийг бас нас барах юм үр хүүхдүүд нь тухайн хөрөнгийг бас иргэний хуульд заасны дагуу өвлүүлж бас болно гэдэг заалтыг оруулах шаардлагатай байна. Үүнийг нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын сангийн алдагдал төсвийн энэ татаастай хольж хутгаад болохгүй гэдэг байдлаар хандаад байх шиг байна лээ. Гэтэл үүнийг холихгүйгээр эрүүл мэнд, боловсрол, орон сууцдаа зарцуулахгүй хүн эдгээр мөнгөө бас өөртөө зарцуулах эрхтэй юм шүү. Үүнийгээ нэмэлт тэтгэвэр байдлаар зарцуулах олон улсын туршлагыг Монгол Улсдаа нэвтрүүлээч ээ гэдэг ийм асуудлыг яриад байгаа юм. Энэ боломжтой юу, үгүй юү гэдгийг Гантөмөр сайд уу эсвэл Сангийн яам уу хариулж өгөөч. Баялгийн сангийн тухай хуулийн өөрчлөлтүүд бас явж байгаа. Энэ дээрээ бас энэ хөгжлийн төлөвлөгөөндөө оруулах нь зүйтэй байх гэж үзэж байна.

2 дахь асуудал нь болохоор энэ зам тээврийн осолтой холбоотойгоор хэнд хариуцуулах вэ ямар санал гаргах вэ гэдгийг би бас мэдэхгүй байна. Түрүүн Эрдэнэболд гишүүн бас үүнийг хэлсэн. Зам тээврийн осолд жилдээ 25 мянга орчим хүн зам тээврийн осолд өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандаж байгаа. Үүнээс 5 мянга нь хүүхэд, 51 хүүхэд бол зам тээврийн ослын улмаас нас барсан.

Тэгэхээр үүнийг хэн хариуцаж хийх вэ. Осол нь Хууль зүйн яам, цагдаагийн газар бүртгэгдээд, зам нь Зам, тээврийн яаманд байгаад байдаг. Жолооны курс жолооны үнэмлэх курстэй холбоотой харилцаа нь Боловсролын яаманд байгаад байдаг. Салбар дунд нь орхигдоод.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгөх хүн байна уу. Сайд чинь түр чөлөө аваад гарчихсан байж байгаа. Мөнхзул Төрийн нарийнаа тэгээд санаачилгаараа босож ирээд гишүүдийнхээ асуултад хариулаач. 4 дүгээр индэр.

Л.Мөнхзул: Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул. Хуримтлалын сангийн асуудлыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх хүрээний асуудалд хуулиар зохицуулж өгсөн. Энэ хүрээнд бол 2024 онд бол 480 орчим тэрбумыг ипотекийн зээлийн эх үүсвэрт бас хуримтлалын сангийн хөрөнгийг зарцуулсан байна. 2030 оноос эхлээд хуулиар эрүүл мэнд, боловсрол, бусад асуудал 3 зүйлд зарцуулах бол эрх зүйн орчин нээлттэй байгаа. Энэ хүртэл бол зарцуулалт зөвхөн иргэнд хуримтлал байдлаар очихоор зохицуулагдсан.

Нийгмийн даатгалын шинэчлэлийн реформыг Засгийн газраас энэ хаврын чуулганд өргөн барихаар төлөвлөж байгаа. Энэ хүрээнд олон давхаргад тэтгэврийн хүрээнд иргэн өөрөө хүсвэл өөрийн хуримтлалыг хоёрдогч зах зээлд оруулах бусад зохицуулалтуудыг бол тусган оруулж байгаа хууль дээр. Тэгэхээр таны саналыг тусган үзэж энэ асуудлыг хэлэлцэх боломжтой гэж үзэж байна.

Мөн түүнчлэн зам тээврийн осолд өртсөн асуудлаар хүүхдийн эндэгдэл нэмэгдсэн. Мөн түүнчлэн гэмт хэргийн улмаас хохирч байгаа хүүхдийн тоо нэмэгдэж байгаа. Энд салбар дундын зохицуулалтууд дутагдаж байгаа учраас яамдын Төрийн нарийн бичгийн дарга нараар ахлуулсан ажлын хэсэг өнгөрсөн 7 хоногоос байгуулагдаж, хүүхдийн эрх хамгааллын асуудлаар бодитой ажил хийхээр ажиллаж

байна. Өнөөдөр гэр бүлийн өдөр болж байгаатай холбогдуулаад мөн манай яамнаас гэр бүлийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, гэр бүл цуцлалтыг бууруулах чиглэлээр Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтарч сэтгэл зүйчдийг ажиллуулахаар бас энэ оноос ажиллаж байна.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Хөөрхий манай Мөнхзул Төрийн нарийн бичгийн дарга тэгээд л уулзаад л хариулж байна. Гэтэл Гантөмөр сайд аа, хүний хөгжлийн асуудал Эдийн засаг, хөгжлийн яамны бас эрхлэх хүрээнд хуулиар бас орчихсон байгаа. Тэгэхээр энэ хүүхдийн эндэгдэл, хөгжил асуудлууд бас танай яаманд хамаарч байгаа учраас Шадар сайдын хувьд Тэргүүн Шадар сайдын хувьд та бас энэ асуудал анхаарч өгөөсэй гэж би нэг талдаа хүсэж байна.

2 дахь нь болохлоор зам тээврийн осол ч гэлтгүй архи согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой өдөрт 3 хүн спиртэд хордож нас барж байгааг Засгийн газар маань бас анхааралдаа аваасай. Яагаад энэ архи согтууруулах ундаанд хордоод байна вэ, хэрэглээндээ байна уу, эсвэл хуурамч болохгүй архи хэрэглээд байна уу. Хэн энэ дээр хяналт тавих вэ гэдэг ийм асуудал байна. Энийг бас хөгжлийн төлөвлөгөөндөө анхаарч болох уу. Хэнд нь хариуцуулж болох вэ Гантөмөр сайд аа.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Тийм ер нь энэ архины хэрэглээ өндөр байгаа нь бол Монголын асуудал мөн. Тийм учраас архиныхаа хэрэглээг багасгах чиглэлээр архигүй Монгол гэж их олон жил явсан. Сүүлийн үед үүнээс болоод нас бараад байна гэдэг ийм зүйл байгаад байгаа. Нас барж байгаа үндсэн шалтгаан бол хөдөлгөөний дутагдалтай холбоотой. Хамгийн гол зүйл хөдөлгөөн. Яаж Монгол хүнийг хөдөлгөөнтэй болгох вэ л гэдэг асуудал байгаа юм. Ер нь бол хөдөлгөөний дутагдлаас болоод ихэнх нь сахартай болж байгаа юм. Тэгээд сахрын өвчтэй хүмүүс архи уухаар зүрх нь зогсоод байна. Судас дахь цус нь ерөөсөө бүлэгнэсэн байдалтай байгаад байна гэсэн нас барсны дараах дүгнэлтүүд нь бол ингэж гараад байна. Тийм учраас энэ хөдөлгөөнтэй байх тал дээр санал санаачилгыг тал талаасаа гаргаад явах ёстой.

Д.Амарбаясгалан: Дахин тодруулж асууя.

А.Ариунзаяа: Сайд аа, энэ архи согтууруулах ундаанд санамсаргүй хордох, архи согтууруулах ундааны улмаас амиа алдаж байгаа өдөрт 3 хүн бол яг архинд хордсон хүн байхгүй юу. Тэрнээс биш нөгөө хөдөлгөөний дутагдал бол биш. Гэхдээ та энийг бас анхаарч, илүү судлаарай. Энэ яг архи согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой борлуулалтын цэг болон ер нь архи согтууруулах ундааны чанар, хиймэл архи гаалиар орж ирж байгаа асуудалд хэн ч, ямар ч хяналт тавихгүй байна. Тэгэхээр энэ бол анхаарах ёстой асуудал байхгүй юу. Тэгэхээр би анхаарах уу эсвэл Засгийн газар анхаарах уу гэдэг дээр 1 асуулт байна.

2 дахь нь болохлоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ дүгнэлт дээр эх үүсвэргүй маш олон төслүүд тавигдсан байна. Хэрэгжих эсэх нь тодорхойгүй. Хэтэрхий өөдрөг байна гэж тавьсан байна. Маргааш төсвийн хүрээний мэдэгдэл орж ирнэ. Ирэх 3 жилд алдагдалгүй төсөв батална гэдэгтээ итгэлтэй байна уу, зөв үү.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Тийм ер нь манай Засгийн газрын онцлог бол за бол ёо үгүй гэдэг ийм л зарчимтай байгаа. Эдийн засгийг 1 хүнд оногдож байгаа хэмжээг 10 мянган долларт хүргэнэ гэсэн бол тэр лүүгээ л явна. 14 мега төсөл хийнэ гэсэн бол тэрийгээ л хийнэ. Тэгээд өнгөрсөн жилийн төсөв батлахад бид нар төсвийг алдагдалгүй батална гээд л хэлчихсэн. Тийм учраас бид нар төсвийг алдагдалгүй баталж, яг энэ хэмжээндээ хувийн хэвшлийн оролцох орон зайг бий болгоё л гэж байгаа. Хувийн хэвшлийн орон зай аяндаа тэлэхэд тэр лүү татах хөрөнгө оруулалт дээр харин Засгийн газар хамтарч ажиллая гэж байгаа юм. Ингэснээрээ бол бид нар алдагдалгүй төсөвтэй төсвийн зардлаар эдийн засгаа тэтгэх энэ хэрэгсэл дээрээ дутуу байна гэж харж байгаа бол үлдсэн нь бол хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтыг урамшуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих гэдэг энэ зүйл дээрээ нэлээн ач холбогдол өгч ажиллана. Тэгэхээр тэр хөрөнгө .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тамгын газраас Бямбацогт, Чойжилсүрэн, Учрал гэсэн 3 сайдаас бусад сайд нарыг танхимд орж ирэхийг дуудъя. Урих биш дуудна шүү. Чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилж байна. 3 сайд гадаадад томилолттой байгаа. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Өдрийн мэнд хүргэе. Хүн төвтэй эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох гээд нэг их сүртэй гоё лоозонтой нэг ийм 2026 оны төлөвлөгөө батлах гэж байгаа юм байна. Тэгээд энэ дээр сая Ариунзаяа гишүүн бас хэллээ. Бид нар ерөөсөө хяналт алга, хэн хяналт тавих юм бэ гэж. Энэ хяналтгүй байгаагийн бас нэг жишээтэй холбоотойгоор яг энэ сонгогчоос гарч ирсэн санал энэ электрон тамхи 10 жилийн хүүхдүүд энэ электрон тамхинд живчихлээ. Энэ хууль зүйн яам нь байдаг юм уу, хууль сахиулах байгууллагууд нь байдаг юм уу энэ дээр хяналт тавьж ажиллах юм уу, эсвэл Боловсролын яам нь хяналт тавьж ажиллаад, сургуулиуддаа үүрэг чиглэл өгөх юм уу. Энэ ирээдүй хойч үе электрон тамхи, үргэлжлүүлээд тамхи гэдэг заваан юмнаас салгах тал дээр нэг хяналт тавьж ажиллах ёстой байна. Тэгээд энийг нь ингээд хэлье гэхээр жишээлэхэд манай Боловсролын сайд алга байна. Хурлын дарга аа.

Дараагийнх нь энэ өчигдөр Төсвийн байнгын хороо дээр бас ярьсан. Тодорхой хариулт авч чадаагүй. Бид нар Солонгосын Эксим банкнаас 10 аймгийн дулааны станц барина гээд зээл авсан. Зарим аймгуудад нь 40, 45 хувьтай гүйцэтгэл хийгдээд зогсчихсон. Тэгээд зарим аймгууд дээр нь ажил эхэлж чадаагүй. 40, 45 хувьтай гүйцэтгэчихсэн байгаа тэр төслүүд чинь одоо зогсчихсон. Тэгээд тэр зогсчихсон байгаа тэр төсөлд чинь өнөөдөр Монгол Улс хүү төлөөд явж байгаа. Яг хэдэн төгрөг Солонгосын талд төлчихсөн юм бэ тэгээд хийгдээд дуусаагүй байгаа ажил дээрээ бид нар мөнгө төлөөд байна. Энэ дээр хэн хариуцлага хүлээх юм бэ. Солонгосын компани нь бид нараас ямар ч хамааралгүйгээр Солонгостоо дампуурчхаад байхад Монголын тал тэр Солонгосын дампуурчихсан компанийнх нь төлөө хүү төлөөд байгаа дээр хэн хариуцлага хүлээх вэ. Хэдэн төгрөг төлчихсөн тэгээд хэн хариуцлага хүлээх вэ. Сангийн яамнаас.

Тэгээд энэ 2024, 2025 онд бас төлчихсөн асуудлууд байгаа. Энэ 2024 онд төсөв, 2025 оны төсвийн асуудал яриад явж байхад 7, 8 сарын өмнө л яг энэ нөхцөл байдал нь яригдаж байсан. Одоо яг тэр тайлбараа хэлээд сууж байгаа. Гараас нь юу ч гараагүй, араас нь хэн ч хөөцөлдөөгүй. Дахиад л нөгөө хяналтын чинь асуудал, дахиад л нөгөө хариуцлагын чинь асуудал яригдаад байгаа юм. Энэ дээр тодорхой

асуулт авмаар байна. Тэгээд дараагийнх нь нэг асуудал одоо бид нар сайн ч, муу ч бас эмнэлгүүдийн байр байна. Хөдөө сумуудаар, аймгуудаар. Сургуулиуд нь байна бас нэг сайн ч муу ч нурчихсан ч хамаагүй нэг сургуулиуд байна. Одоо бид нар дотор нь ажиллах боловсон хүчний асуудлыг ярихгүй бол хөдөө орон нутагт эмчийн асуудал ч хүнд байна. Багшийн асуудал ч хүнд байна. Тэгээд энэ асуудлыг нь ярих гэхээр дахиад нөгөө Эрүүл мэндийн сайд чинь гараад явчихсан. Байхгүй.

Уг нь энэ Боловсролын зээлийн сангийн асуудлыг тухайн сумд нь квотыг нь өгч байгаад, нарийн мэргэжлийн багшийн асуудлыг эсвэл эмчийнх нь асуудлыг шийдэж өгөөд 3-5 жилийн циклтэй яваад байдаг бол боломж нь байна гэж харах гээд байгаа юм. Тэгтэл тэгээд нөгөө улс төрд ойрхон, эрх мэдэлтэй хүмүүсийнх нь дарга, цэрэг нарынх нь хүүхдүүд хусаад Боловсролын сангаа дампуур буруулаад хаячихсан. Энийг бас нэг жоохон хариуцлагатай ажиллуулах чиглэлд Боловсролын яамнаас байр суурийг нь тодруулмаар байна.

Тэгээд Эрүүл мэндийн сайдаас бас асууя гэж бодож байсан юм. Дундаж наслалтыг бид нар өсгөнө. Эрүүл дундаж наслалтыг өсгөнө гээд. Одоо энэ индэр дээр бол бид нар гоё сайхан юм ярьж ханалаа шүү дээ. Хэдэн жил ярилаа. Баянхонгор аймагт жишээлэхэд эхийн эндэгдэл сүүлийн 6 сарын дотор 2 удаа гарч байна. Түргэнийх нь машин тэнд бензингүй байна. Даргыг нь халж байна. Чанарын менежерээ халж байна. Одоо сувилалч нар нь энэ 7 хоногт сургалттай ч билүү, семинартай ч билүү ирсэн. Уулзсан. Аймаг нь эмнэлгийнхээ даргыг ч томилж чадахгүй ийм байдалтай сууж байна шүү дээ. Тэгээд байхад энд манай Эрүүл мэндийн сайд гоё гоё юм яриад л яваад байх юм. Тэгээд Эрүүл мэндийн сайд нь болохоор өөрөө гоё ийм рийл, зургаа авхуулаад, бичлэг хийлгээд яваад байна. Энэ үндсэн ажилдаа анхаараад, нүдэн дээр дампуураад байгаа энэ салбар луугаа анхаарахгүй бол Баянхонгор аймагт бол эрүүл мэндийн салбар нүдэн дээр дампуурчихлаа. Энэ дээр бас сайдынхаа байр суурийг сонсчихмоор байна. Төсөв хэлэлцэж байхад бас хавдрын эмнэлгийн хэрүүл яваад байсан. Одоо бас ямар байр суурьтай байгаа юм. Хавдраараа л монголчууд үхээд дуусаж байгаа шүү дээ. Энэ дээр бас байр суурийг нь сонсмоор байна.

Тэгээд энэ халамжийн асуудал чинь бас яг энэ тарааж өгсөн төсөл дээр чинь 13 төрлийн халамж бид нар тараадаг Монгол Улс халамжийн улс л болсон. Хэн ч юу ч ажил хөдөлмөр эрхэлж, мөнгө төгрөг олъё гэж боддоггүй. Энэ дээр нь бас халамжийг бүр зоригтойгоор хасах чиглэлд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнбуянгийн Амарсайхан, Тогмидын Доржханд, Эрдэнэбилэгийн Одбаяр, Буяагийн Тулга, Равжихын Эрдэнэбүрэн, Батмөнхийн Батцэцэг, Болдын Жавхлан, Оюунсайханы Алтангэрэл, Цэвэгдоржийн Туваан, Салдангийн Одонтуяа, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Борхүүгийн Дэлгэрсайхан, Чинбатын Номин, Жамбын Батсуурь, Жадамбын Энхбаяр, Мөнхсайхан сайд ороод ирсэн. Сайд нар орж ирье. Асуултад хариулъя. Сайд нарыг орж ирэхээр хариулт өгүүлнэ.

Жоохон ухамсартай бай л даа сайд нар аа. Сонсоод байж байна гэж та хэд чинь энд хариулах гээд сууж байх ёстой биз дээ. Төсөв хэлэлцэх, төсвийн хүрээ хэлэлцэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтөө ярих энэ асуудал дээр сайд нар сууж байгаад хариулчхаач ээ гээд одоо шаардаж бас хэлсэн шүү дээ. Эсвэл байнга уурлаад, байнга хэрэлдээд сууж байвал таатай байдаг юм уу. Хэн ч уурлаж чадна шүү дээ. Хэн ч хэрэлдээд байж бас чадна шүү дээ. Энэ төрийнх нь ажил эмх цэгцтэй

аятайхан шиг яваасай, санаачилж байгаа ажлууд нь бас цаг хугацаандаа хэрэгжээд биелээд яваасай. Ард иргэдийн хүсэж хүлээж байгаа тэр нөхцөл боломжийг бий болгохын төлөө нөхцөл боломжийг нь дэмжээд явах юм сан гэсэн ийм хандлагаар хандаад байхаар тэгээд 1 жоохон ухамсар гаргах асуудал дээр л алдаад байх шиг байх юм Засгийн газрын гишүүд маань. Чуулганы хуралдаанд заваараа орж ирж хариулт өгч байгаа юм шиг хэлбэрээр яваад байдаг. Энэ бол Улсын Их Хурлын гишүүдийн шүүмжлээд байгаа. Яагаад зарим асуудал дээр чинь асуудлыг чинь босгож ирж, шаардлага, шахалт үзүүлээд байгаа шалтгаануудын чинь үндэс энэ шүү дээ. Хүн хүндэтгэлтэй хандвал хэн ч бусад нь эргээд л хүндэтгэлтэй л ханддаг шүү дээ. Тэгээд хүндэтгээд асуудлыг нь бариад яваад байх тусам давраад эд нар яадаг юм гэж бодоод байгаа юм уу. Араа шүдээ үзүүлбэл хэн ч, хаана ч үзүүлж чадна. Тэгэхдээ төрийн ажил тэгж явах зохимжгүй.

Бусад сайд нар яав. Гантөмөр сайд хариулт өгч байя. Цогтбаатар гишүүний асуулт бол Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд руу чиглэсэн асуулт байсан. Эхлээд Тогтмолын Мөнхсайхан сайд хариулт өгье.

Т.Мөнхсайхан: Энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сүүлийн жилүүдэд үнэхээр огцом сайжирч байгаа. Энийг харуулж байгаа тоо баримтууд нь байгаа шүү дээ. 2020 онд 18 сая хүнд тусламж, үйлчилгээ үзүүлж байсан бол 2024 оны байдлаар бид нар 26 сая хүн амд тусламж, үйлчилгээгээ үзүүлсэн байна. Хавдрын тусламж, үйлчилгээний хүртээмж, очер дугаар бол мэдэгдэхүйц буурч байгаа. Ганц жишээ хэлэхэд хавдар дээр туяа эмчилгээ хийлгэх гэж 2 сар болдог байсан бол өнөөдөр оношлогдоод маргааш нь шууд эмчилгээнд орох боломж бүрдчихсэн. Бид нар маш цогц арга хэмжээнүүдийг авч байгаа. 12 сарын 1 гэхэд бид нар хавдрын тусламж, үйлчилгээг үндэсний төв дээр ямар нэгэн очер дугааргүй болгоно.

Ялангуяа хөдөө орон нутаг, аймаг орон нутгуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор санхүүжилт болон бусад бодлогын арга хэмжээнүүдийг маш эрчимтэй авч хэрэгжүүлж байгаа. Ялангуяа Баянхонгор аймагт онцгой анхаарал хандуулаад, шинэ баригдаж байгаа амбулаторийг улсын хэмжээний жишиг төв болгохоор бид нар маш олон ажлуудыг хийгээд, гадагшаа дотогшоо сургалтад явуулаад, туршлага судлуулаад Баянхонгор аймаг дээр онцгой анхаарал хандуулж байгаа. Одоо энэ аймаг, сумын эмнэлэг болгон дээр гарч байгаа тэр хариуцлагын алдаануудыг бүгдийг нь яам хариуцахгүй шүү дээ. Баянхонгор аймгийн эмнэлгийн даргыг бол Баянхонгор аймгийн Засаг дарга нь томилж байгаа. Эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцийн бодлогын сургалт бүх юмыг нь хангаж өгч байгаа. Одоо тэнд 2 ч удаа эхийн эндэгдэл гаргасан асуудлыг хариуцлагыг нь тооцох хэрэгтэй байхгүй юу. Бид нар бол яагаад ийм асуудал гарав гэдэг мэргэжлийн салбар зөвлөлийг нь ажиллуулаад, бүх үнэлгээ дүгнэлтийг нь гаргаад, дахиж эхнийх нь гаргахад гаргахгүй байх талаас нь бүх арга хэмжээг авсан. Гэтэл аймаг, орон нутагт байгаа хариуцлагагүй асуудлаас болоод 2 дахийг нь гаргаж байгаа энэ зүйл дээр тэр даргын томилдог тэр аймгийн удирдлагууд асуудлуудаа хэлж ярих хэрэгтэй. Бүх шатны эмнэлгүүдийн хариуцлагыг Эрүүл мэндийн яам хүлээнэ гэдэг тийм асуудал байхгүй. Санхүүжилтийн тогтолцооны хувьд ч гэсэн өөрсдөө тэр бензин тосныхоо мөнгийг хангалттай хэмжээнд шийддэг болсон шүү дээ. Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн төсөв 2020 оныхоос хойш 2 дахин нэмэгдчихсэн байгаа. Тэгээд яахаараа бензинийхээ мөнгийг авч чаддаггүй, машин тэрэгнийхээ бензин хийж чаддаггүй менежментийн алдаа байхгүй юу. Түүнээс Эрүүл мэндийн яамны алдаа биш. Аймаг, орон нутгуудад тусламж үйлчилгээ сайжраад, төвлөрөл өнөөдрийн байдлаар 15 хувь, сүүлийн 8 сарын

хугацаанд 15 хувиар буурчихсан байж байгаа. Бид нар энийг ирэх жил гэхэд 50 хувь бууруулаад Улаанбаатар луу ирдэг энэ урсгалыг багасгаж, ард иргэдэд учирч байгаа төвөр чирэгдэл, санхүүгийн эрсдэл дарамтыг бууруулах бүх тооцоо тооцооллуудаа хийгээд, эхнээсээ бодит үр дүнгүүдээ өгөөд эхэлчихсэн байгаа. Тэгэхээр энэ дээр бол шаардлагатай арга хэмжээнүүдийг бүгдийг нь авч ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Энэ нэг ярьж байгаа асуудал чинь Мөнхсайхан сайд маань салбарын яам, бодлогын яам яах гэж байдгийн л асуудал шүү дээ. Иймэрхүү асуудлууд үүсээд байгаа бол энийгээ шийдэхийн тулд та нар ямар санаачилга гаргаж ажиллаад байгаа юм бэ гэдэг асуултууд ерөнхийдөө явж байгаа. Тэгээд эрүүл мэндийн салбарынхан мэдээж хэрэг тангараг өргөсөн ард иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө зүтгэж яваа цагаан нөмрөгтнүүд. Тэгээд ганц 2 нөхцөл байдлаас хамаараад салбар тэр чигтээ доргиод байж бас болохгүй.

Гэхдээ нөгөө талаараа ард иргэдийн хүсэж хүлээгээд байгаа эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж чаддаг тийм хандлага, ёс суртахуунтай байх салбар. Түүнээс тэр Засаг дарга томилсноос болж алдаа гараад байгаа. Сайд томилсноос болж алдаа гардаггүй гэдэг ойлголт байж болохгүй. Хэн ч томилж болно шүү дээ. Хэн ч хаана ч томилогдож болно. Гол нь харилцаа хандлага, энэ салбар чинь өөрөө яаж энэ үйлчилгээ нөхцөлөө хөнгөрүүлэх юм бэ гэдэг дээр их сайн төвлөрч ажиллах хэрэгтэй.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал. Танай сайд хаачсан юм. 4 дүгээр индрээс хариулт өгье.

Х.Батжаргал: Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал. Гишүүний асуултад хариулъя. 2 асуулт.

Электрон тамхины хэрэглээ, ялангуяа насанд хүрээгүй, өсвөр насны хүүхдүүдийн түвшинд бол өндөр байгаа нь судалгаагаар гарч ирсэн байгаа. Тэр дээр тантай бол санал нэг байгаа. 2024 онд Боловсролын сайдын 11 сард тушаал гарч боловсролын сургалтын байгууллагын орчинд электрон тамхи, тамхины хэрэглээг хязгаарлах, худалдаалах энэ бүхнийг хориглосон тушаал гарсан. Гэсэн хэдий ч бас энэ нэлээн салбар дундын шинжтэй хэрэглээг нь бас нэлээн маркетинг, амт, үнэр, электрон танхимын бас нэг онцлог байна. Тэр асуудлуудыг шингээсэн нэлээн салбар дундын шинжтэй асуудлуудыг шийдвэрлэх асуудлууд бол гарсан байгаа бас судалгаагаар. Тэгээд үүнтэй холбогдуулаад Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн ажлын хэсэгтээ Эрүүл мэндийн яам дээр бас салбарынхантай .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэгээд энд Номинчимэг гишүүн ахалчихсан электрон тамхины зохицуулалтыг хийх хуулийн төсөл санаачлаад явж байгаа. Уг нь бол төслөө өргөн барихад нэлээн бэлэн болчихоод байж байгаа. Надад өнгөрсөн 7 хоногт танилцуулагдсанаар Эрүүл мэндийн яам болон Сангийн яамнаас хуулийн төсөл дээр өгөх санал дээр жоохон хойрго хандаж байна гэдэг асуудал яригдсан. Энэ асуудал дээр би бас салбарын сайд нарыг ирэхээр бас ярилцъя гэж бодож байгаа. Электрон тамхины зохицуулалтын хуулийг яаралтай горимоор бид хэлэлцэх ёстой. Энэ дээр Засгийн газар ч гэсэн удаахгүй 1 өдрийн дотор ч болсон энэ төсөл санаачлагчид хариуг нь өгөх ажил дээр Алтангэрэл сайд анхаарч ажиллаад, тэгээд

ингээд Засгийн газрын Сангийн яам болон Эрүүл мэндийн яамны санал, Засгийн газрын санал ирсэн тохиолдолд Номинчимэг гишүүн болон түүний ажлын хэсэг энэ электрон тамхийг зохицуулах хуулийн төслөө өргөн барихад бэлэн болчихож байгаа юм. Тэгэхээр энэ ажил ирэх 7 хоногт өргөн баригдчихвал Улсын Их Хурал энэ хаврын чуулган завсарлахаас өмнө эцэслэн батлах тэр боломж нөхцөл бүрдэх юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр Засгийн газар талаас бас анхаарал тавиач гэдгийг энэ ташрамд хэлье.

Батжаргал Төрийн нарийн бичгийн дарга гүйцээж хариулъя.

Х.Батжаргал: Тэгээд Тамхины хяналтын тухай хуулийн хэлэлцүүлэг бас өнгөрсөн 7 хоногт эрүүл мэндийн салбарынхантай, өчигдөр бас боловсролын салбар буюу ерөнхий боловсролын сургуулиудын бүх шатны удирдах болон оролцогч албан хаагчидтай хэлэлцүүлэг хийгээд, саналыг нэгтгээд Номинчимэг гишүүнээр ахалсан ажлын хэсэгт бол хүргүүлэн ажиллаж байгаа. Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтаар бол нэлээн тулгамдсан асуудлууд шийдвэрлэгдэнэ гэж харж байгаа.

Боловсролын зээлийн сангийн тухайд бол таны шүүмжтэй бол бас санал нэг байгаа. Түүний дагуу бас Улсын Их Хурал Боловсрол, спорт, соёл, шинжлэх ухааны байнгын хороон дээр бас тусгайлан ажлын хэсэг байгуулагдаад санал, дүгнэлт гараад Засгийн газарт чиглэл хүргүүлэгдээд, ер нь тулгамдсан байдаг иргэдийн шүүмжлэлийг бас дагуулдаг эдгээр бүх тодорхой бус зохицуулалтуудыг тодорхой болгоод, Засгийн газрын тогтоолоор энэ сонгон шалгаруулалтын шинэчилсэн журмыг бол баталсан байгаа. Тэгэхээр түүгээр бол ялангуяа сонгон шалгаруулалт дээр бол хиймэл оюун цахимжилтыг бүрэн ашиглаж, олон нийтэд нээлттэйгээр энэ жилийн сонгон шалгаруулалтыг бол/минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя. Даваагийн Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Да.Цогтбаатар: Эксим банкны зээл дээр. Тодруулга явах болоогүй. Сангийн яам.

Д.Амарбаясгалан: 3 дугаар индрээс хариулт өгье. Наранбаяр сайд гадаадад томилолттой байгаа юм байна. Хүсэлт нь Их Хурал дээр ирсэн байгаа юм байна. 3 дугаар индрээс хариулт өгөх үү. 4 дүгээр индрээс хариулт өгье.

О.Хуягцогт: Сайн байна уу. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт.

10 аймгийн дулааны станц төслийн зээл бол анх 2018 онд байгуулагдаж, үүний дагуу уг зээлийн хэлэлцээрээр зөвхөн Солонгосын компаниуд тендерт шалгарах нөхцөлтэй ийм гэрээ. Ингээд 2021 онд тендер шалгаруулалт эцэслэж, 2022-2026 онд дуусах ийм нөхцөлтэй ажил явж байсан. Ажлын гүйцэтгэл бол 10 аймгаас 9 аймаг дээр нь 44-46 хувьтай байгаа. Санхүүжилтийн гүйцэтгэл одоогийн байдлаар 43,6 хувьтай байна. Энэ тендерийн нэг асуудал нь бол түлхүүр гардуулах нөхцөлтэй, гэрээний үнэнд тохируулга хийхгүй гэдэг нөхцөлтэй хатуу гэрээтэй. Харамсалтай нь өнгөрсөн хугацаанд гүйцэтгэгчээр шалгарсан компани санхүүгийн хүндрэлд орсны улмаас төслийн хэрэгжилт удааширсан. Энэ асуудлаар энэ компани нь ../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

О.Хуягцогт: Төслийн ерөнхий гүйцэтгэгч Пэксан Инженеринг компани бол Солонгосын компани байгаа. Энэ компани 2026 оны эхний улиралд гэрээгээ дуусгах ийм нөхцөлтэй ажлаа бол хяналт тавьж шахаж явсан. Харамсалтай нь 2025 оны 3 сарын эхээр Солонгосын талдаа хуулийн дагуу санхүүгийн хүндрэлд орсон учир дахин санхүүжүүлэх ийм хүсэлт гаргасны улмаас шүүхийн процесс явсан. Энэ шүүхийн процесс дээр бол БНСУ-ын Эксим банк, Монгол Улсад суугаа БНСУ-ын Элчин сайд, мөн Солонгос Улсад Монгол Улсаас суугаа Элчин сайд болон Эрчим хүчний яам хамтран энэ нөхцөл байдлыг маш шуурхай хуулийн хүрээнд эрсдэл багатай даван туулах ажлыг зохион байгуулж байна.

Зээлийн хүү энэ хугацаанд бол жилийн 0,15 хувийн хүүтэй. Энэ хүүг бас хэрхэн шийдвэрлэх талаарх хүсэлтийг бид Эксим банканд Сангийн яамтай хамтран гаргасан байгаа. Ямар ч тохиолдолд энэ төслийг бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээгээд хариулчихъя даа.

О.Хуягцогт: Энэ шүүхийн процессоос хамаараад 6 сараас 1 жилийн хугацаа бидний төлөвлөсөн хугацаанаас хойшлогдох эрсдэл үүссэн. Тэгээд хамгийн бага хугацаанд энэ нөхцөлийг даван туулж шийдвэрлэх чиглэлээр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч байна.

Д.Амарбаясгалан: Сангийн яамнаас хэн хариулт өгөх юм. 3 дугаар индэр.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Дэлгэржаргал Сангийн яам. Хугацааны хувьд бол 40 жилийн хугацаатай, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 10 жил байгаа. Жилийн хүү 0,15. Одоогоор 610,7 саяыг хүүд төлсөн. Үндсэн төлбөрийн төлөлт бол 2028 оноос эхэлнэ.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Баянхонгор аймагт Эрүүл мэндийн яам тусад нь байгуулж өгөх ёстой юм байна. Тэгж байж тэнд эрүүл мэндийн асуудал, эмнэлгийнх нь асуудал шийдэгдэх юм байна. Тэгэхгүй тэнд чинь Баянхонгор аймгийн Засаг дарга эрүүл мэндийн асуудлыг мэдэхгүй шүү дээ. Салбарынх нь асуудал тэнд унаад байна гэдгийг л хэлэхээр сайд нь энд биеэ өмөөрөөд суугаад байх юм. Уучлаарай сайд аа.

Энэ 610 сая доллар төлчихжээ. Нөгөө 10 аймгийн дулааны станцыг нь зөвхөн хүүд нь. Нөгөө дулааны станц чинь ашиглалтад ороогүй. Бүр ашиглалтад орох нь байтугай гүйцэт баригдаа ч үгүй байгаа. Одоо бид нар хэн рүү хандах юм бүү мэд. 610 сая доллар чинь тоглоомын мөнгө үү. Солонгосын талтай энийгээ хэн ярих ёстой юм. Эрчим хүчний яам юм уу, Сангийн яам юм уу, Гадаад харилцааны яам юм уу. Хуулийн асуудал байгаа бол Хууль зүйн яам юм уу. 610 сая доллар үргэдчихээд байна шүү дээ. Барих ёстой нөгөө сургууль, цэцэрлэгээр чинь бол бас нэг сургууль, цэцэрлэгийн мөнгө явчхаж.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Хөгжлийн төлөвлөгөө ярьж байгаа. Тэгээд хөгжлийн төлөвлөгөөгөө бид зөв баталж байж төсвөө зөв батална л даа. Би нэг 2024 оны

эхний 4 сар сарыг 2025 оны эхний 4 сартай харьцуулаад хэдэн тоо баримт хэлье. Надад байгаа тоо баримт буруу бол Сангийн яам тодруулаарай.

Энэ төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал бараг 1,2 их наядтай байгаа. Энэ ямар мөнгөөр энэ олон төлөвлөгөөг хийх вэ. Ноднингийн тухайн үед төсөв 2,1 их наяд би буруу санаагүй бол ийм ашигтай байсан юм. Тийм учраас нэлээн том төлөвлөж чадаж байсан юм л даа. Төлөвлөгөө бол нэлээн том батлагдсан. Одоо Эдийн засаг, хөгжлийн яам бол 2026 оны төлөвлөгөөг эрс тийм танасан маягтай батлах хэрэгтэй. Энэ тоо баримт дээрээ үндэслэх хэрэгтэй. Тэр яаж 14 мега төсөл хийх гэж байгаа юм. Юугаар хийх гэж байгаа юм гэдгийг сонсвол уг нь сайн байна. Ямар мөнгөөр хийх гэж байгаа вэ гэдгийг сонсвол сайн байна.

Энэ манай экспорт буусан. Энийг нөгөө нүүрсний үнэ гээд янз янзын зүйлтэй холбож байгаа юм. Импорт мөн адил буусан. Импорт ингээд урд жилүүдээ бодвол байнгын өсөлттэй байсан. Энэ жил бол яг адилхан тоо барьж байгаа. Энэ юу хэлж байгаа вэ гэхээр ард иргэдийн хэрэглээ буусан. Амьжиргаа буусныг харуулж байгаа юм. Өчигдөр би сүүлийн 8 жилд ард иргэдийн амьдрал ядуурал энэ жил их байна гэж хэлснийг хэвлэлийнхэн нэлээн л тийм гуйвуулсан юм ярьж байна лээ л дээ. 2025 онд ядуурал өмнөх 8 жилээсээ маш их байна. Худалдан авах чадвар эрс буусан байна.

Дараагийн асуултаа асууя. Энэ инфляц 8,6 гэж байгааг бол ихэнх тоо баримтууд бол үгүйсгэж байгаа юм. Яаж 8,6 гардаг юм бэ. Энэ чинь бараг 10 гарчихсан байна гээд. Энэ дээр хариулаач. Ямар аргачлалаар бодсон юм. Энэ аргачлалаа өөрчилчихсөн юм уу. Эсвэл яаж 8,6 гараад байгаа вэ. Хариулаарай.

Төгрөгийн ханш ноднингийн мөн үед 3378 байсан. Өнөөдөр хэд байгааг мэдэж байгаа. 3370 хүчээр барьж байна. Тэгээд 5 тэрбум доллартой юм бол яагаад төгрөгийн ханш буухгүй өсөөд байгаа юм байгаа юм. Надад хариулж өгөөрэй. Энэ Монголбанк байхгүй учраас Сангийн яам л хариулах байх л даа. Маш их доллартой байж яагаад төгрөгийн ханш өсөөд байна. Би энэ хөгжлийн төлөвлөгөөг батлаад энэ нь ажил хэрэг болоосой гэдэг үүднээс асууж байгаа шүү.

Дараагийн асуулт энэ биржийн тухай хууль чинь хүчин төгөлдөр байгаа. Сая 1 баахан хууль оруулж ирээд буцчихсан. Тэгээд Эрдэнэ Тавантолгой компани эхний 4 сарын байдлаар 10 сая тонн нүүрс зарсан юм байна. Тэрнийхээ нэгхэн саяыг биржээр зарсан байна. Ноднин яг мөн үед 10 саяыг зараад, 9 саяыг нь биржээр зарж байсан юм. Тэгээд төсвийн тэнцвэржүүлсэн орлого чинь 2,1 их наядын ашигтай, 2025 оны төлөвлөгөөгөө маш өндөр батлах эх суурь болсон юм. Тэгээд өнөөдөр мөнгө байхгүй. Бид нар чинь нүүрсээр л амьдарч байгаа шүү дээ. Одоо нөгөө экспорт өссөн гээд байгаа тэр Оюутолгойн бараг 500 сая долларын өсөлт гэдэг чинь манайхаар дамжихгүй шүү дээ. Манай мөнгө биш. Зүгээр л тоо баримт. Зүгээр л тоо харагдаж байгаа байхгүй юу наадах чинь. Тэгэхээр яг манай бодитой экспорт бол манай нүүрс, алт. Тэгэхээр энийгээ яах вэ. Яаж мөнгөтэй болж, яаж энэ Гантөмөр сайдын хэлээд байгаа гоё гоё төлөвлөгөөнүүдийг, гоё гоё мега төслүүдийг явуулах юм бэ.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн яам Ганбат дарга. Санжаадорж хариулт өгнө. 3 дугаар индэр.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй хамт давхар орж ирж байгаа 1 баримт бичиг бол төсвийн хүрээний мэдэгдэл байж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдлийн хувьд бол ирэх жилийн төсвийн орлого болон зарлагыг яг энэ жилийн батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлтэй буюу энэ жилийн нэгдсэн төсвийн нийт тоонуудтай ойролцоо байдлаар бол оруулж ирсэн байгаа. Мэдээж хэрэг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт заасан 4 жилийн хэрэгжүүлэх ёстой хөтөлбөрүүдийг хэрэгжүүл гээд Улсын Их Хурлаас бол үүрэг даалгавар өгчихсөн. Засгийн газраас мөн боловсруулаад орчихсон учраас энэ дээр бол тодорхой хэмжээнд орон зай гаргах шаардлагатай. Тийм учраас зарлага нэмэгдэхгүй байгаа тохиолдолд нөгөө талдаа яаж бид нар энэ орон зайг гаргах вэ гэдэг дээр бол зарлагын нэлээд том хэмжээний реформын шинжтэй хэмнэлтүүдийг хийхээр бол ажиллаж байгаа. Энэ дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан төсөвтэй холбоотой ажлын хэсэг байгаа. Мөн Засгийн газрын түвшинд бол бүтээмж болон хэмнэлттэй холбоотойгоор зөвлөлийг бол Учрал сайд бол ахлаад ажиллаж байгаа. Энэ 5 дахь өдрийн Засгийн газрын хурлаар бид бас төлөвлөгөөгөө оруулъя гэсэн байдлаар ажиллаж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл ирэх жилийн төсвийнхөө суурийг нь энэ жилдээ давхар хэмнэлтүүдээ хийгээд явна гэдэг байдлаар бол харж байгаа. Мэдээж хэрэг зарлагын бүтцийн хувьд бол та хамгийн сайн мэдэж байгаа. Нийт зарлагын бүтцийн маань 74 орчим хувь нь бол урсгал зардал байгаа. Үүнээс цалин, тэтгэвэр маань дийлэнх зардлууд болчхоод байгаа. Тэгэхлээр бид нар энэ том зардлууд дээрээ л орж ажиллахаас өөр аргагүй болчхоод байгаа. Ер нь ажиллах чиглэл маань 2 янзаараа ажиллая гэдэг ийм бодлого зарчим барьж байгаа.

1 дүгээрт төрийн чиг үүрэг гэдэг зүйлүүд ер нь юу юм бэ. Зарим ачаануудаа бид нар хувийн хэвшилдээ илүү хөнгөлөх ямар боломж байна гэдэг дээр бүхэлд нь энэ судалгаа хийх асуудлуудыг бол том зургаар нь ярьж гэж байгаа юм. Энэ тохиолдолд бид нарт яг төрийн чиг үүрэгт хамаарахгүй байгууллагуудыг орон тоог хэмнэх замаар тодорхой хэмжээнд зардлыг хэмнэнэ.

2 дахь асуудал бол ер нь энэ төсөвтэй холбоотойгоор маш олон хуулиуд яг тодорхой хэлэх юм бол 208 хуулийн 1028 заалтаар төсвийн харилцааг зохицуулснаар байгаа төрийн чиг үүрэг болгож. Ялангуяа энэ төрийн албаны хуулиудыг салбар болгоны хуулиар зохицуулаад байгаа асуудлыг нэгдсэн байдлаар төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны хуулийг санаачлаад оруулж ирж, энэ нь өөрөө төрийн албан хаагчдын орлогын ялгаатай байдлыг арилгах гэх мэт ийм томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Энэ хүрээндээ урсгал зардлыг бол ер нь 15 хүртэлх хувиар бууруулах, энэ хэмжээгээр буурсан дүнгээрээ нөгөө талдаа бүтээмжээ яаж сайжруулах вэ, төрийн үйлчилгээ бүтээмж бол муудахгүй байхаар яаж хийх вэ гэдэг энэ учир холбогдолтой дараалалтайгаар ажиллахаар төлөвлөгөө гаргаад явж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Статистикаас хүн байна уу. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Гантөмөр дарга хариулах уу. Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 8,6 хувийн инфляц байна гэдэг бол улсын хэмжээнд гарч байгаа тоо. Улаанбаатар хотод бол 10,1 хувьтай байна гэж байгаа юм. Энэ тооцооллыг бол Статистикийн ерөнхий газар гаргаж, манай яаманд ирүүлсэн байгаа.

Биржийн хууль бол хэвээрээ байгаа. Яг хуулиараа явж байгаа. Биржийн худалдаа бол үнэ унаж байгаатай холбоотой жоохон тийм амжилтгүй дуудлага худалдаа яваад байна гэж ингэж харж байгаа юм. Ер нь бид нарын гарц гаргалгааны хувьд дуудлага худалдаанаас айхтар ухаръя гэсэн бодлого бол байхгүй шүү сайд. Гол нь ам нөхцөлөөр дуудлага худалдвал яах вэ гэдэг ийм асуудал байгаа. Ер нь цаашдаа бол энэ дотоодод бий болж байгаа үйлдвэрүүдийг хэрхэн бид нар эрдэс баялгаар хангах вэ гэдэг шинэ бодлого гарах юм байна лээ. Тэгэхгүй бол яг гаднын экспортын худалдан авагчидтай зэрэг дуудлага худалдаанд ороод ирэх юм бол одоо энэ Алтанширээ дээр баригдаж байгаа Үйлдвэр технологийн парк хэр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Нүүрс болохлоор нөгөө 10 сая гараад байгаа. Тэгээд тэрийгээ 1 саяыг нь л зараад байгаа л даа. Тэгээд Гантөмөр сайд аа 10 саяас ядаж 7, 8 саяыг нь биржээр зарах ёстой шүү дээ. Юу ч гарахгүй биржээр юу ч зараагүй бол би юм ярихгүй л дээ. 10 сая гарчхаад байна. Тэгээд биржээр зарахгүй байна гэж.

Ер нь бол улсын төсвийг 2026 онд Эдийн засгийн яам төлөвлөхдөө орлого талыг нь их тийм зөв тооцоолоод, тэр төсвийн алдагдал бол байх боломжтой шүү дээ. Заавал алдагдалгүй байхаараа гоё гэсэн үг биш шүү дээ. Орлого талдаа л зөв тооцох хэрэгтэй. Энэ бол хамгийн чухал. Та өчигдөр тэр Аргентины Ерөнхийлөгчийн хэлж байгааг сонссон байх. 17 мянган хувьтай байсан инфляцыг 1,2-т буулгасан. Өчнөөн олон юм ярьсан л даа. Зүгээр тэр нь 17 мянган хувьтай байсан инфляц. Тэгээд алдагдал нь нөгөө гадаад худалдааны алдагдал нь 500 тэрбум төгрөгийн ашигтай гарсан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Бид энэ хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа алсын хараатай бодит чиг баримжаатай байх ёстой. 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцэхээс өмнө ирэх 5 жилийн үндсэн чиглэлээ тодорхой болгосон байх ёстой боловч тэгж чадахгүй байна. Бид нар сууриа тавиагүй байж ханаа өргөх гээд байна л даа. Ирэх 5 жилийн чиглэлийг хэзээ боловсруулж, хэзээ хэлэлцэх вэ гэдэг үндсэн асуулт байна. Энэ 2026 оны жилийн төлөвлөгөөтэй 5 жилийн чиглэл маань яаж уялдахаар төлөвлөж ажиллаж байгаа вэ.

Хоёрдугаарх нь бид Алсын хараа 2050-аараа үндэсний хэмжээний зорилго, зорилтоо тодорхойлсон. Энэ зорилгодоо бид нар алхам алхмаараа урагшлах ёстой. Энэ жилийн хөгжлийн төлөвлөгөөний 331 шалгуур үзүүлэлт Алсын хараа 2050-ын 73 шалгуур үзүүлэлттэй хэдэн хувь нийцэж байгаа вэ гэдэг 2 дугаар асуулт байна.

3 дахь асуулт. Өнгөрсөн жилээс л хойш хэлээд байгаа. Хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй ээ сайд нар аа. Хэзээ төлөвлөгөө боловсруулж сурах юм бэ. Жилийн хөгжлийн төлөвлөгөө уг нь их богинохон бичиг баримт. 50 хуудас хүрэхгүй. 3 хавсралттай. Энэ 3 хавсралт хоорондоо үг үсгийн зөрөөгүй үр дүнгээ хэмжих энэ KPI буюу шалгуур үзүүлэлт нь зөв байх шаардлагатай. Энийг л бид нар хийчихэд төсөв зөв болоод, хөгжлийн төлөвлөгөө тодорхой болоод, төрийн хамгийн том үүрэг буюу тодорхой байх явдал хангагдана. Тэргүүлэх чиглэлийн 1 дүгээр хавсралт 12 хуудас, төсөл арга хэмжээний жагсаалтын 2 дугаар хавсралт 26, хяналт үнэлгээний 3 дугаар хавсралт нь 15 хуудастай. Бид эндээс энэ 3 дугаар хавсралтад л онцгой ач

холбогдол өгч хийх ёстой. Улсын Их Хурлын гишүүдийн хийх ёстой ажил бол. Улсын мөнгө гэж байхгүй, төрийн мөнгө ч гэж байхгүй. Татвар төлөгчдийн мөнгө л гэж байгаа. Бид энэ иргэдийн төлсөн татварын төгрөг бүрийг үр ашигтайгаар зарцуулах ёстой. Үүнийгээ бид нар энэ 3 дугаар хавсралтаараа хангах ёстой. Харамсалтай нь энэ 3 дугаар хавсралтын шалгуур үзүүлэлтийн 42 хувь нь суурь түвшингүй, зарим нь зорилтот түвшингүй, зарим нь логикийн алдаатай байна. 3 дахиа хэлж байна би нэгдсэн чуулган дээр. Энийгээ засахгүй бол бид иргэдийн төлсөн татварын 100 төгрөг тутмын 42 төгрөгийг нь үр ашиггүй зарцуулах нөхцөл байдал үүсэх гээд байгаа юм.

Бодит жишээ хэлье. 3 дугаар хавсралтын 4.2 батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлж, сөрөн тэсвэрлэх чадавх бүрдсэн байна гэсэн зорилготой. Шалгуур үзүүлэлт байхгүй, суурь түвшин байхгүй, зорилтот түвшин байхгүй, мэдээллийн эх сурвалж ч байхгүй. Батлан хамгаалах яам яаж энэ ажлынхаа үр дүнг хэмжих гэж байгаа юм. Энэ төсвийг юунд зарцуулахыгаа бид нар яаж үр дүнгээ хэмжих юм. Ийм төлөвлөгөө боловсруулж болохгүй шүү дээ.

2 дугаар жишээ мөн хавсралтын 4.11 Монгол Улс гадаад бодлогын байр суурийг бэхжүүлж, олон улс дахь нэр хүнд нөлөөг бэхжүүлсэн байна гэж байгаа юм. Ийм зорилго. Шалгуур үзүүлэлт нь гадаад айлчлалын тоогоор хэмжих гээд байна. Өнгөрсөн жил 34 байгаа нь 2026 онд 55 гадаад айлчлалыг төлөвлөнө гэж байна. Айлчлал олон байх тусмаа Монгол Улсын нэр хүнд өснө гэж бодохгүй байна. Энэ логикийн алдаатай. Өөр оновчтой хэмжүүр байх ёстой. Гадаад яам ажлын үр дүнгээ яаж хэмжих гэж байгаа юм бэ. Оновчтой шалгуур үзүүлэлттэй болох ажлыг хэзээ хийх вэ. Энэ 5 асуултдаа хариулт авмаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Гантөмөр сайд эхэлж хариулъя.

Л.Гантөмөр: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Ер нь Лувсанжамц гишүүний хэлээд байгаа энэ KPI гэдэг зүйлийг Монголын Засгийн газар нэвтрүүлэх гэж оролдоод 4, 5 жил болж байгаа. Зүгээр энэ Монголдоо хамгийн амархан авч болдог нэгж нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт байдаг. Энэ зорилт бол ингээд суурийн тооцоолол их сайн хийгдэж эхэлсэн учраас хүрэх үр дүн дээрээ бол төвлөрөөд ингээд явчихдаг. Тэгэхээр бид нар энэ төлөвлөлтөө сайн хийгээд, төсөвжилтөө зөв хийгээд, хяналт шинжилгээгээ сайн хийж чадах юм бол хариуцлага гэдэг зүйл рүү очно. Мэдээж таны хэлж байгаа яг энэ хүрэх үр дүн, тэрнийх нь аргачлал асуудалтай байна гэдэг зүйлс бол байна. Яг таны нэрлэж байгаа энэ салбаруудад. Энэ дээрээ бол бид нар ажиллаж байна. Ер нь 5 жилийнхээ төлөвлөгөөг бид нар ойрын үед өргөн барина. Суурь нь юу юм бэ гэж. 4 жилийн Засгийн газрын хөтөлбөр, 2050 Алсын хараа урт хугацааны бодлого энэндээ бол зангидагдана. Бидний хийх нэг апдэйт хийх шаардлагатай зүйл бол 2050 алсын хараа дээрээ бид нар тал талаасаа ажиллаж байна. Ер нь энэ сүүлийн үеийн AI нэвтрэлт, AI -ийн хөгжил, ногоон шилжилтийн технологийн шийдлүүд бид нарыг яалт ч үгүй хүний нөөцийн хөгжил, хүний нөөцийн бодлогын өөрчлөлт бол яалт ч үгүй энэ холын хараагаа бид нар дахиад нэг апдэйт хийх шаардлага байна гэж үзэж ажиллаж байгаа.

5 жилийн төлөвлөгөөг ойрын үед өргөн барина. Суурь нь юу юм бэ гэвэл 2 бичиг баримтаа би хэллээ. Алсын хараа 2050-аа бид нар мэдээж хэрэгжүүлэх учиртай. Хуулиараа тийм. Мөн Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр буюу улс төрийн намууд сонгуульд орохдоо ард түмэндээ амласан амлалт. Энийг

ажил хэрэг болгох ёстой. Яг энэ дээрээ манай дээр ялгаагүй энэ үр дүнд суурилсан тогтолцоо руу нэвтрэх, үр дүнгээ их тодорхой хэмждэг, хэмжигдэхүйц болгох, тэр нь өөрөө олон улсын байгууллагуудын жишигт нийцэх гэдэг ийм зүйл рүү алхаж байгаа шүү. Тэгээд Гадаад хэргийн сайд бас дэвшүүлж байгаа бодлогуудынхаа зорилтуудыг хэрхэн түвшнээ юунаас аваад, юу руу зорьж байгаа тухай тайлбарлах байх. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн байвал тайлбарлах байх. Манай Эрдэнэбат дарга яг энэ Лувсанжамц гишүүний асуултад хариулахаар бол гараа өргөөд, нэмэлт хариулт өгөөрэй. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Алив хариулт өгөх хүмүүс 4 дүгээр индэр дээр. Зүүн талын жигүүрийнхэн 3 дугаар индэр дээр очоод, хариултдаа бэлэн зогсож байя. 4 дүгээр индэр.

Ц.Эрдэнэбат: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль бол их сайн хууль батлагдсан. Тэгээд энэ хууль маань хэрэгжээд бид нар 4 дэх жилийнхээ нүүрийг үзэж байна. Жил болгон энэ хөгжлийн бодлогын баримт бичгүүд богино, дунд, урт хугацааны баримт бичгүүд чанаржиж байгаа. Энэ дээр сайжруулалт байгаа гэвэл хэрэгтэй байгаа. Түүнийгээ сайжруулахын тулд Засгийн газрын түвшинд төлөвлөлт, төсөвлөлт, хяналт үнэлгээний ажлын хэсэг гараад, энэ дээр бол ойрын үед нэгдсэн платформ хийхээр эхний ажлууд нь хийгдээд явж байгаа.

Мөн Улсын Их Хурлын даргын 185 дугаар захирамжаар таны ахалсан ажлын хэсэгтээ бид 5 сарын 5 онд уулзаад, одоо ингээд маргааш нөгөөдөр ахиж арга хэмжээ хийгээд явна. Тэгээд энэ болгон дээр энэ сайжруулалтууд хийгдэх юм. Энэ хуулийн дагуу яамнууд маань өөрсдөө шалгуур үзүүлэлт болон, ярьж байгаа энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ц.Эрдэнэбат: Яамнууд маань энэ дээр шалгуур үзүүлэлтүүд ирүүлээд, бид нар энэ Эдийн засаг, хөгжлийн яаман дээр нэгтгэл хийхдээ дээрээс доошоо, доороос дээш зарчмыг баримтлан нэгтгэлээ хийж, бодлого гаргаад, бодлогынхоо хүрээнд салбаруудын уялдааг хангах энэ түвшинд явж байгаа. Тэгээд энэ түвшин дээр энэ KPI маань сайжрах ёстой. Энэ сайжруулалт бол жил болгон хийгдээд явж байгаа. Таны ахалсан ажлын хэсэг бол Засгийн газрын ажлын хэсгийн үр дүнд нэгдсэн платформд орчихвол талуудад эхнээсээ хэзээ, хэн төлөвлөсөн юм, ямар түвшинд бусадтайгаа уялдаж байгаа юм гэдэг маань гараад ирвэл улам төгс төгөлдөр болох юм. Тэгээд бидний бодож байгаагаар бол энэ жил болон 2026 онд энэ чиглэлээр бас нэлээд ажлууд төлөвлөсөн байгаа. Энэ дээр бол нэлээд дорвитой үр дүн гарсан байна гэж бодож байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс нэмэлт хариулт өгье.

Б.Эрхэмбаяр: Батлан хамгаалах яам. Хурандаа Эрхэмбаяр. Гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр захирамжаар үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулах стратеги боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, энэ ажлын хэсгийг манай Батлан хамгаалахын сайд ахалж байгаа. Түрүүн таны хэлсэн манай энэ хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь түвшин, зорилтот түвшин дээр манай шинэ арга хэмжээнд тул суурь

түвшинд байхгүйгээр бусад шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнээ бас тодорхойлоод тусгагдсан байгаа гэж ойлгож байгаа.

Төлөвлөгөөний төсөлдөө бол хүргүүлсэн. Энэ алдаа гарсан юм болов уу. Манайх бол холбогдох журмын дагуу боловсруулаад хүргэгдсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Чуулганы танхимд Улсын Их Хурлын гишүүдийн асуултад үнэн зөв, бодит мэдээлэл өгөх үүрэг хүлээдэг гэдгээ төрийн албан хаагчид мэдэж байгаа байх. Хуулиар хүлээсэн үүрэг шүү дээ. Батцэцэг сайд хариулт өгье.

Б.Батцэцэг: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Тэгээд Гантөмөр Шадар сайдын хариулт дээр нэмээд хэлэхэд Гадаад харилцааны яам бол бүх салбарын үйл ажиллагаанд оролцдог онцлогтой. Тэгээд улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, хөгжлийн таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхийг улс төр дипломатын аргаар зорино гэсэн ийм зорилготой байдаг. Тэгэхээр сүүлийн жилүүдэд тэлж байгаа гадаад харилцаа, олон хийгдэж байгаа айлчлалуудын үр дүн бол бас 1 үр дүн нь гэж хэлж болно. Мэдээж салбарын бас онцлог байгаа. Бүх улс оронтой бүхий л салбарын үйл ажиллагааг уялдуулах, ярьж тохирох ажлыг хийдэг. Тэгээд айлчлал тоо нь нэмэгдэж байгааг бас олон талаар тайлбарлах ийм боломжтой. Мэдээж айлчлалын тоо нэмэгдэж байгаа нь зүгээр нэг зочлоод, эсвэл газар үзээд яваад байдаг асуудал биш. Айлчлал өөрөө харилцааны хамгийн оргил хэсэг нь байдаг. Олон жилийн туршид ярьсан тухайн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Батцэцэг: Тухайн оронтой харилцах харилцаандаа гарч байгаа дэвшил оргил хэсэг нь бол айлчлал байдаг юм. Тэгэхээр айлчлалуудын үр дүнгээр маш олон баримт бичгүүд, гэрээ хэлцлүүд байгуулагддаг. Засгийн газар хоорондын болон байгууллага хоорондын эрх зүйн орчныг нь бүрдүүлдэг. Ээн таатай эрх зүйн орчныг бүрдүүлснээр бидний гадаад худалдаа, экспорт, хөрөнгө оруулалт нэмэгдэх, иргэд хоорондын харилцаа нэмэгдэх гэх мэт олон давуу талууд бол гарч байгаа. Тухайлбал бид нар зөвхөн эдийн засаг, худалдааны агуулгаар нь бас дүгнэж болохгүй. Энэ өөрөө улс төрийн харилцаа. Дэлхийн олон улсын хамтын нийгэмлэгт Монгол улсын хувьд бас оруулах хувь нэмрийг бас илэрхийлж байдаг. Тийм болохоор улс орныг бас хооронд нь харьцуулаад байх ийм боломжгүй. Зөвхөн худалдаагаар ингээд хэмжээд үзэх юм бол өөрсдөө манайх дотооддоо үйлдвэрлэлээ хөгжүүлээд, манай экспортод гарах бараа бүтээгдэхүүн их байж чадах юм бол бүхий л боломж нөхцөлийг нь бүрдүүлсэн байна. Жишээлбэл .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Таны илтгэлийг сонсгох гээгүй. Асуултад тодорхой хариулчих. Ерөөсөө айлчлалын тоо давтамж нэмэгдсэнээр ажлын чинь гүйцэтгэл сайжраад байгаа юм уу, үгүй юм уу л гэж асууж байна шүү дээ. Тэгэхээр тэрийгээ л хариулчих.

Б.Батцэцэг: Ажлын гүйцэтгэл мэдээж нэмэгдэж байгаа. Эрх зүйн орчин 1 дүгээрт бүрдэж байгаа. Олон баримт бичгүүд байгуулагдаж байна. Эдийн засгийн хувьд аж ахуйн нэгжүүдэд боломж үүд хаалга нь нээгдэж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг нь би бичгээр явуулъя даа.

Д.Амарбаясгалан: Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Тодруулж асуухаасаа илүүтэй зөвлөгөө өгье дөө. Эдийн засаг, хөгжлийн яаман дээр бүх яамнуудын зорилт, зорилго, шалгуур үзүүлэлтүүд очиж байгаа. Алсын хараа 2050, 5 жилийн чиглэл, 4 жилийн хөтөлбөртэй нийцэхгүй байх юм бол буцаачихмаар байгаад байгаа юм. Тийм л зорилготой яам болов уу гэж бодож байна. Зорилго руугаа ойртоно уу гэхээс биш, тэрнээсээ шал далий юм хийгээд яваад байж болохгүй шүү дээ. Яамнууд бол.

2 дугаарт энэ Батлан хамгаалах яам үнэн зөв, бодит хариулна уу. Бид нарт тараасан материал дээр юу ч байхгүй байгаад байгаа юм. Боломжтой бол та бичгээр ямар материал, төсөл өгснөө бас над руу илгээхийг хүсэж байна.

3 дугаарт Гадаад яамны шалгуур үзүүлэлт дээр бол боломжит шалгуур үзүүлэлтийг санал болгож байна. Монголыг сонирхож байгаа гадаадын хөрөнгө оруулагчдын тоо хэмжээ, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх, визгүй зорчих боломжтой улсуудын тоо нэмэгдэх гэх мэт бодитой шалгуур үзүүлэлт байвал зүгээр болов уу гэж бодсон зөвлөгөө хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батцэцэг сайд сая хариулт өглөө. Энэ визээ гаргуулж авчхаад, зардал мөнгөөрөө билетээ захиалаад, тухайн улсдаа нэвтэрч чадахгүй байгаа буюу жишээлбэл Солонгос улс руу нэвтэрч чадахгүй байгаа иргэдийн асуудлыг ер нь Гадаад яам хэрхэн яаж анхаарч байна. Тэгээд 1 л зарчим шүү дээ. Яах гэж виз өгсөн юм. Тэгээд визээ авчхаад яваад очихоор оруулахгүй. Тэгээд хүний эрхийн зөрчил үүсгэж байгаа энэ нөхцөл байдал дээр Гадаад яам иргэдийнхээ эрхийг хамгаалах чиглэл дээр ямар ажил хийв. Иргэд энэ асуудлаар төрдөө хандаад, удаа дараа асуудал тавьж байна. Хэвлэлийн бага хурал ч хийж байна. Жижиг асуудал биш л дээ. Нөгөө талын асуудал гээд орхих асуудал ч бас биш. 1 л зарчим байгаа шүү дээ. Виз өгөгдчихсөн юм бол яагаад оруулахгүй байгаа юм л гэдэг асуудал. Батцэцэг сайд энэ дээр хариулаад өгөөч.

Б.Батцэцэг: Гадаад харилцааны яам сүүлийн жилүүдэд байнга харилцан адил байх, визний хөнгөлөлт үзүүлэх талаар БНСУ-ын Засгийн газартай байнга ярьж байгаа. Хил дээр иргэд зорчих хөдөлгөөн бол маш их нэмэгдсэн. Ковидоос хойш бол 2 дахин нэмэгдсэн. 60 орчим мянган хүн тэнд ажиллаж, амьдарч, сурч байгаа. Сүүлийн үед зөрчил гаргах тоо нь маш их нэмэгдсэн. Хил дээрээс буцах журам нь бол их нарийн Солонгос улс хууль бусаар ажиллаж байгаа иргэдээ буцаах ийм компанит ажлыг сүүлийн 2 жил хийж байгаа. Энэтэй холбоотой манай дээр зорилгоо тодорхойлж чадахгүй байна. Бөглөсөн материалаасаа зөрсөн зүйл ярих, буцах хаягаа мэдэхгүй, очих хаягаа мэдэхгүй гэх мэт ийм яг өөрийнх нь хууль дүрэмд нийцэхгүй, шаардлагыг нь хангахгүй байгаа учраас хил дээрээс зарим иргэдийг буцаасан асуудал гарч байгаа. Нөгөө талдаа гомдол гаргаж байгаа иргэд энэ 2025 оны 1 сараас хойш 5 сарын хугацаанд албан ёсоор манай яаманд гомдлоо гаргасан 3 иргэн байгаа. Энэ 3 иргэний асуудлыг Солонгосын талд тавихад Солонгосчууд бол урдаас манай Солонгост байгаа ЭСЯ-ны Консулын хэлтсийн ажилтнуудыг дуудаад, яг тухайн нөхцөл байдлын бичлэгийг үзүүлж, эрх нь зөрчигдсөн эсэх дээр бол бас 2 талтай зүйл ярьж байгаа. Яг одоо бид нарт мэдээлэгдэж байгаа нь Солонгосын талтай зөрүүтэй байх, өөрсдөө бас зөрчил гаргасан, тэрийгээ мэдүүлээгүй байх. Жишээлбэл утсаа үзүүлэе гээд гарын үсэг зурсан. Утсаа үзүүлэхгүй байх нь өөрийнх нь эрхийн асуудал. Өмнө нь зөрчил гаргаад, дахиад худлаа материал бүрдүүлээд өгсөн байна гэдэг асуудал, танхайрахад бол өөрсдөө эхэлсэн ч гэдэг юм уу айлын тал сөргүүлээд бид нарт бол мэдээллүүдийг нь бол өгч байгаа. Тэгэхээр энийг бол яг ганцхан талын асуудал гэж хэлж болохгүй. Иргэдээ

мэдээллэжүүлэх, материал бүрдүүлж өгч байгаа 14 компани байгаа. Визний мэдүүлгийг нь бөглөж, өмнөөс нь ЭСЯ-нд энэ визийн мэдүүлгийн үйлчилгээ үзүүлдэг компаниудтай бас бид нар ярилцах, Солонгосын ЭСЯ-нд энэ хүсэлтээ удаа дараа тавьсан. Иргэдийн гомдлыг ирсэн нөхцөлд Солонгосын талаас нотлох баримттай материал өгөөч. Ганцхан сошиал дээр тавьсан мэдээлэл бид нарт хариулт өгөхийн тулд учир дутагдалтай байна гэдэг зүйлийг ярьж байгаа. Ер нь сая бас таны Их Хурлын даргын урилгаар ирсэн Их Хурлын даргынх нь айлчлалын үеэр ч гэсэн энийг бүр өндөр дээд хэмжээнд бид нар тавьсан. Энийг бас манай Монгол-Солонгосын парламентын бүлгийн гишүүд ч бас ярьж байгаа. Тэгэхээр Солонгосын парламентын ер нь бол хууль бусаар буцааж байгаа иргэдийн асуудал ганцхан Монголын асуудал биш. Энэ Зүүн өмнөд Ази, Азийн, Төв Азийн нэлээн хэдэн орны иргэд бас адилхан ингээд буцдаг. Тэгээд бүгдэд нь адилхан дүрэм журам үйлчилдэг гэдгийг бол айлын тал тайлбарладаг. .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэгэхээр Гадаад яам энэ дээр ер нь идэвхтэй ажиллах хэрэгтэй. Нэг ч Монгол хүний эрх хаана ч очиж зөрчигддөггүй л байх ёстой. Бид бусад улсын жуулчид, зочид бүх түвшинд нь илүү хүндэтгэлтэй хандаж, дотоод дүрэм журмаа цэгцтэй байлгаж, улс хоорондын аливаа асуудал үүсгэхгүй, үл ойлголцол бий болгохгүй байх үндсэн бодлогыг Монголын төр барьж ажилладаг. Яг Монголтой дипломат харилцаатай улс орнууд ч гэсэн Монголчуудад, Монголын ард иргэдэд яг л тэр зарчмаар адил түвшинд хүндэтгэлтэй ханддаг л байх ёстой. Тэгээд энэ бол ерөөсөө Монгол хүний эрхийг хамгаалах асуудал. Тэгэхээр Гадаад яам энэ дээр онцгой анхаарч ажиллах хэрэгтэй. Тэгээд салбар дундын асуудал болгож хаядгаа бас болих хэрэгтэй шүү. Хууль зүйн яам энийг хариуцаж байгаа. Тэр тэрийг хариуцаж байгаа, энэ энийг хариуцаж байгаа гээд яамнууд хоорондоо бие бие рүүгээ түлхээд орхидог асуудал ерөөсөө байж болохгүй. Тэгэхээр энэ дээр онцгой анхаараарай. Энэ сүүлийн 5, 6 жил бас маш өргөн хүрээнд яригдаж байгаа сэдэв шүү Батцэцэг сайд аа. Энийг ер нь тэгээд таслан зогсоох ёстой.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг бид нар хэлэлцэж байна. Маш чухал бичиг баримт. Үүний хүрээнд ирэх жилийн төсөв ер нь ямар бизнесийн орон зайн хувийн хэвшилд үүсэж байгаа ч гэдэг юм уу, ямар секторыг бид нар бодлогоор дэмжих гэж байна гэдэг юм уу маш олон зүйлүүдийг эндээс зураглал харж болно. Энэ зөвхөн төрийн гэхээсээ илүүтэй хувийн хэвшлийн ч гэсэн бас бизнесийн үйл ажиллагаагаа яаж тэлж болох, ямар нөхцөл байдлууд үүсэх гэдгийг бас төсөөлдөг ийм бичиг баримт гэж би хувьдаа ойлгодог.

Тэгэхээр бас Шадар сайдаас л асуумаар байгаа юм л даа. Бид хэдийн төлөвлөлт бол их гоё байна. Их өөдрөг. Тэгэхдээ өнөөдрийн энэ уул уурхай дахь бараа бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, үнэ тогтож буй нөхцөл байдал, дээрээс нь Монгол Улсын төсвийг алдагдалгүй батлах зарчим, төсвийн хүрээний мэдэгдэл ч гэсэн энэ чигтээ ороод ирлээ. Таны энэ баталж байгаа, төлөвлөж байгаа энэ зүйл чинь ер нь бүрэн хэрэгжих бололцоо байгаа юу Шадар сайд аа. Энэ дээр бас ний нуугүй хэлээч. Ямар гарц гаргалгаа байна. Асуудлуудыг бид хэд парламент дээрээ ямархуу байдлаар шийдвэл боломжтой байна. Тэгэхгүй бие биеэ жоохон хуураад л байна л даа. Алдагдалгүй төсөв. Энэ талдаа эргээд тэрийг ярьж байгаа хүмүүс нь гоё ганган болоод, шударга сайхан болоод. Нөгөө талдаа энэ бүтээн байгуулалтыг явуулчихъя гэж байгаа хүмүүс нь нэг ийм хулгайч царайтай ч юм шиг, хулгайч болох гээд ерөөсөө л нэг л болж өгөхгүй байна. Тэгэхээр та бас энэ дээр яг гол уулзвар

дээр нь сууж байгаа хүний хувьд бас юу гэж бодож байна. Гарц гаргалгаа ямар байж болох вэ. Энэ дээр бас ний нуугүй хэлээч гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт урсгал зардлыг бас хэмнэх чиглэл дээр жишээ нь төрийн албан хаагчдыг цомхотгох тухай ярьж байна. Багш, эмч нараас бусдыг нь 9 хувиар цомхотгоно гэж байна. Эргээд төрийн албан хаагчдын бас олгож байгаа цалин хөлсний асуудлыг нэгдмэл 1 хуульгүйгээс болоод ингээд байна гэж бас тайлбарууд явж байна. Би энэ дээр огт санал нийлдэггүй. Нэгдмэл 1 хуультай гэхээсээ илүүтэйгээрээ яг энэ төрийн албан хаагчдын тоо, бүтээмж, чиг үүргийн давхардал дээр бид нар ерөөсөө яг бодитой алхам хийж чадахгүй байгаа байхгүй юу. Чиг үүргүүд нь давхардсан маш олон. Энийгээ бид нар яриагүй байж нэгдмэл 1 хууль гаргаагүй, эсвэл цалин хөлсийг тал талын өөрийн хуулиар явж байгаагаас болж байгаа гэж ерөөсөө яримааргүй байгаа юм. Энэ дээр та ямар бодол байна.

2 дугаарт өнөөдөр яг цахимжилтын асуудлыг дэмжиж байгаа боловч ямар бүтээмжүүд гарч байна гэдэг дээр та бас энэ нөхцөл байдалтай уялдуулж авч үзэж байгаа юм бэ. Төрийн албыг цомхотгох гэдэг бол амархан. Тэгэхдээ үнэхээр цомхотгож байгаа үндсэн шалтгаан нь яг юу гэж дүгнээд байгаа юм. Цахимжилтыг дэмжээд энэ нөхцөл байдлууд үүсэж байна гэж үзэж байгаа юм уу. Чиг үүргийн давхардал маш их болчихсон гэдгээ Засгийн газар хүлээн зөвшөөрч байгаа юу. Яг энэ нөхцөл байдлуудыг бас иргэд олон нийтэд бас байр сууриа хэлээч гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт энэ давхар төсөв энэ тэр гээд сүүлийн үед бас их ярьж байгаа. Гадаадын зээл тусламжийн үр ашгийг нэмэгдүүлэх хууль яриад эхлэхээр энэ бол давхар төсөвтэй болох тухай. Давхар төсөв чинь энэ төрийн өмчит компаниуд дээр жинхэнэ яваа шүү дээ. Өнөөдөр 60 мянган хүн тэнд ажиллаж байна. 120-оод компани ажиллаж байна. Бүх Монголын ард түмний баялгийг тэнд өмнөөс нь менежмент хийж байгаа боловч үр ашиг маш бага байгаа. Бараг эдийн засгийн үр өгөөжөөрөө 7,7 хувьтай л байгаа. Жилийн. 2023 оны үзүүлэлтийг л би ярьж байна л даа. Тэгэхээр энэ давхар төсвийн асуудал гэдэг юм уу, энийг төсвийн бодлоготой уялдуулах юм бол энэ төрийн өмчит компаниудын засаглал, менежментийг л хурдан сайжруулахгүй бол болохгүй. Тэгэхээр энэ жилийн төлөвлөгөө дээр бас юу гэж орж ирж байгаа юм бэ. Ярьсаар л байдаг. Яг энэ давхар төсөв ярьж байгаа боловч энэ хууль нь ерөөсөө явж өгдөггүй. Энийг хэдэн жилээр гацаагаад л байж байна л даа. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ.

Дараагийн нэг асуудал байна. Монгол Улс өөрөө хэрэглэгч. Тэгэхээр аль болохоор энэ хэрэглэгч эдийн засгийн хувьд бид нар төр, хувийн хэвшилгүй хэмнэлтийн бодлогууд л баймаар байна. Өөрөөр хэлэх юм бол энэ түрээсийн эдийн засгийг дэмжих. Өнөөдөр тендерт орох гэж байгаа аж ахуйн нэгж эсвэл тусгай зөвшөөрөл авах гэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага дээр заавал ийм тоног төхөөрөмж байна энэ тэр гээд тавьдаг. Тэр тоног төхөөрөмж нь зөвхөн зүгээр ажил эхлэх газар шорооны ажил дээр шаардагдаж байгаа байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Хариулт хангалтгүй бол тодруулж асуудаг зориулалттай дэгээрээ. Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Нүүрсний экспорт манай эдийн засагт их том байр суурьтай болчихсон. Он гараад өнөөдрийн байдлаар экспортын бүтээгдэхүүн болох нүүрсний маань үнэ 40 хувь буурчихсан.

Бид нар бол 5 хувиар гарцыг нь нэмэгдүүлэхийн төлөө зүтгэж байгаа. Өнөөдрийн байдлаар бол өнгөрсөн жилийнхээ экспорттой яг адилхан байгаа. Нөгөө биет хэмжээ. Тийм учраас биет хэмжээгээ нэмэгдүүлэх ийм зорилт байна. Яг үүнтэй уялдуулаад эдийн засгийн нөхцөл байдалд маш том сорилтууд ирж байгаа. Эрсдэл байна. Энэ эрсдэлийг давж гарах сорилтоо давж гарахын тулд даргын дэргэдэх зөвлөл дээр бид нар тодорхой ажлуудыг танилцуулсан, ярьсан. Алтаа яаж олборлох вэ гэдэг. Энэ дээр тодорхой шийдэл гаргая. Мөн төр, хувийн хэвшлийн түншлэл дээр боломж бололцоогоо бий болгоё. Энэ дээр тодорхой шийдэл гаргая. Биржийн хуулийнхаа асуудлыг нэг мөр шийдье. Ам нөхцөлөөр авдаг болгоё. Маш олон үйлдвэрүүд хаалгаа барьчихсан байгаа. Баяжуулах үйлдвэрүүд, боловсруулах үйлдвэрүүд өнөөдөр үйлдвэр байгаад байдаг ажиллаж чаддаггүй. Давхар татварын асуудал байна. Тэгэхээр энэ давхар татварынхаа асуудлыг шийдээд явъя. Дээр нь хөрөнгө оруулалтынхаа хуулийг яаралтай өргөн барья гэх мэтчилэн 10 байна уу, 11 бодлого билүү Амарбаясгалан дарга дээр ярилцаад, ерөнхийдөө энийг хэдүүлээ тал талаасаа дэмнээд явъя гэдэг ийм шийдэлд бол хүрсэн байгаа шүү гишүүн ээ.

Төрийн албыг бол таны хэлдгээр бүтээмжээр нь шийднэ. Давхардал байгаа. 1 ажлыг олон газар хийж байна. Цэвэр бүтээмж нөгөө талдаа бол цахим засаглал 2-ыг хэдүүлээ бүрэн дайчилъя л гэж байгаа юм. Цахимаар хийж болох үйлчилгээг заавал хүн суулгаад, дэмий цалин өгөөд, нөгөө зах зээл нь хүнгүй байна гэдэг зүйлийг манай хувийн хэвшлийнхэн хэлээд байгаа юм. Ажиллах хүн алга байна л гээд байгаа юм. Тэгээд тэр ажиллах хүмүүсийг нь бид нар төрийн албандаа бариад байгаа юм биш биз дээ гэдэг ийм зүйл байгаа учраас хэдүүлээ энэ цахим засаглалыг энэ ондоо багтаагаад бүр яг ингээд зургийг нь гаргаад тэгээд хувийн хэвшлээ дэмжээд явах нь зөв гэж, чиг үүргийн давхардлыг арилгах нь зөв гэж ингэж харж байгаа юм.

Төрийн өмчит компаниудын шинэчлэлийг хэдүүлээ хийнэ. Хийхээс өөр аргагүй. Ашиггүй байгаа өмчөө бид нар олон нийтийнх болгох нь зөв. Энэ дээр бол эргэлзэхгүй байгаа. Бүтээмжийг нь хэдүүлээ 30 хувь нэмэгдүүлнэ гээд огцом том зорилт тавиад, тал талаасаа шамдаад шахаад ажиллавал тодорхой үр дүнд хүрэх болов уу гэж ингэж харж байгаа. Нээлттэй байдлыг нь бий болгох хэрэгтэй юм байна лээ. Түрүүн хэлж байгаа тэр Хөрөнгийн биржээ дэмжихийн тулд манай энэ компаниуд Хөрөнгийн биржид .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайдад минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: Тэгэхээр энэ компанийн хуулиар Учрал сайд дээр нэлээн том судалгаа байгаа. Гарсан судалгаагаа олон нийтэд дэлгэх хэрэгтэй гэж бид үзэж байгаа. Олон нийтийнх болгох ёстой. Үүний дагуу арга хэмжээгээ авъя. Манай Амарбаясгалан даргын үед хийчихсэн судалгаа дөнгөж саяхан дууссан. Тэрийг олон нийт рүү ил болгох нь их чухал байна гэж харж байгаа. Худалдан авалтын хуулиа янзалъя гэж байгаа. Одоо худалдан авалтын хуулийг ойрын үед Учрал сайд эцэслээд, Их Хуралд өргөн барина. Энийг Их Хурал анхааралтайгаар хуралдаж, шийдэх хэрэгтэй. Тантай санал нэг байна. Өмчтэй бай, хатуу бай гэдэг зүйл бол өөрөө таны хэлж байгаа энэ түрээсийн элдэв эх үүсвэр ашиглах боломж бололцоог хумьж байгаа нь бодитой. Тэгээд тухайн хуулийг орж ирэхээр та бүхэн бас ажлын хэсэг дээрээ олон талаасаа яриад, асуудлаа шийдэх нь зөв гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Би асуултаа гялс гүйцээчихье. 1 минут байгаа учраас. Ер нь зүгээр эдийн засгийг төрөлжүүлэх гол салбар маань аялал жуулчлал, хөдөө аж ахуй болчихоод байна. Энэ чиглэлд ер нь ирэх онуудад юу хийгдэх вэ. Ямар бодлогын шийдвэрүүд гарах гэж байна. Ямар зүйл нь дутаад байгаа вэ. Энэ 2 дээр нэг салбарын сайдын хувьд хариулж өгөөч.

Ер нь түрээсийн эдийн засаг гэдэг дээр би юу хэлэх гэж байна гэхээр тусгай зөвшөөрөл болон тендерт оролцогч байгууллагууд дээр ийм ч тоног төхөөрөмжтэй бай, тийм ч юм гээд яахаар энэ байгууллагын зардлыг зардлыг өсгөөд байх шиг байна. Манайх шиг ийм жижигхэн эдийн засагтай орнууд дээр байгаа юмаа хуваалцаж явахын оронд ингээд 1, 1 байгууллагууд гаднаа бульдозертой болох шаардлага л гарчхаж байгаа байхгүй юу. Тэр нь бараг тэр ажлын 5, 10 хувьтай л хийгдээд л хаягддаг. Тэгэхээр ийм зүйлүүдийг бид нар яг бодлогын түвшинд цаашдаа засаад, хувийн хэвшил илүү зардал гаргах гэдэг юм уу, төр илүү зардал гаргахаас, Монгол Улс илүү зардал гаргахаас бас ангижруулах энэ түрээсийн эдийн засаг тал руу орооч. Жишээ нь магадгүй нэг жийп унаж байгаа хүн бол 4 дугуйгаа өвөл, зун сольж байгаа байхгүй юу. Магадгүй хувийн хэвшил өвлийн дугуйг түрээсэлдэг л байх юм бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Номин сайд хариулт өгье.

Ч.Номин: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Манай аялал жуулчлалын салбар бол сүүлийн 4 жилийн хугацаанд маш сайн тэлсэн салбаруудын нэг. Бид олон улсад Монгол Улсыг сурталчилснаар өнөөдрийн байдлаар аялал жуулчлалын өсөлт маань ковидын үетэй харьцуулахад 40 хувиар өссөн байгаа. Жил болгон 7-9 хувийн өсөлттэй явж байгаа. Бидний зорилт бол 2030 он гэхэд яг 2 сая жуулчин авна. Жилд 16 хувиар өсөж явна гэж үзэж байгаа. Энэ 2026 оны төлөвлөгөөний хүрээнд бол бид нар 1 сая жуулчин авч, 2 тэрбум долларыг эдийн засгийн эргэлтэд оруулна гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Хэдий тийм боловч манай яг энэ салбарыг эдийн засагт нөлөө үзүүлэх бүхий том зах зээл болгож хөгжүүлэхийн тулд бол бид нар хувийн хэвшил суурьтай хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Тэгэхээр 2 зүйлийн хөрөнгө оруулалт бол яг энэ салбарт оруулах шаардлагатай байгаа. 1 дүгээрт томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалт. Энэ дээр мэдээж тог цахилгаан, дээрээс нь .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Ер нь бол аялал жуулчлал дээр бид нар их ойлгомжтой баймаар байна. Хил орчмын аялал жуулчлалыг хэдүүлээ нээе.

2 дугаарт МИАТ-аа хэдүүлээ том болгоё. Чадвал IPO хиймээр байна. Бараг 100 сая долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй. Ингэж байж манай нислэг өөрөө хямдарна. Ингэж байж манайх руу хүн явдаг болно.

3 дугаарт яг аялал жуулчлал үзүүлж байгаа тэр кампуудын үйлчилгээг жоохон либералчилъя. Хэтэрхий хааж боосон зүйлс байна. Маш ойлгомжтой. Хөдөө аж ахуйн салбар дээр бол Энхбаяр сайд бид 2 их тодорхой зүйл ярьж байгаа. Тэр нь бол ноолуур. Ноолуураа гүрийж байгаад үнэд оруулъя.

2 дугаарт нь ноос. Ноосон дээрээ нэлээн чухал бодлого хийе.

3 дугаарт нь сүү.

Тэгээд 4 дүгээрт нь мах. Махаа бол Евро-Азийн зах зээл рүү энэ намар хүчээ үзэх. Тэгэхээр хөдөө аж ахуйгаас энэ жил хүлээж байгаа хүлээлт бол 1 дүгээрт ноолуур. Ноолуурынхаа экспортыг бид нар 500 сая долларт хүргэх..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэгээд энэ хөнгөн үйлдвэрийн салбар дээр Гантөмөр сайд аа, ер нь энэ мах, ноос, ноолуур, гурил гээд одоо энэ ард иргэдийн амин чухал хэрэгцээ хангадаг бүтээгдэхүүнүүд л болчхоод байна шүү дээ. Тэгээд энэ салбар маань өөрөө яг гар дээрээ бас бэлэн мөнгөтэй, мөнгөгүй янз янз л байна шүү дээ. Одоо ноолуур гэхэд л зөвхөн дотооддоо угааж самнадаг болгоё гээд л Засгийн газар нэлээн хатуу шийдвэр гаргаад л явахад тухайн салбарынх нь үйлдвэрүүд нь бүрэн худалдаж авах, дааж чадах хэмжээний санхүүжилт байхгүй. Тэгээд л цаг нь тулахаар төр 1 удаа асуудлыг нь шийдэж, мөнгө хэвлэж өгдөг хэлбэр шахуу л болох гээд байна шүү дээ. Тэгэхээр энийг дундын худалдааны компаниуд гэдэг юм уу, одоогийнхоор бол ченжүүдийн тогтолцоо байгаад байдаг. Энийг бас мэргэжлийн түвшинд тийм ачаа дааж чадахуйц хэмжээний өрсөлдөх чадвартай болгох бол бараг энэ төрийн нуруун дээр ирээд байгаа том ачааг шийдвэрлэх ганц гарц боломж талаасаа харагдаад байгаа шүү дээ. Тэгэхээр дотоодод ийм худалдааны компаниудыг байгуулж, иргэн үйлдвэрийг холбодог үүргийг төр биш, тэр худалдааны компаниуд хийдэг тэр тогтолцоог бүр боловсронгуй болгох чиглэл дээр яаралтай арга хэмжээ авмаар санагдаж байна.

Тэгэхгүй бол ерөөсөө яг л энэ салбаруудад зориулаад л гурилд жил болгон 100 тэрбум, ноолуурт жил болгон 500-600 тэрбум, маханд жил болгон 100-200 тэрбум гэж шинээр л хэвлэж мөнгө оруулаад байна шүү дээ зах зээл рүү. Тэгээд л энэ нь өөрөө төгрөгийн ханш унах үндсэн суурь нөхцөл болоод байдаг. Тийм ээ. Тэгэхээр энэ дээр ер нь нэг дорвитой арга хэмжээ авах тал дээр Засгийн газар ажиллах нь зүйтэй байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг та бид хэлэлцэж байна. 2026 он гэдэг бол та бид энэ парламентын бүрэн эрх талдаа орж байх тэр цаг хугацаа. Тийм учраас энэ бол бид юу хийж чадах вэ гэдгээ л ер нь нэлээн ихэвчлэх ийм л хөгжлийн бодлогын бичиг баримтын талаар бид ярьж байна гэж миний хувьд бол ойлгож байгаа.

Гэхдээ бас энэ 8 сард эхэлсэн 14 мега төсөл гэж цаасан дээр байсан энэ зүйл 20 жил улс төржсөн бизнесийн, улс төрийн бүлэглэлүүдийн дундах маш том тэмцэл дундуур явж ирсэн. Энэ Гашуунсухайтын төмөр замыг бас холбож чадсан. 14-ийнхөө 1-ийг эхлүүлж чадсанд би бас талархалтай байна. Тэгээд энэ том төслүүд хэрэгжих гэж нэлээн юм болдог юм байна л даа. Ер нь эцсийн шийдийг нь гартал л ер нь энэ Гашуунсухайтыг ярих болгонд л янз янзын асуудлууд бас сөхөгдөж гарч ирж байдаг юм байна. Тэгэхээр дараагийн 13 төслүүдээ бас амжилттай явуулах нь та бидний хувьд бол туйлын чухал гэж ингэж үзэж байгаа юм. Энэ хөгжлийн төлөвлөгөө дээрээс 4 асуулт байна.

1 дүгээрт энэ стратегийн ордуудыг ер нь ямар түвшинд зүгээр эргэлтэд оруулна л гэсэн ийм зүйл ярьж байгаа юм. Энэ нь 16 ордоо ярьж байгаа юм уу, нөгөө цаана нь 30 хэд байгаагаа ярьж байгаа юм уу. Энийгээ ер нь нэлээн тодорхой болгочихвол яасан юм бэ. Тэгээд энэ уурхайн салбар дээр ажиллаж байгаа компаниуддаа ч бодлого нь ойлгомжтой. Иргэддээ ч ойлгомжтой. Тэгэхээр би энийг

1 дүгээрт асуух гэж байгаа юм. Ер нь энэ Монголын өрх болгонд энэ эдийн засгийн өсөлтийг оруулахад уул уурхайн салбараас энэ боловсрол, эрүүл мэнд, орон сууц гэсэн энэ бодлого чинь л айл өрхийн хаалгаар хамгийн түрүүнд орох ийм л бодлого болж байгаа л гэж ингэж үзэж байгаа юм.

2 дугаарт нь Эрдэнэс Тавантолгойн хувьцаатай холбоотой ялангуяа төрд 1 сая төгрөгөөр өгчихсөн, 3 хуваагаад өгчихсөн гээд маш олон хүний гомдол байгаа. Энийг бас Засгийн газрын тэргүүн бол Хэрэг эрхлэх рүүгээ энэ асуудлыг судлаад, танилцуул гэдэг ийм чиглэлийг өгсөн. Энэ ер нь ямар түвшинд яваа вэ гэдгийг 2 дугаарт асууя.

3 дугаарт энэ татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлууд Засгийн газар бас өргөн барина гэсэн. Одоо ингээд энийг чинь зах зухаас нь 30, 40-үүлээ шүүрч аваад дундаас нь бага сага тийм косметик маягийн өөрчлөлтүүдийг өргөн барих гээд байгаа. Миний хувьд бол Засгийн газар бүр нэг өргөн бариад, үнэхээр татварын шинэчлэл болгож, тэр аж ахуйн нэгжүүдэд нь дэм болох, нийгмийн даатгалын шимтгэл, тэр хураамжууд нь яг ямархуу түвшиндээ байх юм. Энийгээ ер нь яг хэзээ өргөн барих юм бэ. Энэ дээр бүгдээрээ нэг тийшээ харна уу гэхээс биш энэ татварын бодлого, нийгмийн даатгалын энэ асуудлыг хэсэг гишүүд зүгээр барьж аваад ингээд яваад байх нь их айхтар тийм урт настай ч байж чадахгүй болов уу даа л гэж л ингэж бодоод байгаа юм. Гэхдээ Засгийн газар өргөн барина гэснээрээ энийгээ хурдан өргөн бариач ээ. Яг ямархуу юм өргөн барих гээд байгаа юм бэ. Энэ том төслүүд хэрэгжиж эхлэхээр бидэнд бас боломж гарна гэж ингэж бас танилцуулж байсан. Тэгэхээр энэ дээрээ бас ямар бодолтой байна.

Дээрээс нь хөдөө аж ахуйн салбартай холбоотой 1 асуудал байгаа. Бид хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг ноолуураас нь эхэлсэнд би жоохон сэтгэл дундуур байгаа. Яг малчдын хувьд бол ноолуур бол гараад л мөнгө олдог ганц юм нь байгаа байхгүй юу. Үнэхээр энэ салбарыг малчинтай байлгая, малтай байлгая гэж байгаа бол үнэтэй байж байгаад үнэгүй болчихсон арьс ширээс нь, ноосноос нь эхэлмээр байгаа юм. Тэгэхээр энэ дээр энэ хөдөө аж ахуйн ноолуур явдгаараа явчихлаа. Одоо дараагийнх нь энэ арьс шир дээр, ноосон дээр яг юу хийх гээд байгаа юм бэ гэдгийг нь би тодорхой бас хариулт авъя гэж ингэж бодож байна.

5 дахь нь бол яах вэ энэ нийгмийн үйлчилгээ хүн төвтэй гэж байна. Үнэхээр бидний явуулаад байгаа энэ үйлчилгээ бас яг тэр болгон сегментдээ хүрч чадаж байна уу, үгүй юу. Хүрэхийн тулд ямар их хүнд суртал, ямар их бухимдал, чирэгдлүүдийг дагуулж байна гэдгийг бас Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүний хувьд бол бас анзаарч л байна л даа. Сая ингээд групп гэж ярьдаг. Тэр асуудлыг ярихад л маш олон хүн мессеж бичиж байгаа шүү дээ. Хаа байгаа Ховдоос энд тэндээс .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лувсаннямын Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Ер нь уул уурхайн салбар дээр бол их ойлгомжтой бодлого гарсан шүү дээ. 2008 онд Стратегийн орд байна. Стратегийн орд бүс нутаг болоод улс орны эдийн засагт ийм ийм хэмжээтэй ордыг стратеги гэнэ гэж.

2 дугаарт Үндсэн хуульд өөрчлөлт орсон. Уул уурхайн баялгийн өгөөжийн 51 хувь бол Монголын талд байна гэдэг. Тэгэхээр энэ томоохон орд газрууд эргэлтэд

орохдоо Үндсэн хуулийн заалтыг бол гарцаагүй баримтална. Мөн стратегийн ордын тодорхойлолтод орж байгаа айлууд бол стратегийн орддоо хамрагдана. Үүний гадуур гарах боломж байхгүй гэж харж байгаа. Хэрвээ стратегийн ордын гадуур гаръя гэж байгаа бол стратегийн орд гэдэг тодорхойлолтыг өөрчлөх хэрэгтэй. Энэ тодорхойлолтод багтахгүй байгаа орд болгоныг бид нар татаж авчраад 34 хувийг нь авъя гэж зүтгэж бас болохгүй. Тэгэхээр тухайн орд газар дээр хийж байгаа дүн шинжилгээнээсээ шинжилгээ нь өөрөө үнэн бодитой байх нь хамгийн чухал байна. Тэгэхээр үнэн бодитой дүн шинжилгээ хийх чадамжийг манай уул уурхай яам өөр дээрээ бий болгох шаардлага байна гэж харж байгаа. Үүнтэй уялдуулаад ер нь уул уурхайн салбар дээр хийж уул уурхайн бүтээгдэхүүний баялгийн 51 хувь нь Монголд талд оногдож байгаа учраас цаашдаа татвар бол уул уурхайгаас бусад салбартаа бол хөнгөлөгдөнө гэдэг ийм логик аяндаа гараад ирж байгаа юм. Уул уурхайнхаа орлогоор ерөнхийдөө бид нар багш, эмч нарынхаа цалинг тавих юм байна. Цагдаа сэргийлэх, төрийн алба, үйлчилгээ. Бусад салбар нь нэн хөнгөлөлттэй буюу татварын маш эерэг орчныг өгч байж уул уурхайтай улсууд босоод байна л даа. Тэгэхгүй бол уул уурхайгаас бусад салбар нь бүдгэрчихээр тэр орон зай алга болчихоор улс орны эдийн засаг эрсдэл их өндөртэй байгаад байна.

Тийм учраас бол татварын шинэчлэл яаж хийгдэх вэ гэвэл уул уурхай ба бусад гэдгээр хийгдэнэ. Бусад салбар дээр бол нэн хөнгөлөлттэй татварын орчин өгнө. Зүгээр энийг өгөхийн тулд бид нар уул уурхайн өнөөдөр оруулж ирж байгаа мөнгөнийхөө хэмжээг баталгаатай харах гээд цаг алдаад байгаа юм. Жишээлбэл нүүрсний үнэ 80 доллароос хэт унахгүй байхад бид нар татварын шинэчлэлээ хийж болж байна. Яг боловсруулж байгаа шинэчлэлээр бол 3-4 их наяд төгрөг багасахаар байгаа юм. Татварын орлого тал. Тийм учраас 3-4 их наядыг багасгахад бид нар дааж гарах уу. Төрийн албаны реформ маань ийм зардлын хэмнэлт өгөх үү. Мөн нүүрс 70 доллароос доошоо унах юм бол бид яах вэ гэдэг зүйлээ бүтэн харж байгаад асуудлаа оруулж ирэх гээд байгаа юм. Манай гишүүд бол яарч байгааг бол мэдэж байна. Тэгэхдээ бид нар энэ зургийг бүтэн харж байгаад шийдвэр гаргахгүй бол тийм хөнгөн хуумгай шийдвэр гаргавал бид нар цалингийн асуудал дээр тулахаар байгаа шүү. Тэгэхээр энэ стратегийн ордууд, тэгээд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, татварын реформ 3 бол нийгмийн даатгалын шинэчлэл бүгдээрээ уяатай..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жадамбын Энхбаяр сайд нэмж хариулт өгье.

Ж.Энхбаяр: Ноолуурын байдал ноолуур бол Монгол Улсын дэлхийд өрсөлдөж байгаа гол хөдөө аж ахуйн гаралтай. Австрали ноолуур, Америк ноолуур, Орос ноолуур гэж байдаггүй. Монгол ноолуур л гэж байгаа юм. Тэгэхээр энийгээ бид нар боловсруулалтынхаа түвшнийг нь ахиулж, ноолуураас олох орлогоо, валютаа нэмэгдүүлэх бодлогыг Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа. Тэгэхээр энэ жил бол бид ноолуураа 100 хувь самнаж, экспортод гаргана. Ингэснээр түүхийг гаргаж байснаасаа 250 сая долларын нэмүү өртөг Монгол Улсад татвар, ажлын байр, ашиг болж үлдэнэ. Энэ бодлогоосоо ухрахгүй. Байгаа нөөцөө гаргаад, тодорхой хэмжээний эргэлтийн зээл гарсан. Монголбанк бодлогын хувьд маш сайн дэмжиж байгаа. Өнөөдрийн байдлаар нийт ноолуурын 55 хувийг үндэсний үйлдвэрүүд худалдаж авч чадсан байна. Одоо баруун бүс .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Баруун бүсийн 5 аймгийн ноолуур самналт эхэлж байна. Энэнд зориулж Монголбанкнаас өрийн бичиг салбарт гаргаж өгч, эхний ээлжийн 250 тэрбум төгрөгийн эх үүсвэр шийдэгдсэн. Арилжааны банкнууд холбогдох гэрээний ажилдаа ороод ажиллаж байна. Ингэснээр энэ жил бид сүүлийн 30 жил анх удаа үндэсний үйлдвэрүүд ноолуураа авч, экспортын буюу валютын нөөц бүрдүүлэх томоохон бололцоо бүрдэж байгаа. Ноос болон арьс шир дээр асуудал хүнд байгаа. Үнэхээр нэг хэсэг өндөр үнийг бий болгож, үндэсний үйлдвэрүүдийг унагаах ийм арга хэмжээ явагдсан. Энэтэй холбоотойгоор ноосны болон арьс ширний үйлдвэрүүд нэлээн хүндэрсэн хэдий ч Цагаан алт бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын бөгөөд эргэлтийн дэмжлэгүүд авснаар салбарын гүн боловсруулалтын чанар нэлээн нэмэгдэж байна. Евро-Азийн эдийн засгийн холбоотой байгуулах гэрээний үр дүнд манай хүйтэн бүсийн зах зээл уламжлалт ноос, арьс ширний зах зээл, мөн махны зах зээл ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Идэрбат гишүүн болсон уу. Тодруулж асууя.

Ц.Идэрбат: Гантөмөр сайд би бол яарах биш яг л таны энэ хариултыг л хүлээж байсан байхгүй юу. Энэ чинь биднээс татварын бодлого энэ юмаа бас нэг цонхоор хардаг энэ чинь бүхэл бүтэн улс шүү дээ. Тэгэхгүй зөвхөн өнөө маргаашийн юугаар ярьдаггүй юм л даа. Тэгэхээр энэ татварын асуудлууд ер нь нэг ул суурьтай орж ирэх нь гэж би харж байна.

2 дугаарт Эрдэнэс Тавантолгойтой холбоотой бас тэр хувьцааны асуудал байгаа юм. Одоо тэгээд бид уул уурхайн өгөөж ард түмэндээ очиж эхэлж байгаа энэ цаг үед энэ маргаантай асуудлыг нэг талд нь гаргаад явах нь хожмын хойчдоо бараг хэрэгтэй байх даа. Тэгэхгүй бол ингээд хаячхаад л яваад байдаг. Тэнд маш их хүмүүс бухимдалтай байгаад байдаг ийм зүйл байгаа.

Дээрээс нь тэр хүн төвтэй төрийн үйлчилгээ гэдэг дээр бас одоо байгаа энэ дүрэм журмуудаа хүнд нэлээн өгөөжтэй болгохгүй бол тэр уналт таталттай хүүхдийн юу байна. Тэр группийн хурлын асуудлууд байна. Олон юмнууд байгаа юм байна лээ шүү дээ.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг нэлээн танилцсан. Хооронд нь бас уялдуулж харах гээд оролдоод байна. Энэ 2026 он өөрөө бүрэн эрхийн хугацааны шийдвэрлэх жил. Энэ жилд хэдүүлээ уг нь гайгүйхэн суурь, зөв алхмууд хийчихвэл үр дүн нь 2028 онд арай ахиу гарах юм л гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ рүүгээ жоохон төвлөрмөөр юм шиг гэж 1.

2 дугаарт ер нь энэ хөгжлийн бодлогын болоод төлөвлөгөөнүүдийг бүх Байнгын хороогоор хэлэлцээд санал, дүгнэлт нь Эдийн засгийн байнгын хороо дээрээ ороод, тэндээ нэгдсэн дүгнэлт хийгдээд чуулган руу орж ирдэг дэгийн зохицуулалтыг бид хийх ёстой юм байна. Тэгж байж бид нарын гарах шийдвэрийн ач холбогдол, чанар сайжрах ийм бололцоо байгаа юм байна гэдгийг би зориуд хэлмээр санагдлаа. 2 дугаарт бид хэд 2025 оныхоо төсөв батлахдаа 2026 оныхоо төсөөллийг харсан л даа уг нь. Өсөлтөө 6,5, инфляцаа 5 энэ тэр гээд тооцсон. Одоо тэгээд 6 сарын дараа 2026 оны маань юм ороод ирэхээр өсөлт 6, инфляц 7 гээд

нэлээн өөр болоод ороод ирж байгаа юм. Үүний өөрчлөлт зүгээр тоо тавиагүй нь ойлгомжтой. Юунаас болоод байгаа юм гэдэг асуудал байгаа юм.

Уг нь бол эдийн засаг дээр тодорхой хэмжээний хүндрэл, уналт өгсөн үед дараагийн сэргэлт нь өндөр гардаг. 2024 онд бид хөдөө аж ахуй дээрээ нэлээн том уналт авсан хүмүүс. 2025, 2026 он дээр өсөлт арай өндөр л гарах ёстой гэж би бол төсөөлөөд байгаа. Энэ нь яагаад тэгж гарахгүй байна вэ. Энэ дээр хариулт авмаар байна.

2 дахь зүйл 2026 онд хэдүүлээ 5 их наядын улсын болоод орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай. 3,6-ийн гадаадын зээлийн ашиглалттай. 6 их наядын шууд хөрөнгө оруулалт татах хэлбэрийн асуудалтайгаар хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулжээ. Гэтэл зээл нь авагдахаар соёрхон батлагдчихсан, төсөл нь эхэлчихсэн, ашиглалтад орох хугацаа нь тодорхой болчихсон олон төслүүд байгаад байгаа юм. Төсвийн тусгай шаардлагаараа зохицуулагдаад зээлээ цаг хугацаанд нь бүрэн авч ашиглаж чадахгүй нөхцөл байдал үүсээд байгаа. 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд чинь энэ асуудлаа зохицуулахаар юу тусаж орсон юм бэ гэдэг асуудал байна.

Миний ойлгож байгаагаар Хөгжлийн банкаа босгож ирж байж, өөрөө өөрийнхөө үйлдвэрлэл гэдэг юм уу, үйл ажиллагаагаар зээлээ буцаагаад төлчихдөг тийм төслүүдийг үүгээрээ дамжуулмаар байна. Энэ дээр юу бодоод байна вэ гэж.

2 дугаарт нөөц хязгаарлагдмал байхад 1 хэсэг хөрөнгөө баялгийн сан дээр аваачиж тавьчихаад яг нарийндаа өгөөж ч тооцуулахгүй хэвтүүлээд байгаа юмаа яаж эргэлтэд оруулъя гэж бодоод байгаа юм бэ. Зарим сангуудын шүү. Бүгдийг нь гээгүй байна. Энэ талаар 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд ер нь юу багтаж оров гэж. Үгүй ээ, үнэхээр нөөц хязгаарлагдмал, байдал амаргүй байгаа юм бол шинэ юм гэхээсээ илүү хуучнаа сэргээвэл яасан юм. Баахан суурилагдсан хүчин чадал байдаг. Ашиглалт муутай. Жишээ нь гурилын үйлдвэрээ хар 850 мянган тонн будаа тээрэмдэх хүчин чадалтай. Гэтэл өнөөдөр бид 200000-ыг тээрэмдэж байгаа. 25 хувь ашиглаж чадаж байгаа юм уу, үгүй юм уу. Энийг яаж ашиглалтыг нь нэмэгдүүлэх юм. Яаж энийг дамжсан бүтээмж бий болгох юм. Ажлын байр бий болгох юм. Цемент мөн ийм. Одоо тэр уул уурхайн угаах, баяжуулахууд бүгд ийм. Үгүй ээ, энэ тал дээр хэдүүлээ том судалгаа хийж, том дүгнэлт гаргаж, эрх зүйн зөв зохицуулалт хийхгүйгээр явахгүй нь. Үүнийг та хэд маань юу гэж харж, юу гэж төсөөлөөд байна вэ гэдэг ийм зүйл байна. Дараа нь баталгаат нөөцүүдийг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Батжаргал гишүүний асуултад хариулъя. 2026 он чухал он жил. Бидний 4 жилийн энэ хөтөлбөрөө хэрэгжүүлэх хамгийн чухал сонгуульгүй, улс төржихгүй, талцахгүйгээр ажил хийж болох ийм он жил байгаа. Тийм учраас 2026 онд их олон реформыг хэдүүлээ бас хамтдаа хийе гэж уриалмаар байгаа юм. Тийм учраас бид нар бол бүгдийг нь биш чухлыг гэдэг ийм зорилготойгоор оруулж ирж байгаа юм. Яамнуудаас 900 орчим санал ирсэн. Ер нь энэ үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулмаар байна гэж. Тэгэхээр бид бол Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг харж байгаад 300 саналыг нь сонгож аваад, 600 саналыг бол буцаасан байгаа. Нэг үгээр хэлбэл чухлыг нь. Тэгэхээр таны хэлж байгаагаар бүх Байнгын хороодоор ороод энэ хэлэлцүүлэг явах юм бол дахиад зах замбараагүй олон санал орж ирэх магадлалтай. Байнгын хороод бодлогын

шийдлүүдээ Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрийг харж байгаад өөрийн харьяалагдаж байгаа Байнгын хорооныхоо бодлогын шийдлүүдээ Эдийн засгийнхаа байнгын хороонд хүргүүлэх нь бол зөв. Хуралдаад ирэх жил бол бид энийг онцолж байна. Онцолж энэ бодлогыг хэрэгжүүлэхийг шаардаж байна гэдэг энэ хэлбэрийг сонгох нь зөв гэж харж байна.

2026 онд тоо хөдөлж байгаа нь ямар учиртай юм бэ гэж. Ер нь бол дэлхийн худалдааны дайн хаа хүрч байгааг бүгдээрээ харж байгаа. Өнөөдөр Америкийн портууд хоосорсон. Хятадын порт хоосорсон. Үндсэндээ бол гангийн үйлдвэрлэлийн шилжилтийг Америк өөр лүүгээ бүрэн хамж байна. Манай гол нэрийн барааны бүтээгдэхүүний үнэ бол 40 хувиар унасан. Бид нар бол оны өмнө ингэж тооцоолох боломж байхгүй. Худалдааны дайныг ийм богино хугацаанд ийм өндөр түвшинд хүрнэ гэж тооцоолох боломж бидэнд байхгүй. Ер нь бол ковидын цар тахлын үеийн тодорхойгүй нөхцөл байдлын индекс өнөөдөр яг тэр түвшинд хүрсэн. Нэг үгээр хэлбэл дэлхий нийт тодорхойгүй болсон. Хэдүүлээ манай улс бид бүхэн их тодорхой, тавьсан зорилтынхоо араас нэхэл хатуутай, ажил хэрэгчээр, ил тод, хариуцлагатайгаар ажиллах нь зөв л гэж бид нар харж байгаа юм.

Тэгэхээр зээлийн шугамыг та Хөгжлийн банк дээрээ ав гэж байна. Энэ бол зөв. Удахгүй бид нар Хөгжлийн банкны хуулийг оруулж ирнэ. Гол нь тэр авсан мөнгө бол ямар нэгэн улс төрийн захиалгагүйгээр үнэхээр зах зээл рүүгээ нийлүүлэгддэг байх. Тэр банкных нь хуулийг хэдүүлээ хийгээд өгчихмөөр юм байна лээ. Тэгэхгүй бол улс төрийн нөлөөнд орох юм бол тодорхойгүй санхүүжилтүүд гараад дангаараа ямар нэгэн төсөл санхүүжүүлээд явах юм бол Хөгжлийн банк өмнө нь давтсан алдаагаа дахин давтах магадлалтай. Мөн экспортыг дэмжих таны хэлж байгаа энэ суурь хүчин чадлаа нэмэгдүүлье гэж байгааг бол санал нэгтэй байна. Энэ хүчин чадлыг, жишээлбэл бид бүх гурилын үйлдвэрээ бүтэн хүчин чадлаар нь ажиллуулахад тэр гурилыг хаана зарах вэ гэдэг асуудал байгаа. Тийм учраас гадаад харилцааг эдийн засагжуул.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: Тэгэхээр Лувсанжамц гишүүний түрүүн гаргасан гадаад харилцааг индексжүүлье. Хэмжих нэгжтэй болгоё гэж байгаа нь бол бид чадаж байгаа зүйлээ аль улс оронд зарах вэ гэдэг дээр онцгой бодлого гаргаж, тэр зах зээлийн нэвтрэлт хөрөнгийн таталт 2 дээр бид нар төвлөрч ажилламаар юм байна лээ. Таны хэлдгээр гурил гаргаад ирэхэд бидэнд зарах газар зөндөө байгаа байхгүй юу. Гэтэл гурилын чинь буудай нь ч гэсэн хажуу оронд ингээд хямдхан байгаа. Энийг ашигласан үйлдвэрлэлийг яг яаж бий болгох вэ гэдэг дээр Энхбаяр сайд онцгойлсон бодлого гаргаж хөтлөх нь бол зөв гэж харж байгаа.

Баялгийн сан дээр бид нар шинэ бодлого гаргана. АМНАТ гэхээр ард түмэн ойлгохгүй юм байна лээ. Тэгэхээр баялаг ашигласны төлбөр гэж нэрлэх нь зөв гэж байгаа юм. Баялаг ашигласны төлбөрийг одоо цаг, маргааш, ирээдүй гэсэн ийм 3 цаг дээрээ жигд хуваах нь зөв байна. Тэгэхгүй бол ихэнхийг нь хадгалаад байдаг. Яг .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм юмнуудаа нэлээн бодмоор байгаа юм. Одоо Ирээдүйн өв сан гээд хэдүүлээ ярьж байгаа юм. Үгүй ээ, ер нь юу гэсэн үг юм гэж. Монголын

хөгжлийг ахиулах тухай ойлголт юм уу, ирээдүйд гарах хүнд хадгалах гээд байгаа зүйл юм уу. Тэгвэл ирээдүйд гарах гэж байгаа хүнд хадгалж байгаа бол гарсан хүүхэд хуримтлалын суурь мөнгөтэй, хуримтлалын сан руугаа орох ёстой. Тийм зохицуулалт байхгүй байгаа. Тэгэхээр би ирээдүй рүүгээ, хөгжил рүүгээ авч ашиглах гэж байгаа юм байна гээд Ирээдүйн өв сангийн тодорхой хэсгийг Хөгжлийн сан руугаа татдаг байх ёстой юм. Тэгж байж энэ Монголыг хөгжүүлмээр байна гэж. Жишээ нь үүнийг ер нь юу гэж төсөөлөх юм хэдүүлээ. Төрийн өмчит компаниудын үр өгөөжийг дээшлүүлбэ гээд хэдүүлээ нэлээн яриад байгаа юм.

Засаглал, менежмент, хариуцлага, бүтээмж, үр дүнгийн тухай л ойлголт л доо. Үүнийг шуурхай хийхгүйгээр бид явахгүй байна. Энэ дээр зоримог яг ингээд хийе гэдэг юмаа оруулаач ээ. Тийм тодорхой өгүүлбэр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Ер нь төрийн өмчийн компани дээр хамгийн их анхаарал татаж байгаа газар Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой. Бид нар бол бүгдээрээ л мэдэж байгаа. Энэ хоёрынхоо менежмент дээр гадаад хүн авъя л гэдэг ийм байр суурьтай. Одоо 6 сар боллоо. Авч чадахгүй байна бодит байдал дээр. Тэгэхээр энэ сонгон шалгаруулалтыг яаралтай эхлүүлэх хэрэгтэй. Ер нь энэ гадаад хүн ямар нэгэн монголчууд цөөхүүлээ байна шүү дээ. Танил байгаад байна. Тэгэхээр хардалт үүсээд байна. Хээл хахуулийн асуудал үүсээд байна. Үүнээс болоод компанийн өгөөж гэдэг юм унаад байна л гэдэг ийм зүйл байгаа юм.

2-т нь ер нь энэ төмөр зам, Эрдэнэт 2-ын энэ нийгмийн асуудлыг шийддэг бодлогыг бид нар яах юм бэ гэдэг асуудал байгаа юм. Энэ 2 компани ашиг олох, компаниа хөгжүүлэхээс илүүтэйгээр нөгөө соёлын төвөө яах вэ, цэцэрлэгээ яах вэ, нөгөө урлагийн заалаа яах вэ гэдэг дээр асар их зардал гаргаад байдаг. Энийг нь жишээлбэл Засгийн газар бид авъя. Та бүхэн бол яг энэ технологийн хөгжилт дээрээ анхаар. Төмөр зам өөрийнхөө тээвэрлэлт дээр анхаар гэдэг ч юм уу ийм .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Нэлээн олон саналууд давхцаж байгаа учраас шууд асуучихъя. Оршилгүйгээр. Төрийн өмчийн хувьцаат компаниудын зардлыг 15 хувиар бууруулаад, бүтээмжийг 30 хувиар нэмэгдүүлнэ гэсэн байна. Яг яаж. 1 жилийн дотор. Бид нар зөвхөн 1 жилийн хөтөлбөр ярьж байгаа шүү. 2026 оны. Энэ дээр байгаа бид нарт өгсөн тараасан материалын 3.5.1 дээр нүүрс хими, кокс химийн цогцолборыг ашиглалтад оруулах гэчихсэн байгаа юм. Оруулах шүү. 1 жилийн дотор бид нар нүүрс хими, кокс химийн үйлдвэр барьж чаддаг тийм супер улс болчихсон билүү. Мөн энэ дээр 3.5.1.5 дээр гангийн цогцолборыг ашиглалтад оруулах гэчихсэн байгаа. Ерөөсөө дандаа оруулах гэчихсэн шүү. Тэгэхээр дуусна гэсэн үг. Тэгээд ийм хэмжээний ийм том 2 төслийг бид нар 1 жилийн дотор хийж чаддаг болчихсон юм байна. Дараа нь дахиад Боловсролын яамны 22 төсөл хөтөлбөр байгаагийн 3-ыг нь гадаадын зээлээр санхүүжүүлнэ гэчихсэн байгаа юм. Боловсролын яамны 22 төслийн 3-ыг нь. 2.2.1.4 дээр үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ. 2.4.1.3 дээр үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ. Яг адилхан нэртэй, төсөвтэй. Тэгээд гадаадын зээлээр хэрэгжүүлнэ гэчихсэн. Түрүүн тэр ашиглалтад оруулах гээд байгаа нөгөө гангийн цогцолбор маань, кокс химийн үйлдвэр маань өнөөдөр жишээ нь хэмжих нэгж нь байхгүй.

Суурь түвшин нь байхгүй. Зорилтот түвшин нь байхгүй. Санхүүжилт нь байхгүй. Тухайн жилд зарцуулах мөнгө нь байхгүй. Зээлд нь санхүүжилтийн эх үүсвэр нь байхгүй. Бүр огт байхгүй, бичээгүй энэ дээрээ. Тэгээд ашиглалтад оруулах гээд оруулах гэж оруулна гэсэн үг шүү дээ. Бид нар 2026 оны 12 сарын 31-ээс өмнө бид нар нүүрс химийн үйлдвэртэй, кокс химийн үйлдвэртэй болох юм байна л даа. Бас гангийн цогцолбортой. Энэ дээр л би 1 асуулт асуух гэсэн юм. Тэгээд Аж үйлдвэрийн яам, Боловсролын яам 2-оос уг нь.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Өнөөдөр бол 2025 оны 5 сарын 16 билүү 17. Тэгэхээр бид нар 2026 оны төлөвлөлтийг ярьж байна гэдэг бол 2026 оны 12 сарын 31-ийг хэлж байгаа юм. Тэгээд энэ хооронд 1 жил 7 сарын хугацаа байна. 1 жил 7 сар гэдэг бол 19 сар аль ч үйлдвэр хамгийн уртдаа 22 сарын хугацаанд ордог. Зөв төлөвлөж чадах юм бол. Тийм учраас энэ коксын үйлдвэр бол орно. Орохгүйгээр бид нар энэ утааны асуудал шийдэж чадахгүй. Энийг бол хүчээр оруулна. Бид нар гангийн үйлдвэрээ оруулна. Орохгүй бол бид нар энэ 150 мянган айлын орон сууцын үндэсний хөтөлбөр ажил болохгүй. Бүгдийг нь гаднаас нөгөө арматураа гаднаас авах ажилтай байна. Тэгэхээр манайд ажлын байр бий болохгүй байхгүй юу. Тийм учраас энэ 2 зорилтыг жоохон өндөр түвшинд тавьж байгаа шүү Шижир гишүүн ээ. Тэгээд ингээд тавиад л зүтгүүлнэ. Энэ зундаа эзэнтэй болгох тухай л асуудал байгаа юм. Энэ намар гэхэд тодорхой болгох. Жишээлбэл зэс хайлах үйлдвэрийг ч гэсэн бид нар энэ жилдээ багтаагаад хөдөлгөх. Одоо 3 том төсөл байна. Кокс химийн төсөл байна. Зэсийн үйлдвэр байна. Гангийн үйлдвэр байна. Энэ дээр нэгнийгээ хардаж сэдэлгүйгээр нээлттэй зарлаад, олон улсын багийг гаднын хөрөнгө оруулалттай оруулж ирэх л асуудал байгаа. Тогтвортой байдлыг нь бид нар амлах л асуудал. Тэгээд яваандаа гангийн үйлдвэр нь Дарханы үйлдвэр лүү шилжих, Зэсийн үйлдвэр нь Эрдэнэтийн бүрэн мэдэлд очих, нөгөө кокс химийн үйлдвэр нь Эрдэнэс Тавантолгой Эрдэнэс MGL-ийн мэдэлд очих гэдэг. Ерөөсөө зураг нь бол энэ. Тийм учраас энэ 3 дээр бол ТЭЗҮ нь бол бүгд хийгдчихсэн, хийгдэж байгаа, эцэслэгдэж байгаа ийм төслүүд учраас би дуусгах гэдэг зорилго тавих нь бол хэрвээ коксын үйлдвэрээ бид нар дуусгаж чадахгүй бол тэгээд утаа хэвээрээ. Тэгвэл бид ард түмний нүүрийг яаж харах юм. Ард түмний өмнө очих эрхгүй болно. Тийм учраас бол энийг зайлшгүй шахаж, тал талаасаа хүчээ гаргаад явах нь зөв гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Энэ төлөвлөгөө чинь батлагдаад намар улсын төсөв дээр бодвол зардлууд нь суух байх л даа. Тэгээд зардал нь гараад ирэхээр 2026 оны эхний улиралд гарна. Тэгэхээр 10 сарын хугацаанд л бид нар 2026 оны 12 сарын 31 гэдэг чинь 10 сарын хугацаанд л 2 том үйлдвэрийн нээлтийг л бүр ажиллуулж эхлээд л нээлтээ хийх юм байна гэж ойлголоо. Тэгээд хугацаагаа бас бодитой хэрэгжихүйц тавьдаг байхгүй бол байнга хэлээд байгаа шүү дээ. Бид нар нэг ийм гоё гоё цаас хийдэг л болчихлоо. Тэгээд ингээд ярихаар нэг талаасаа Засгийн газрын үйл ажиллагааг нь эсэргүүцээд байгаа юм шиг хандлага төрүүлээд, уг нь бол тийм биш шүү дээ. Аль болох л бид нар энэ төслүүдийг нь бүгдийг нь явуулчихъя гэж байна. Тэгээд сая бас тэр Боловсролын яамнаас асуусан асуултад хариулт авсангүй. Төрийн өмчийн компанийн юмыг яг яаж гэдгээс бас хариулт авсангүй. Тэгээд асуултдаа бүрэн авдаг болчихвол бид нар бас үр дүнтэй ярилцдаг болохгүй бол ингээд асуусан, хариулсан бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. 4 дүгээр индэр.

Б.Цэнгэл: Шижир гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид бүтээмжийг 30 хувиар өсгөж, зардлыг 15 хувиар бууруулна гэсэн ийм нэлээн өөдрөг зорилт дэвшүүлж байгаа. Төрийн өмчит компаниудын зардалд бол 16,9 их наяд байгаа. Энийг 15 хувиар бууруулахад бид 2,5 их наядыг бууруулна гэж төлөвлөж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл зардлыг 14,9-14,3 руу оруулна. Энийг бол бололцоотой гэж төлөвлөсөн.

Төрийн өмчит компаниуд бол үндсэндээ 5 их наядын ашигтай ажилласан. Энийг бүтээмжийг 30 хувиар өсгөнө гэвэл 6,5 их наяд болгох ийм тооцоо судалгаа гаргасан. Ер нь бүтээмж өөрөө бол нэлээн өргөн ойлголт. Энийг яг базаад хэлэх юм бол 4 арга хэрэгслээр бид нар энийг 30 хувийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэнгэл дарга гүйцээж хариулъя.

Б.Цэнгэл: Техник технологийн шинэчлэлтийг хийнэ. 2 дугаарт төрийн өмчит компаниуд дээр засаглалын реформыг хийхээр төлөвлөж байна. Нөгөө 3 дахь асуудал нь бол төрийн өмчит компаниудын хүний нөөцийн бодлогыг бол зайлшгүй эргэж харах шаардлага байж байгаа. 4 дэх гол асуудал нь бол зардлыг хэмнэж, үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр ерөнхийдөө шаардлагагүй зардал орон тоог бол багасгах гэсэн ийм цог 4 арга хэмжээг авч хэрэгжүүлсний үндсэн дээр ер нь хөрөнгийн өгөөжийг 30 хувь руу хүргэх бололцоо байж байгаа. 2022 оноос авч хэрэгжүүлсэн үр дүнд бол 135 компанийг 106 болгосон. Бид ирэх жилд компаниудын тоог бол 70 хүртэлх хувиар бууруулах ийм төлөвлөгөө гаргаж ажиллаж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Хурлын дарга аа, нөгөө асуултдаа хариулт авахгүй болохоор миний 2 тодруулга ингээд хоёулаа байхгүй болчхоод байна л даа. Одоо тэр Боловсролын яамны 2026 оны 22 төсөл хөтөлбөрөөс 3 хөтөлбөр байна. Үүний 1 нь үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ. Гадаадын зээлээр гээд яг адилхан нэртэй 2 хөтөлбөр байна. 1 нь 2.2.1.4 дээр, 1 нь 2.4.1.3 дээр. Тэгээд энэ яг ямар заалтууд юм бэ. Яагаад.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Батжаргал Төрийн нарийн. 4 дүгээр индэр.

Х.Батжаргал: Шижир гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал. Тэгэхээр 2026 оны төсвийн жилийг боловсролыг дэмжих жил болгон Засгийн газраас зарлаж байгаа. Тэгээд энэ хүрээнд бол үе шаттай ажлууд бэлтгэл ажил хангагдаад явж байна. 2028-2030 оны түвшинд бол хүн амын динамик өсөлт сургууль, цэцэрлэгийн хэрэгцээ хамгийн өндөр түвшиндээ хүрэхээр ийм судалгааг бас Дэлхийн банкнаас гаргаад, судалгаагаа хийгээд санхүүжих зээлийн төслөө бас боловсруулаад ажиллаж байгаа. Тэгэхээр үндсэндээ бол энэ зээлийн төслүүд бол сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, тэр дундаа бас давхар боловсролын чанарыг сайжруулах, хот, хөдөөгийн боловсролын ялгаа, тэгээд Улаанбаатар хотод байгаа бас өндөр үүссэн байгаа хэрэгцээ, бүлэг дүүргэлт, чанар стандартыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төслүүд байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Шинэ Хархорин хот, Хүннү хотыг бүтээн босгоно гээд бид нар чинь ярьж байгаа. Тэгэхээр 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд энэ 2 хот руу чиглэсэн хөрөнгө оруулалт, бодлогын ямар арга хэмжээнүүд хийгдэх вэ. Ер нь хөрөнгө оруулалтаа энэ 2 хот дээр яаж шийдэх юм бэ. Удахгүй Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль орж ирэх юм шиг байна. Тэгээд хувийн хэвшилд бол боломж байгаа гэж би харж байгаа. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, хувь хүмүүс бас хөрөнгө оруулалт хийх, хадгаламжтай боломжтой бас нөөцтэй ийм байна. Тэгэхээр энэ хувийн хэвшлийнхээ нөөцийг хэзээ ашиглаж дайчлах вэ.

Ер нь хот хөдөөгийн хөрөнгө оруулалтын зөрүү их болж байна. Одоо сүүлийн жилүүдэд бол Улаанбаатар хот буюу энэ нийслэл дагуул хотууддаа л хөрөнгө оруулалт хийх тухай маш их ярьж байна. Гэтэл хөдөөд мөн бүсийн төвүүд, аймгийн төвүүд дээр томоохон хэмжээний дорвитой хөрөнгө оруулалт хийгдэхгүй байна. Тэгэхээр хотод хөрөнгө оруулалт их хийгдээд байх тусмаа л хүн амын төвлөрөл, хүн амын суурьшил хот руу их болоод байна. Тэгэхээр бид нарын бодлого чинь хөдөө нутагтаа аятай тохитой амьдрах таатай орчныг бий болгож байж л энэ улсын хөгжил энэ өргөн уудам нутагтаа тархан суурьшиж бид нар чинь нутагтаа эзэн болж амьдарна шүү дээ. Тэгэхээр энэ хот, хөдөөгийн хөрөнгө оруулалтын зөрүүг яаж тооцох вэ.

Дээр нь энэ Хөшигтийн хөндийд төмөр зам барьж эхэлсэн байгаа Багахангайгаас. Тэгээд энэ жил 10 сард ашиглалтад орно гэж байгаа. Энэ төмөр замын хөрөнгө оруулалт хаанаас гарч байгаа юм бэ. Төр хувийн хэвшилд түншилж байгаа юм уу. Ийм богино хугацаанд төмөр зам барьж чадаж байна гэдэг чинь нэлээн л хөрөнгө оруулалтын таатай орчинтой, хөрөнгө оруулалтаа сайн татсан болоод л хийж байгаа байх. Тэгэхээр ер нь сүүлийн жилүүдэд хараад байхад Монгол Улсад энэ төмөр зам барих болохоор мөнгө олдоод, төмөр зам дээр их хөрөнгө оруулалт орж ирээд байх юм. Тэгээд бусад салбарт, бусад томоохон эрчим хүч, цахилгаан дулаанчид юм уу томоохон юман дээр хөрөнгө оруулалт татах гэхээр хөрөнгө оруулалт байхгүй. Эсвэл орж ирсэн хөрөнгө оруулалт нь саатчихдаг. Одоо тэр 10 аймгийн дулааны станцаас өгсүүлээд ашиглалтад ороогүй байж байж хүү төлөөд явж байх жишээний ийм зүйлүүд байна.

Төгсгөлд нь тэр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг удахгүй Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирэх юм шиг байна. Тэгээд энэ хууль дээр ямар бодлогын дорвитой өөрчлөлтүүд хийх юм бэ. Ер нь бол би олон удаа хэлж байгаа. Хувийн хэвшилд хөрөнгө оруулалт хийх боломж нөөц байна. Монголчууд сая сүүлийн 1 сарын статистикаар гэхэд 22 их наядын хадгаламжтай байна гээд Монголбанкны статистик байна. Тэгэхээр энэ нөөц боломжууд байна. Мөн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд чинь бас гадна дотноос зээл, хөрөнгө оруулалт татах, зээл авах гээд олон боломжууд байна. Тэгээд энэ болгоныгоо хэрхэн зохицуулж бид нар энэ улс орныхоо дэд бүтцийн бүтээн байгуулалтыг босгож ирэх юм бэ. Ер нь ийм өргөн уудам нутагтай манайх шиг улс орон дэд бүтцийн бүтээн байгуулалтаа онцгой анхаарч, энэ чиглэл энэ дэд бүтцээ босгож ирэхгүйгээр бид нар энэ Монгол хүн Монгол нутагтаа сайхан амьдрах, аятай тухтай амьдрах орчин нөхцөл бүрдэхэд бол хол байна. Тийм учраас энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээрээ бас онцгой анхаарч ажилламаар байна.

Д.Амарбаясгалан: Гантөмөр дарга асуултад хариулъя. Ер нь Батжаргал гишүүний түрүүн хэлсэнчлэн энэ хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээг голлох Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодоор бүгдийг нь хэлэлцүүлэх ийм үүрэг даалгаврыг бол Их хурлаасаа өгнө. Тэгэхээр ирэх 7 хоногт ажлын хэсэг ч байгуулагдана. Бүх Байнгын хороодоор орж энэ асуудал яригдана. Өнөөдөр бид хэлэлцэх эсэх асуудлаа хэлэлцэж байгаа. Зарчмын зөрүүтэй саналууд болон бусад хөтөлбөр төлөвлөгөөнд оруулах өөрчлөлттэй холбоотой саналуудыг гишүүд ирэх 7 хоногт нээлттэй гаргаж хэлэлцэх боломж бүрэн байгаа шүү. Энэ дээр бас давхар сануулаад хэлчихье. Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Хархорин хотоо хэдүүлээ сэргээн байгуулна. Гол нь хот маань ямар ид шидтэй хот байх вэ гэдэг концепцын асуудал яригдаж байгаа. Тэр бол эцэслэгдээд гарах учиртай. Ингэж байж олон нийт олон хөрөнгө оруулагч нар тийшээгээ нөгөө концепц руу нь очдог. Эдийн засгийн чөлөөт бүс байх юм уу, санхүүгийн чөлөөт бүс байх юм уу, аж үйлдвэрийн тусгай бүс байх юм уу, аялал жуулчлалын онцгой бүс байх юм уу, кино үйлдвэрлэлийн бүс байх уу гээд их олон зүйл яригдаж байгаа. Энэ ойрын үед шийдэл нь гарчихна.

3 зүйлийг бол хувийн хэвшлээрээ хийлгэнэ. Хамтарсан төсөл. Эрчим хүчний асуудал байна, дулааны асуудал байна, цэвэрлэх байгууламжийн асуудал байна. Ерөнхий төлөвлөлтөө хийгээд, Олон улсын нисэх буудлын асуудал байна. Энийг манайхан ингээд төсвийн хөрөнгөөр хийнэ гээд зөрүүдлээд байгаа л дутагдал байна. Одоо яг үнэнийг хэлэхэд. Үгүй ээ төсвийн хөрөнгөөр хийхээр л захаас нь тэр дунд түвшний мэргэжилтнүүд нэг юм хазчих гээд оролдоод байдаг. Хувийн хэвшилд энэ 4 эх үүсвэрээ өгчих юм бол энэ хот бол зүгээр дуугүй босоод ирнэ. Тэгээд гол нь энэ хот бол ирээдүйн ногоон хот болно. Ногоон хот болох учраас моджуулах, ойжуулах ажлаа эхлээд санаачлаад хийгээд явж байна. Тэрбум модны гол санхүүжилт, цаашдаа хөдөлгөөн бол энд эхний 1 сая модыг бол ойрын үед хүлээж авна гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Тэгэхээр энэ дээр асуудалгүй явна. Тантай санал нэг байна. Хувийн хэвшлээ дайчлах нь зөв. Хувийн хэвшилдээ таарсан газрыг нь дэд бүтцийг нь шийдэж өгөөд, гол нь энэ болгоныг хуваарь хийлгэгчхээч гэхээр л хаа нэг газраас орж ирээд, төсөв рүү ормоор байна л гэх юм. Энэ алдааг Хархорин, Хүннү 2 дээр давтмааргүй байна. Төсвийн хөрөнгөөр энэ 2 хотод хөрөнгө оруулаад, хот болгоно гэдэг бол үлгэр. Бидэнд тийм төсвийн нөөц байхгүй. Тэгэхээр энэ цэвэр дулаан, цахилгаан дамжуулах бүх эх үүсвэрүүдээ бид нар хувийн хэвшлийн үйлчилгээ дээр суурилж явна гэдэг ийм шийдэл гаргаад, тэгээд 2 хот маань өөр өөрийн гэсэн концепцтой байхад бол босоод ирнэ гэж харж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс Нийслэлийн Засаг даргын орлогч хариулт өгье.

Т.Даваадалай: Гишүүний асуултад хариулъя. Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай. 2026 онд Улаанбаатар хотын дагуул хотуудтай холбогдолтойгоор 3 төсөл арга хэмжээ улсын төсвөөр суусан байж байгаа.

1 дүгээрт Налайхын барилгын материалын үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийн ажлыг үргэлжлүүлэх ажил байна.

2 дугаарт нь бол тархмал дулааны эх үүсвэрүүд дээр Хүннү хот дээр дулааны тархмал эх үүсвэрийг гүний дулаанаар шийдэхээр ажил бол төлөвлөгдсөн.

3 дугаар ажил дээр болохоор Багануур үйлдвэр технологийн паркийн цахилгаан хангамжийн үндсэн дэд станцыг барих гэсэн ийм 3 ажил төлөвлөгдсөн байна.

Хүннү хотын хувьд болохоор эрчим хүчийг бас сэргээгдэх эрчим хүчээр шийдвэрлэх гээд төр, хувийн түншлэлээр хэрэгжүүлэх гээд ТЭЗҮ-ийн ажил хийгдэж байгаа. Гүний дулаан дээр хэлсэн. Цахилгааны шугам хоолой болон цэвэр усны байгууламж, далангийн ажил хийх 7 төрлийн инженерийн дэд бүтцийн ажлууд энэ жил 70 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хосбаяр гишүүн тодруулж асууя.

Г.Хосбаяр: Хөшгийн хөндийн төмөр замын санхүүжилт эх үүсвэр юмыг асуусан.

Д.Амарбаясгалан: Зам, тээврийн яамнаас хүн байна уу. 3 дугаар индэр.

Г.Батбаяр: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батбаяр. Хөшгийн хөндий Багахангайн чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг Монголын Төмөр зам компанийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа. Тэгэхдээ Монголын Төмөр зам компани яг бүрэн санхүүжилтийг хийж чадахгүй учраас бас зээл тусламж Хөгжлийн банкнаас холбогдох шаардлагатай зээлүүдийг авахаар бас ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Даваадалай орлогч гүйцээгээд хариулъя. 4 дүгээр индэр.

Т.Даваадалай: Энэ жил нийслэлийн төсвийн тодотголоор Хүннү хотын цэвэрлэх байгууламжийн төсөвт 10 тэрбумыг тодотгосон. Тэгээд энэ жил болохоор зураг төслийн ажил бол дуусаж байгаа. Тэгээд мөн логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хуулийн дагуу хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байгаа. Тэгээд бас сая өнгөрсөн чуулганаар Хүннү хотын хөгжлийн корпорацыг байгуулж ажиллаж байгаа. Тэгээд 2026 онд бол Хүннү хот дээр бүтээн байгуулалтууд ид өрнөнө.

Д.Амарбаясгалан: Даваадалай орлогч индэр дээрээ байж бай даа. Нэг асуулт асуугаадахъя. Энэ Улсын Их Хуралд хандаж 2 ч янзын шаардлага ирчхээд байгаа. 1 дэх нь энэ Улаанбаатар хотын бүтээн байгуулалттай холбоотойгоор үндэсний аж ахуйн нэгжүүд дотоодынхоо аж ахуйн нэгжүүдийг ажлаар хангах бодлогыг огт баримтлахгүйгээр шалгуурыг нь их өндөр тавьж, зориудаар гаднын гүйцэтгэгч нарыг оруулж ирж байна гэдэг ийм шаардлагыг Улсын Их Хуралд хандаж иргэдээс гарын үсэгтэйгээр ирсэн байгаа. Ер нь тэгээд энэ аж ахуйн нэгжүүд чинь ер нь цаашдаа яаж амьдрах юм бэ. Ихэнх ажлыг нь төр булааж аваад хийчихдэг. Дахиад томоохон бүтээн байгуулалтын ажил гарч ирээд тендер нь оролцоод ажил төрөл хийгээд явъя гэхээр шалгуурыг нь өндөр тавиад гаднын компанид зориулаад тендер зарлачихдаг. Тэгээд ер нь Монголд дотоодын аж ахуйн нэгж гэж байх юм уу. Улаанбаатар хот энэ дээр яаж бодлогоор дотоодынхоо аж ахуйн нэгжүүдийг дэмжих, бойжуулах, илүү чадвартай болох тал дээр ер нь яаж анхаарах гэж байгаа юм бэ. Барилга барьсан ч гаднын компани, зам барьсан ч гаднын компани. Тэгээд энэ дотоодын аж ахуйн нэгжүүд чинь ерөөсөө бүр ямар ч ажилд орж чадахаа байлаа шүү дээ. Сая баруун бүс дээр очоод бас 2, 3 замын нээлтүүд болсон. Мэдээж тэр Азийн хөгжлийн банк, гаднын зээл, тусламжаар хийж байгаа зам учраас тэгсэн байх. Дандаа гаднын

компаниуд л орж ирж гүйцэтгэж байгаа. Гэтэл дотоодод олон замын компаниуд, барилгын компаниуд өдөр болгон л хувийн журмаар ажил, бизнесээ хийгээд л яваад байдаг. Яагаад эдгээр аж ахуйн нэгжүүд энэ дотоодын бүтээн байгуулалтад оролцож чадахгүй болчихсон юм бэ. Би Улсын Их Хурлын даргын хувьд тэр иргэдээс ирсэн тэр аж ахуйн нэгжүүдээс ирсэн шаардлагад хариу өгөх ёстой. Энэ дээр бодитой тайлбар хийе дээ. Даваадалай. 4 дүгээр индэр.

Т.Даваадалай: Их Хурлын даргын асуултад хариулъя. Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай. Улаанбаатар нийслэлийн зүгээс бол Монголын аж ахуйн нэгжийг бол дэмжиж байгаа. Улаанбаатар хотоос 2025 он дээр хөгжлийн 24 мега төслийг бол хэрэгжүүлэхээр зорилго зорилт тавиад ажлуудыг эхлүүлж байна. Энэ дээр бол бид нарт олгогдсон хууль, эрх зүйн хэмжээнд гэрээ дээр олон улсын Фидикийн гэрээний загварчлал ашиглахдаа бид нар хамгийн багадаа тус нэмүү өртөг буюу төслийн өртгийн нийт 20 хувь нь Монголын дотоодын үйлдвэрлэл буюу 51 хувиас дээш Монгол эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд олгоно гээд олон улсад хэрэглэгддэг локал контентын минимум хэлбэрийг бол 20 хувь гэж зааж өгч, бүх томоохон төслүүдээ оруулж байгаа. Энэ нь метро, туулын хурдны зам, трамвай гэх Монголын аж ахуйн нэгжүүд хийж чадахгүй ч гэсэн тус аж ахуйн нэгжүүд компаниар шалгараад Монголд хийж хэрэгжүүлэхэд дотоодын бетон түгээмэл тархацтай материал, катеринг гэх зэрэг үйлчилгээнүүд дээр нийт дүнгийн 20 хувийг бол үндэсний үйлдвэрлэл дээр олгоно гэдэг энийг бодлогоор нийслэлийн зүгээсээ бол барьж байгаа.

Томоохон төслүүдийн хувьд болохоор мега төслүүд учраас дандаа нөгөө олон улсын жишгээрээ 35 сая доллароос дээш өртөгтэй төслүүдийг хэлдэг. Энэ дээр нь төсвийн менежментийн оновчлолыг хэрэгжүүлэх гээд олон жижиг хуваах боломжгүй байж байгаа учраас зохимжит байдал дээр нь багцалж задлахад 1 багцынх нь дүн нь тодорхой өндөр дүнтэй болж байгаа дээр бол тодорхой жижиг болон дунд хувийн хэвшлүүд бол орох жоохон хүнд шалгууртай байгаа. Энийг бас Монголын барилгачдын холбоо болон бусад холбоодтой хамтраад энэ дээр хуулиуд дээр хамтран ажиллаж, ирээдүйд хуулиудын өөрчлөлтүүдийг хамтдаа хийе гэдэг дээр холбоодтой уулзаад, хамтраад ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Гаднын төсөл хөтөлбөрөөс авч байгаа зээл тусламж мэдээж тавигддаг шаардлага нь тэр шаардлагыг хангасан гадаадын голцуу компаниуд орж ирж гүйцэтгэхээс өөр аргагүй байдал байдаг. Гэтэл хотоос тавьж байгаа шаардлага нь 20 хувийн боломж дотоодын компаниудад туслан гүйцэтгэгч хийх хэмжээнд байна гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Та нар ийм нөхцөл байгаа юм бол, дотоодынхоо нөхцөлийг мэдэж байгаа юм бол яагаад тэдгээр компаниуддаа зориулсан дүрэм журмаа эхнээс нь гаргачхаж болдоггүй юм бэ. Хүний сэтгэлээр хандаад байна шүү дээ та нар дотоодынхоо компаниудад. Гадна талаа хэтэрхий их шүтэж байгаа юм биш үү. Та нар дотоодын нөхцөл боломжийг ашиглаж, гаднаас босгосон бондоороо бүтээн байгуулалт хийх гэж байгаа биз дээ. Тэгээд тэрийг чинь орж ирж гаднын компани аваад гараад явна. Яагаад дотоодын компани хийж болдоггүй юм. Энэ юман дээр та нар ер нь жоохон дотоодын үндэсний үйлдвэрлэлээ дэмжих сэтгэлээр асуудалд хандмаар байх юм. Дотоодын энэ барилгын компаниуд чинь дэлхийн зиндаанд хүрсэн бүтээн байгуулалтыг хийж чаддаг л болчихсон шүү дээ. Гэтэл Сэлбэ дэд төв дээр том хороолол барихын тулд гаднын компани орж ирнэ гэдгийг чинь монголчууд ойлгохгүй шүү дээ. Яаж ойлгох юм. Орон сууцын хороолол барихаар хувийн хэвшил бүрэн чадаад байдаг. Төрөөс зарлаж байгаа ажилд оролцох болохоор хувийн хэвшил чадахгүй болчихдог. Ингэж

хүний сэтгэлээр хандахгүй ээ Даваадалай. Асуудлыг тодорхой болго. Тэгээд юм л бол хуульд буруугаа чихдэгээ болиорой. Байгаа хуулийн орчиндоо нийцүүлээд ил тод, шударга, зарчимтай ажиллах. Тэр талаа бодох хэрэгтэй. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Би энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ер нь үр ашигтай болгох тал дээр хэдэн санал хэлье гэж бодсон юм.

1 дүгээрт сая Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаад, улсын төсөвтийн төсвийн ачаалал үзүүлээд байгаа хуулиуд, дээрээс нь улсын төсвийн үр ашгийг ер нь яаж сайжруулах вэ гэдэг ажлын хэсэг гарч ажилласан. Энэ ажлын хэсгийг нь би ахлаад ирэх 7 хоногт бид бараг Төсвийн байнгын хороо дээр санал, дүгнэлтээ танилцуулахаар ажиллаж байгаа. Нам намын төлөөллүүд орчихсон. Тэгээд 1 зүйл анзаарагдсан нь өмнөх парламентад бид нар бас хийж байсан өнгөрсөн 15 жилийн төсөв дээр дүн шинжилгээ хийж байхад зарим аймгууд 15 жил тасралтгүй бүр бүх улсын төсвийн хөрөнгө оруулалтыг 1 хүнд нь буюу тухайн аймгийн иргэдэд нь хуваагаад үзэхэд зарим аймгууд энэ Монгол Улсын төр засгийн хаанаас нь төрчихсөн юм гэмээр тасралтгүй муу хөрөнгө оруулалт авч байгаа аймгууд их байна. Тэгээд зарим нь хөөцөлдлөгөө сайтай болохоороо гишүүд нь гүйж байгаад, Байнгын хорооны дарга болохоороо, сайд болохоороо тасралтгүй сайн хөрөнгө оруулалтыг татдаг аймгууд байна. Үүнийг болиулах тал дээр юуны төлөө бид нар Эдийн засаг, хөгжлийн яамтай, хариуцсан сайдтай боллоо анхаармаар байна.

Тэгээд үүний тод жишээ нь манай баруун аймгаас Говь-Алтай аймаг сүүлийн 15 жил ер нь тасралтгүй муу хөрөнгө оруулалт татаж байсан. Тэгээд үүний үр дүнд өнөөдөр Говь-Алтай аймаг баруун бүсээс 42,4 хувь ядуурлаараа, улсын хэмжээнд бүх аймгуудаас хамгийн өндөрт. Төвийн бүсээс болохоороо Булган аймаг бас хөөрхий минь тасралтгүй муу хөрөнгө оруулалт татдаг. Ингээд улсын төсвөөс ерөөсөө хөрөнгө оруулалт оруулдаггүй гэсэн үг. Тэгээд үүний үр дүнд бас ядуурлынх нь түвшнээр 38,7 хувь, говийн бүсээс Говьсүмбэр, Дундговь гэж 2 аймаг улайсан. Ерөөсөө хөрөнгө оруулалт байхгүй. Ингээд үүний үр дүнд бас энэ Говьсүмбэр аймаг бол ядуурлаараа говийн бүсээсээ 1-т, зүүн бүсээс Дорнод аймаг улсын төсөвт төвлөрүүлдэг аймаг мөртөө өөрсдөө уул уурхайтай, аялагтай ийм аймаг мөртөө зүүн бүсээс хамгийн муу хөрөнгө оруулалттай, бас ядуурлаараа 37,1 хувь. Тэгэхээр үүнийг улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ийм зарчмаар бид нар өгнө гэдэг тийм зарчмыг тогтоох ёстой юм биш үү. Хэрвээ ингээд байвал энэ зарим аймгууд бол хүн амаа алдаад дуусч байна. Залуучууд нь дөрвөөд гарч байна. Тэгээд энэ аймгууд бол энэ ядуурлынхаа циклээс ерөөсөө гарахааргүй болж байна. Тэгээд энэ дээрээ та бүхэн анхаарахгүй юм уу.

Тэгэхэд зарим аймаг бол тасралтгүй сайн. Бусад аймгуудаас ер нь бараг 10 дахин энэ тэр хөрөнгө оруулалт сүүлийн 15 жил авсан байна. Тэгээд манай Хөвсгөл аймаг байна. Тасралтгүй сайн хөрөнгө оруулалт татдаг. Орхон аймаг байна. Яагаад ч юм тасралтгүй сайн хөрөнгө оруулалт татдаг. Тэгэхээр энэ нь хөөцөлдлөгөөнийх гэнээ. Ингээд хөөцөлдлөгөөгөөр хөрөнгө оруулалтыг татвар төлөгчдийн мөнгийг шийддэг биш зарчмаар стратегиар яг ийм хөрөнгө оруулалтаа шийддэг ийм зарчим руу ормоор байна.

2 дахь асуудал нь энэ хөрөнгө оруулалтуудыг нь бид нар арай гэж төлөвлөөд л бид нар хөөрхий Улсын Их Хурлын гишүүдийг бараг л хөрөнгө оруулалтын мөнгө

төсвийг шийддэг юм шиг юм болдог. Тэгээд өнгөрсөн хугацаанд би 4 жил гишүүн байхдаа хэдэн сургууль, цэцэрлэгийн араас хөөцөлдсөөр байгаад л таарсан. Тэгээд үүнийгээ бүр өөрийнхөө бараг хойд талын хашаандаа барих гэж байгаа аятай л юм болдог юм. Газрынх нь асуудлыг нь шийдэх гээд л нийслэлтэй яриад л дүүрэгтэй яриад л. Тэгэхээр үүнийг ер нь энэ Эдийн засаг, хөгжлийн яам дээр энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтын бэлтгэлийг хангадаг бүр тусгайлан бүтэцтэй болмоор юм шиг харагдаж байгаа юм. Тэгээд энэ дээр жишээлбэл ирэх жил энэ олон сургуулийг барина гэхэд Баянзүрх дүүрэг дээр Боловсролын яамнаас хариулаад өгөөч. Ирэх жил хэдэн сургууль барих вэ. Газар чөлөөлөлтүүд нь хийгдсэн үү. Энэ дээрээ анхаарч өгөөч ээ.

Дээрээс нь энэ аймгийн Засаг дарга нартаа энэ олон төсвийн хөрөнгө оруулалтуудыг чинь аймаг руу хуваагаад л тавина. Тэгэхээр эд нартай байгуулдаг гэрээнийхээ үр дүнгийн гэрээгээ нэг сайжруулаач ээ. Үүнийгээ би дүгнэдэг гэж бол бараг бодохгүй байна. Үүнийг эрх биш төсөв нь хэрвээ хэтэрчихсэн бол нэг хариуцлага тооцно гэж байгаа байх. Үүнээс цаашаа бол бараг байхгүй байгаад байна.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Булгантуяа гишүүн айхтар анзаарсан байна. Ер нь бол энэ цөөхөн гишүүнтэй аймгууд ингээд үлдээд байдаг. 1 төлөөлөл, 2 төлөөлөлтэй нь үлдээд, 3, 4 гишүүнтэй нь урагшаа яваад, хөрөнгө оруулалт татсан ийм тохиолдол бол асар их байгаад байгаа юм. Тэгээд яг тэр хэмжээгээр ядуурал хадгалагдаж байна гэдэг дүгнэлт бол бид нарын хийж байгаа судалгаатай их ойрхон. Эндээс гарах арга ерөөсөө л бүсчилсэн хөгжлийн зөвлөлөө сайн ажиллуулах. Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтөө их сайн хийх. Энэ бол яг ядуурлаас гарахын тулд энэ төлөвлөлтөд одоо бид нар сая 2, 3 газар хөгжлийн зөвлөлдөх уулзалтуудаа хийсэн. Ингээд харахаар аймаг нь хаягдахгүй байна. Ерөнхий төлөвлөлт бол ханатай гарахаар харагдаж байна. Тийм учраас бол энэ аргачлалаараа ер нь бүсийн хөгжлийн төлөвлөгөө гэдэг зүйл дээрээ суурилад, тэгээд аймгууд өөрснөө хөгжлийнхөө төлөвлөлтийг хийж сурах шаардлага байна. Таны хэлж байгаа шаардлагын дагуу бид нар аймгуудын Хөгжил төлөвлөлтийн хэлтсийг сургах ажил байна. Сумдын дарга нарын төлөвлөлтийн чадавхыг нэмэгдүүлэхийн тулд бас сургалт хийх шаардлага байна. Тэр аль нам нь байхаас үл хамаараад аймаг дээр, сум дээр ажиллаж байгаа хүмүүсийн төлөвлөлтийн чадавх бол бидэнд маш тийм хэрэгцээтэй зүйл байна гэж харж байгаа.

Тэгээд бид нар хөгжлийн нэгдсэн мэдээллийн санг тэр газар нутаг, орон зайн хувьд бүтэн тооцоолдог системийг бий болгохоор ажиллаж байгаа. Тэгээд одоохондоо энэ систем худалдаж авах хөрөнгө байхгүй учраас бид нар Азийн банк болоод бусад доноруудаасаа гуйсан маягтай байна. Тэгэхдээ бид нар ойрын үед энийгээ авчих болов уу гэж бодож байна. Тэгэх юм бол таны хэлдгээр тухайн аймаг дээр ямар хөрөнгө оруулалт оров, ямар явцтай байна, ямар үр дүнтэй байна, ямар шаардлага байна гэдэг том зургаараа 1 платформ дээр ороод ирэх юм бол Их Хурлын гишүүд нь ч хараад мэддэг, яамдууд нь ч хараад мэддэг, сумын дарга нь ч хараад мэддэг, аймгийн удирдлага ч ороод мэддэг гээд 1 ийм платформ хийчих юм бол ерөөсөө тэр мэдээллийн нэгдсэн сан бол өөрөө хаана юу дутагдаж байгааг хэлж өгдөг. Хаана, ямар боломж байгааг гаргаж өгдөг. Ингээд энэ бол өөрөө хөгжлийн бодлого төлөвлөлтөд асар том үүрэг гүйцэтгэх юм байна гэж бид нар харж байгаа.

Тэгээд олон газрууд тэр программыг түрээслээд байгаа. Тэгээд энийг Монгол улс 1 газар Эдийн засаг, хөгжлийн яаман дээрээ авчихъя. Тэндээсээ бусад нь шэйрлээд явъя гэхгүй бол бүгд 1 программ, 1 платформд бүгдээрээ төлбөр төлөөд, тус тусдаа хэрэглэдэг. Ингээд нийт өгч байгаа зардал өртөг нь бол их өндөр гарчхаад байгаа ийм зүйл байгаа учраас энэ нэгдсэн мэдээллийн сангаа хэдүүлээ үүсгээд явахад таны хэлж байгаагаар төлөвлөлтийн асуудал дээр мафаан гарахгүй, хоцрогдохгүй, зарим нэг нь завшихгүй ийм зүйл бол байгаа гэдгийг хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Батжаргал Төрийн нарийн бичгийн дарга 4 дүгээр индрээс.

Х.Батжаргал: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. 2028 оныг хүртэлх хугацаанд бол боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр өсөн нэмэгдэж байгаа хүүхдийн хэрэгцээг хангахаар боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхээр 108 сургууль, 95 цэцэрлэгийн хэрэгцээ шаардлага байгаа. Түүний дагуу төсөв хөрөнгө оруулалтыг бол төлөвлөж байгаа. 2026 оны төлөвлөлт урьдчилсан байдлаар төлөвлөж 50 сургууль, 43 цэцэрлэгийг төлөвлөсөн байгаа. Тэгэхдээ Улаанбаатар нийслэл хотын хэрэгцээ шаардлага бас үүнийг дагаад 84 сургуулийн ийм хэрэгцээ шаардлагыг тодорхойлоод нарийвчилсан байршлыг нь манай нийслэл дээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Үүний гол тулгамдаж байгаа асуудал бол мэдээж газрын асуудал байгаа. Тэгэхээр яалт ч үгүй Баянзүрх дүүрэг 26 дугаар хороо гэх мэтчилэн нягтаршил ихтэй газар дээр бол газар байхгүй. Гэхдээ бас давхарлаад ингээд барих/минут дуусав/

Х.Булгантуяа: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Яг тарааж өгсөн материалын чанар бас сайнгүй байна. Тэгээд яг аль тоо нь зөв гэдгийг харахад маш хэцүү байна. Би жишээ хэлье. Энэ дээр 150 мянган орон сууц барина гэхихсэн байж байна. Гэтэл энэ нь бараг 150 мянга чинь нийт Монгол Улсын хэмжээнд орон сууцын нийт нөөцийн бараг 50 хувьтай тэнцэхээр. Тэгээд хавсралт 3 дээр болохоор 19 мянган орон сууцыгаа 54 мянга болгоно гэсэн өөр тоо байх юм. Сая Соёлын сайд жишээлбэл жуулчдын тоог 1,1 сая гэж байхад энэ дээр болохоор 1,6 сая гэсэн байна. Энэ дээр бас өөр цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг Эрүүл мэндийн яам хариуцна. Мэдээллийг нь гаргаж өгнө гэсэн бүс нутгийн 1.6.1 дээр биччихсэн байгаа мөртөө яг тэр асуудлаа эдийн засгийн бодлого гэдэг дээр бас 3.6.1 дээр ингээд бичсэн гэх мэтчилнээр яг аль тоо нь зөв юм. Аль нь тодруулахад их төвөгтэй байгаад байна. Тэгэхээр энэ асуудал боловсруулж байгаа хүмүүс маань энэ дээр нэлээн сайн анхаарч ажиллахгүй бол болохгүй байгаа харагдаад байна. Дээр нь энэ хавсралт 1, 2, 3 хоорондоо бол уялдах ёстой.

Нэг дээр жишээлбэл сая ярьж байна. Төрийн өмчийн компаниудтай холбоотой зардлыг нь 15 хувь, бүтээмжийг нь 30 хувиар нэмэгдүүлнэ гэсэн заалт байгаа мөртөө яг 2, 3 дээр жишээлбэл яг тэр асуудлууд нь яаж явах гэж байгаа гэдэг үзүүлэлтүүд нь байхгүй байх жишээтэй. Зарим 1 үзүүлэлтүүд нь сайжруулна гэсэн мөртөө ерөөсөө яг өөрчлөлт байхгүй, 1 хивэндээ үзүүлэлтүүд байж байна. Жишээлбэл, төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлнэ гэсэн мөртөө 3 байна. Тэрийгээ 3 байлгана л гэж байна. Тэгэхээр яах вэ, зүгээр чанарын хувьд боловсруулалтуудын хувьд бол Гантөмөр сайд аа илүү сайн ажиллахгүй бол яг асуухад жоохон төвөгтэй. Тэгээд буруу зөрүү юм асуугаад дахиад Улсын Их Хурлын хувьд бол бас гишүүд мэдээлэл өгч байгаа хүмүүс бол үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй байдаг. Гэтэл боловсруулаад бичгээр цаасаар орж

ирсэн асуудлууд нь ингээд зөрүүтэй. Түрүүн бас Батлан хамгаалахын яам хэлсэн. Бид нар материалаа цаасаар өгчихсөн гэж байхад яг жишээлбэл нэгтгэсэн материал дээр нь юу ч байхгүй байх жишээтэй. Тэгээд ийм асуудлууд байгаад байна. Үзүүлэлтүүд нь яг байгаа оносон биш буруу үзүүлэлтүүдийг тавьсан байна. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ дээр боловсруулалт ажиллагаа илүү хийх хэрэгцээтэй байсан ийм дүр зургууд харагдаад байна.

Тэгээд энэ 2026 оны улсын хөгжлийн төлөвлөгөө хувийн хэвшлийн төрийн оролцоог багасгана гэсэн үзүүлэлтүүд байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр уг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр эдийн засаг дахь төрийн оролцоог буулгаж, хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлнэ гэсэн ийм заалт байгаа. Тэгэхээр энэ үзүүлэлт 2026 онд хэд болох вэ гэдэг асуулт байна.

Дээр нь хамгийн гол жишээ бол иргэдийн бухимдуулж байгаа асуудал агаарын бохирдол, түгжрэл 2 байгаа. Тэгээд үүнтэй холбоотой яг тодорхой үзүүлэлтүүд, түрүүн нийслэлээс тайлбар хэлж байсан бас яг тодорхой юм хэлсэнгүй. Нэг үзүүлэлт байгаад одоо хавсралт 3 дээр ч юм уу агаарын чанарын индекс гээд 1 үзүүлэлт байгаад, тэрнийхээ төлөө ажилладаг. Тэр үзүүлэлт тэр чинь өөрөө бусад юу хийхийг нь заагаад өгдөг ийм үзүүлэлтүүдтэй болмоор байгаа харагдаад байна. Тэгэхгүй бол энд тэндээс яамнуудаас авсан материалуудаа дутуу хагас нэгтгээд тавьчихсан юм шиг зүгээр эхний байдлаар тэгж харагдаад байна. Тэгэхээр энэ агаарын бохирдол, түгжрэлтэй холбоотой 1 үзүүлэлтүүд нэмж болох уу гэдэг 2 дугаар асуулт байна.

3 дугаарт нь стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна гээд заасан байна. Тэгэхээр энэ дээр ямар ямар стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар төлөвлөж байгаа вэ гэсэн ийм асуултууд байна.

Х.Булгантуяа: Шадар сайд Гантөмөр сайд эхлээд хариулах уу.

Л.Гантөмөр: Тэр 150 мянган орон сууцтай холбоотой гаргасан алдааны тухай Эрдэнэбат тодорхой хариулъя. Ер нь логик холбоо бол гурвууланд нь байгаа шүү Энхтүвшин гишүүн ээ. 1, 2 алдааг ингээд 300 заалт руу нялзааж болохгүй. Хэд нь алдаа байгаа юм яг тоолоод энэ чинь алдаатай байна гэж хэлсэн нь зөв байх. Тэгвэл энийгээ бид нар хэлэлцүүлгийн явцад засаад явахын тулд яг тодорхой энэ, энэ буруу байна, энийг ингэж засъя гээд ажил хэрэгчээр хандах нь зөв болов уу.

Түүнээс бичиг баримт нь ингээд өөрөө юутай форматтай. Форматынхаа дагуу явж байгаа. Форматаа бол бид нар цаашдаа энэ Их Хурал дээрээс гарсан том шүүмжлэл байгаа шүү дээ. Энэ хяналт үнэлгээтэйгээ яаж холбох юм бэ. Үр дүнгээ хэрхэн хэмжих вэ гэдэг дээрээ бодлогын бичиг баримтын хувьд цаашаагаа хөгжөөд, шинэчлэгдээд явах ёстой. Тэгээд Эрдэнэбат чи тэр гарсан алдаануудтай холбоотой асуудлуудаа өөрөө тайлбарлаад явах нь зөв. Жишээлбэл 1,6 сая жуулчин чинь яагаад 1,1 сая болоод энэ мэдээллийн зөрүү чинь ямар учиртай юм гээд. Энэ тайлан мэдээллийн үед ч гэсэн Энхтүвшин гишүүн бол яг энэ мэдээллийн нэгдмэл байдлыг та нар нэг бүрэн хангачхаж чаддаггүй юм уу гэдэг байдлаар асуудалд хандаж байгаа. Энэ тавьж байгаа асуудлыг би сайдын хувьд бол хүлээж авч байгаа. Яг бичиг цаас хийж байгаа хэсэг дээрээ ингээд анзааргагүй зарим нэг алдаа гарч байгааг бол үгүйсгэхгүй байна. Эрдэнэбат тэр асуултуудад хариулаадах.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 4 номер микрофоноос албан тушаал, нэрээ хэлээрэй.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. 150 мянган айлын орон сууцын тухайд болохоор ипотекийн зээлийн санхүүжилтээр 2024-2025 оны хооронд нийслэлд 30.430, орон нутагт 6.925, орон нутгаас Дархан-Уул аймагт 1366 хамгийн их, хамгийн бага нь Говьсүмбэр аймагт 36 орон сууц орохоор явж байгаа юм байна лээ. Тэгээд бид нар энэ тоон дээр түшиглээд ер нь бол энэ ядуурлыг бууруулахад хамгийн их нөлөө үзүүлэх нь энэ орон сууцын хөтөлбөр юм байна гэж үзэж байгаа. Ийм үүднээс 150 мянган айлын орон сууцын хөтөлбөр ингэж яригдаад явж байгаа. Энэ хэрэгжсэнээр ядууралд тодорхой хугацаанаасаа хамаараад 3-4 функтээр нөлөөлөх юм байна лээ. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний онцгой 2 тоо байгаа. 1 нь ядуурал 2028 он болтол 2 дахин бууруулах, нөгөөдөх нь 10 мянган долларт хүргэх гээд энэ хүрээн дээр .../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээр нэмж минут өгье. Товч бөгөөд тодорхой хариулна шүү.

Ц.Эрдэнэбат: Тэгээд энэ хүрээндээ бид нар тэргүүлэх чиглэлээрээ 150 мянган айлын орон сууц гэж орсон. Яг яамнаас ирсэн саналын дагуу тэр шалгуур үзүүлэлт дээр нь өөр тоо орсон байгаа.

Жуулчны тооны хувьд болохоороо Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон арга хэмжээний төлөвлөгөө гэж саяхан засаг дээр батлагдсан. Энэ тоон дээр 1,6 гэсэн тоо орж ирсэн. Яамнаас ирсэн санал засгийн түвшинд бид нар ярилцаад, яамны гаднын зөвлөх компанитай хамтарч яам маань стратегиа аялал жуулчлалын стратегиа боловсруулаад шинэчилсэн байна лээ. Энэ хүрээнд бол яамны саналаар 1 саяар тооцогдохоор орж ирж байгаа юм.

Х.Булгантуяа: Уул уурхайн яамнаас сайд нь байхгүй байгаад байдаг. Уул уурхайн яамнаас хариулах хүн байхгүй юу. Хэрэг эрхлэхийн Дэд дарга Батцэцэг ирчихсэн байх шиг байсан. Хаачив. Тэндээс бас хүн алга. Энхтүвшин гишүүн нэмж тодруулах уу.

Д.Энхтүвшин: Нөгөө хувийн хэвшлийн төрийн оролцоог багасгана гэсэн үзүүлэлт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр байгаа. Тэрийг энэ хавсралт 3 дээрээ оруулж өгч болохгүй юу. Энэ үзүүлэлтүүдийг танилцуулгууд дээр эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гэсэн үзүүлэлтүүд байгаа. Энийгээ хэмжилт үзүүлэлт дээр оруулж болох уу гэдэг тийм асуулт байсан.

2 дугаарт нь тэр агаарын бохирдолтой холбоотой агаарын чанарын индекстэй юм уу, түгжрэлтэй холбоотой ийм1 үзүүлэлтүүдийг энэ үзүүлэлт бас хавсралт 3 дээрээ оруулаад явах бололцоо байсан уу гээд ийм асуултуудад хариулт авсангүй.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Хувийн хэвшилтэй холбоотойгоор болохоор үндсэн концепц нь төсвийн урсгал зардлыг ДНБ-тэй харьцуулахыг 24 хувьд хүргээд, тэрний хэмнэлтийн томоохон төсөл арга хэмжээнүүд ялангуяа хувийн орон зай руу шилжүүлбэ гэсэн үндсэн тоо явж байгаа.

Үүнтэй мөн холбоотойгоор процессын дахин инженерчлэл, төрийн чиг үүргийн цогц шинжилгээ хийгээд, энэ дээрээсээ үүдэлтэйгээр яг нарийн тоонууд нь гараад, төрийн чиг үүрэг, үйлчилгээнүүдийг хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагуудаар хийх гэсэн үндсэн бодлого маань гараад явж байгаа. Яг энийг ажлын хэсгийн хүрээнд 3 дугаар хавсралт дээр энэ тоонуудаа нягтлаад нарийвчлаад оруулах боломжтой.

Х.Булгантуяа: Нэмэлт Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Эрдэнэбүрэн нэмж хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Түгжрэлтэй холбоотой авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлсэн байна гээд жоохон ерөнхий тавьчихсан байгаа. Тэгээд энийг километр цагаар нь нарийсгаад, одоо ямар байгаа юм. 2026 онд ямар болох юм бэ гээд хэлэлцүүлгийн явцад засаад явчихъя.

Утаатай холбоотой асуудал дээр ч гэсэн адилхан. Бас дахиад тоо хэмжээнүүд нь байж байгаа юм чинь тоогоор тавья гэж ингэж хэлмээр байна. Хэлэлцүүлгийн явцад.

Х.Булгантуяа: Тамгын газраас зарим яамны сайд нь ч байхгүй, Төрийн нарийн бичгийн дарга нь ч байхгүй байгаад байгаа юм. Зарим нь сайдтайгаа, Төрийн нарийнтайгаа бүтэн өдөр энд суугаад гишүүдийн асуултад хариулж байна. Номин сайд, Батцэцэг сайд, Энхбаяр сайд гээд яамаараа бараг энд сууж ажиллаж байна. Тэгэхэд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргыг дуудъя. Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дэд дарга нараас дуудъя. Өөр яг яам болгоноос 1 төлөөлөл танхимд байх ёстой. Ингээд асуултад нь хэн хариулах нь тодорхойгүй байна. Энхтүвшин гишүүн нэмж 1 минут тодруулга.

Д.Энхтүвшин: Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр байгаа тоог л асуусан юм. Нөгөө хувийн хэвшлийн нэмэгдсэн өртгийн ДНБ-д эзлэх хувийг 78 хувьд хүргэнэ гээд 2026 онд тавьчихсан байгаа. Тэгэхээр энэ үзүүлэлтээ бас оруулаад, ажлуудаа шахаад явбал яасан юм бэ гэдэг. Нөгөө талдаа бас энэ агаарын бохирдолтой холбоотой үзүүлэлт болохоор ер нь яг бид нарын гол зорилт учраас энийгээ нэлээн анхааралд авч, яг энэ үзүүлэлтүүдийг заавал оруулах ийм хүсэлтэй байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

Л.Соронзонболд: Түрүүн харин Гантөмөр сайд энэ Эрдэнэс Тавантолгойн удирдлагатай холбоотой асуудал дээр ярьсан асуудлаар бас саналаа хэлчихье гэж бодоод энэ Монгол хүний үнэлэмжийг сайн бодож байхгүй бол бид нар чинь сүүлийн 20 жилд Монголчууд үр хүүхдээ гадаад, дотоодын дээд сургуульд сургаж мэргэжил эзэмшүүлсэн. Бид авлигаас болоод энэ механикаар гадаадын мэргэжилтнийг шүтдэг. Дээр үед социалист нийгмийн үед Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг шүтдэг байсантай адилхан ийм хандлага байж болохгүй. Бид энэ авлигын эсрэг ёс зүйтэй байх соёлыг, орчныг, процессыг нь бүрдүүлэхдээ л бид анхаарах ёстой болохоос биш энэ авлигаас болоод бид нар гадаадын мэргэжилтэнг Монгол Улсынхаа хийж чадах ажил дээрээ тавина гэдэг бол маш утгагүй асуудал гэж бодож байгаа. Ялангуяа энэ нүүрсний уурхайг ажиллуулахад бид нар гадаадын мэргэжилтэн ажиллуулна гэж бодож байгаа нь буруу л гэж бодож байна.

2 дугаарт болохоор би энэ хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлтэй бол ингээд танилцсан. Ер нь ингээд би бас энэ зээлийн хүүг бууруулах ажлын хэсгийн хяналтыг стратегийн хэрэгжилтийг хянах ажлын хэсэгт ажиллаж байгааг харахаар яалт ч байхгүй инфляц, дотоодын нөөц гээд асуудлууд маань явсаар байгаад Монгол Улсын эдийн засгийн бүтэц дээр очоод байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын өөрийнх нь нөхцөл байдал, нөөц хүчин зүйлийг хараад үзэхээр хамгийн оновчтой байж болох манай Монгол Улсын эдийн засгийн бүтэц маань ямар юм бэ гэдэг дээр бид нар бодлогоо гаргах ёстой юм болов уу гэж бодож байгаа. Ялангуяа энэ дээр бол Эдийн засаг, хөгжлийн яам ажиллах ёстой. Бид нар 5 жилийн дараа, 10 жилийн дараа ямар болсон байх ёстой юм. Тэгвэл бид нарын энэ батлаад байгаа энэ хөгжлийн төлөвлөгөө маань жил жилдээ тэрэндээ яаж дөхөж байгаа юм бэ гэдгийг ярьдаг байх хэрэгтэй байна. Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яам энэ талаараа бол анхаараарай гэж хэлмээр байгаа юм.

Тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөөг харахаар 2025 оны төсөвт суусан шинээр хэрэгжих байсан ажлууд маань дахиад 2026 онд дахиад цоо шинээр хийгдэх гэж байгаа юм шиг дахиад суугаад явж байна л даа. Тэгэхээр энэ ажлууд 2025 онд хийгдэхгүй гэж харж байгаа учраас ингэж төлөвлөгөөндөө оруулаад байгаа юм уу гэдэг ийм асуулт байна. Жишээ дурдах юм бол Баруун-Урт Бичигтийн замын асуудал байна.

2 дугаар асуулт маань юу байна гэхээр энэ Инновац, цахим бодлого харилцаа холбооны яамтай холбоотой 4.14.1.11 дээр ингээд олон салбарт хиймэл оюун ухаан, их өгөгдөл, дэвшилтэт технологийг 100 тэрбум төгрөгөөр 2026 онд ажил хийнэ гээд. Тэндээсээ 29 тэрбум төгрөгийг зарцуулна гэсэн. Энэ яг ямар ажил хийх гээд байна вэ. Эдийн засаг, хөгжлийн яам дээр болохоор Үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийг хэрэгжүүлэхэд нийтдээ 56 тэрбум төгрөгийн төсөв тавьж байгаад, 16 тэрбум төгрөгөөр 2026 онд ажил хийнэ гэсэн байна. Шинжлэх ухаан, технологи, аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн үндэсний технологи дамжуулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд 37 тэрбум төгрөг зарцуулна. Үүнээсээ бол 7-г нь 2026 онд зарцуулна гээд. Энд яг ямар ажлууд төлөвлөөд байна вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 4 номерын микрофон дээрээс хариулъя. Микрофон чинь асчихсан шүү.

Д.Баттогтох: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох. Үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийн тухайд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар шинээр улсын хэмжээний томоохон аж үйлдвэрийн салбаруудын судалгаа хөгжүүлэлтийг хийх зохицуулалттай томъёологдсон байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол одоо хэрэгжиж байгаа суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологи, туршилт, зүгшрүүлэлтийн судалгаанаас илүү өргөн хүрээтэй судалгаа хөгжүүлэлтийн төслийг хэрэгжүүлэхээр ингэж томъёолсон байгаа юм.

Технологи дамжуулах хөтөлбөрийн тухайд тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр мэдлэгийн эдийн засгийг эргэлтэд оруулах, дотоодын инновац, үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлэх замаар эдийн эдийн засгийн өсөлт, экспортыг дэмжих эерэг нөлөө үзүүлнэ гэж харж байгаа. Энэ технологи дамжуулах үндэсний хөтөлбөрийг бид нар боловсруулаад, энэ ондоо батлуулаад, 2026 оноос хэрэгжүүлэхээр байгаа.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр шинжлэх ухаан, технологи болон аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг дэмжих зорилгоор эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, их сургууль, аж үйлдвэр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан ийм технологи дамжуулах тогтолцоо бүрдэнэ гэж харж байгаа. Энэ хөтөлбөрөөр инновацын бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, технологи нутагшуулж арилжаалах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл явцыг дэмжих ийм төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ гэж төлөвлөж байгаа юм.

Х.Булгантуяа: Баатархүү сайд нэмж хариулъя.

Ц.Баатархүү: Соронзонболд гишүүн маш чухал асуудлыг хөндөж байна. Хиймэл оюуны дэвшил бол 2 зүйл дээр дэвшил авчирна. 1 дүгээрт нь бол шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг гаргана.

2 дугаарт одоо байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний хэмнэлтийг бий болгоно. Бүтээмжийг сайжруулах чиглэлд бол ажиллана. Тэгэхээр бид нар бол хиймэл оюуныг ямар ямар салбарт Монгол Улс хамгийн түрүүнд нэвтрүүлэх вэ гэдэг үндэсний стратегийг боловсруулаад дууссан. Удахгүй Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулна. Хиймэл оюуныг нэвтрүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг хийх шаардлага үүссэн. 1 дүгээрт өндөр хүчин чадал бүхий компьютер, тоног төхөөрөмж GPO бид нар авч, тийм хиймэл оюуныг хөгжүүлж байгаа start up технологийн компаниуд дундаа хэрэглэх энэ боломжийг олгох хэрэгтэй байна.

Мөн өгөгдлийг ангилах бүтэцтэй болгох, өгөгдлийг эргэлтэд оруулахын тулд өгөгдөл.../минут дуусав

Х.Булгантуяа: Баатархүү сайдад нэмж минут өгье.

Ц.Баатархүү: Өгөгдлийг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлаас сэргийлэх, тархмал дэд бүтцийг бий болгох чиглэлд тодорхой тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг бол Монгол Улс бэлтгэх шаардлагатай байна. Юу хэлэх гээд байна гэвэл хиймэл оюун гэдэг зүйлийг бий болгохын тулд шаардлагатай дэд бүтцийн хөрөнгө оруулалт Монгол улсад хязгаарлагдмал, дутмаг байгаа учраас энэ чиглэлийн хөрөнгө оруулалтыг бид нар хийнэ гэдгийг хариулъя. Баярлалаа.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

Л.Соронзонболд: Энэ нөгөө 2025 оны төлөвлөгөө төсөв дээр тусчхаад, 2026 онд дахиад шинээр тусаж байгаа ажлууд чинь ямар учиртай юм бэ. Яагаад тавьж байгаа юм бэ гээд асуугаад байгаа шүү дээ. Тэгэхээр 2025 онд огт хэрэгжихгүй гэсэн үг юм уу. Хэрвээ тийм бол 2025 оны төлөвлөгөөт төсвөөс хэдэн хувь нь 2026 он руу шилжинэ гэж тооцоолоод энэ ажлуудыг тусгаад байгаа юм бэ. Тэгээд гол асуугаад байгаа юм нь Бичигтийн замын асуудал гарсан шүү дээ. Баруун-Урт Бичигтийн замыг асуусан.

Х.Булгантуяа: 3 номерын индэр.

Г.Батбаяр: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Батбаяр. Баруун-Урт бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам барих төсөл байгаа. Нийт төсөвт өртөг нь 324 тэрбум төгрөгийн

өртөгтэй. 2025 онд бол ажлыг эхлүүлэхээр явж байна. Зураг төсөлтэй барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Бид нар бол 2025 оны санхүүжилт, 2025 оны барилгын ажлын зорилтот түвшинд төсөл хэрэгжих хугацааг үндэслээд 2026 ондоо энэ ажлыг бас үргэлжлүүлэхээр тооцож байгаа. 2026 онд нийтдээ 97 тэрбум төгрөг санхүүжих шаардлагатай гэж үзэж байгаа. Одоо бол яг барилгын ажил эхлээгүй байна. Сонгон шалгаруулалт хийгдээд явж байгаа. Тийм учраас энэ дахин төлөвлөсөн юм шиг харагдаж байгаа байх.

Х.Булгантуяа: Гантөмөр сайд нэмэлт хариулт.

Л.Гантөмөр: Ер нь бол шинэ Төсвийн хууль хэрэгжээд эхэлчихсэн. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Шинэ төсвийн хуулиар 5 сарын 31-нд гэрээ хийгдээгүй төсөл хөтөлбөрийн санхүүжилт тухайн жилдээ бол байхгүй гарахгүй гэж байгаа юм. Тийм учраас зарим нэг төслүүд маань энэ жил шалгарлаа ч гэсэн дараа жилээс санхүүжилт хийх ийм зүйл рүүгээ шилжих байх. Зүгээр асуудал бол хуулиараа төсөл шалгаруулаад хийсэн гэрээ дараа жил хүчинтэй юу, үгүй юу гэдэг асуудал тавигдах байх. Тэгээд энэ дээрээ гаргалгаа гаргаад явах нь зөв л гэж харж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг өмнөх буюу 2025 оныхтой харьцуулаад үзэхээр энэ 4 бодлогод авч үзсэн байгаа. Эдийн засгийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого гээд. Тэгээд харьцуулаад харахаар дэд зорилтууд нь бол маш их хэмжээгээр буурсан байна л даа. Жишээлэхэд яг тоолоод аваад үзэхээр эдийн засгийн бодлого дээр 131 дэд зорилт тоогоороо бол буурчихсан байгаа юм. Тэгэхээр энэ юуг хэлж байгаа юм бол. Төдий хэмжээний дэд зорилтууд нь хангагдаад энэ жил шаардлагагүй гэж үзсэн юм уу эсвэл бол яагаад ийм цөөхөн болоод ороод ирж байгаа юм болоо гэсэн агуулга байгаа юм. Хүний эрх хөгжлийн бодлого дээр жишээлбэл бас дэд зорилт 10-аар дутаад ороод ирсэн. Тэгэхээр хэрэгжээд яваад байгаа учир хасагдаад байгаа юм уу, яагаад байгаа юм болоо гэсэн нэг ийм асуулт.

2 дугаарт бид нарын нөгөө баталсан Засгийн газрын 4 жилийн мөрийн хөтөлбөр байгаа. Тэгээд тэр мөрийн хөтөлбөрт бол тусгагдсан бид нарын баталсан их чухал чухал зүйлүүд байна л даа. Жишээлбэл, тэгээд эд нар болохоор одоогийн энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд зарим нь харагдахгүй байгаад байна. Жишээ нь НДШ төлсөн даатгуулагч бүрийг миний тэтгэврийн мөнгөн хуримтлалтай болгож, тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ гээд. Яг одоогийн иргэдийн аж амьдралтай холбоотой 2.1.3.8 халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилнэ. Ядуурлын бууруулах бодлого баримтална гээд одоо ерөөсөө ядуурал чинь улам нэмэгдээд байгаа. Уг нь ингээд бууруулна гээд тусгачихсан. Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангиас эхлэн англи хэл, робот болон хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлнэ гээд.

Тэгээд энэ 4 жилийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зүйлүүд чинь энэ хөгжлийн төлөвлөгөөнөөс харагдахгүй байна. Тэгэхээр тусгахгүйгээр цаагуураа хэрэгжүүлээд яваад байгаа юм уу. Эвэл 2 дахь жилдээ 2 дахь жилийн төлөвлөгөө шүү дээ энэ чинь. 2025 оныхоо бид нар баталчихсан хийгээд явж байна. Одоо 26 дахь буюу 2 дахь жилийн төлөвлөгөөндөө энэ чухал ажлууд нь ингээд харагдахгүй байгаа нь яг юу гэсэн үг юм бол. Тусгахгүй, шаардлагагүй гэж үзээд хасчихсан юм уу. Эсвэл

дараа жилээс оруулах гэж байгаа юм уу. Ер нь энэ хэрэгжиж эхэлж байна уу. Үгүй юу гэдэг дээр нь 1 асуулт асууя.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Баярмаа гишүүний асуултад хариулъя. Ирэх жилийн нөгөө төсвийн хүрээний мэдэгдэл бид нарын энэ эдийн засгийн багтаамж, юмнаасаа үүдэлтэйгээр түрүүн сайдын хэлсэнчлэн бараг 900 орчим төсөл, арга хэмжээний санал ирснээс Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, мөн яамны боловсруулсан аргачлалын дагуу хууль дээр бол 17 зарчим аргачлал дээр 18 шалгуур нийт 35 шалгуур үзүүлэлтээр авч үзээд байгаа юм. Тэгээд үүнээсээ үүдэлтэйгээр шалгуур үзүүлэлтэд хангагдаагүй. Тухайлбал нөхцөл байдлын дүн шинжилгээ хийгээгүй, хөгжлийн загвар, төсөөлөл, үр нөлөө, гарах үр дүнг тооцоогүй, нөөцийн судалгаа, санхүүгийн хэмжээ, эх үүсвэрийн тооцоолол хийж бодлогын хувилбарыг боловсруулах гэх мэтчилэн энэ нөхцөлүүд нь хангагдаагүй учраас зарим төсөл, арга хэмжээнүүд нь орох боломжгүй болчихоод байгаа юм.

Тийм учраас тодорхой төсөл, арга хэмжээнүүд нь гэхдээ бид нарын ядуурлыг бууруулах бодлого болон 10 мянган доллар, экспортыг дэмжих гээд энэ гол ажлуудыгаа хийхэд зориулсан тэр тооцооллын дагуу 150 мянган айлын орон сууц байдаг юм уу, энэ бодлогын ажлууд маань нэлээд түлхүү суугдсан. Тэгэхээр хариулт маань болохоороо 2026 оны бид нарын төсөөлөл жоохон даруухан байгаа. Түүнтэй холбоотой бодлогынхоо гол гол ажлуудыг түлхүү оруулахыг эрмэлзсэн юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Тэгэхдээ ийм шүү. Жишээлбэл, Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөр бол хэрэгжинэ. Жишээ нь саяын Баярмаа гишүүний асуудаг тэр нийгмийн даатгалтай холбоотой 2 хувийн хуримтлал хийнэ гэдэг энэ зорилт бол хэрэгжээд л явна. Тэрийгээ хэрэгжүүлнэ гэдэг зорилтынхоо хүрээнд тавьчихсан байгаа. Мөн нийгмийн халамжийн бодлогыг хумих тухайд бол Нийгмийн хамгааллын яам бол маш тодорхой хөтөлбөр оруулж ирнэ гэж байгаа шүү дээ. Хөтөлбөрийнх нь санхүүжилт үе шаттай буурна гэдгийг төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ бид нар тавьчихсан байгаа. Нэг үгээр хэлбэл түрүүн хэн гишүүн хэллээ дээ бас халамжийн улс боллоо гээд. Тэр халамжийн зардлын хэмжээ бол ерөөсөө нэмэгдэхгүй. Дотор нь төрөлжүүлэлтээ зөв болгоод хүндээ хүрсэн халамжийн тогтолцоонуудаа сонгоод явах юм бол болно гэж байгаа шүү. Гуйвуулж яримааргүй байна гэдгийг бас жишээлбэл сая Эрдэнэбат .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жудагийн Баярмаа гишүүн нэмж тодруулъя.

Ж.Баярмаа: Ер нь бэлтгэл хангагдаагүй байсан учраас олон төрлийн гэх юм уу бэлтгэл хангагдаагүй учраас хэрэгжих боломжгүй гэж үзээд, зарим зүйлийг хассан гэж байна. Зөв байна. Сайн байна. Нэгэнт боломжгүй байсан бол нэгэнт биччихсэн юм чинь гээд зүтгүүлээд, муйхарлаад байж болохгүй. Тэр бол сайн байна. Яг энэ шигээ дахиж шинээр оруулж байгаа юмнууд нь бас тооцоо судалгаа муутай, бэлтгэл хангагдаагүй ийм байгаад бас муйхарлаад орчихсон. Тэгээд тэрийг нь бид нар анзаарахгүй батлаад дараа жил дахиад энэ шиг бэлтгэл хангагдаагүй буюу бас бус зүйлүүд нь бэлэн бус байсан учир хассан юм гээд байж байх вий дээ.

Тэгэхээр энэ төлөвлөлт чинь төдий чинээ маш их тийм шүүсийг нь шахсан ар дээр нь дандаа нөгөө санхүүжилтийн эх үүсвэр нь байсан ийм хэмжээнд авч үзэж төлөвлөхгүй бол эргээд нэг ийм байнгын эргэж буцсан л нэг ийм шийдвэрүүд гараад байдаг болчихлоо шүү дээ..../минут дуусав/

Х.Булгантуяа: Гантөмөр сайд нэмж хариулъя. Баярмаа гишүүн уурлаагүй байх. Зүгээр сая асуусан шүү.

Л.Гантөмөр: Түрүүн тэнд Эрдэнэбат нөгөө үндсэн чиглэлд энэ төлөвлөгөөнд орохдоо ямар хуулийн шаардлага хангадаг тухай л тайлбарласан. Төсвийнхөө зарлагын хэмжээнд бид нар нийцүүлж байгаа. Жишээлбэл төсвийнхөө хөрөнгө оруулалтын хэмжээг 3.2 их наяд гэж тавьсан бол яг энэ хүрээндээ бид нар арга хэмжээнүүдээ төлөвлөж байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Нэг үгээр хэлбэл ирэх оны төсөвт тусгагдаагүй зүйлс бол 2027 оны төсөвт тусгагдах боломжтой. Тийм учраас бид нар түрүүн буруу төлөвлөчихсөн юм байна лээ. Тийм учраас дараа жил хийхгүй юм гэж ийм яриа бол гараагүй шүү. Засгийн газар зорьсон зорилгоосоо ухарсан нэг ч төсөл байхгүй. Их Хурал дэмжихгүй байгаа зарим асуудлууд байна. Тэр бол Их хурлын шийдвэр шүү. Түүнээс Засгийн газар өөрийнхөө гаргасан санаачилгыг зогсоосон, ухарсан зүйл бол ерөөсөө гаргаагүй байгаа. Гаргахгүй гэж байгаа. Төлөвлөсөн 4 жилийнхээ хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх итгэл үнэмшилтэй .../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат гишүүн.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Тэгээд миний гарт Үндэсний аудитын газрын 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний хэрэгжилт гээд байгаа. Хэрэгжилт 2 сарын өмнө 52,8 хувьтай байсан. 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөл орж ирж байна. Энэ дээрээ бас нэлээн ултай суурьтай хандсан байх гэж ажил хариуцаж байгаа бүх хүмүүстээ бол найдаж байгаа. Тэгээд энэтэй холбоотой 2, 3 асуулт асууя.

2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл төрийн байгууллагуудын зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлнэ гэж байгаа. Яг ямар ямар чиг үүргүүдийг шилжүүлэх гэж байна. Тодорхой. Энэ дээр нэг асуулт. Хэзээнээс эхлэх вэ.

2 дугаарт нь баялгийн санг арвижуулах хүрээнд геологи хайгуул болон ашиглалтын түвшнийг нэмэгдүүлэх стратегийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна гэж байгаа юм. 2026 онд яг ямар ямар стратегийн орд эдийн засгийн эргэлтэд орох гээд байна. Аль сум, аль аймаг. Тэр чинь бас ажлаа цаашаа төлөвлөмөөр байна шүү дээ. Энийгээ тодорхой хариулаад өгчхөөрэй.

3 дугаарт нь төсвийн урсгал зардлыг 15 хувиар бууруулж, ДНБ-ийг 24 хувьд барих, төрийн албан хаагчдын тоог 8 хувиар бууруулах реформын шинжтэй ийм бодлогын юм орж иржээ. Бараг 20 мянган төрийн албан хаагч ажлаас бол халагдах юм байна. Энэ хүмүүсийн цаашаагаа яаж ажил хөдөлмөрөө хийх боломж бололцоог нь судалж тооцсон тооцоо байвал энийг сонсчихмоор байна. Жавхлан сайд бол төсвийн зардлыг бууруулж болохгүй гэдэг байр суурин дээр байдаг хүн 15 хувиар бууруулна гэсэн байна. Энэ нь яг аль аль зардлуудаас бууруулах юм бэ.

4 дүгээрт нь 2026 оны бодлогын тэргүүлэх чиглэлийн 3.4.6-д 10 мянган нарны дээвэр хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж байгаа. 14 хоногийн өмнө билүү Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр Чойжилсүрэн сайд орж ирээд манай эрчим хүчний салбар 4 толгойтой болсон гэсэн. Нөгөө 10 толгойтой атгаалжин хар мангас гэдэг шиг 4 толгойтой болсон. Бид нар шийдвэр гаргаж чадахгүй байна. Хүнд байна, хэцүү байна гэсэн. Доржханд сайд байна уу. Доржханд сайд Эрчим хүчний үндэсний реформын хороог байгуулахдаа бид нарт бараг 10 хэдэн зүйл заалттай материалууд танилцуулж байсан. Хэрэгжсэн ажил одоогийн байдлаар байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийг яаж ямар арга замаар хэрэгжүүлэх гэж байна. Өнөөдөр 4 толгойтой болчихсон гээд сайд нь яриад сууж байдаг. Тэгээд сайд нь байвал бас энэ дээр хариулт авчихмаар байх юм.

5 дугаарт гадаадын зээлийн ашиглалтын хэмжээг нэмэгдүүлнэ. Төслүүдийн хэрэгжилтийг хурдасгах шаардлагатайг энэ дээр бас танилцуулсан байна. Энэ шаардлагатай. Тэгвэл одоо зарим Их Хурлын гишүүд өнөөдөр зарим гадаадын тусламж зээлээр хэрэгжүүлэх арга хэмжээг төсвөөс гадуур авч явах гээд хуулийн төсөл санаачлаад явж байгаа. Энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам ямар байр суурьтай байгаа юм. Ер нь Монгол Улсын төсөв нэгдсэн 1 төсөвтэй байх юм уу. Энэ чинь төсөвтэй болох гээд байна шүү дээ. Одоо бол 2 төсөвтэй гэж яриад байгаа шүү дээ. Улсын нэгдсэн 1 төсөв, нөгөөдөх нь төрийн өмчит том компаниудын төсвөө бид нар мэдэхгүй байгаад байгаа. Энийг дахиад гадаадын зээл тусламжийг нь тусдаа 1 төсөв болгоод ингэж авч явах ёстой юм уу. Энийг хариулаад өгчихвөл зүгээр байгаад байна.

Дараа нь татварын багц хуулийн ажлын хэсэг ажлаа хийж байгаа. Татвар багасах юм уу, багасахгүй юм уу. Иргэд, аж ахуйн нэгжүүд энийг хүлээж байна. Их Хурлын гишүүд 126 гишүүнтэй болчихоод энэ татвар багасаад, зөв бодлого, зөв менежментээр улс эх орныг авч явж чадах уу, үгүй юу гэдгийг харж байна. Хэрвээ энийг зөв хийж чадахгүй бол Их Хурлын дархлаа ч гэсэн унах гэж байгаа юм. Тэгээд энэ дээрээ Жавхлан сайдаас хариулт авчихмаар байна.

Хамгийн сүүлд нь Их Хурлын даргыг магтахгүй бол болохгүй байх. Энэ Улаанбаатар хоттой холбоотой төсөл хөтөлбөрүүдийн хэчнээн нь яг энэ гаднын компаниуд тендерийг нь авчхаад байгаа юм. Энэ хотын орлогч дарга сууж байх шиг байна. Бүх төслүүдийг чинь авчхаад байгаа юм уу. Тодорхой яг тэр тэр төслүүдийг авчхаад байна гээд энэ дээрээ хариултаа өгөөд, дотоодын буюу энэ барилгын салбарыг хөгжүүлсэн энэ олон аж ахуйн нэгжүүдээ яаж дэмжих юм бэ. Тэрийг нэг .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд эхлээд хариулах уу. Төсвийн зардал бууруулахтай холбоотой татвар бууруулахтай холбоотой. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Очирбат гишүүн ээ, та хүн андуурсан юм шиг байна шүү. Төсвийн суурь зардлыг бууруулахгүй гэж Сангийн яам хэзээ ч, хаана ч, ямар ч тийм байр суурь илэрхийлж байгаагүй. Хэрвээ та тэгж сонссон бол тэрийгээ нотолж өгөөрэй. Нотолж өгөөрэй за юу.

Энэ үндсэн чиглэл дотор урсгал зардлыг 15 хувь бууруулна гээд бид нар 4 жилийнхээ том бичиг баримтад хийчихсэн байгаа. Тийм учраас бид ирэх жил, энэ жил бид нар бас нэлээн буулгасан. Ирэх жил дахиад буулгана. 2027 онд ч дахиад

буулгана. 2028 онд ч дахиад буулгана. Ингээд нийт төсвөө ер нь бид ДНБ-ийхээ 30 хувь дотор багтаах, урсгал зардлаа ер нь 25 хувиас доош оруулах энэ зорилгодоо хүрнэ. Дээрээс нь бид энэ ирэх жилүүдэд томоохон ер нь реформуудыг цаг алдалгүй урагшлуулъя гэдэг дээрээ бүгд санал нийлээд ингээд явж байгаа. Тэр дотор саяын таны хөнддөг татварын реформ явж байна. Татварын реформ бол өөрөө нэлээн том өртөгтэй хийгддэг. Одоогоор бид нарын ямар ч байсан судалгааны түвшинд бэлдчихсэн байгаа татварын реформ маань төсөв дээр багадаа 4 их наядын өртөгтэй болно. Яг төсөв дотроо бичилтээ хийгээд ирэх юм бол энэ чинь ингээд бүр 2 талдаа даблдаад 8 их наядын өртөгтэй болно. Энийг багтаахын тулд бид төсвийн урсгал зардал дээр, цаашилбал бүр хөрөнгө оруулалтаа ч танана. Ингээд ямар ч байсан энэ 4 жил бол татварын реформын ийм 4 жил байх болно. 1 далайлтаар энэ чинь бас бүгдийг нь хийж бид нар амжихгүй. Төсөв дийлэхгүй. Тийм учраас ер нь 3-4 багц болгоод 4 жилийн хугацаанд ингээд цувуулаад төсөв дээрээ шат дараатайгаар ачааллаа аваад, эдийн засгийнхаа суурийг тэлэх талдаа ийм бодлого ингээд явуулна гэсэн үг.

Татварын реформ бол бид нэг удаа энэ жил гэнэт сэтгэл хөдлөлөөр хийх гэж байгаа зүйл биш. Сүүлийн ер нь ковидоос хойш энэ сэдэв бол нэлээн хөндөгдсөн. Нэлээн судалгаа, шинжилгээ хийгдсэн. Ингээд ямар ч байсан хэлэлцүүлэг бол нэлээн далайцтай хийгдсэн. Маш олон ч саналуудыг авсан. Авах ч санал байна, авч дийлэхгүй ч саналууд байгаа. Тийм учраас ер нь удахгүй дээ 5 сардаа багтаад бид ямар ч байсан Улсын Их Хуралд өргөн барихаар Засгийн газар нэлээн шахуу ажиллаж байна. Ингээд бараг ирэх 7 хоногоос ер нь эхнээс нь өргөн барих болов уу гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Х.Булгантуяа: Жавхлан сайдад нэмж минут өгье.

Б.Жавхлан: Тэр зээлийн ашиглалт гэж байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууна лээ. Яах вэ би бас нэмээд хариулчихъя. Монгол Улс бид зээлийн хязгаартаа багтаж амьдрах хэрэгтэй Очирбат гишүүн ээ. Тэрийг хэн ч, хаана ч хөндөөгүй болов уу гэж бодож байна. Таныг ч бас хөндөхгүй болов уу гэж бодож байна. Төсвийн зардлын хязгаар, Монгол Улсын зээлийн хязгаар 2 чинь 2 өөр асуудал шүү. Одоо Төсвийн хүрээний мэдэгдлээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирчихсэн байгаа зээлийн хязгаар 60 биш бүр 50 гээд оруулаад ирчихсэн байгаа. Энэ дотроо яаж ийж байгаад л багтана. Гишүүдийн тэр өргөн барьсан хууль дээр бол би баяртай байгаа. Дэмжинэ. Тэр дотор чинь Их Хурал шийдчихсэн, зээлийг нь ав гээд шийдвэрээ гаргачихсан ийм 3 төсөл байгаа шүү дээ. Тэгээд энэ 3 төсөл чинь маш олон шалгуураар бас давж гарч ирж байгаа юм. Энэ 3 төсөл нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэн, Сэлбэ сэргэлт эдгээр төслүүд өөрөө өөрсдийгөө энэ зээлээ төлөөд явчих төслүүд юм байгаа юм. Эргэн төлөлтөөрөө. Төслийн санхүүжилт .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тэгэхээр 1 удаа ингээд 2 өгүүлбэр 2, 3 минутаар бас ярьчих асуудал биш юм байгаа юм. Энэ бол ер нь бид нарын сайн мэддэг Азийн бар гэгддэг орнуудын 1980, 1990 онд яг туулж байсан зовлон нь байхгүй юу. Эдийн засаг нь тэлэх гээд байдаг, бүүст болох гээд байдаг. Гаднын хөрөнгө оруулалт санхүүжилтүүд зээлүүд нь бүтээд байдаг гэтэл нөгөө жижигхэн нөгөө төсвийнхөө хязгаар дотроо багтчихаад, тэрийгээ зарлагадаж чаддаггүй. Зээл чинь ингэдэг байхгүй юу. Эх үүсвэр нь болохоор төсвийнхөө орлого талд бичигдэхгүй, зардал

талдаа ашиглалт нь бичигдэж явдаг манайх ийм дүрэмтэй байхгүй юу. Гэтэл нөгөө төслүүд чинь өөрсдөө томроод Их Хурал дээрээс зөвшөөрч байгаа зээлийн дүнгүүд нь томроод байдаг. Гэтэл энэ хязгаартаа багтах гээд олигтой ашиглалтаа хийж чадахгүй, нөгөө төслүүдээ ашиглалтад оруулж чадахгүй. Одоо байгаа энэ багтаамж энэ хурдаараа энэ 3 төсөл чинь дахиад 10 жил явахаар байгаа шүү. Ашиглалтад орох гэж. Гэтэл бид нар нефть боловсруулах үйлдвэрийг 2028 оны 5 сард ашиглалтад оруулах ёстой. 5,7 их наяд төгрөг. .../минут дуусав/

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя. Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Чойжилсүрэн сайд маань ороод ирлээ. Нөгөө Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр эрчим хүчний салбар 4 толгойтой болчихсон гээд та хэлсэн. Нөгөө 10 толгойтой атгаалжин хар мангас гэдэг шиг. Шийдвэр гаргахад хүнд байна гэсэн. Эрчим хүчний яам шийдвэр гаргахаар болохгүй. Эрчим хүчний реформын үндэсний хороо нь хажуугаас орж ирээд байдаг. Одоо бас Хэрэг эрхлэх газар дээр цуглуулж байгаа тэр “Эрчис Монгол” гээд компани байна гээд байгаа. Өшөө бас 1 толгой хэлсэн шүү дээ. Та энэ толгойнуудынхаа учрыг олоод, ер нь эрчим хүчний салбар цаашдаа яаж явах юм. Энэ 10 мянган дээвэр төсөл чинь хэрэгжих юм уу, хэрэгжихгүй юм уу. 0.7 га газартай байгаа иргэн өөрийнхөө газар дээр сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалт хийгээд оруулалт хийгээд, тэндээс орлого олгох боломж нь байгаа юм уу, байхгүй юм уу. Тэрийг та нэг хэлээд өгч байгаач. Уг нь Доржханд сайд байсан бол их зүгээр байсан юм. Доржханд сайд бүр яг тэгж хэлж орж ирээд, Аж үйлдвэрийн байнгын хороон дээр би бас танаас асуусан шүү дээ. Тэгсэн чинь хүнд байна. 4 толгойтой болчихсон гэсэн. Толгойнуудаа яаж таслах вэ сайд аа. 1 толгойтой болмоор байна.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт Улсын Их Хурлын гишүүнүүдээс уучлалт хүсье. Сая 11 цагт томилолтоор яваад, онгоцноос буугаад шууд хүрээд ирлээ. Өглөө амжсангүй. Томилолтоор явж байсан учраас хүлцэл өчье.

Очирбат гишүүний асуултад хариулъя. Яг бодит байдал ийм байгаа. Эрчим хүчний салбар 4 толгойтой болсон. Эрчим хүчний реформын Үндэсний хороо гэж байна. Улсын Их Хуралд дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Энхцэцэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг буюу Эрчим хүчний хууль болон бусад хуулийн төслүүд дээр өөрчлөлт оруулах талаар. Түүнээс гадна “Эрчис Монгол” гэдэг компани руу сая 3 сард эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын 66 хувь нь менежментийн эрх шилжсэн. Урьд нь бол Эрчим хүчний сайд энийг хариуцдаг байсан. Төрийн тэр 66 хувийн хувьцаа эзэмшигчийн эрхийг эрчим хүчний сайд хэрэгжүүлдэг ийм 4 талдаа 4 газар шийдвэр гардаг болсныг би түрүүчийн Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдаан дээр хэлсэн. Бодит/минут дуусав/

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд нэмээд хариулчихъя.

Б.Чойжилсүрэн: Ийм асуудлыг ярьсан. Харамсалтай нь Эрчим хүчний сайдын эрх мэдлээс давсан асуудал учраас яаж шийдэгдэхийг би урьдчилан таамаглаж хэлж чадахгүй байна. Сэргээгдэх эрчим хүчний тухайд зарим гишүүд гоё юм юу ярьдаг. Биелэх бололцоотой, техникийн хувьд биелэх бололцоотой юмыг бол

Эрчим хүчний яам дэмжээд явж байгаа. Биелэх бололцоогүй юу зүйлийг нь бол ийм байна, ингээд болохгүй гэдэг тайлбарыг нь хэлээд явж байгаа юм.

Айл болгон өөрөө сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлээд сүлжээнд нийлүүлэх юм бол жишээлбэл Улаанбаатар хотоор жишээ авахад 100 мянган айл сэргээгдэх эрчим хүчний илүүдэл дутагдлаа сүлжээнд 1 зэрэг нийлүүлж өгч, авна гэвэл системийн тогтвортой байдлыг одоо байгаа түвшинд нь хадгалж чадахгүй. Систем өөрөө тогтвортой байх ёстой. Хэрэглээ нь ч хувьсаж байдаг. Нийлүүлэлт нь ч хувьсаж байдаг. Ийм нөхцөлд бол системийн тогтвортой байдлыг хадгалах техникийн бололцоо байхгүй гэдгийг түрүүчийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын .../минут дуусав/

Х.Булгантуяа: Очирбат гишүүн ахиад 1 минут нэмж тодруулъя.

Г.Очирбат: Уг нь хоттой холбоотой, гадаад зээл, тусламжтай холбоотой зөндөө асуултууд асуусан шүү. Баялгийн сантай бас холбоотой асуултууд бас хариулт аваагүй байна.

Энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл дээр Чойжилсүрэн сайд аа, та өөрөө санал өгсөн биз дээ. Энэ яг 10 мянган нарны дээвэр хөтөлбөр гээд байгаа шүү дээ. Би эндээс асуугаад байгаа байхгүй юу. Хэрвээ энийг та дэмжээгүй бол хэн оруулаад ирчихсэн юм бол. Цаашдаа энэ хөгжлийн хөтөлбөр чинь биччихсэн байгаа бүх ажлууд чинь хоорондоо зөрчилтэй, сайд нарын саналаа оруулаагүй ийм байдалд тавиад энэ улс эх оронд чинь дахиад энэ хардаа. Би эхлээд сануулсан шүү дээ. 2024 оны аудитын тайлан шиг жилийн эцэст 2026 оны тайланг бид нар хэлэлцээд сууж байхад 50 хувьтай F дүнтэй ажилласан байх вий дээ. Ингэх юм бол Их Хурлын дархлаа сайд нарын манай парламентын засаглалын дархлаа хүртэл унах хэмжээнд яригдаад байна шүү л гэж би хэлээд байгаа юм.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. Энэ 4 толгойтой болчхоод гэдэг чинь яг энэ. Би наад саналыг чинь өгөөгүй. Гэтэл ямар учиртай юм ингээд жилийн төлөвлөгөөнд суугаад ороод ирчхээд байгаа юм. Энийг биелүүлж чадахгүй. Хэн ч чадахгүй.

Х.Булгантуяа: Нэгтгэн оруулж ирсэн Эдийн засаг, хөгжлийн сайд. Сайд нар нь ингээд байхаар үгүй мөн хэцүү юм. Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Бид нар бол ногоон корпорацаа байгуулсан. Ногоон корпорац дээр бид нар гаднаас мөнгө авч байгаа. Хөгжлийн банк бас тэр лүү мөнгөө нийлүүлж байгаа. Энд орж ирэх мөнгөөр бол угаасаа амины орон сууцыг сэргээгдэх эрчим хүчээр хангана гэсэн ийм Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй. Энэ хүрээндээ тархмал эх үүсвэрийг бид нар бол ирэх 7 хоногийн хурлаар тодорхой шийдэлд хүрье гээд магадгүй Чойжилсүрэн сайд нөгөө говийн бүсэд очоогүй. Тэр дээр Засгийн газрын хурлаар ийм шийдэлд хүрчихсэн шүү. Ерөнхий тархмал эх үүсвэр дээр бол чөлөөлнө. Бүгдийг нь хяналтдаа байлгах гэж оролдоод бол хэрэггүй. Тийм учраа нөгөө талдаа Ногоон хөгжлийн зээл чинь ороод ирчихсэн мөнгийг одоо бид нар ашиглана. Ашиглахдаа эрчим хүчний нэг төсөл рүү биш, айл өрхийн эрчим хүчний эх үүсвэрийг шийдэх зориулалттай сэргээгдэх эрчим хүчний болоод тэр эх үүсвэрийг нь .../минут дуусав/

Х.Булгантуяа: Төсөв нь бол байгаа юм байна. Тийм ээ. Энэ 2 маань хоорондоо яриагүй л юм шиг байна. Ингээд хэцүүхэн л юм болж дээ. Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг.

М.Ганхүлэг: Гишүүддээ олон улсын гэр бүлийн өдрийн мэндийг дэвшүүлье. Асуултаа бас үүнээс эхэлье. 2024 оны статистикаас харахад Монгол Улсад өдөр бүр ер нь 12 гэр бүл гэр бүлээ цуцлуулсан ийм мэдээлэл байгаа. Үүнийг бас сануулъя. 40 орчим хувь нь бол 10 хүртэлх жил болж байгаа залуу гэр бүлийн асуудлууд бас байна. Тэгэхээр 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд залуу гэр бүлийг дэмжих, ялангуяа орон нутагт байгаа залуучууд мөн бас залуу малчдын гэр бүлийн болон энэ нийгмийн асуудалтай холбогдолтой ямар асуудлуудыг тусгаж байна вэ гэсэн энэ асуултаас эхэлье гэж бодож байна.

Ерөнхий агуулгаараа бид хэлэлцэх эсэх асуудлыг ярьж байгаа. Энэ утгаараа ер нь Монгол Улсын Засгийн газар хүн амын дийлэнх хэсэг болсон энэ залуучуудынхаа төлөө байгаа юу гэдэг асуултыг би бас асууя. Залуучууд маш хэрсүүгээр удаа дараа өөрсдийнхөө санаа бодлыг илэрхийлээд маш идэвхтэй нийгмийн хувьд бол идэвхтэй байсаар байгаа. Гэсэн хэдий боловч энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд залуучуудтай холбогдолтой яг энэ асуудал гээд хэлэх хэмжээний ийм тодорхой заалт агуулгууд бол алга байна. Тэгэхээр ер нь агуулгынхаа хүрээнд бас тусгасан болов уу гэж бодож байна. Засгийн газар залуучууд руу чиглэсэн ямар үр дүнг бид 2026 онд гаргаж чадах вэ. Ер нь ирээдүйдээ итгэлгүй залуучууд, залуучуудаа сонсдоггүй төрийн энэ байдал нийгмийн хуваагдлыг бий болгох хэмжээ рүү очиж байна. Тэгэхээр энэ байгаа асуудлуудыг бид бүхэн мэдсэн ч мэдээгүй юм шиг явалгүйгээр тодорхой яг энэ ярьж байгаа асуудлууд дээрээ заалтууд болгож тусгах асуудлыг бид нар зайлшгүй анхаарах хэрэгтэй байна.

2026 оныг бид Залуусын хөгжлийг дэмжих жил болгон зарлах тухай ярьж байсан. Гэтэл өнөөдөр 1 бүлэг ч алга. Тэгээд ийм байгаа учраас бид энэ залуучуудынхаа хүлээлтэд нийцсэн ийм байдлыг бол бий болгож чадахгүй байна. Тэгээд энэ дээр бас ерөнхий байдлаар асуулт асууя.

3 дахь нь бас орхигдсон нэг зүйл байна. 2024-2028 оны хөгжлийн төлөвлөгөөнд хөдөө аж ахуй шинэ хоршоо хөдөлгөөн, чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэдэг тодорхой бүлэг заалтыг бид оруулсан. 2026 онд төлөвлөгөө дотор би буруу хараагүй бол шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбогдолтой ямар ч заалт алга. Жилийн өмнө хамгийн их яригдаж байсан энэ хөдөлгөөн энэ асуудал жилийн дараа бид анхаарахаа больсон уу. Шинээр байгуулагдсан 2024 онд бий болсон 7800 гаруй хоршоонуудаа 2026 онд бид нар яаж дэмжих вэ, яаж сургах вэ. Тэдэнд тулгамдаж байгаа төслөө хэрэгжүүлэх гээд явж байгаа энэ асуудлуудыг бид нар Засгийн газар ер нь анхаарахаа больчихож байгаа юм уу гэсэн ийм агуулга эндээс бас харагдаж байна. Төлөвлөгөөнд огт тусаагүй малын эзэн, үйлдвэрийн эзэн гэдэг шинэ агуулга хаанаас яагаад гараад ирэв. Тэгээд туссан ажлаа бид нар тусгахгүй мөртөө шинээр ийм өөр агуулгуудыг ингээд орж ирдэг тогтворгүй ийм байдалтай байгаа энэ алдаануудаа засах боломж бид бүхэнд байна уу.

Утааны ажлын хэсэгт бас миний бие ажилласан юм. Тэгээд Эрчим хүчний сайд маань бас энэ тал дээр эсрэгээрээ бид нар яндангаа буулгасан айлуудаа хохироосон асуудлыг 2025 онд гаргасан. 2026 онд энийг давтах уу. Энэ эрчим хүчний хөнгөлөлт гэр хорооллын нүүрс түлэхгүй байгаа айлуудыг дэмжих чиглэл рүү

явах заалт агуулга энэ дотор тодорхой туссан зүйлүүд байгаа юу гэсэн асуултуудыг би бас асууя.

Х.Булгантуяа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан түрүүлж хариулъя.

Л.Энх-Амгалан: Ганхүлэг гишүүндээ баярлалаа. Өнөөдөр бас дэлхий нийтээрээ гэр бүлийн өдөр гэж тунхагласнаас хойш 31 дэх жилийг үдэж байгаа. 32 дахь жилийг угтаж байгаа. Тэгээд өнөөдөр Монгол Улсын хэмжээнд бас Үндэсний гэр бүлийн өдөр болгож орон даяар тэмдэглэж байгаа өдөр. Тэгээд нийт Монгол Улсынхаа бүх гэр бүл, гэр бүлийн гишүүдэд бас Гэр бүлийн баярын мэндийг хүргэе.

Ингээд шинэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн дээр хуучин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг Гэр бүлийн яам болгож, хөдөлмөрийн бодлогын өмнө, нийгмийн хамгааллын бодлогын өмнө бол гэр бүлийн бодлого байна. Гэр бүлд суурилсан нийгмийн хамгааллын үндэсний тогтолцоог бий болгох энэ том бодлогыг хийх яамыг эмхлэн зохион байгуулсан байгаа. Энэ хүрээндээ яг 2026 оны төлөвлөгөө дээр гэр бүлийн гишүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээ сайжирсан байна гэж байгаа юм. Тэгэхээр нийгмийн үйлчилгээ сайжирсан байна гэдгийг яг юугаар хэмжих вэ гэдэг хэмжүүр шалгуур үзүүлэлтүүд зорилтот түвшин бас тодорхой байх ёстой. Тэгэхээр 2025 онд бид нар энэ хаврын чуулганд 2 хуулиа өргөн барих гэж байна.

1 дүгээрт нь Гэр бүлийн тухай хууль

2 дугаарт нь Гэр бүлийг дэмжих тухай хууль.

Тэгэхээр та сая бас өөрөө дурдлаа. Өнөөдөр Монгол Улсад бол 986 мянган өрх гэр бүл байна. Үүнээс жил бүхэн 17800 гэр бүл шинэ залуучууд гэрлэлтээ бүртгүүлдэг. Гэтэл 5-8 жилийн дотор энэ гэрлэлтээ бүртгүүлсэн энэ 17 мянган залуучуудын 4200 нь бол гэр бүлээ цуцлуулаад байна. Үндсэндээ 4 гэр бүлийн 1 нь цуцлагдаж байна гэсэн үг. Яг юунаас болоод байгаа юм бэ гэдэг шалтгаануудыг бас тодруулсан. Бид нар үндэсний хэмжээнд Монгол гэр бүлийн судалгаа хийсэн. Удахгүй бас Улсын Их Хурал дээр Байнгын хороон дээрээ бас танилцуулъя гэж бодож байна. Хэд хэдэн суурь асуудлууд байгаа. Мэдээж гэр бүлийн орлогын асуудал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал, мөн орон сууцын асуудал, хүүхдийн сургууль боловсрол, гэр бүлийн боловсрол, эрүүл мэндийн хүртээмжийн асуудал, гэр бүлийн амьдрах орчны асуудлууд гээд хэд хэдэн суурь асуудлууд байгаа. 1 өдөр гоё өргөс авсан юм шиг болчихгүй хууль батлагдсанаар. Тэгэхээр энэ гэр бүлийг дэмжих тухай хуулийн хүрээнд бид нар яг энэ Монгол гэр бүлийн өмнө тулгамдаад байгаа асуудлуудыг бид нар их онцлогтойгоор авъя. Яг одоо та маш зөв эмзэг сэдвийг хөндөж ярьж байна. Энэ залуу малчдын, залуу малчин гэр бүлийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг яаж шийдэх вэ. Энийг яаж бид нар дэмжих вэ. Яавал залуучууд маань хөдөө тогтвор суурьшилтай аж төрж амьдрах вэ. Байнга орлоготой байх вэ. Стандарт хангагдсан амины орон сууцуудаар яаж хангагдах вэ. Эрүүл мэндийнх нь үйлчилгээ хүртээмжийг бид нар яаж шинэ түвшинд гаргах вэ. Нийгмийн хамгаалал ирээдүйд тэтгэвэрт гарахад нь нийгмийн хамгааллын асуудлуудыг нь яаж шийдэх вэ гээд цогцоор нь шийдэх/минут дуусав/

Х.Булгантуяа: Энх-Амгалан сайд нэмж хариулах уу.

Л.Энх-Амгалан: Ийм хэлбэрээр яг ийм цогц үйлчилгээг үзүүлэх ийм эрх зүйн шинэчлэлүүдийг хийсэн жил байх болно. Тэгээд мэдээж хөдөө орон нутагт энэ гэр бүлийн цогц үйлчилгээний төвүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулъя гэж байгаа юм. Энэ бол шинээр байшин барилга барина гэсэн үг биш. Сум дээр, аймаг дээр, дүүргүүд дээр байгаа ашиглалт муутай байгаа төрийн үйлчилгээний байгууллагуудыг бид нар салбар дундын зохицуулалтаар гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээнүүдийн төвүүд болгож ингэж шинэчлэн зохион байгуулахаар бас ажиллаж байгаа. Энэ хүрээнд 2026 онд нэлээн тийм ахиц гарсан жил байх болов уу гэж бодож байна.

Өнгөрсөн 9 сарын 1-ээс бид нар ямар ч байсан 330 сум, 170 хороондоо хүүхэд хамгаалал, гэр бүл хариуцсан нийгмийн ажилтантай болсон. Энэ бол үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд маш чухал дэд бүтэц, хүний нөөцийн сайн дэд бүтэцтэй болсон. Энэ чиглэл рүү бол нэлээн ахиц дэвшил гарах болов уу гэсэн ийм бодолтой байна. Залуучуудын бодлогыг бол Номин сайд хариулах байх.

Х.Булгантуяа: Номин сайд залуучуудын асуудалд нэмж хариулъя.

Ч.Номин: Ганхүлэг гишүүндээ баярлалаа. Ганхүлэг гишүүн бол маш чухал сэдвийг хөндөж байна. Энэ дээр яг үнэхээр байхгүй болсон. Энэ бол бодитой зүйл. Залуучуудын яамны зүгээс бол бид нар саналаа Эдийн засаг, хөгжлийн яаманд Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд орсон хэлбэрээр нь хүргүүлсэн. Гэхдээ энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд орсонгүй гээд бид нар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхгүй орхихгүй. Бидний хувьд залуучуудын хөгжлийн оролцоог нэмэгдүүлэх, залуучуудын хөгжлийг дээшлүүлэх ийм хөтөлбөр стратеги гаргаад, үүнийгээ хэрэгжүүлнэ гэсэн ийм төлөвлөгөөг бол Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ хэрэгжүүлээд явна. Бидний хувьд бол энийгээ хэрэгжүүлэхдээ хамгийн гол нь та бүхэнтэй хамтарч Залуучуудынхаа хуулийг шинэчлэн батална гэж үзэж байгаа. Манай хөтөлбөр, стратеги маань 7 тулгууртай байгаа. Энэ дотор түрүүн Энх-Амгалан сайдын хэлсэнчлэн хөдөө орон нутагт .../минут дуусав/

Х.Булгантуяа: Номин сайдын микрофоныг нэмж өгье. Манай Ганхүлэг гишүүний залуучуудын асуудалд онцгой ач холбогдол өгч анхаарч байгаа. Тэгэхээр бүтэн хариултыг нь авчихмаар байна.

Ч.Номин: Хөдөө, орон нутагт ажиллаж, амьдарч байгаа малчин залуучуудын хөгжлийг яах вэ. Өөрийнхөө малаа маллангаа яаж сурч боловсрох боломжийг олгох вэ, яаж бизнес эрхлэх вэ. Дээрээс нь орон нутагт амьдарч байгаа залуучуудыг бизнес эрхлэх боломжийг яаж нэмэгдүүлэх вэ. Мөн үүнээс гадна нийт залуучуудын 6 орчим хувь нь гадаадад амьдарч байгаа. Буцаж яаж эдгээ тэр залуучуудыг Монголдоо авчирч боловсон хүчнээ нэмэгдүүлэх үү гэх мэтчилэн эдгээр залуучуудад чиглэсэн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, орон сууцжуулалтын бодлого хөтөлбөр, дээрээс нь стратеги нь гарсан. Энийгээ бид нар 2026 онд суусан байсан ч, байхгүй байсан ч хамаагүй хэрэгжүүлээд, Засгийн газрын үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хүрээнд хийгээд явна. Тэгээд үүнийгээ Ганхүлэг гишүүнтэй хамтраад хийхэд бэлэн байгаа.

Яг энэхүү хөтөлбөрийн хүрээнд, хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд бол орон сууцжуулах хөтөлбөр маань орсон байгаа. Энэ дээр миний түрээсийн орон сууц, миний анхны орон сууц гээд эдгээр ажлууд .../минут дуусав/

Х.Булгантуяа: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарч хэрэгжүүлнэ гэж байна. Ганхүлэг гишүүн нэмж тодруулъя гэсэн байна.

М.Ганхүлэг: Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбогдолтой асуултдаа бас хариулт авъя. Тодорхой л зүйлийг хүсээд байгаа юм л даа залуучуудын хувьд. Тэгээд байгаа асуудлуудыг нь тодорхойлоод, илүү уялдаа холбоотой ажиллах чиглэл дээр ер нь арай нэг ахиц дэвшил гараасай л гэдэг ийм талаас нь бас саналаа хэлээд байгаа юм. Тэгэхгүй ингээд 2 талд ингээд гарчхаад аль нь алиныгаа ойлгодоггүй ийм нийгмийн хуваагдал руу явах тусам энэ бас тодорхой сөрөг үр дагаврууд бол гарна. Шинэ 30 жилийг бас тогтвортой байгаасай гэж хүсээд байгаа. Илүү нийгмийн олонх болсон бүлгээ сонсдог, ойлгодог ийм бас тогтолцоо байгаасай гэдэг агуулгын хүрээнд яриад байгаа юм.

Тэгээд соёлын яамнаас оруулсан саналуудыг 7, 8 саналуудыг өгсөн юм шиг байна. Түүнээс 1 л санал нь орсон байгаа. Залуучуудын асуудлаар. Тэгээд яагаад хасагдсан бэ гэдэг чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас нэмэлт тодруулга авъя. Шинэ хоршооны тухай бүр дурдахаа больж байгаа асуудал дээр үнэхээр яг бодитой хариулт авахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: Шинэ хоршооны асуудлаар Энхбаяр сайд хариулах уу. Эдийн засаг, хөгжлийн яамнаас ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Шинэ хоршооны асуудлыг Үндэсний хороо тусдаа байгуулагдсан. Монгол Улсын Шадар сайд Амарсайхан хариуцаж, удирдлага, зохион байгуулалт бодлогыг нь хариуцаж байгаа. Ийм зохицуулалттай яваа шүү. Тэгэхээр Шадар сайд ажлын албанаас хариулах нь их зүйтэй байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: 4 номерын ажлын хэсгийн микрофон.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яамны Эрдэнэбат. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028-д тусгагдсан төсөл, арга хэмжээ ажлууд бол хийгдэнэ. Энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй гэдэг нь хийхгүй гэсэн үг биш. Зарим 1 урсгал зардлаар тодорхой төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөө шийдэж болох ажлууд нь энэ дээр орхигдсон, оруулаагүй тал бий. Гэвч энэ нь бол юу гэдэг юм хийгдэхгүй гэсэн ажил биш. Үргэлжлэх ажлууд нь үргэлжлээд явах юм.

Х.Булгантуяа: Ганхүлэг гишүүн дахиж тодруулъя гэсэн байна. Ганхүлэг гишүүний микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Тэр Соёлын яамны оруулж ирж байгаа саналууд дээр дахиад тайлбар нэмэлтээр бас авъя. Яагаад хасагдсан юм.

Х.Булгантуяа: Номин сайд. Эдийн засаг, хөгжлийн яам 4 номер.

Ц.Эрдэнэбат: Соёлын яамны ажлууд дээр зарим ажлууд нь бол нөгөө урсгал зардлаар хийгдэж болох, эсвэл үргэлжлээд өөр эх үүсвэрээр үргэлжлээд хийгдэж болох ажлууд байсан учраас бас нөгөө түрүүний ярьсан шалгуур болон бусад агуулгын хүрээнд ороогүй. Тэгэхдээ энэ нь бол бас хийгдэхгүй гэсэн ажил биш. Энэ ач холбогдол өгөхгүй байгаа гэсэн үг бас биш. Бид нар яг юу гэдэг юм ажлын хэсгийн

хүрээнд зарим нэгэн тухайлсан ажлуудыг нэмэлт саналаар таны хэлсний дагуу оруулах бас боломжтой байгаа.

Х.Булгантуяа: Номин сайд нэмж хариулъя.

Ч.Номин: Ганхүлэг гишүүний санаа тавьж байгаад маш их баярлаж байгаа. Бид нар нийт хүн амынхаа талаас дээш хувьд бараг хүрэх гэж байгаа залуучуудынхаа асуудлыг бол бид нар заавал хөгжлийн төлөвлөгөөндөө оруулж явж байх ёстой. Тэгээд яамтайгаа хамтраад бид нар бас та бүхэнтэй хамтарч ажиллана. Тэгэхдээ дараагийн жил боловсролын жил болгож зарлаж байгаа. Энэ нь залуучуудын асуудал орхигдож байгаа гэсэн зүйл бас биш. Бид нар боловсролын жилээр харин дамжуулж илүү залуучуудынхаа асуудал дээр анхаарч байгаа гэдгийг бас түрүүн хэлэхээ мартсан байгаа учраас хэллээ. Тэгээд түрүүн бас Эдийн засаг, хөгжлийн яамтай адилхан бид нар хөгжлийн төлөвлөгөөнд ороогүй байсан ч үйл ажиллагааны хөтөлбөрт орсон учраас ажлаа бол хэрэгжүүлээд аваад явна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Тодорхой асуултуудыг сайд нараас асуугаад явчихъя. 2025-2026 оны өвөлжилтийн хүрээнд ямар түлш түлэх вэ Улаанбаатарчууд. Одоо байгаа түлшнийхээ нөөцийг яаж бүрдүүлж байгаа вэ. Технологио яаж өөрчилж сайжруулж байгаа вэ Чойжилсүрэн сайд аа. Дахиад нөгөө утаатайгаа өвөлжих үү яах вэ гэдэг дээр хариулт өгөөч ээ.

Энх-Амгалан сайд нийгмийн даатгалын тогтолцоог өөрчлөх НДШ-ийн хувь хэмжээг бууруулах бололцоо боломж байгаа юу. Нийгэмд ийм хүлээлт үүсчихлээ. НДШ-ийг бууруулах юм байна гэдэг. Та бүхэн салбарын хэмжээнд бодлого барьж байгаа хүмүүс ямар бодлого барьж байна вэ. Ирэх жил нийгмийн даатгалын тогтолцооны хувьд ямар өөрчлөлт, шинэчлэлтийг хөгжлийн төлөвлөгөөндөө тусгаж байгаа вэ.

Сангийн сайдаас татварын хувь хэмжээг бууруулах бололцоо боломж байгаа юу. Татварын эрх зүйн орчныг сайжруулах тал дээр яам ямар бодлого барьж ажиллаж байна вэ. Хөгжлийн төлөвлөгөөнд хэрхэн яаж туссан бэ.

Хөдөө аж ахуйн сайдаас энэ хөгжлийн төлөвлөгөөнд ерөөсөө малын гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуурыг боловсруулах ажил ерөөсөө огт тусаагүй байх юм. Одоо энэ малчдын арьс шир хог дээр хаягдаад байх энэ ажил хэр удаан үргэлжлэх юм бэ. Дархан дээр арьс шир боловсруулах үйлдвэр гээд л олон жил яригдсан. Энэ ажил ер нь ямар шатдаа байгаа юм бэ. Энэ ажлыг ажил хэрэг болгохгүй юм уу. Та энэ сайд байх хугацаандаа. Энийг ажил хэрэг болгож чадвал үнэхээр энэ хэдэн малчдад хэрэгтэй байна. Арьс шир боловсруулах үйлдвэрийн юу нь болохгүй байгаа юм. Юу нь гацаад байгаа юм. Хөрөнгө мөнгө байхгүй гээд байгаа юм уу. Эдийн засаг, ТЭЗҮ байхгүй гээд байгаа юм уу. Яагаад энэ ажил хэрэг болж болдоггүй юм бол гэсэн ийм 4 асуултыг 4 сайд маань хариулж өгөөч ээ.

Х.Булгантуяа: Эхлээд Чойжилсүрэн сайд Улаанбаатар хотын ирэх жилийн түлшний асуудал.

Б.Чойжилсүрэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Сандаг-Очир гишүүн ээ, энэ асуултыг надаас биш Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас

асуух ёстой. 2023 оны 12 сарын 31-ээр дуусгавар болгоод, тухайн үеийн Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгаад, нийслэлийн агаарын асуудлыг нийслэлийн Засаг даргад хариуцуулаад, бусад орчны бохирдлын асуудлыг Байгаль орчны сайдад хариуцуулаад ийм шийдвэр гарчихсан. Тэгэхээр одоо манай Эрчим хүчний яам энийг хариуцахгүй байгаа учраас таны асуултад хариулах бололцоогүй байна.

Х.Булгантуяа: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариулт өгөхөд бэлдээрэй. 4 номерын ажлын хэсгийн микрофон дээр. Засаг даргын орлогч Даваадалай

Т.Даваадалай: Сайн байна уу. Гишүүний асуултад хариулъя. Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай. Ирэх оны Улаанбаатар хотын түлшний бэлтгэлийн хувьд Улаанбаатар хотыг ногоон, шар бүсээр хувааж, ногоон бүсийн 51 мянган айл өрхийг цахилгаан болон газ эх үүсвэр дээр холбохоор бэлтгэл ажлуудыг төлөвлөгөөний дагуу хийгээд явж байгаа. Бусад хэсгүүд дээр болохоор бол ирэх жил 340 мянган тонн нүүрсийг бэлтгэнэ. Үүнээс 40 мянгыг нь бол уламжлалт аргаараа, 300000-ыг нь бол хөх нүүрсэнд шилжүүлэх гээд бэлтгэл ажлыг үндэсний хороон дээрээ ярилцаад явж байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Ганцхан минутад хариулж чадахгүй юм байна. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ өөрөө их том реформын шинж чанартай асуудал. Түрүүн манай Жавхлан сайд бас хэллээ. Татварын хуулийн реформ шинэчлэл нийгмийн даатгалын реформ гэдэг бас нэлээн тийм тогтолцооны шинж чанартай. Тэр тооцоо судалгаа үндэслэл сайтай реформ хийхгүй бол 1 удаагийн тийм гал унтраасан арга хэмжээ авч, нөгөө хойд хормойгоо авч, урд хормойгоо нөхсөөр яваад өнөөдрийн ийм тогтолцоо дээр маш том асуудлууд үүсчхээд байна. Яг ямар асуудлууд үүсчхээд байна вэ гэхээр 1 дүгээрт мэдээж яагаад ер нь энэ тэтгэврийн реформ хийх үндэслэлүүд үүсчхэв гэж.

1 дүгээрт бол хүн амын насжилт нэмэгдэж байгаа. Нөгөө яг жинхэнэ жишээ аваад хэлэх юм бол урьд нь 1 хүний төлж байсан НДШ-ээр 3 хүний тэтгэврийг тавьж байсан бол одоо 3 хүний төлж байгаа шимтгэлээр 1 хүний тэтгэвэрт хүрэхгүй хэмжээнд ийм асуудлууд бас ачааллууд ирж байна. Энэ бол тогтолцооны асуудал. Тогтолцооны асуудал. Тэгэхээр цаашдаа бид нар хуримтлалын тогтолцооноос хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоо руу шилжих ийм үнэхээр ийм шаардлага бас гарч ирж байгаа.

2 дугаарт нь тэтгэврийн үндсэн үзүүлэлтүүд ерөөсөө хоорондоо ямар ч уялдаагүй байна. Энэ шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэврийн нас, тэтгэвэр бодох хэмжээнүүд хоорондоо уялдаа оновчтой бус өнөөдөр байгаад байна. Энэ нь эргээд тэтгэврийн сан дээр маш том ачаалал өгч байна.

3 дугаарт нь хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэрт гардаг тоо хэмжээ асар их болсон байна. Өнөөдөр нийт тэтгэвэр тогтоолгож байгаа хүний 47 хувь буюу 2 хүний 1 нь хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэрт гарах ийм нөхцөлийг бид нар бий болгочихсон байна. Монгол Улсад ажил мэргэжлийн жагсаалт 4000 гаруй байхад бараг 1000 гаруй нь хөнгөлөлттэй нөхцөлөөр хэвийн бус нөхцөлөөр гардаг ажил

мэргэжлийн жагсаалт гаргачихсан ийм улс орон гэж дэлхий дээр 1 ч байхгүй. Энэ жил ирэх тусам тэтгэврийн сан дээр маш их ачааллуудыг өгч байгаа.

3 дугаар асуудал бол өнгөрсөн хугацаанд ер нь тэтгэврийн сан дээр маш их ачаалал өгсөн. Улс төржсөн, тооцоо судалгаа муутай хуулиудыг бид нар баталсан. Үүнээс болж 5,8 их наядын ачааллыг энэ сан дээр өгсөн. Бид нарын нөгөө 1979 оноос хойш нэрийн дансанд шилжүүлээд тэтгэвэр тогтоолгох энэ аргачлалыг бид нар сонгосон. 1995 онд. Гэтэл өнөөдөр цаашдаа яг энэ нэрийн дансаараа тэтгэвэр тооцохоор одоогийн байгаа тогтолцооноос бага тэтгэвэр авчих гээд байгаа. Нийгмийн хамгаалал нь буурах ийм нөхцөл байдал.

Эцэст нь бол нийгмийн хамгааллын хамрагдалт, албан бус секторын хамрагдалт, орлого цаашдаа энэ сангийн орлогыг нэмэгдүүлэхэд энэ хамрагдалт ерөөсөө ийм бодитой болж чадахгүй байна гэсэн ийм хэд хэдэн үндэслэл, нөхцөл суурь язгуур нөхцөлүүд үүссэн учраас бид нар энэ тэтгэврийн шинэчлэлийг илүү тогтолцооны шинэчлэл, дахиад дээрээс нь тэтгэврийн сангийнхаа алдагдлыг багасгах урт хугацаанд тэтгэврийн сангаа тогтвортой авч явах ийм л бодлого параметрийн буюу энэ шинэчилж .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Түрүүн бас гишүүдээс асууж байсан. Тэгэхээр Сангийн яамны хувьд бид төсвийн урсгал зардал бууруулах, хөрөнгө оруулалтыг илүү үр дүнтэй оновчтой болгох тал дээр үргэлж ажиллаж ирсэн. Цаашдаа ч энэ зарчим дээрээ байна. Одоогоор 208 хуулийн 1024 заалтаар энэ удаагийн төсөвт багтаагүй 14 их наяд төгрөгийн урсгал зардал ингээд хүлээгээд байж байдаг. Энэ бүхэн төсвийн зардлыг бууруулахад хамгийн том саад гэх үү, эсвэл даваа гэх үү, эсвэл сорилт гэх үү ийм зүйл болчихоод байгаа. Энэ бүгдийг судалгааг нь гаргаад хууль бүрээр нь 1 бүрчлэн Их Хуралд хүргүүлсэн байгаа. 2025 оны төсөв батлахад мөн бидэнд ийм үүрэг өгсөн. Энэ судалгааг ирүүл гээд. Ингээд харин ирүүлсэн байгаа .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайдад нэмж микрофон өгье.

Б.Жавхлан: Энэ дээр бол харин дараагийнхаа даалгаврыг авмаар байгаа. Энэ энэ хуулиудыг ингэж хойшлуул, энийг нь үйлчлэх хугацааг нь зогсоо, энэ хуулийг нь бүр хүчингүй болго ч гэдэг юм уу ийм саналуудаа оруулж ирэхэд бол бэлэн байгаа шүү гэдгийг дахин хэлье.

2026 оны төсөв өргөн баригдахаас өмнө энэ бүгдийг нэг тийш нь болгохгүй бол бид төсвийн зардлыг бууруулна гэдэг хууль давсан ийм үйлдэл болох гээд байгаа учраас бүгдээрээ энийг нэг тийш нь болгоход гишүүд харин санал 1-тэй 1 талдаа байна байх гэж найдаж байна шүү.

Татварын хувь хэмжээ гэж байгаа юм. Ийм байгаа шүү Сандаг-Очир гишүүн ээ, одоо бид яг төлөвлөгөө ярьж байна. Энэ төлөвлөгөө маань бол үндсэн 4 чиг үүрэгтэй, 4 хэсгээс бүрдэж байгаа. Эдийн засаг, бүсчилсэн хөгжил, хүний хөгжил, хүний эрхийг дээдэлсэн засаглал гээд үндсэн 4 хэсгээс. Үүний эдийн засаг дотор маш олон зүйлүүд байгаа. Ялангуяа хувийн хэвшлийг дэмжих, хувийн хэвшил, хувийн бизнесийн харилцааг дэмжсэн бүх хуулиудыг хэдүүлээ эргэж харъя гэж байгаа..../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайдад дахиад минут өгье.

Б.Жавхлан: Тэгээд татварын орчноо дэмжье гэж байгаа. Цаашдаа ер нь бид нар төсвөө нэлээн хумих учраас хөрөнгө оруулалтуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, гаднын хөрөнгө оруулалтууд, зээл тусламжийн хөрөнгө оруулалтуудыгаа аль болох нэлээн өргөн боломжуудыг нь опшнуудыг нь нэмж өгье гэдэг ийм өөрчлөлтүүдийг хийгээд явна. Татварын реформын багц бол удахгүй өргөн баригдана. Татварын багц реформыг харин 1 минутад, 3 минутад ярих бол ямар нэгэн боломжгүй. Тэгэхээр Хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ болон татварын тайлагнал, татварын харилцааг бүх шатад нь тодорхой хэмжээнд өөрчлөлтүүд орж байгаа ийм багц хуулийг удахгүй өргөн барина. Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг давхар цуг ажиллаад явж байгаа учраас Их Хурал бол тодорхой хэмжээнд бас мэдээлэлтэй. Бодлого дээрээ бас зэрэгцээд цугтаа энэ дээр явж байгаа гэдгийг дуулгая.

Х.Булгантуяа: Энхбаяр сайд. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр.

Ж.Энхбаяр: Арьс шир, ноос ноолуурын боловсруулалтын түвшнийг сайжруулах Улсын Их Хурлын 63 дугаар тогтоол гарч, “Цагаан алт” хөтөлбөр батлагдсан. Энэ хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа. Энэ хүрээнд бид ноолуурынхаа бүрэн боловсруулалтын түвшинд 20 хувийг 40 хувьд хүргэнэ. Ноосныхоо бүрэн боловсруулсны түвшнийг 25 хувийг 55 хувьд хүргэнэ. Арьс ширний боловсруулалтын түвшин 30-50-д хүргэх зорилготой бөгөөд энэ хөтөлбөрийн 18, 19, 20 дугаар зүйлд тодорхой туссан эх үүсвэртэй. Энэ жил хэрэгжиж байгаа бодлого үргэлжлээд явна. Үр дүн 2028 онд тайлагнахаар бодлого тогтвортой байгаа.

Одоо бол хүчин чадал хангалттай суурилагдсан. Ноос боловсруулах, ноолуур боловсруулах, арьс боловсруулах. Мөн түүнчлэн Ховд аймагт баруун бүсийн 5 аймгийн арьс.../минут дуусав/

Х.Булгантуяа: Энхбаяр сайдад нэмж минут өгье.

Ж.Энхбаяр: Ховд аймагт баруун бүсийн арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийн ажил үндсэндээ хөрөнгө оруулалт хийгдээд, маш идэвхтэй явж байна. Энэ ондоо дуусна. Ирэх оноос хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтууд бодитой тэнд ажил болохоор байна.

Дархан хот дахь арьс ширний парк бол Дархан-Уул аймагтай хамтарсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ бол хувийн хэвшлийн болон орон нутгийн хамтын түншлэл дээр үйл ажиллагаа явагдаж байгаа. Энд яамны зүгээс ямар нэг хэмжээнд оролцохгүй байгаа. Бид бол “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд одоо байгаа суурилагдсан хүчин чадал бүхий үйлдвэрлэл явуулж байгаа гол бүс нутаг болсон төвийн бүсийн үйлдвэрүүд дээр онцгой анхаарч, хүчин чадлыг нэмэх арга хэмжээг явуулж байна.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээрээс бас нэмж хариулахаар байгаа. Тэгчхээд нэмээд тодруулах уу. Тодруулга байхгүй. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр энэ Чойжилсүрэн сайдын хариултаас үзэхээр Эрчим хүчний яам чинь бараг татан буугдах хэмжээнд болчихоод байгаа юм уу хаашаа юм. Бүх ажлаа манайд хамааралгүй болгоод, хамаарч байгаа ажил нь юу байгаа юм. 66 хувь нь “Эрчис Монгол”-д оччихсон л гэнэ. Утаатай тэмцэх ажлаа нийслэлд өгчихсөн л гэнэ. Тэгээд Эрчим хүчний яам чинь юу хийх гээд байгаа юм. Ойлгохгүй байна 1-т.

2-т Гантөмөр дарга аа, та нар ингээд төлөвлөгөөндөө ирэх жил төрийн албан хаагчдыг 10 хувь цомхотгоно л гэх юм. Оруулж ирсэн хөгжлийн төлөвлөгөөнд чинь маш олон төвүүд байгуулах асуудлууд орчихсон байна. Энэ төвүүд байгуулагдахаар хэдэн төрийн албан хаагч нар нэмэгдэх вэ. Энийг нягталж үзсэн үү. Үгүй ээ, бүр Батлан хамгаалах яам дээр дрон угсралтын төв байгуулна л гэнэ. Тийм эрдэм шинжилгээ, судалгааны төв байгуулна л гэнэ. Тийм парк байгуулна л гэнэ. Тийм эм хангамжийн төв байгуулна л гэнэ. Үгүй ээ, энэ чинь нэг гараараа тоог бууруулна гээд, нөгөө гараараа баахан орон тоонууд нэмэх асуудал яриад байна шүү дээ.

Х.Булгантуяа: Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Ер нь парк эсвэл инновацын хөгжүүлэх төв энэ тэр бол тодорхой хугацаанд, тодорхой санхүүжилтээр хийгээд, тэгээд л хувийн хэвшил рүүгээ өгнө гэдэг ийм л зүйлс явна. Түүнээс биш төрийн алба бол мөнхийн цалинтай байгаад байна шүү дээ. Мөнхийн орон тоо. Тэгэхгүй бол ер нь төв гэдэг зүйл, хороо гэдэг зүйл бол байгуулагдаад асуудлаа шийдээд татан буугдах эсвэл тухайн байгууллага нь хувийн хэвшил рүү шилжих гэдэг ийм философиор л явах хэрэгтэй.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах.

Ж.Галбадрах: Баярлалаа. Бид өнөөдөр маш чухал асуудал хэлэлцэж байна. Энэ төлөвлөгөө дээр үндэслээд улсын төсөв гарах учиртай. Өнгөрсөн жилүүдийн улсын төсөвт хийсэн аудитын дүгнэлтүүдийг анхаарч үзэхийг хүсэж байна. Би үргүй зардал ихтэй маш их олон зөрчил гаргадаг ийм олон ажлууд төлөвлөдөг байсныг анхаарч нягталж үзэж байх гэж бодож байна. Би Боловсролын салбарынхаа төлөвлөгөөнд туссан ажлуудыг нэлээн нягталж харлаа. Ингээд бид нар ингэж их эрт ярьж байгаа маань салбаруудаа эрэмбэлэх боломжийг бид нарт олгоно гэж найдаж байна. Тэгээд өнөөдөр Монгол Улсад аль ч салбарт маань хүний нөөц маш их том дутагдалд орчихсон байгаа. Тэгээд чадварлаг хүний нөөцийг бол зөвхөн бид нар боловсролоо л чанаржуулж байж гаргаж ирэх ийм учиртай. Энийг хүн болгон мэдэж байгаа. Тэгэхээр Засгийн газраас ирэх 2026 оныг боловсролыг дэмжих жил болгон зарласанд туйлын талархалтай хандаж байгаа. Энэ салбарт оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Энэ салбарт ажиллаж байгаа багшлах боловсон хүчин, удирдлага, захирал, менежерүүдийн талаар авах арга хэмжээнүүд нэмэгдэнэ гэж ийм хүлээлт байгаа. Тэрчлэн мөн Сангийн яам, Боловсролын яам маань нэг ширээний ард суугаад, тооцоогоо нийлж байгааг харах бас их таатай байгаа. Би өөрөө хүртээмжийн дэд ажлын хэсгийг нь ахлаад суурь судалгаанууд хийсэн. Надад 4 асуулт байна.

Боловсролын яам ирэх жил ер нь боловсролыг дэмжих жил болгосонтой холбогдуулж ямар алсын хараа, ямар том зорилго тавиад байгаа бэ. Энийг их тодорхой хэлж өгөөч. 2028 он цаашлаад 2030 он гэхэд ямар түвшинд хүрэх тийм тодорхой зорилтууд энийг тоогоор хэлж өгнө үү гэж хүсэж байна.

Мөн төрийн өмчийн их дээд сургуулиудыг бодлогоор дэмжих ёстой гэж ярьдаг. Тэгээд энэ жил болгож зарласантай холбогдуулаад төрийн өмчийн дээд сургуулиудад ялангуяа өндөр технологийн лабораториудыг шинээр байгуулахад энэ төлөвлөгөөнд хөрөнгө оруулалт тусгасан уу. Энэ талаар тодорхой зүйл байвал хэлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Манай боловсролын салбарт бүх л салбарт хүний нөөц, ялангуяа боловсролын салбарт багшийн хомсдол бол бодитой нүүрлээд байна. Сургуулиуд бид нар олноор хүртээмжээ дээшлүүлэхийн тулд олон сургууль цэцэрлэг барих ийм тооцооллуудыг хэлсэн. Түрүүн Төрийн нарийн бичгийн дарга хэлж байсан. 108 сургууль, 95 цэцэрлэг бид нар барихаар байгаа. Тэгвэл энд шинээр сургуулиуд барилаа. Тэгээд багшгүй сургуулиуд бий болчих вий. Багшийнхаа нөөцийг яаж гаргах гэж байгаа вэ. Багшийн цалин хангамж, урамшуулал, нийгмийн асуудлыг шийдэхэд ямар шинэчлэлийн бодлогууд хийх гэж байна вэ. Ингэснээрээ хүний нөөцөө хэрхэн татаж чадах гэж байгаа вэ. Энэ талаар бас тодруулж асууя.

Эцэст нь бол Шадар сайдын ажлын алба Гантөмөр сайд өөрөө энд байгаа учраас би бас Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бүс нутаг бүрд Косейн сургуулийг байгуулна гэсэн зорилт тавьсан байгаа. Энэ төлөвлөгөөний 1.5.1.2-т бол Косейн хөтөлбөрийг нэвтрүүлэхэд 1,3 тэрбум төлөвлөснөөс 2026 онд 300 сая төгрөг төлөвлөжээ. Хөдөө орон нутгуудад шинээр косейн сургуулиуд байгуулагдаад эхэлсэн байгаа. Тэгээд энэ 300 сая төгрөг яг юунд зориулагдах мөнгө вэ. Энийг би Гантөмөр сайдаас асууя. Ер нь тэгээд Косейн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Боловсролын сайд байж байхдаа та эхлүүлсэн хүн. Тэгээд энэ талаар цаашдынх нь ирээдүйг нь юу гэж харж байгаа вэ гэдгийг бас тодруулж асууя.

Х.Булгантуяа: Баярлалаа. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал 4 номерын микрофоноос.

Х.Батжаргал: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Төрийн нарийн бичгийн дарга. 2026 оны хөгжлийн бодлогыг төлөвлөх, 2026 оныг боловсролын жил болгон зарласан явдалтай холбогдуулаад угтсан бэлтгэл ажлууд бол хийгдэж байгаа. Томоохон бас ажлын хэсгүүд гаргаад ажиллаж байгаа. Тэгэхээр энэ бол үндсэндээ 2 томоохон зорилгод чиглэж байгаа. Чанар болон хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын чанар, боловсролын хүртээмж.

Боловсролын чанарын асуудал бол мэдээж багш нарын хомсдол дутагдлыг арилгах, багш нарын тогтвортой ажиллах үйл ажиллагааг дэмжсэн хөшүүрэг болгосон бодлогуудыг бол дэмжиж байгаа. Тэгэхээр дэмжих жилийн гол үр дүн бол 2028 оны өсөн нэмэгдэж байгаа өндөр хэрэгцээг 2028 онд гарах үр дүнг л бэлтгэл ажлууд бол хийгдсэн. Энэ голлох төлөвлөлтүүд бол ингэж хийгдэж байгаа гэж хэлж болно.

Нөгөөтээгүүр их, дээд сургуулиудын боловсролын чанарыг нэмэгдүүлэх чиглэл дээр бол өндөр технологийн лабораторийн асуудлуудыг бол та хөндөж асуулаа. Энд бол одоо явагдаж байгаа бодлогын арга хэмжээнүүд бол байгаа. Жайка олон улсын байгууллагатай хамтраад мянган инженерийн төсөл гэж томоохон төсөл 10-аад жил хэрэгжиж байна. Маш амжилттай 98 хувийн гүйцэтгэл үр дүнтэй явж байгаа. Энэхүү төслийг дараагийн шатанд нь үргэлжлүүлж судалгааны их сургуулийн бэлтгэл ажил, судалгааны чиглэлээр өндөр технологи нарийн мэргэжлийн

лабораториудыг бол төрийн өмчийн Их сургуулиудыг өргөжүүлэн хөгжүүлэх энэ чиглэл дээр бол томоохон хөрөнгө оруулалтыг төлөвлөөд, төслийн дизайн бэлтгэл ажлууд бол хийгдэж байгаа гэж хэлэх байна.

Багшийн хомсдолыг арилгах чиглэлээр ер нь Монгол Улсын Засгийн газраас батлагдсан тодорхой бодлого байгаа. Тэр бол багшийн 3 тулгуурт хөгжлийн бодлого байгаа. Багшийн 3 тулгуурт хөгжлийн бодлогын хүрээнд бол нийгмийн асуудал, багшийн ажлын байран дээр тасралтгүй хөгжлийг дэмжсэн асуудал, багшийг ажлын байран дээрээ тогтвортой ажиллахад чиглэсэн мөн багш мэргэжлээрээ суралцаад, төгсөөд яг мэргэжлээрээ ажиллах чиглэл рүү нь дэмжлэг үзүүлсэн Боловсролын зээлийн сангийн хөшүүргүүдийг ашиглаж санхүүгийн механизмын боловсронгуй болгож ашиглах ийм бодлого бэлтгэгдэж боловсруулагдаж байгаа. Санхүүгийн механизм бол энэ багшийн тогтвортой ажиллах, цаашлаад эхний 5 жилийн тогтвортой ажиллах ажиллагааг бол дэмжээд өгөхөд цаашаа үргэлжлүүлээд багш нар маань төрөл бүрийн нэмэлт урамшууллын хүрээнд ажиллах ийм бололцоотой байгаа.

Харин цалингийн нэмэгдлийн тухайд бол энэ өөрөө боловсролын салбарт 100 гаруй мянган албан хаагчид ажиллаж байна. Тэрний .../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээр нэмж минут өгье.

Х.Батжаргал: Учраас энэ бол бас тодорхой нэмэгдлийг шууд макро эдийн засгийн тодорхой үзүүлэлтүүдэд шууд нөлөөлөх хэмжээний тоо байдаг учраас энийг бол туйлын болгоомжтой, нэлээн нухацтай бодогдох ёстой. Харин зүгээр багшийн гар дээр очдог урамшуулал, төрөл бүрийн урамшуулал, нэмэгдэл, боломжууд бол байгаа. Тэрийг бол бид Боловсролын сайдын багцын хүрээнд урсгал зардлын зохион байгуулалтыг илүү нарийвчилж боловсронгуй болгож нэмэгдүүлэх бодлого барин ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Эдийн засаг, хөгжлийн сайд Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Косейн боловсрол, инженер бэлтгэх энэ ажил бол Монгол Улсад тодорхой хэмжээгээр нутагшиж байна. Энд их олон хүн хүчээ өргөж байгаа. Баяртай байгаа. Хамгийн гол нь бол энэ чанарын асуудал байгаа. Чанарын асуудлыг ерөөсөө унагаж болохгүй гэдэг ийм л шаардлага тавигдана. Дээр нь хүн хүч, хүний нөөц, багш, дээр нь лаборатори, тоног төхөөрөмж гээд энэ хөрөнгө оруулалтыг тасралтгүй цаашаагаа 10-20 жил Японы Засгийн газартай хамтарч ажиллах хэрэгтэй. Ингэж байж яг Япончуудын хүсдэг хийж чадсан тэр инженерийг Монгол Улсад бэлтгэх ажил хийгдэнэ.

Боловсролын яам бол өөрийн гэсэн vision-тэй байна лээ. Тэлэхдээ бол жилд 150 сая төгрөгөөр политехникийн коллежуудын шилжилтийн программаа хийж байгаа. Мэдээж яг Косейн болоод эхлэх юм бол тэрийг ийм халтар мултар бол ерөөсөө хийж болохгүй. Тэрийг яг шилжилт .../минут дуусав/

Х.Булгантуяа: Гантөмөр сайд болчихсон уу хариулт. Галбадрах гишүүн нэмж тодруулъя гэж байна. Микрофон өгье.

Ж.Галбадрах: Гантөмөр сайдыг энэ дээр бас илүү анхаараасай гэдгийг бас хүсэж асуусан юм байгаа юм. Үнэхээр чанар унах гээд байгаа энэ асуудлууд ийм байгаа учраас тал талаасаа анхаарах хэрэгтэй.

Түрүүн тэр багшийн асуудал дээр тэр нөөц багшийн асуудал өнөөдөр багш мэргэжлээрээ төгсчхөөд ажиллахгүй байгаа, багшаараа ажиллахгүй байгаа хүмүүсийг эргэж татахын тулд санхүүгийн төсөв мөнгө төлөвлөх хэрэгтэй байна. Багш нар ажлаас их гарч байна. Энэ гарч байгаа хурдыг багасгах зорилгоор бас ажлын байрны нөхцөлийг сайжруулах тал дээр төсвүүд хэрэглэх хэрэгтэй байна. Төгсөгчид багш мэргэжлээрээ ажиллахгүй байгаа энэ хувь дөнгөж 35 хувьтай байгааг 60 гаруй хувьд хүргэх хэрэгтэй байна. Энэ талаар бас тодорхой бодлого гаргах хэрэгтэй байна.

Мөн багш болж байгаа хүмүүсийн чанарыг дээшлүүлэхийн тулд ерөнхий боловсролын сургууль төгсөж байгаа шилдэг төгсөгчийг оруулахын тулд цалинтай оюутан систем энэ тэр оруулья гэсэн энэ тодорхой зорилтуудыг яам хэрэгжүүлээсэй гэж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт. Алга байна. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн алга байна. Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ төлөвлөгөөнд аялал жуулчлалын талаар ерөөсөө тусгаагүй байх юм. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 5 Богдын тусгай хамгаалалттай газар хил орчмын аялал жуулчлалын бүсийг хөгжүүлнэ гээд тавьсан. Олон жил болж байна. Жилд 30-40 мянган жуулчин очиж байгаа. Гэтэл отоглох газар, ариун цэврийн байгууламж юм байхгүй. Энийг Соёлын сайд энэ төлөвлөгөөнд яагаад тусгаагүй юм бол. Хөрөнгө оруулалт ч нэмэгдэнэ. Энэ дээр яагаад анхаараагүй юм бол 1 дүгээрт.

2 дугаарт Мөнхсайхан сайд аа, энэ эрүүл мэндийн салбарын бүсчилсэн оношилгооны төв гээд яриад байгаа ер нь би эрүүл мэндийн салбарт олон жил ажиллаж байгаагийн хувьд бүсчлээд ч нэмэргүй юм. Ер нь цаашдаа аймаг болгонд оношилгооны төв байхгүй бол хотын эмнэлгүүдийн ачаалал буурахгүй юм.

Нөгөө талаар жишээлбэл Хэнтийн ард иргэд цаашаагаа Дорнод руу 400км явж байснаас наашаагаа явна л даа. Тэгэхээр энэ аймаг болгонд ер нь цаашдаа төлөвлөгөөндөө тусгаад жилд 4 аймгийн хотын хэмжээний бүрэн оношилгооны төв байгуулах талын асуудлыг оруулж болохгүй юу. Нөгөө талаар энэ эмийн үйлдвэрийн асуудал янз бүрийн хэл ам болж байдаг. Лабораторийн тоног төхөөрөмжийн асуудлыг энд тодорхой тусгасан уу та.

Энхбаяр сайд малын түүхий эд боловсруулах үйлдвэр энэ 2025 оны юун дээр чинь Ховдод нэг түүхий эд боловсруулах үйлдвэр, Дарханд, Замын-Үүд, Эмээлт гээд яаж байсан тухайн үед. Энийг малын түүхий эд арьс шир, ноос дотор эрхтэн нь ихээр хаягдаж байна. Энэ түүхий эд боловсруулах үйлдвэрийг цаашдаа төлөвлөөд, саяын эрүүл мэндийн салбар шиг яах аргагүй тулгамдсан малчдын, ард иргэдийн борлуулж чадахгүй байгаа асуудал л даа. Энэ дээр ер нь ямар бодлого баримтална гэж төлөвлөгөөнд тусгаж байна. Аймаг аймгаар нь тусгаж болохгүй юу гэдэг асуудал тавья. Дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Чинбатын Номин сайд хариулт өгье.

Ч.Номин: Бейсен гишүүний асуултад хариулъя. Манай аялал жуулчлалын салбартай холбогдолтой ажлууд маань тусгагдсан байгаа. Та хэрвээ зам тавих чиглэлийн асуудлуудыг ярьж байгаа бол Зам, тээврийн яамнаас асууна. Яг аялал жуулчлал дээр бол 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд тавьсан байгаа. Мөн хэмжих үр дүн дээр бид нар тоон бүрэлдэхүүнээрээ 1 сая жуулчин хүлээж авна. 2 тэрбум орчим долларыг Монголын эдийн засагт оруулна гээд KPI нь тавигдаад орж ирсэн байгаа. Гэхдээ ер нь таны хэлсэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлаар бол бид нар саналаа өгсөн боловч, манайхаас явсан 30 орчим саналаас 7, 8 нь хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаад, үлдсэн нь бас хасагдсан байгаа. Гэхдээ бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр маань энэ орсон ажил учраас Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд яамнаас энэ дээр анхаарал тавьж ажиллаж явах болно. Яг зам тавих болон дэд бүтцийн асуудлууд бол Зам, тээврийн яам дээр хэрэгжигдэх ажлууд байгаа.

Д.Амарбаясгалан: Тогтмолын Мөнхсайхан сайд хариулт өгье.

Т.Мөнхсайхан: Гишүүний асуултад хариулъя. Энэ аймгийн эмнэлгүүдийг хөгжүүлэх тал дээр Эрүүл мэндийн яамны гол бодлого анхаарч байгаа. Тийм ч учраас өнгөрсөн хугацаанд 13 аймгаар ороод, шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцийн сургалт энэ асуудлуудыг нь шийдээд явж байгаа. Бид нар аймаг болгонд оношилгооны төвтэй байх юм бол эргээд үр ашиг, үр өгөөжөө бодох хэрэгтэй. Жишээ нь Говь-Алтай аймагт дээд тал нь 60 мянган иргэнд 1 том оношилгооны төв байгаад, тэрийг хангах хүний нөөцийн ажиллагаа, тоног төхөөрөмжийн хэрэглээ, баталгаат засварын хугацаа, зардал мөнгө гэж тооцоолохоор аймаг болгонд байх нь яагаад ч бид нарын хувьд ашиггүй байгаад байгаа юм. Тийм учраас бид нар энэ БОЭТ-үүдийн байрлалын асуудал дээр бид нар онцгой анхаарах ёстой. Таны хэлж байгаа бол үнэн. Цаад Хэнтий аймагт байгаа хүн Дорнод аймгийн БОЭТ рүү явахгүй. Тэгвэл зүүн бүсийн оношилгооны төв Хэнтий аймагтаа байгаад, тэнчээнээ чадавхжаад Дорнод, Сүхбаатар аймгийн иргэд Хэнтий аймагтаа ирж үзүүлж, оношилгоо эмчилгээгээ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Т.Мөнхсайхан: Энэ тогтолцоог бол бид нар оновчтой зөв болгоод, өнөөдөр байгаа, оршин сууж байгаа хүнийхээ тоонд хамаараад, тухайн бүс нутагт ямар оношилгоо эмчилгээг, ямар хүчин чадалтай хийх вэ гэдэг энэ зүйл дээр анхаарах ёстой. Иргэд аль болох амьдарч байгаа бүс нутгаасаа эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх энэ бодлого руу л бид нар орж ажиллаад, энэ маань өнөөдрийн байдлаар 15 хувийн төвлөрлийг сааруулчихаад байна.

Эмийн лабораторийн хувьд бид нар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтраад цар тахлын эсрэг сангаас санхүүжилтийг нь босгоод, 1,2 сая долларын хөрөнгө оруулалтыг татаад, барилгынх нь ажил эхлэх түвшиндээ явж байгаа. Тоног төхөөрөмжийнх нь худалдан авалтууд ирэх сард эхэлнэ. Тэгэхээр энэ маань ирэх оны хөгжлийн төлөвлөгөөнд орохгүй. Энэ жил эмийн лаборатори маань ашиглалтдаа ороод, үйл ажиллагаагаа явуулна. Одоо харин энэ лаборатори бүрэн хүчин чадлаараа ажиллах юм бол 45 хүний нөөцтэй байх ёстой. Тэгэхээр энэ хүнийг

эргээд ирэх жилүүдэд ажиллах хүний нөөцийн ажиллах цалин мөнгө нь .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Малын гаралтай түүхий эдийг боловсруулах зорилгоор “Цагаан алт” хөтөлбөр улсын хэмжээнд хэрэгжиж байгаа. Ховд Баруун 5 аймгийн түүхий эдийг боловсруулах чиглэлээр үндсэндээ дэд бүтцийн ажлууд нь хийгдээд дөхөж байна. Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтаар Эмээлтэд арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүд Эмээлтэд төвлөрнө. Мөн Дарханд улсын төсвийн хөрөнгө оруулалттай хөнгөн, хүнсний үйлдвэр технологийн парк гэсэн ийм 3 паркийн хэмжээнд улсын төсөв дээр зөвхөн дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь тусаад явж байгаа. Дотор хийгдэх хөрөнгө оруулалт зөвхөн хувийн хэвшлээр хийгдэнэ. Энэ нь өөрөө Улсын Их Хурал төсөв батлагдахдаа хувийн хэвшлийн хийх бололцоотой аливаа салбарт улсын төсвөөр хөрөнгө оруулалт оруулахыг хязгаарлана гэсэн ийм төсөв баталсан. Тэгэхээр энэ хүрээндээ л ноос ноолуур, арьс ширний .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэгээд тэр яах вэ дараа нь тэр шалгадаг хянадаг газар нь хянаад шалгаад явна биз. Одоо хамгийн их хөрөнгө оруулалтыг Ховд аймагт үйлдвэр технологийн парк аваад явж байгаа. Энэ жил гүйцээж дуусах улсын төсөвт хангалттай хөрөнгө нь тавигдчихсан байгаа. Дээр нь жилийн гүйцэтгэлээр үр дүн гарах байх. Аймаг болгонд үйлдвэр технологийн парк барих шаардлага байхгүй. Тийм дэд бүтэц байхгүй. Үйлдвэрийн, эрчим хүчний, дулааны, цэвэрлэх байгууламж гээд маш их хөрөнгө оруулалт хийгдэнэ. Тэгэхээр одоо байгаа энэ Ховд, Эмээлт, Дархан гэсэн энэ 3 дээрээ төвлөрөөд энэ асуудлаа шийдэх хангалттай хүчин чадал суурилсан байгаа.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Номин сайд аа, одоо энэ урьд 4 жилд ч ярьсан. Одоо ч яригдаж байна. Энэ отоглох бүс ариун цэврийн байгууламж байхгүй. Байгаль орчин гол горхи ихээр бохирдож байгаа. Энэ дээр тодорхой төсөв тавиагүй юм байна.

2 дугаарт Эрүүл мэндийн сайд аа, энэ Говь-Алтайгаар төсөөлж болно. Говь-Алтайд чинь манай их сургуулийн салбар байгаа. Тэнд бүрэн боломжтой гэж бодож байгаа. Баян-Өлгий аймагт тэр том эмнэлэг баригдсан. Үүний төсөв Сангийн сайдаас нэмж асууя. 3 тэрбум 758 сая төгрөг цалингийн зөрүүтэй холбоотой юм тусгагдаагүй. Уг нь 6 сарын 23-нд баруун бүсийн чуулга дээр хүлээлгэж өгөх ёстой байсан. Дутуу санхүүжилттэй байгаа. Энийг 2026 онд яагаад тусгаагүй юм бол. Энийг тусгах боломж бий юу.

Д.Амарбаясгалан: Чинбатын Номин сайд нэмж хариулъя.

Ч.Номин: Бейсен гишүүний асуултад хариулъя. Бейсен гишүүн ээ, ер нь бол бид нар аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ хувийн хэвшил суурьтай хөгжүүлнэ гэж үзэж байгаа. Тэгээд энэ ч утгаараа аялал жуулчлалын кампуудыг өөрийнхөө камп, эзэмшлийн газруудаа 4 улирлын аялал жуулчлалд нийцүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй зээл авах боломжийг бий болгохоор ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ хүрээндээ бид нар ариун цэврийн байгууламжуудаа тухайн кампууд нь сайжруулах болон нэмэлт отог байгуулах дээр хамтарч ажиллана гэж үзэж байгаа. Би тантай санал нэг байгаа зүйл юу вэ гэхээр орон нутгийн сумдууд дээр байгаа ариун цэврийн байгууламжуудыг бид нар өргөтгөж янзлахгүй бол яг ийм асуудлууд үүсэж байгаа. Тэгээд энийг бол орон нутагтай хамтарч хийх нь хамгийн чухал байгаа гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Дэлхийн эдийн засгийн нөхцөл хүлээлтийн байдал руу ороод их гүрнүүдийн удирдагч нар ямар шийдвэр гаргахаас шалтгаалж, түүхий эдийн зах зээл зогсчихлоо. Үүний дам нөлөө нь Монгол Улсад нүүрс дээр илэрлээ. Нүүрсийг бид нар одоо зарж чадахгүй байна, гаргаж чадахгүй байна гээд одоо алтаа ухъя гэнэ. Дараа нь алт байхгүй болчихвол нэг юмаа ухъя гэнэ. Тэгэхээр хөгжлийн төлөвлөгөө бид нар өнөөдөр хэлэлцэж байна. Тэгэхээр хөгжлийн төлөвлөгөө чинь бие даасан улсын байдлаар биш, гадаад зах зээлийн нөхцөл байдал дээрээ хэдэн удаа тодотгол хийх юм бэ гэдэг ийм ямар нэгэн стратегийн салбаргүй байгаагийн л шинж байхгүй юу.

Тэгэхээр бид нар ямар улс юм бэ гэхээр эдийн засгаа солонгоруулна. Уул уурхайн улс мөн, хөдөө аж ахуйн улс мөн, аялал жуулчлалын улс мөн гээд. Аялал жуулчлалын улс юм бол энийг манай нүүдлийн соёл иргэншлийг л үзнэ. Малчдыг л харна. Энэ соёл иргэншлийг л дэлхий онцолно. Бид нарын ондоошил энэ.

Тэгэхээр энэ хөдөө аж ахуйн салбар маань ер нь сүйрч байна даа. Малчид маань өдрөөс өдөрт хот руу нүүгээд ирж байна. Хотын түгжрэл дийлдэхээ больж байна. Хөдөөд ажлын байр байхгүй, амьжиргаа байхгүй. Тэгэхээр энэ асуудлаа хэдүүлээ яг хамтарсан засаг байгаа юм бол дорвитойхон өөрчлөлт хийе. Хөгжлийн төлөвлөгөө дээр харахаар 68 хувийн арьс ширний үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан байна гээд тавьчихаж. 1 ёсны малчдын 68 хувь нь л арьс ширээ боловсруулаад л байгаа юм байна. Манай бүс дээр лав 68 байтугай 1 хувь ч алга. Жалганд хаягдаад л байж байгаа. Тэгэхээр энэ яг үнэн бодит тоо мөн юм уу. Ер нь 2028 он хүртэл бид нар арьс ширний үйлдвэртэй болохгүй юм шиг байна. Тийм үү хөдөө аж ахуйн сайд аа. Тэгээд 2028 онд эргээд тойрог дээрээ очихдоо ямар нүүрээрээ очих юм бэ. Би лав ичиж байна.

Тэгэхээр энэ 68 хувь гээд байгаа чинь ямар тоо юм. Манай Монгол Улсын ДНБ-ий 10 хөдөө аж ахуйн салбар эзэлж байгаа. Хөдөлмөрийн зах зээлийн 21 хувь нь ажилладаг. 300 мянган иргэн ДНБ-ийхээ 10 хувийг үйлдвэрлэж байна. Үнэхээр солонгоруулах гээд байгаа бол хөдөө аж ахуй руу л бид нар солонгорно. Тэгтэл энэ салбар чинь ДНБ-ийхээ 10 хувийг үйлдвэрлэж байна. Хүн амынх нь хөдөлмөрийн зах зээлийнх нь 21 хувь нь ажиллаад, 10 хувийн бүтээмжтэй байна гэдэг чинь угаасаа шилжилт хөдөлгөөн хийх нь тодорхой шүү дээ. Тэгтэл Америкийн Нэгдсэн Улс хөдөлмөрийн зах зээлийнхээ 3 хувиар хөдөө аж ахуйн бүх дэлхийн 30-40 хувийг нийлүүлж байна. Тэгтэл бид нар бүр цаанаасаа ондоошлоороо нүүдлийн соёл иргэншлээрээ өчнөөн мянган жил уламжлагдаж ирсэн ийм улс ийм сайхан газар нутагтай ийм өргөн уудам бэлчээртэй байж байж хөдөлмөрийн зах зээлийнх нь 21 хувь нь ажиллаад, ажиллаад ДНБ-ийхээ 10 хувийг л үйлдвэрлэж байна. Энэ дээр манай Засгийн газар 1 дорвитой эрс реформ маягийн юм хийгээч ээ. Одоо та юу гэж хариулна гэхээр “Цагаан алт”-аа ярина. Хүнсний хувьсгалаа ярина. Энэ бол реформын шинж чанартай үйлдэл биш. Энэ бол хувийн хэвшлийг дэмжиж байгаа

бодлого. Тэгэхээр реформ нь яг юу юм. Хэзээ бид нар яг арьс ширээ үйлдвэрлэж, эцсийн бүтээгдэхүүн болгох юм бэ. Энэ дээр Хөдөө аж ахуйн сайдаас хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Эрхэм гишүүн тантай санал 100 хувь нийлж байна. Ингээд яриад өгдөг бас дэмжээд явдаг гишүүд олон байгаасай л гэж бодож байна. Үнэхээр Монголын нийгэмд тулгамдсан гол асуудлыг шийдэхэд бол хөдөөгийн хөгжил. Хөдөөд хүн ажиллах, амьдрах, бизнес эрхлэх, орлоготой байх тэр нөхцөлийг л бүрдүүлж байж бидний өнөөдрийн энэ түгжрэл, бохирдол, олон асуудлын ард гарна. Тэгэхээр яамны маань Улсын Их Хурлын баталж өгсөн 3 хөтөлбөрийн хүрээнд л энэ юмыг цогцоор нь шийдэх гэж оролдож байгаа юм. Атрын 4-өөр газар тариалангаа, эрчимжсэн мал аж ахуйгаа, Цагаан алтаараа арьс шир, ноос ноолуурынхаа боловсруулалтын түвшнийг сайжруулъя. Хүнсний хувьсгалын хүрээнд хүнсний үйлдвэрүүд, хүнсний аюулгүй байдлаа хангая гэсэн энэ 3 бодлого дээр л эргэлдээд байна.

Олон асуудал байгаа юм. Малчны эрх зүйн байдлын асуудал байна. Малчны хөгжлийн асуудал байна. Шинэ салбарт тулгамдаж байгаа боловсон хүчний нөөцийн асуудал байна. Хэрхэн бэлдэх юм. Хамгийн гол нь энэ салбарт байгаа тулгамдсан бүтцийн алдаатай байдал байгаа юм. Салбарын дэргэдэх шинжлэх ухааны байгууллагууд тусдаа, өөр яамны харьяанд. Хүний нөөцийн бодлого нь өөр яамны харьяанд буюу бодлого маш хүчтэй задрах ийм байдалтай. Энийг Их Хурал залруулж өгөх ёстой. Салбарт зөвлөх ёстой, шинжлэх ухаанч хандуулах ёстой тэр хүрээлэнгүүд яг өнөөдрийн энэ жил орчмын хугацаанд 1 удаа тал хуудас цаас ирсэнгүй. Хөдөө аж ахуйн сайд аа, газар тариаланд ийм агро технологийн бодлого барина гэсэн юм алга. Малын үржил угсааг сайжруулахад ийм бодлого барина гэсэн юм алга. Малын гоц халдварт өвчинтэй ингэж ингэж тэмцэнэ гэсэн зүйл алга. Олон зуун эрдэмтэд цалин аваад, тэнд улсын төсвөөс санхүүжээд байж байгаа. Тэгээд ийм байгууллагаар яах юм. Тийм биз. Үндсэн салбараасаа тусдаа байдаг, салбартаа зөвлөж чаддаггүй, салбартайгаа ажилладаггүй. Хүний нөөцийн гүн дутагдлын асуудлыг иж бүрэн шийдэх хэрэгтэй. Үнэхээр тоон дээр та зарим нэг тоо алдчихлаа. Тэр экспортын 6 хувь, ДНБ-ий 30 орчим хувь, нийт 600 мянган хүн энэ салбарт ажиллаж байгаа. 2 хүний 1 нь ажиллаж байгаа. Эдийн засгаасаа илүү улс төр нийгмийн тогтвортой байдлыг хангаж байгаа. Энэ хүмүүсийг ажилтай орлоготой байлгах, баялгийн хуваарилалтыг хамгийн сайн жигд хийж байгаа салбар шүү дээ. Ёстой 2 идэхгүй, хоосон хонохгүй. Нутаг орондоо хөдөөдөө сэтгэл амгалан ажиллаад, тариагаа тариад ногоогоо ургуулаад малаа маллаж байгаа энэ хүмүүсийн асуудлыг бид онцгой анхаарах цаг болсон буюу төрийн бодлого онцгой энд чиглэх ёстой. Тэгэхээр энд дэмжлэг хэрэгтэй байгаа юм. Улсын Их Хурал дахь дэмжлэг хэрэгтэй байна. Үнэхээр хөдөөгийн хөгжлийг бид нар шийдэж байж л Монгол Улсын хөгжлийн асуудал хангагдана. Хөдөө хөгжиж байж бид нар олон тулгуурт эдийн засагтай болно. Уул уурхайгаас ангид, эх орондоо амар тайван амгалан амьдрах гол бололцоог бол хөдөөгийн хөгжил дээр байгаа гэж би хардаг. Тэгэхээр энэ мэтчилэн та байнга дэмжлэг үзүүлээрэй. Ингээд ирэх төсөв арай өөр байх болов уу гэж найдаж байна.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Ерөнхий сайд маань хаана байна, Хотын дарга маань хаана байна. Бид нар Монгол Улсын хөгжил ярьж байгаа бол энэ хүмүүс байхгүйгээр бүрэн бүтэн

ярьж чадах уу. Н өгөө талаар Их Хурлын дарга маань л тэр сайд нь байхгүй, энэ сайд нь байхгүй гээд л ингээд байх юм. Тэгээд л байнга энэ юм явагдаж байх юм. Ер нь яагаад ийм хариуцлагагүй байдаг юм бэ. Ийм хариуцлагагүй байхаар чинь энэ улс орон хөгжинө гэж хэн итгэх юм, хэн найдах юм. Ингээд ярьж байгаа юмыг нь хараад байхад байж байгаа юм энэ тэр бол бүгд л их сайн сайхан болж байгаа юм шиг, сайн сайхан болж байгаа, бүтэж байгаа ийм байдалтай юм яриад байх юм. Улсын төсөв бол маш их данхайсан. Томорчихсон. Орон тоо бол ихэсчихсэн ийм л байгаа. Гэтэл иргэдийн амьдрал эсрэгээрээ л байна шүү дээ. 2024, 2025 онд хэчнээн хүн ядуурлаас гарсан юм бэ. Гэнэт л 2026 онд 5 хувийн ядуурал багасах юм гэнэ. Одоо энд итгэж байгаа хүн байгаа юм уу энэ дотор. Тэрийг асуучихъя.

Тэгээд орон тооны цомхотгол хийнэ гэнэ. Энийгээ дэс дараатай хийсэн нь дээр байх. Ганцхан жил 5 хувь биш. Энэ жилээс эхэлсэн нь дээр. Улсынхаа төсвийг оруулаад ир л дээ. Тэгээд энэ дээрээ ярилцъя. Хийгээд явъя гэсэн ийм санал оруулж байна. Тэр хийнэ гэсэн юмаа дандаа л ирээдүй цаг дээр ярих юм. Удахгүй тийм болгоно, ийм болгоно гээд. Тэгээд энэ иргэд чинь эх орноосоо дайжаад байна шүү дээ. Би энэ Нийгмийн хамгааллын яамнаас асууя. Ер нь залуучуудын хэдэн хувь нь улс улс орондоо үлдэж амьдрах ийм хүсэлтэй байна. Ганц жилийн өмнөх судалгаагаар бол танай яамнаас ярьсаар байгаад бүгдийг нь улных болгосон. Тэгээд 70 хэдэн хувь нь гадаадад гарч ажиллах хүсэлтэй байна гэсэн ийм сэтгэгдлээ илэрхийлсэн юм байна лээ. Одоо энэ байдал ямар байгаа вэ. Сайжирчихсан уу.

Монгол Улс бол автократ засаглалтай болсон гэж ярьж байна. Автократ засаглалтай болсны 1 шинж нь бол хариуцлага ярьж чадахгүй, хариуцлага тооцож чадахгүй. Тийм болчихсон. Уг нь Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага гээд хуульд байгаа юм л даа. Үндсэн хуульд. Одоо тийм биш болчихсон. Зүгээр энэ Улсын Их Хурал бол хуулийн хэлтэс шиг л байгаа гэж гадуур яриад байгаа. Ийм үнэн байгаа. Засгийн газрын хуулийн хэлтэс шиг л байгаа. Энийг өөрчлөх цаг болсон байх.

Энэ олон яамнууд 10 билүү цомхотгол хийнэ гээд байгаа. Одоо хэдэн яамнаас цомхотгох юм. Хэдэн сайд нь цомхотгогдох юм. Тэрийгээ хэлчихмээр байх юм. Одоо хэдэн яам байдаг юм 23 сайд байна уу. Энэ 23 сайд ийм их төсөвтэй 33 их наядын төсөвтэй шүү дээ. Та нар өнгөрсөн жилүүдэд ямар сайхан юм хийсэн юм бэ. Ард түмэндээ хэрэгтэй. Өнөөдөр юу гэсэн бэ, Гэр бүлийн баяр гэнэ үү. Үгүй ээ, энэ чинь хэдэн гэр бүл нь сайхан амьдраад, хэдэн гэр бүл нь ямар амьдраад байгаа юм бэ. Энэ гадаад талбай дээр гараад ирчихсэн ард иргэд чинь бол хэлээд байна шүү дээ. Энэ Засгийн газрыг тойрсон хэдхэн хүн л сайхан амьдарч байна гэж хэлээд байна. Ийм л байна шүү дээ. Хэзээ энэ Монгол Улс чинь хүн шиг амьдрах юм бэ. Хамаг мөнгийг нь төсөв дээр аваачсан, хувийн хэвшлүүдээ дандаа ад үзнэ. Бүгдийнх нь хаалгыг нь бариулна. Тэгээд ажлын байр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Ер нь хөгжлийн төлөвлөлт бол баян улс ч хийж л байдаг. Манайх шиг ядуу улс бол бүр их хийх хэрэгтэй. Хүмүүсээ хэрхэн ядуурлаас гаргах вэ гэдэг дээр тодорхой бодлого гаргах шаардлагатай. Ингэж, ингэж гарна гээд зоримог шийдлүүд гаргана. Тийм учраас өнөөдөр бид нар ирэх оныхоо төлөвлөгөөг ярьж байгаа. Бид нарын төлөвлөгөө биелэх ёстой. Биелэхийн тулд чамбай бүтээлийг Их Хурал шүүсийг нь шахаад, тал талаасаа хэлэлцээд гаргаасай гэж бодож байна. Бүх

юм болж байгаа, бүх юм сайхан байгаа гэж ярьж байгаа хүн байхгүй. Болохгүй байгаа болохоор л энд ажил хийе, болохгүй учраас болгохын тулд төлөвлөлт хийе л гэж байгаа юм. Хувийн хэвшлээ дэмжихийн тулд тэрийг хүний нөөц болоод тэр орон зайг бий болгохын тулд төрийн алба өөрөө цомхон болохоос өөр сонголтгүй. Тэрийг өнөөдөр эхэл гэдэг таны шаардлагыг бол ойлгож байгаа. Бид нар одоогоос тооцоолол судалгаагаа яам болгон хийж байгаа, сайд болгон хийж байгаа. Салбар болгоноо дүгнэж байгаа. Ингээд ирэх ондоо энэ ажил өөрөө идэвхтэйгээр өрнөх учиртай гэж ингэж харж байгаа шүү Ганбат гишүүн ээ. Түүнээс биш бүх юм болж байна, бүтэж байна, тэгээд засаг тойрсон хэдэн хүн сайхан амьдарч байна гэдэг бол гүтгэлэг шүү. Тэгвэл Их Хурлын гишүүдийг тойрсон хүмүүс сайхан амьдарч байна гэж ард түмэн бас ярина. Тэгээд 1 жоохон бизнестэй хэд чинь л сайхан байна гэж бас дахиад нэг хэсэг нь ярина. Ийм байдлаар бид нар бол ажил хийж байгаа, бүтээхийн төлөө явж байгаа хүмүүсээ сулруулдаг бүхэл бүтэн соёл бий болголоо. Бизнес хийвэл муухай, баян байвал заваан, шуналтай гэж ингэж тал талаас нь мэрсээр байгаад төрд ажилладаг ч хүнгүй, хувийн хэвшилд ажилладаг ч хүнгүй болох нь байна шүү нөхдүүд ээ. Тийм болохоор бид нар энэ соёлын довтолгоог ажил хийж байгаа хүнээ хүндэлдэг, хайрладаг тэр соёлын довтолгоо руу хэдүүлээ орох хэрэгтэй. Тэгэхгүй бол бид нарын дунд бол бүр соёл болчихлоо. Нэг гайгүй аятайхан ажил хийж байгаагаа ад үздэг бүр нэг ийм соёл сууж байна. Тэрийг нь дэвэргэдэг Би бол гадна талаас энэ нөлөөлөл орж ирж байгаа гэж харж байгаа. Аятайхан Монгол хүнийг хямгадахын төлөөх юм, ажил хийж байгаа хүний нүдний зовхийг унагахын төлөөх юм. Тийм учраас хэдүүлээ ер нь бол ажил хийдэг хүнээ дэмждэг улс орон. Хувийн хэвшил дээр явна. Эргэлт буцалтгүй чөлөөт эдийн засаг руу алхаж байгаа гэдгээ байнга тодотгож, тэр лүүгээ алхаж баймаар байна. Тэр сэтгэл зүрх энэ Засгийн газарт байна гишүүн ээ. Сайд болгонд тэр байна. Бүгд зүтгэж байна. Хийхийн төлөө байна. Түүнээс биш хувийн хонжоо, хувийн аж ахуйг өөд нь татаж байгаа 1 ч сайд эд нар дотор алга.

Д.Амарбаясгалан: Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Би тодорхой асуултуудыг асуугаад байдаг. Ер нь Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандана гэдэг чинь хуулийн зүйл заалттай байх. Гэтэл тийм юм алга л даа. Хувийн хэвшил хэцүүдсэн. Миний мэдэхийн өнгөтэй өөдтэй юмыг дандаа хувийн хэвшлүүд л хийж байсан. Тэр Эрдэнэтийн 51 хувийг авчирсан шүү дээ. Одоо өшөө 50 хувийг авчирч барьж байгаа тийм газар байгаа юм уу энэ Засгийн газар. Тийм гэрэл гэгээтэй зүйл хийсэн хүн байна уу. Байхгүй шүү дээ. Мухар замаа тэгээд хил гаргаад л мухар зам хэвээрээ л үлдэж байна. Гэйблиэсийн хэлсэн үг байдаг л даа. Үгүй ээ, надад тэр хэвлэл мэдээллээ л өгчих. Ямар ч ард түмнийг би гахайн сүрэг шиг болгоод өгье гэж. Үгүй ээ, үнэхээр л энэ Пи Ар чинь тэгж л явж байна шүү дээ. Тийм юман дээрээ л та нар сайн ажиллаж байгаагаас биш ард түмний амьдралыг сайжруулах .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбат гишүүн сайн байна. Одоо яг чуулгандаа ингээд сайхан бүтэн суудаг үлгэр жишээ үзүүлдэг гишүүн болох хэрэгтэй. Орж ирж бүртгүүлчхээд гараад явчихдаг байж ерөөсөө болохгүй. Тэгж байж бүгдээрээ бас Засгийн газар, сайд нартаа шаардлага тавина шүү дээ. Тэгэхгүй сайд нар нь орж ирээд суучихдаг зарим гишүүд нь бүртгүүлчхээд гараад явчихдаг байхаар Их Хурлын ажил чинь өөрөө хаана харагдах вэ. Тэгэхээр та бас олон сонгогдсон ахмад гишүүн. Маш сайн үлгэр жишээ өгч, бүтэн суудаг байх хэрэгтэй.

Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя. Ганбат гишүүн, Хөөе Ганбат гишүүн.

Б.Жаргалан: Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг бол Эдийн засаг, хөгжлийн яамнаас өргөн барьсан. Тэгээд Эдийн засгийн эрх чөлөөний реформ гэсэн гарчигтай ийм хөгжлийн төлөвлөгөө өргөн барьсан явдалд бол талархаж байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бол бид эдийн засаг дахь төрийн оролцоо үлэмж нэмэгдэж байна, хувийн хэвшлийн орон зай шахагдаж байгаа талаар бол маш их ярьсан. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас бас энэ асуудалд анхаараад, төрөөсөө төсвийн бодлогоосоо эхэлье гэдэг ийм агуулгаар ийм концепцтой хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг өргөн барьж байгаад бол баяртай байгаа юм. Тэгэхээр төрийн албаны реформыг хийе гэсэн зорилт тавьсан байна. Төрийн захиргааны албан тушаалтнуудыг 9 хувиар бууруулъя гэсэн байна. Төсвийн урсгал зардлыг ДНБ-ий 24 хувьд барья гэсэн байна. Мөн сүүлийн жилүүдэд бидний маш их ярьсан ТӨК-удын реформыг хийе, бүтээмжийг нэмэгдүүлъя. Тэнд ажиллаж байгаа 50, 60 мянган хүмүүсийг бас цомхотгоё гэсэн зорилтуудыг тавьсанд бол талархаж байна. Тэгэхээр Гантөмөр сайдад бас баяр хүргэе.

2 дугаарт нь бол яг энэ төсвийн бодлого талтайгаа бас нийцүүлээд хувийн хэвшлийнхээ орон зайг тэлэхийн тулд бид бас татварынхаа бодлогыг давхар авч явах ёстой гэж үзэж байгаа юм. Тэгэхээр Засгийн газраас Татварын багц хуулийг өргөн барина гэсэн хүлээлттэй байгаа. Өчигдөр Эдийн засгийн байнгын хороо дээр асуухад бол төсөвтэйгөө хамт намрын чуулганаар өргөн барина гэсэн зүйл яригдсан. Тэгэхээр энэ дээр Сангийн яам эртхэн ажлуудаа хийгээд, хувийн хэвшилтэйгээ бас хамтарч ажиллаад Татварынхаа багц хуулийг маш тийм чамбай хууль оруулаад ирмээр байна. Тэгэхээр энэ тал дээр явц ямар байна гэж Жавхлан сайдаас асууя.

2 дугаарт 2025 оны төсөв дээр бас их асуудлууд яригдаж байгаа. Нүүрсний үнэ буурсантай холбоотойгоор төсвийн орлого тодорхой хэмжээнд буурч байгаа гэсэн зүйлүүд байгаад байгаа. Түүнээс гадна 2025 оны төсөвт хөрөнгө оруулалт талдаа суусан төслүүдийн төсөл арга хэмжээнүүдийн тендер эхний хагас жилдээ багтаад явсан байх ёстой. Тэгэхээр үүнээс бол яг хэдэн хувийн гүйцэтгэлтэй байгаад байна. Одоо 2 7 хоног үлдчихлээ шүү дээ та бүхэнд. Тэгэхээр түүн дээр бол бас хариулт авмаар байна.

3 дугаарт нь бол ер нь бид нар жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэгдэж байгаа энэ цаг мөчид ер нь энэ мега төслүүд гэгдээд байгаа хөрөнгө оруулалтын томоохон төслүүдээ яах юм бэ. Эдийн засгийн нөхцөл байдал бас өөрчлөгдөж байна. Намар байснаас бол бас арай өөр нөхцөл байдал бий болчихлоо. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор энэ хөрөнгө оруулалтын бодлого дээрээ Улсын Их Хурал, Засгийн газар бас тодорхой шийдэмгий бай байр сууриа нэгтгээд гаргачих нь зөв гэж хараад байгаа юм. Тэгэхээр жишээлбэл энэ хөгжлийн төлөвлөгөөнд ороод ирчихсэн нөгөө Засгийн газрын яриад байгаа 14 мега төсөлд багтсан төслүүд дээр жишээлбэл хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь тодорхойгүй, ТЭЗҮ байгаа эсэх нь тодорхойгүй төслүүд бас яваад байна. Тэгээд би өчигдөр Эдийн засгийн байнгын хороо дээр Сангийн яамнаас бас асуусан л даа. 2024 оны төсвийн тодотголд чинь бид нар бараг 300, 400 тэрбум төгрөгийн ТЭЗҮ-ийн зардал баталчихсан шүү дээ. Тэгэхээр тэр ТЭЗҮ-ийн зардлууд ер нь юу болсон бэ гэсэн чинь 258,4 тэрбум барьцаа хөрөнгийн дансанд байгаа гэсэн юмыг надад хэлсэн. Тэгэхээр би тэрийг сануулъя. Бүсийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын

төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөвт 70 тэрбум Шадар сайд дээр, Өөдөө тэмүүлэх ган татлагад гүүр 28,6 тэрбум, Шинэ их тойруу, хурдны зам 23 тэрбум гэхчлэн 2024 оны төсвийн тодотголд багтсан тэр ТЭЗҮ-үүд ер нь юу болж байгаа вэ Жавхлан сайд аа. Тэр дээр бас танаас хариулт авъя.

Мега төслүүдийн нэг болох Тавантолгой цахилгаан станцын асуудал байна. Бид эрчим хүчний тусгаар тогтнолоо хадгалах ёстой байгаа. Тэгэхээр энэ Тавантолгойн цахилгаан станцын явц бас ямар байна. Хөгжлийн төлөвлөгөөг харахад бол хөрөнгө оруулалтын эх үүсвэр тодорхойгүй байна. Энэ тал дээр Чойжилсүрэн сайдаас хариулт авъя. Тэгээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулаад явъя. Энэ жил манай гол түүхий эдүүдийн үнэ бас нэлээн хүнд байна. Хүнд байна, амаргүй байна. Тийм ч учраас үүнтэй холбоотой төсвийн орлого талд бас тасалдаж байгаа асуудлууд бол байна. Гэхдээ Засгийн газар энэ дээр дорвитой арга хэмжээ аваад, ямар ч байсан энэ жилийнхээ төлөвлөгөөний дагуу Засгийн газрын 1 ч үйл ажиллагаа тасалдахгүй, бүрэн санхүүжилт хийгээд явж байгаа гэдгийг хэлье. Бид энэ дээр 2 асуудал, 2 хязгаар байгаа гээд ойлгочих хэрэгтэй шүү. Бид алдагдалгүй төсөв гээд баталчихсан. Тийм учраас орлогодоо баригдаад л бид нар үйл ажиллагаагаа санхүүжүүлээд явна. Тэгэхээр жилийн эцэс рүү ямар ч тохиолдолд бид алдагдалгүй төсвөө бариад л гарна. 1 дүгээрт.

2 дугаарт саяын таны дурдсан тэр 5 сарын 30 гээд хэмнэлтийн хуулийн заалт байгаа юм. Энэ жилээс хэрэгжиж эхэлж байгаа юм. Өмнөх жилүүдэд бол байнгын сануулдаг байсан. Энэ жилээс хэрэгжиж эхэлж байгаа учраас манай сайд нар бол нэлээн хичээж ажиллаж байгаа. Энэ жил бол цөөхөн шинэ хөрөнгө оруулалтууд байгаа. Тийм учраас энэ жилийн тендер зохион байгуулалт бол харьцангуй ачаалал багатай. Бид нар чинь жилдээ бараг орон нутагтайгаа нийлэх юм бол 1000-аад тендер байдаг байхгүй юу. Энэ жил бол орон нутагтайгаа нийлээд нийлээд 200 хүрэхгүй байгаа. Улсын төсөв дээр бол 42 байгаа. Гүйцэтгэлийг нь би яг тоо хэлж мэдэхгүй байна. Доржханд сайд тоо байвал хэлчхээрэй. 5 сарын 30-аар хэдэн хувь ч байсан гэсэн шууд тасалбар болгоно. 5 сарын 30-нд бүр тендер зарлах битгий хэл бүр гэрээ байгуулсан нь л энэ жил санхүүжилтээ авна. Гэрээ байгуулаагүй бол уучлаарай 5 сарын 30-нд ажлын цаг дуусахад тасалбар болгоод энэ жил бараг тодотголтой, тодотголгүй энэ чинь бараг тодотгол хийчхэж байгаа байхгүй юу. Хөрөнгө оруулалт талдаа. Урсгал зардалдаа бид нар орлогоо харж байгаад л орлогодоо бариад, зардлаа санхүүжүүлээд явчихаар бид энэ жил төсвийн хувьд алдагдалгүй гэдэг төсвөө бол ингээд бариад явчихна.

Татварын багц хууль бид бэлдэж байгаа. Олон жил бэлдсэн. 5 жил бэлдсэн гэж ойлгоорой. Намар төсөвтэй өргөн барина гэж үгүй ээ, бид энэ хавартаа багтааж өргөн барина. Хавартаа багтааж өргөн барина. 5 сарын 30-ыг хараадахъя. Бас биднээс шалтгаалахгүй гадна талаас шалтгаалах их олон зүйлүүд байна. Энийгээ бас харзнаадахъя. Ингээд 2026 онд хэчнээн хэмжээний өртөгтэй татварын реформыг бид нар дийлэх нь үү, 2027 онд ямар байх нь вэ, 2028 онд ямар байх нь гээд шат дараатай хийнэ. 1 далайлтаар 1 удаагийн жилийн төсвөөр бид нар энэ том татварын реформыг дийлэхгүй. Энэ чинь өөрөө маш өндөр өртөгтэй. Багадаа л 4 их наядын. Тийм учраас пакеж яг 4 болох нь уу, 3-4 ийм хэсэг болгож бид шат

дараатай, ямар ч байсан энэ 4 жил бид Татварын багц хуулийн ийм 4 жил байх болно гэдгийг хэлье. 14 мега .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя. 1 минут өнгөрсөн.

Б.Жавхлан: Өнгөрсөн 4 жил бид нар шинэ сэргэлтийн бодлого гээд явсан. Энэ шинэ сэргэлтийн бодлого маань 14 мега төсөл болж хувираад, маш тодорхой төслүүд дээр бид фокус болоод явж байгаа. Тэгэхээр бид эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, эдийн засгийн эрх чөлөө гэж байна. Бүсчилсэн хөгжил гэж байна. Хүний хөгжил гэж ярьж байна. Энэ бүхнийг бид уул уурхайгаас үл хамааралтайгаар, дунд, урт хугацаанд тогтвортой хийж чадах бидний суурь бол ерөөсөө л энэ 14 мега төсөл. Эд нарыгаа явуулж байж л бид нар эдийн засгийн эрх чөлөөнд хүрнэ. Тэгэхээр эндээс бид нар 1 ч ухарч болохгүй. Харин ч эсрэгээрээ энэ рүүгээ улам их зүтгэх ёстой. Алийг нь төсвөөр хийх юм, алийг нь төсвөөс гадуур зээл тусламжаар, гаднын хөрөнгө оруулалтаар, төр, хувийн хэвшлийн түншлэлээр алийг нь хийх ёстой юм. Мэдээж зураг төсөвгүй юм гэж ганц ч байж болохгүй. Бушуухан зураг төсөвтэй байж байгаад, дараа нь хөрөнгө мөнгөө олох асуудлаа бид шат дараатай ингээд яриад явна. Тэгэхээр манай .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Тавантолгой дулааны цахилгаан станцыг 2023 онд 1 удаа зарласан. Тендерийн нөхцөл 30 хувийг нь Эрдэнэс Тавантолгой компани санхүүжүүлэхээр, 70 хувийг нь И Пи Си контрактор нь санхүүжилтээ олгоод, сангаа олоод орж ирэх ийм нөхцөлтэйгөөр тендер зарласан. 2 оролцогч ороод, харамсалтай нь хоорондоо маргалдаж явсаар байгаад, Дээд шүүхийн 3 шатын шүүхийн шийдвэр гараад, тендерийг дахин зарлахаас ондоо нөхцөл байдал үлдээгүй байна. Гэхдээ өнөөгийн нөхцөл байдлаар Тендерийн тухай хуулиар И Пи Си нөхцөлтэй тендер зарлах бололцоогүй байгаа. Тендерийн хуулиас хасагдсан байгаа учраас одоо Засгийн газраас тендерийн хуульд холбогдох өөрчлөлтүүдийг оруулах ийм хуулийн төслүүд өргөн баригдаж байгаа. Улсын Их Хурал баталсан тохиолдолд Тавантолгойн дулааны цахилгаан станцын тендерийг дахин зарлах бололцоо бүрдэнэ.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Жавхлан сайд татварын багц хуульд яг аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгч нарт таатай ямар заалтууд орж байгаагаа бас товчхон яг энэ завшааныг ашиглаад хэлчихвэл сайн байна.

2 дугаарт ер нь бид энэ хөгжлийн төлөвлөгөөгөө ярилцаж байгаа энэ цаг мөчид энэ мега төслүүд дундаас яг хэд нь бодитой ирэх 3 жилд хэрэгжих боломжтой юм бэ. Хөрөнгө оруулалтын янз бүрийн эх үүсвэрийг татан оролцуулаад, алийг нь бид нар шийдэх боломжтой юм бэ гэдэг эрэмбэ дэс дараагаа гаргаад, тэгээд тэр хуулийн шинэчлэл, хуулийн өөрчлөлт, эрх зүйн орчин нь дутмаг байх юм бол тэр зүйлүүдээ бас яаралтай шийдвэрлээд явахгүй бол одоо бидэнд ерөөсөө 3 жил үлдлээ шүү дээ. Дараачийн Их Хурлын сонгууль хүртэл.

Тэгэхээр энэ хаврын чуулганаар эдгээр асуудлуудаа хэдүүлээ 1 талд нь болгохгүй бол зүгээр 1 мега төсөл гэдэг лоозогносон юм яриад бас явахгүй байгаад

байна. Тэгэхээр энэ дээр бол бүгдээрээ итгэл үнэмшилтэйгээр бас улс орноо хөгжүүлчихье гэсэн тийм зорилго, зүрх байгаа гэдэгт итгэж байгаа. Тэгэхээр бол энэ дээр бол жишээлбэл улс төржихгүйгээр тэгж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. 3 минут үнэхээр багадна шүү. Багц хууль гэдэг бол өөрөө багц хууль. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, НӨАТ, тэгээд татварын харилцаа тайлагналаасаа эхлээд татварын байцаагч нарын ёс зүй. Өмнө нь бид 3000 татварын байцаагчтай бол цаашдаа энэ хуулиа өргөн бариад, амжилттай батлагдваас 3000 зөвлөн туслагч байх болно. Актыг зөрчил гаргасан хойно нь биш, актыг үүсгэдэг зөрчлийг гаргахаас урьдчилан сэргийлж, эрсдэлээс хамгаалдаг ийм татварын орчинтой болно. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр шатлалууд нэмэгдэнэ. Одоо бид 3 шатлалтай бол энэ шатлалууд нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл манай аж ахуйн нэгжүүд маань тэлэх биш улам хумигддаг, жижгэрдэг ийм байдалд олон жил явж ирсэн бол энийг нь илүү их чөлөөлж өгнө гэсэн үг. Дээрээс нь .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна. Алга байна. Энхбатын Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний тухай хуулиараа яг хөгжлийн бодлогын баримт бичиг гэвэл бидний урт хугацааны хөгжлийн бодлого, дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу хөгжлийн зорилтот хөтөлбөр, тэгээд Монгол Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл, тэгээд үүнийг дагасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хөрөнгө оруулалтын жагсаалт, тэгээд үүнээс гадна өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөө байгаа.

Тэгэхээр энэ маань дэс дараалалтай явах учиртай. Бид урт хугацааны, дунд хугацааны, 5 жилийн, 1 жилийн гээд. Тэгэхээр би энэ дундаас 1 зүйлийг тодруулж асуух нь энэ дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу хөгжлийн зорилтот хөтөлбөр хуулийн дагуу нийтдээ 8 зорилтот хөтөлбөр гаргах ёстой байдаг. Одоогоор бол зөвхөн 1 нь буюу эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр Улсын Их Хурлаар батлагдсан. Тэр бол шинэ сэргэлтийн бодлого байгаа. Тэр маань ч гэсэн үр дүнгээ өгөөд, энэ боомтын гацааг арилгах, эрчим хүчний дутагдлаас гаргах, аж үйлдвэржилтийн бодлого, ногоон хөгжил, төрийн бүтээмж гэх мэтчилэн 6 сэргэлтийн бодлого байгаа. Маш тодорхой зорилтуудаа дунд хугацааны зорилтоо тавьсан үед эдгээр бодлого нь үр дүн гаргаад байна л даа. Тэгэхээр бид нар бусад энэ 8 нийт байгаагийн бусад 7 буюу хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, байгаль орчны зорилтот хөтөлбөр, засаглалын зорилтот хөтөлбөр, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр, мөн шинжлэх ухаан технологийн зорилтот хөтөлбөр гэсэн эдгээрийг Засгийн газар хэзээ бэлдэж, Улсын Их Хуралд оруулах вэ. Энэ бусад 7-г энэ бүрэн эрхийнхээ хугацаанд бэлдээд оруулбал цаашдын жилийн энэ хөгжлийн хөтөлбөрүүд илүү тодорхой болох болов уу гэж бодож байна. Тэгэхээр энийг яг тодорхой цаг хугацаатай тодруулж асууя гэж бодож байна.

Тэгээд асуулт санал хамт явж байгаа болов уу гээд 1 тодорхой саналыг ирэх 2026 оных дээр оруулъя гэсэн ийм бодолтой байна. 2026 оныг бол Боловсролыг дэмжих жил болгон Засгийн газраас зарласан байгаа. Энэ хүрээнд хүүхдийн шим тэжээлийн асуудлыг онцгойлон оруулж ирээсэй гэсэн ийм саналтай байна. Ер нь бол олон улсын судалгаанууд дээр хамгийн сүүлд бол Дэлхийн банкны судалгаан дээр хүүхдийн шим тэжээлд зориулсан 1 ам.доллар тутам бол 18 долларын үр өгөөж өгдөг буюу яг хөгжлийн бодлогын хувьд бол хамгийн өндөр үр өгөөжтэй төсөл хөтөлбөрүүдийн нэг. Зарим судалгаа бол бусад судалгаа нь бүр өндөр 100 гаруй долларын үр өгөөж өгдөг гэсэн ч ийм судалгаанууд байдаг. Тэгээд орон нутгийн туршлагаас хуваалцахад энийг заавал төсөв дээр нэмэлт зардал гаргахгүйгээр бас хийх бүрэн боломжтой байгаа. Жишээлбэл Ховд аймагт 2 сургууль дээр бид нар зөвхөн үдийн цай хөтөлбөр маань 5 дугаар анги хүртэл явж байгаа бол 6-аас төгсөх анги хүртэлх хүүхдүүдийн сарын 32 мянган төгрөгийг нь эцэг эхчүүд нь гаргаад, картаар хүүхдүүдийг хооллох боломжийг гаргаж байгаа юм. Хамгийн сүүлийн манай нийт хүн амын шим тэжээлийн судалгаан дээр бол яг энэ сургуулийн насны хүүхдүүдийн шим тэжээлийн дутагдал, мөн бас илүүдэл жингийн асуудал гээд нэлээд олон ийм асуудлууд гарч ирсэн байгаа юм. Тэгэхээр энэ саналыг Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, тэгээд нийтэд нь базаад Эдийн засаг, хөгжлийн яам энэ бол өөрөө зөвхөн эрүүл мэнд, боловсролын асуудал биш. Эдийн засгийн бодит асуудал гэдэг утгаас нь оруулж ирээсэй гэж бодож байгаа юм. Ялангуяа 2026 оныг боловсролыг дэмжих жил гэж зарласан хүрээнд зөвхөн сургууль цэцэрлэг барина гэж харалгүйгээр яг эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжтэй асуудал буюу хүүхдүүдийн шим тэжээлийн дутагдлыг арилгах энэ асуудлыг оруулж ирээч ээ. 2026 оны хөгжлийн төлөвлөгөөндөө маш тодорхой оруулаач ээ гэж хүсэх байна. Тэгэхээр эхний асуулт маань энэ дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдээ хэзээ оруулж ирэх .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 4 номерын индэр.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Болормаа гишүүний асуултад хариулъя. Яг энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө маань хөгжлийн дунд хугацааны буюу 5 жилийн үндсэн чиглэл мөн зорилт хөтөлбөрүүдээр суурилна гэсэн хуулийн заалт байгаа. 5 жилийн үндсэн чиглэл маань бас энэ жил дуусаж байгаа. Бид нар 5 жилийн үндсэн чиглэлийн 1 дүгээр хавсралт буюу хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэсгийг саналуудыг аваад багцлаад дуусаж байна. Засгийн газрын түвшинд бас хэд хэдэн ажлын хэсэг байгуулаад, Алсын хараагийн 5 жилийн эхнийх нь ревью хийх ажлууд бас давхар хийгдэж байгаа. Зорилтот хөтөлбөрүүдтэй холбоотойгоор бид нар бэлтгэл ажлуудаа хийж байна. Тэгээд энийгээ бас нэлээд судалгаатай, суурьтайгаар хийхийн тулд саяын өмнө дурдсан ажлуудаа хийж байж энэ араас нь орж ирэх юм. Энэ дээр жишээлбэл далайн тээвэр ч байдаг юм уу нэлээд нарийвчилсан салбар болгоны бодлого нь энэ зорилт хөтөлбөрүүдээр гарч ирэх, мөн олон улсад бид нарын амласан ногоон хөгжлийн ч байдаг юм уу, энэ заалтууд маань бас үүнтэй уялдах учраас бэлтгэл ажил нэлээд шаардагдаж байгаа. Бид нар энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлуулсны араас энэ ажлууд руу шуурхай орж, 5 жилийн болон 10 жилээр хийгдэж байгаа дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдээ Улсын Их Хуралд өргөн барих болно.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: За байз тэгэхээр энэ баримт бичгээ нөгөө бэлдэх дарааллаа буруу хэлээд байна л даа. Одоо бэлтгэл ажил хийгээд 1 жилийн, 5 жилийн, түүний дараа нөгөө дунд хугацааны гээд. Яг хууль дээрээ юу гэж заасан бэ гэхээр энэ дунд хугацааны 10 жилийнхээ төлөвлөгөө дээрээ суурилж, 5 жилийнхээ гаргах ёстой. Түүн дээрээ суурилж 1 жилийнхээ гаргах ёстой. Тийм болохоор та бүхэн маань дэс дарааллаа буруу хийгээд байна гэж би хэлмээр байна л даа. Урт хугацааны хөгжлийн хөтөлбөр Алсын хараа 2050 бол 30 жилээрээ батлагдсан. 8 зорилтот хөтөлбөрийн эхнийх нь буюу эдийн засгийнх нь 10 жилээрээ батлагдсан. Тухайн ажлын хэсгийг би өөрөө ахалж ажилласан. Энийг бол 4 сарын хугацаанд яг хийсэн. Тэгэхээр энийг бүрэн хийх боломжтой гэж хараад байна л даа. Одоо 5 жил, 1 жил рүүгээ орохоосоо өмнө дунд хугацааны хөтөлбөртөө орох ёстой. 10 жилийнхээ. Хуульдаа ч тэгж заасан байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар ерөнхийдөө бэлдэж ажиллаж байна, судалж ажиллаж байна биш, маш тодорхой цаг хугацаа заагаад Их Хуралд оруулж ирэх .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Бид хэд ингээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг батлах гээд сууж байгаа юм. Тэгээд 2024 оны гүйцэтгэлийн тайланг бид нар үзээд л Улсын Их Хурлын Тамгын газраас 45 хувьтай хэрэгжсэн гэж үнэлсэн. Тэгэхээр юу ярих гэж байна гэхээр бидний өнөөдрийн орж ирж байгаа энэ эдийн засгийн бодлогын хүрээнд үндсэндээ олон зорилтуудыг тавиад, эдийн засгийн өсөлт 6 хувь байна, инфляц 7 хувь байна, жуулчдын тоог 1,6 саяд хүргэнэ, ядуурлын 5 хувиар бууруулна гээд л баахан тоонууд тавьж байгаа юм. Энэ нь бодит биш байгаад байна л даа. Яг ийм өндөр тоо тавьчихдаг. Тэгээд дараа нь хэрэгжих шатдаа бол хэрэгждэггүй. Тэгээд үнэлэлт дүгнэлт өгөхөөр 45 хувьтай болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ тоонуудаа яагаад ийм бодитой биш тавиад байдаг юм бэ. Жишээ нь 150 мянган айлын орон сууцыг барина. Монголын аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлнэ. Ажилгүйдэл, ядуурлын бууруулна гэхчээ байгаа юм. Тэгээд яг өнөөдрийн байгаа байдал дээрээ хэдүүлээ ингээд харъя л даа. Харахаар нийслэл дээр 10 мянган айлын орон сууц барих гэж байгаа юм. Тэгээд 10 мянган айлын орон сууцаа ганц ч дотоодын аж ахуйн нэгж биш, гаднынханд зориулсан тендер нь бүр шалгарчихсан. Метр квадрат нь 7 саяын өртөгтэй орон сууц барих гээд сууж байгаа юм л даа. Тэгэхээр энэ нөгөө бидний тавьж байгаа зорилт, хийж байгаа ажлын гүйцэтгэл маань эсрэгээрээ яг ийм эсрэг байж байгаа. Тэгээд энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам нийслэлээ удирдаж чадаж байна уу. Нийслэл чинь яахаараа ийм юм хийгээд байдаг юм бэ. Тэгэхэд өнөөдөр Монголын аж ахуйн нэгжүүд, монголчууд барилгаа барьж чаддаг болчихсон шүү дээ. Түрүүн Улсын Их Хурлын дарга хэлж байна л даа. Хэнд үйлчлээд байгаа юм бэ гээд. Яг өнөөдөр энэ хөгжлийн хөтөлбөр дээр чинь ийм зүйл биччихээд, хийж байгаа үйлдэл чинь өөр байгаад байна шүү дээ. Тэгэхэд л бид метр квадратын өртөг, газраа өөрсдөө худалдаж аваад Монголын аж ахуйн нэгжүүд инженерийн дэд бүтэц, гадна тохижилтоо бид нар өөрсдөө хийгээд, зээл аваад ингээд барихад л 2,5-3 сая, 4 саяын хооронд л зарж борлуулж, барилгаа барьж байна шүү дээ. Жилд 22 мянган айлын орон сууц барьж чадаж байна шүү дээ. Тэгэхэд яахаараа өнөөдөр Монгол ийм мөнгөтэй юм уу, эсвэл ийм баян болчихсон юм уу. 7 сая м²-ын өртөгтэй орон сууцыг гаднынхнаар, Хятадуудаар, тэгээд тэр тусмаа 30 хувийн урьдчилгаа өгөөд бариулах гэж байгаа шүү дээ. Ийм тендерийг зарлаад сонгон шалгаруулалт 2 хятад компанид өгчхөөд сууж байна шүү дээ. Тэгээд нийт төсөвт өртөг нь ингээд 3,4 их наяд төгрөгийн

тендер байж байгаа. Яг үүнтэй ялгаа байхгүй, адилхан Сэлбэ биш Туулын хурдны зам гээд 2,3 их наядын тендер зарлагдсан. Эхний тендер нь 1,9 их наядаар зарлагдаад, 3 Хятад компани ороод, 1 нь 1,5 их наяд, нөгөөдөх нь 8, 1 нь 1,9 гээд. Тэгснээ тендерээ цуцлаад, дахиад 500 тэрбумаар нэмэгдүүлээд, 2,4 их наядаар зарлачхаж байгаа. Үгүй ээ, тэгээд ийм их мөнгөтэй болчихсон юм уу Эдийн засаг, Хөгжлийн сайд аа. Тендерээ нэг цуцлаад л, дахиад л 400, 500 тэрбумаар нь нэмж зарлаад, тэгээд л ялгаа байхгүй Монгол аж ахуйн нэгж ерөөсөө орж чадахгүй, дандаа гаднынханд үйлчилсэн ийм л тендер зарлаж байна шүү дээ. Тэгэхээр чинь бид нар яаж ажилгүйдэл, ядуурлаасаа гарах юм. Яаж үндэсний үйлдвэрлэлээ дэмжих юм. Тэгээд энэ тоо чинь яг энэ дээр бичсэн юмнууд чинь ерөөсөө эсрэгээрээ байна шүү дээ. Эсвэл энэ нийслэл чинь тусдаа вант улс болчихсон юм уу. Монгол Улсын төсвийн хуульд захирагдахаа байчихсан юм уу. Энэ дээр хариулт авмаар байна.

Дээрээс нь яг энэ хөгжлийн хөтөлбөр дээр орж ирж байгаа энэ гаднын банкны салбарыг нээж байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ гээд байж байгаа. Энэ ямар учиртай юм. Энэ дээрээ бас тайлбар өгөөч ээ гэсэн.

Дараагийн асуудал нь инфляц нэмэгдэж байгаа. Одоо 2 оронтой тоо руу орж байна. Улаанбаатарт л 10,3 хувьтай байна шүү дээ. Энэ 2 сарын байдлаар .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайдад хариулт өгье.

Л.Гантөмөр: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Ер нь Улаанбаатар хотын энэ тендерийн шалгаруулалттай холбоотой ажилд Засгийн газар оролцож байгаа зүйл ерөөсөө байхгүй. Та өөрөө аймгийн Засаг дарга байсан хүн орон нутгийн бие даасан байдлын тухай ойлголт бол бусад хүнийг бодоход арай өөр байгаа болов уу гэж харж байна. Тэгэхээр зүгээр яг Засгийн газар өнөөдөр оролцож, хяналт тавь гэдэг даалгаврыг өнөөдөр Их Хурлын дарга болоод Их Хурлын гишүүд Засгийн газартаа өгч байна гэж би хувьдаа ойлгож байна. Яг энэ ойлголтынхоо хүрээнд бид нар асуудлыг татаж аваад харъя, үзье, танилцъя, чиглэл өгье. Үндэсний компаниуд бол энэ төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ажил дээр 1 номерт орох хэрэгтэй. Ер нь төсвийн хөрөнгөөр хийж байгаа ажлаа гаднын компаниар хийлгэдэг улс орон гэж байхгүй шүү дээ. Одоо бол ер нь байхгүй. Гаднын зээл тусламжаар явж байгаа төслүүд дээр дагасан компаниуд орж ирдэг. Энэ бүх улс оронд байдаг л ийм л жишиг. Тийм учраас манай төсвийн хөрөнгө өөрөө Монголдоо үлдэх гэдэг энэ зарчим бол хөдлөхгүй. Энэ бол яг Засгийн газрын хувьд бол байр суурь ижилхэн байна.

Төлөвлөлтийн тухайд бол бид нар хамгийн багаар төлөвлөж байгаа шүү. Ер нь дэлхий бол солиорчихсон. Дэлхий бол өнөөдөр галзуурчихсан байгаа. Тэгээд энэ галзуурчихсан дэлхий дотор бид нар эрүүл саруул байх гэж хичээж байгаа. Тэгээд галзуу солиорчихсон ертөнц чинь бид нарыг хаашаа чирч явах нь бас тодорхойгүй байгаа. Бид нар энийг бүгдээрээ тал талдаа ойлгох хэрэгтэй. Тийм учраас жижиг сажиг хөдөлгөөн гарна. Эрсдэл бол байна. Гэхдээ бид нар бол хамгийн боломжит хэлбэрээр, хамгийн өөрсдийнхөө чадах зүйлээ төлөвлөөд алхаж байгаа. Тэгээд эрхэм гишүүдээсээ хүсэхэд бол энэ төлөвлөгөөг хүслийн жагсаалт битгий болгоорой. Ирэх жилийн төсвийн хүрээг өргөн барьчихсан. Алдагдалгүй явна. Төсвийн зардлаа бид нар багасгана. Тийм учраас энэ жил тодотгол хийх хэмжээнд төсвийн зардлыг бид нар танах шаардлагагүйгээр энэ жил гарч байгаа. Ирэх жил ч

гэсэн хэдүүлээ ингэж амьдарна. Тийм учраас бодлогын чанартай өөрчлөлтийг энэ төлөвлөгөөнд тусгаж өгөөрэй л гэж хүсмээр байгаа юм.

Тэгэхгүй яг тойргийн асуудлаа оруулаад, баахан жагсаалт нэмээд ингээд асуудлаа эвдчих юм бол таны хэлдэг биелэлт нь 40 хувьтай гардаг ийм осолтой зүйл болдог юм. Түүнээс бол яг өнөөдрийн энэ төлөвлөсөн зүйлс бол яамнууд өөрсдөө ажлаа мэдэж байгаа, төлөвлөчихсөн, хийгээд явж байгаа. Бид нарын 4 жилийн мөрийн хөтөлбөрт туссан зүйлс байгаа гэдгийг хэлье гишүүн ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Харин Гантөмөр Шадар сайд энэ дотоодын аж ахуйн нэгжүүддээ боломж олгох л гарцыг гаргахгүй бол би бас түрүүн хэлсэн шүү дээ. Төр өмнүүр нь ороод ажлыг нь булаагаад аваад хийчихдэг гээд маш хүнд асуудалтай байж байсан чинь одоо дотоодод бүтээн байгуулалт, дотоодын хөрөнгө оруулалтын ажлыг хийх гээд тэгсэн чинь шалгуурыг нь та нар давж чадахгүй байна гэж хэлээд гаднын компаниуд орж ирж байгаа нөхцөлийг бид бол яагаад ч тэвчиж болохгүй зүйл. Дотоодынхоо аж ахуйн нэгжүүдийг хөл дээр нь босгож, хурдан бойжуулж байж, эдгээр аж ахуйн нэгжүүд чинь ер нь энэ улс орныхоо эдийн засгийг нуруун дээрээ үүрч, авч явна гэдэг дээрээ бид хатуу итгэл үнэмшилтэй, хатуу бодлоготой л байх ёстой шүү дээ. Хэчнээн жил ковид цар тахлаас эхлүүлээд л эдийн засагт ямар их сөрөг нөлөөллүүд оров. Сэхэж чадахгүй, хөл дээрээ босож чадахгүй арай гэж амиа тээгээд л явж байхад нь бонд босгоод л томоохон дорвитойхон хөрөнгө оруулалт хийх гэж байна гээд л төр нь ажиллаж байтал гэнэт дунд шатандаа очоод л дотоодын компаниуд орох боломжгүй боллоо гээд зарлаж байгаа энэ байдал яагаад ч байж болохгүй зүйл юм.

Ер нь Гантөмөр дарга энэ хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд төрийн хийж болох ажил, хийж болохгүй ажлыг ялгаж, 1 мөр шийдвэл яасан юм бэ. Зам цэвэрлэхээс өгсүүлээд л олон ажлыг төр өөрөө хийгээд байгаа энэ байдлыг ер нь болиод урт хугацаатай дотоодынхоо аж ахуйн нэгжүүдэд итгэлтэй, баталгаатай хэлбэрээр нь өгдөг больё л доо. Замын цэвэрлэгээг орчин үеийн дэлхийн стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хийж чадахгүй өнөөдрийг хүртэл явж л байна шүү дээ. Тэгээд тэр нь яадаг вэ гэхээр төр өөрөө жил болгон тодорхой хэмжээний ийм баталсан төсөвтөө багтааж 1 юм хийдэг. Үгүй ээ, энийгээ жишээлбэл энэ хувийн аж ахуйн нэгжүүдэд 5, 10 жилээр нь урт хугацаагаар төр гэрээ хийгээд өгчихвөл тэр аж ахуйн нэгжүүд чинь гаднаас тэр өндөр технологиудыг чинь оруулж ирээд, ард иргэдийн уур бухимдлыг хүргэхгүйгээр асуудлыг цэвэрлэхийг боломжтой шүү дээ. Тэгээд сүүлдээ нээрээ бараг зам цэвэрлэж байгаа машинаа төрийн шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа хүмүүс нь өөрсдөө бариад замаа цэвэрлэх үзүүлэн тоглолт хүртэл хийх хэмжээ рүү явдаг болох гээд байна шүү дээ. Одоо энийгээ л хэдүүлээ больё. Тэгээд аж ахуй нэгжүүддээ жоохон дэм өгцгөөе гэж хэлмээр байна.

Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: 30 гишүүн асуулт асууна гэдэг ер нь бол бүгдийг нь хамж шимээд болоод байх шиг байгаа юм. Тэгэхээр давхардаагүй, давхардал үүсгэхгүй байхыг хичээж асууя. Энэ Монгол төгрөг гэдэг 1 төгрөгийг эгнүүлээд 1м2 нь наахад обойн үнээс дор орчхоод байгаа шүү дээ. Уг нь тэр чинь манай үнэт цаас шүү дээ. Энэ төгрөгийн ханш ингэж уруудаад, 1300-1700 боллоо, 1370 боллоо гээд л Сүхбаатарын талбай дээр хүмүүс салаавч гаргаад л зогсоод л байсан шүү дээ. Ардын намын хүмүүс. Тэгээд өнөөдөр энэ төгрөгийн ханш ингэж уруудаж байгаа тохиолдолд гаднаас гадаад валютаар хөрөнгө оруулалт яаж орж ирэх юм. Оруулсан

хөрөнгө оруулалтаа буцаагаад гаргах болоход тэр чинь нөгөө оруулсан хөрөнгө оруулалт нь ханшийн уналтаар алга болчихоод байгаа юм. Дээрээс нь энэ ханшаа ямар байлгах юм. Одоо бид нар 2025 оны 5 сар гээд байж байна. 2026 оны 12 сар болоход төгрөг гадаад валюттай голлох валюттай харьцах ханш тэдэн төгрөг байна. 1 доллар тэдэн төгрөг байна. 1 евро тэдэн төгрөгтэй тэнцэж байна гэдэг ч юм уу, юань ч юм уу шууд хэлж чадах уу. Өнөөдөр байгаа ханш яаж өөрчлөгдөх юм. Тэр Жи Ти Пи өсөөд, иргэдийн ноогдох тоо чинь нэмэгдэнэ л гээд байдаг. Тэгээд тэр нь ямар ч хүртээмжгүй, тийм нөхцөл байдалтай байхад бид нар энэ дээр тодорхой хариулт хэлж өгөөсэй гэж хүсэж байгаа юм. Дараа нь эргээд жилийн дараа асуухад ч гэсэн.

2 дугаарт нь тэр шударга ёсны асуудал. Шүүх тэгээд тэр шүүхэд хүргэх хүртэл явдаг байгууллагууд шударга уу, үгүй юу гэдгээс хамаараад, тэгээд энэ Монгол төгрөгийн ханш гэдэг юмнаас хамаараад хөрөнгө оруулалт чинь яаж шийдэгдэх юм бэ. Энэ дээрээ Засгийн газар яаж анхаарч, юу оруулж ирж, энэ Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах ёстой юм байвал юу байх юм бэ гээд асууж байна.

2-т нь Улсын Их Хурлаас ингээд хуулиар хөгжлийн баримт бичгийг, төлөвлөгөөг батлах ёстой байгаад байдаг. Өмнө нь Улсын Их Хурлаас баталсан, Байнгын хорооноос баталсан Засгийн газарт чиглэл өгсөн тогтоолуудын биелэлт, хэрэгжилт гэхэд чинь учир замбараагүй, зүгээр л 1 тогтоол гаргуулаад л авчихсан. Засаг нь тэрийгээ хийж хэрэгжүүлээгүй, буруу хэрэгжүүлсэн гэдэг юм яваад л байдаг шүү дээ. Тэрийг нь хэрэгжүүлэхгүй болохоор л бүх юмыг нь Их Хурал дээр татаж авчирч засгийн хийгээд болчих зүйлүүдийг заавал Их Хурал руу оруулах шаардлага засагтаа ч үүсдэг, Их Хурлын гишүүдэд ч гэсэн тийм асуудал үүсээд яваад байгаа.

Дээрээс нь эдийн засгийн эрх чөлөө гэж байна. Эдийн засгийн эрх чөлөө гэж. Тэгвэл иргэдийн санхүүгийн эрх чөлөө яаж дээрдэх юм. Сайжрах юм. Манай өр гэдэг чинь 2009 онд 3, 4 тэрбум доллар байсан бол одоо 37 тэрбум доллар болчихсон. 1 хүнд ноогдож байгаа өр чинь 40 гаруй сая төгрөг Монгол төгрөгөөр бодохоор болчихсон явж байна. Энийг яаж багасгах юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Ер нь бол төгрөгийн ханш өөрөө инфляцтайгаа л уялдаж уншигдах учиртай. Тэгээд ирэх 2026 оны инфляцыг бид нар 7 хувьтай байх болов уу гэж төсөөлж байгаа юм. Тийм учраас тэр хэмжээндээ төгрөгийн ханшийг харъя гэж ойлгож байгаа. Бид нар ханш эвдэх хэмжээнд төгрөгийн нийлүүлэлтийг бол ерөөсөө хийхгүй гэдэг ийм хатуу бодлоготой байгаа шүү дээ. Урсгал зардал бол байнгын ашигтай байхаар ингэж байж байгаа юм. Тэгээд илүү гарсан төгрөгөө гаднаас орж ирж байгаа долларын хэмжээний төгрөгийг бид нар бас нөөцөд аваад байгаа. Тийм учраас зах дээр байгаа төгрөгөө бол Засгийн газар сүүлийн хэдэн жил чадах чинээгээрээ л татаж байгаа. Дээр нь нэмээд төв банкны бодлогын хүү бол өссөн. Тийм учраас төгрөгийн нийлүүлэлт тэр хэмжээгээр багасна. Зүгээр сөрөг тал нь бол зээлийн олдоц муудна гэсэн ийм зүйл байгаа. Зээлийн олдоц элбэг байхаар импорт руугаа хэтэрхий довтлоод байна. Тэгээд өнгөрсөн жилийн ханшинд нөлөөлсөн хамгийн чухал хүчин зүйл бол хэрэглээний импорт бол эрс нэмэгдсэн. Бүр эрс. Тэгээд түрүүн гишүүд хэлж байна лээ. Энэ жил бол өнгөрсөн жилийнхээ түвшинд хадгалагдаж байна гэж. Бидний тооцоогоор бол өнгөрсөн жилээсээ бууж гарах учиртай. Энэ жил 2025 оны импорт бол өнгөрсөн жилээс тэрбум доллароор

татуу гаргах гэдэг ийм зургийг бол бид нар харж, мөнгөний бодлого, төсвийн бодлогоо хийж байгаа.

Тэгэхээр ийм санаатайгаар доллар байсаар байтал доллар, төгрөгийн ханш унадаг ийм зүйл бол байж болохгүй. Долларын нийлүүлэлт бол хомсдохгүй. Бид нар яг сар сар тутамд нь хараад явж байгаа. Одоо энэ жилийн орж ирэх хөрөнгийн хэмжээг бид нар 3 тэрбум доллароос илүү хэмжээгээр харж байгаа. Нэг үгээр хэлбэл шууд хөрөнгө оруулалтуудыг нийлбэр дүнгээр нь харвал. Тэгээд зүтгэвэл 4 тэрбум доллар давчихаар байгаа гэх мэтчилэн бид бол төгрөгөө нандигнана гэж Батбаатар даргын хэлж байгаатай санал 1 байна. Төгрөг тогтворгүй байвал гаднын хөрөнгө оруулалт бол орж ирэхгүй. Төгрөгөө алдаад байх юм бол Засгийн газар ирээдүйд өрөө төлж дийлэхгүй. Төгрөг чангарч байж Засгийн газар өөрийнхөө өрийг ирээдүйд нэр төртэйгөөр төлнө. Тийм учраас бол энэ дээр байгаа. Зүгээр том төслүүд бол яалт ч үгүй бид эдийн засгаа босгож, хөгжүүлж байж л тэр санхүүгийн эрх чөлөө ирнэ. Өөр арга байхгүй. Тэр 10 мянган доллар 1 хүнд оногддог эдийн засагтай болсны дараа одоо шоолж байгаа хүмүүс харах хэрэгтэй л дээ. Тэр үед нэг юм харагдана. Түүнээс 1 хүнд оногддог ДНБ 10 мянган доллар гэж яриад байгаа шалтгаан тэр үед нэг эдийн засгийн эргэлт чинь арай өөр болно. Одоо бол мухар. Мухар зам байна. Унахад бэлэн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 10 гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан сайд яагаад нэр нь ороод ирэв. Андуураад дарчхав уу, үгүй юу. Дахиад дарчих.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлье.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын гишүүд ч тэр, Засгийн газрын гишүүд ч тэр бид бүгдээрээ Үндсэн хууль дээр гараа тавиад, тангараг өргөдөг. Өргөсөн тангарагтаа үнэнчээр, 1 сэтгэл зүйгээр энэ үйл хэрэгтэй явж байна гэж ойлгодог. Тэгэхээр чуулганы хуралдаан дээр парламентын өөрийнх нь амин сүнс бол энэ мэтгэлцээн. Үзэл бодлоо илэрхийлэх, нээлттэй байх, иргэдийн мэдэх эрхийг хангана гэдэг бол бидний том зарчим байдаг. Энэ зарчмаа л хэрэгжүүлж байгаа юм.

Тэгэхээр бид нарын гол ярих зүйл бол тоо баримт, дээрээс нь судалгаа, үнэлгээ ил тод байх ёстой гэдэг энэ зарчим байгаа юм. Тоо баримт асуухаар субъектив байдлаар хариулаад байж болохгүй сайд нар аа. Маш эмзэг байна. Цочоо ихтэй байна. Хардамтгай байна. Тэгэхээр ер нь бол тодорхой тоо баримт дээр тоо баримт хариулаад, асуудлыг 2 талд биш яг 1 талд Монгол Улсын хөгжлийн хөтөлбөр ярьж байгаа учраас бид нар нэгдмэл эрх ашгийн төлөө байр суурьтай байх ёстой гэсэн зүйл байгаа.

Эцсийн эцэст явж явж энэ төрд итгэх итгэл гэдэг бол төрийн бодлого нь нээлттэй, ил тод, энгийн иргэддээ ойлгомжтой байж байж л дэмжлэг авдаг. Тийм учраас энэ хөгжлийн хөтөлбөр гэдэг зүйл энд орж байгаа зорилт болгон иргэдэд ойлгомжтой, энгийн хэмжигдэхүйц байх ёстой. Дээрээс нь бид нар 48 сарын хөтөлбөр дотроос эхний 10 сарыг нь ингээд хэрчээд харах юм бол явцын биелэлт

нь ямар байгаа тухай асуусан. Энэ дээр бас хариулт Байнгын хорооны түвшинд дахиад асууж авъя гэж бодож байгаа юм.

Түрүүн Гантөмөр сайдын хэлж байгаа зүйл байсан. Юу гэхээр бид нар Улсын Их Хурал 2024 оны 11 сарын 20-д хавиар Амарбаясгалан дарга аа, хүн төвтэй стратеги хэрэгжүүлнэ гээд баталсан. Өөрөөр хэлбэл хөгжлийн хөтөлбөрийн дараа төсөв баталсны дараа энэ стратегийг 5 тулгууртайгаар баталсан юм. Тэгэхээр одоо миний хэлэх гээд байгаа санаа бол 2026 он, цаашлаад энэ 2028 он хүртэл бүхий л зөвхөн энэ хөгжлийн хөтөлбөр төдийгүй төсөв бүхий л зүйлдээ энэ хүн төвтэй байх 5 шалгуурынхаа хэмжүүрээр Их Хурлаас гарч байгаа энэ шийдвэрүүдээ нягталж, магадалж, шүүж, тунгааж, сорьж үзмээр байгаа юм. Тэр утгаараа энийг дахин дахин хэлээд байгаа юм. Тэгэхээр бид нарын гол зүйл бол эдийн засгийн өсөлт чинь иргэдийн гар дээр очиж байна уу, үгүй юу. Бид маш гоё үгээр зорилт бичиж болно. Тэгэхдээ энийг зүгээр хийсвэр хийсэн гэж бодохгүй байна. Мэдээж Эдийн засаг, хөгжлийн яам, холбогдох яамнууд бүгдээрээ л судалгаа, үндэслэл, нотолгоо гаргаад л хийж байгаа байх. Харамсалтай нь жишээлбэл өнөөдөр хүүхдэд зориулна гэсэн төсвийн мөнгө чинь яг хүүхдэдээ очиж байгаа юм уу, үгүй юу. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүчирхийллийн хэргийн золиос болчихоод төвд очиход тэнд нь мэргэжлийн сэтгэл зүйч байхгүй ч гэдэг юм уу яг амьдрал дээр тулаад ирэхээр хүний эрх чинь маш хэцүү байгаад байгаа байхгүй юу. Тэр парламентаас гаргаж байгаа энэ шийдвэрүүд хууль дүрэм журам энэ бүх зүйл чинь амьдрал дээр яг амилж байгаа юм уу гэдэг дээрээ бид нар том чихээр сонсож, хүлээцтэй хандах ёстой шүү Засгийн газраа. Тэгэхгүй болохоор нь нөгөө оруулж ирсэн бичгийг нь зарчмын байдлаар санал гаргаад хэлэхээр шууд шүүмжлэл гэж ойлгоод, субъектив утгаар хүлээж аваад, таталдаад байж болохгүй ээ.

Монгол төрийн бодлого бол олон олон талаас нь магадалж байж, үзэл бодлоо уралдуулж байж, тоо хэмжээс ярьж байж гардаг байх ёстой юм.

2 дугаарт бид энэ Их Хурлын чуулганы танхимд хэлж байгаа, амнаас гарч байгаа авиа болгон дээрээ хариуцлагатай байх ёстой. Хувь хүний үзэл бодол гэхээс илүүтэйгээр тухайн салбарын үндэслэл, тооцоо мэргэжилтнүүдийн гаргаж өгсөн тэр баримтууд дээр сэдвүүдийг нь түшиглэж ярьж байх ёстой шүү гэдгийг уриалж байгаа юм.

Эцэст нь гэж хэлэхэд мэдээж энд Монголынхоо эсрэг, Монголоо хорлоё гэсэн хүн байхгүй байх. Аливаа асуудал дээр бид нар объектив хандах ёстой. Бодитой хандах ёстой. Өнөөдөр мэдээж цар тахал, худалдааны дайн, олон улсын нөхцөл байдал муу гээд энэ бүх зүйлийг ойлгож байгаа. Гэхдээ энэ хөгжлийн хөтөлбөр, түүний үзэл баримтлалыг оруулж ирэхдээ л дэлхийд ийм байгаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн үг хэлье.

А.Ариунзаяа: Энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулж, 1 жилийн хөгжлийн төлөвлөгөө баталдаг байдаг асуудлаа болихгүй бол энэ ер нь их хийсвэр төлөвлөгөө явдаг юм. Энэ бол улсын төсөв биш. Төсөв дахиад тусдаа орно. Улсын Их Хурлын гишүүд энэ хөгжлийн төлөвлөгөөг төсөв мэт буруу ойлгож, маш ихээр хүслийн жагсаалт оруулж, тэгээд тэр нь ердөөсөө хэрэгждэггүй, батлагддаггүй. Ер нь хөгжлийн төлөвлөгөө гэвэл л урт хугацааны, дунд хугацааны байгаад, тэр хөгжлийн төлөвлөгөөнийхөө дагуу улсын төсөв нь батлагддаг байх нь зүйтэй юм. Энэ хөгжлийн төлөвлөгөө бол санхүүжилтийн эх үүсвэр төсвийн

тодорхойгүй, хэрэгжилтийн хяналт, үнэлгээ, тогтолцооны нарийвчлал дутмаг, хэт өөдрөг ерөнхий заалтууд дэвшүүлсэн, төсвийн сахилга үр ашигт хангалттай анхаараагүй, олон бодлого давхардсан байж болзошгүй гэсэн дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хийсэн байгаа юм.

Тэгэхээр ер нь энэ хөгжлийн төлөвлөгөө 1 жилээр нь гаргадаг нь төсөвтэйгөө давхардаж ямар ч үр ашиггүй хий дэмий цаг зарцуулдаг ийм асуудал байгаа юм. Төсвийн хүрээний мэдэгдэл орж ирнэ. Төсөв орж ирнэ. Төсвийн алдагдалгүй байх тал дээр би бас саналаа хэлье гэж бодоод байгаа юм. За бол ёогүй байдаг тэр Монгол эрийн зан яг энэ Засгийн газрын түвшинд байх ёстой ч юм уу, үгүй ч юм уу. Ичсэн хүн, хүн ална гэгчээр яаж томоохон төслүүдээ явуулах вэ, авсан зээлээ хэрхэн яаж ашиглах вэ гэдэг дээрээ толгой гашилган сууж байна шүү дээ. Тэгэхээр уг нь бол зүгээр л тэр давхар давхар төсвүүдээ больсон учраас зээлээ ашиглах тал дээр нь төсөвтөө оруулаад, хэлэлцээд, яриад төсөвтөө оруулаад явуулсан нь зүйтэй гэсэн миний байр суурь байгаа.

Төсөв бол хүнд байгаа. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл эхний улирлын байдлаар 353 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,2 их наяд төгрөгөөр буурсан байгаа. Нөхцөл байдал хүнд байгаа шүү дээ. Энэ жил ямар ч хөрөнгө оруулалтууд байхгүй, ирэх жил байхгүй, тэрний дараагийн жил байхгүй. Яаж улс орны хөгжил явах юм. Яаж мөрийн хөтөлбөртөө оруулсан тэр хөрөнгө оруулалтууд явагдах юм. Тэгээд алдагдалгүй төсөв байна гээд эхний жилээ нэлээд улс төржөөд явлаа. Одоо тэгээд үнэтэйгээ нүүр тулаад гарцаагүй энэ төсөв дээрээ ядаж авсан зээлүүдээ ашиглая гэдгийгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй шүү дээ. Нөхцөл байдал хүнд байна. Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энэ дээрээ бас дүгнэлт хийх хэрэгтэй. Сонгогч олондоо юу гэж хэлэх гэж байгаа юм. Тойргоос сонгогдсон гишүүд. Одоо байгууллагууд төсөв бас хүнд байгаа шүү дээ. Цалингаа тавьж чадахгүй байгаа. Хүнд байгаа. Хязгаарлагдаж байгаа. Үнэтэйгээ нүүр тулъя. Алдагдалтай ч гэсэн энэ зөв төсвөө явуулсан нь зүйтэй. Хуулийн хулгайн аргаар яаж алдагдалгүй мөртөө цаагуураа давхар төсөв явах вэ гэдэг асуудлыг бид нар яримааргүй байна. Түүхийн өмнө бид нар ч гэсэн хэзээ нэгэн цагт дахиад шүүгдэх цаг ирнэ. Ийм учраас бас үнэтэйгээ нүүр тулж зөв төсвөө оруулаасай, зөв дуугараасай, бүгдээрээ хүлээн зөвшөөрөөсэй гэдэг ийм үгийг хэлж байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Өнөөдөр бас хуулийн дагуу л бид нар энэ асуудлыг хэлэлцээд явж байна. Би Ариунзаяа сайдын зарим зүйлтэй бараг ижил байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн зарим зүйлүүдийг уялдуулж, давхцалыг нь арилгах ийм зүйл баймаар байна. Магадгүй бараг үүнийхээ оронд бид нар төсвийн гүйцэтгэл энэ тэрийг бол илүү их чамбай хэлэлцдэг байх нь л зөв байгаад байгаа юм. Тэгэхдээ нэгэнт энэ асуудал хуулийн дагуу хэлэлцэж байгаа учраас бас ганц 2 зүйлийг хэлмээр байна. ДНБ-ийг ирэх онуудад 8090 долларт хүргэнэ гээд энэ үзэл баримтлал дээрээ тусгасан байгаа. 2026 оны хөгжлийн төлөвлөгөө дээр. Өнөөдөр 7000 руу дөхөж байна. Гэхдээ 1 хүнд ноогдож байгаа ДНБ-ий өсөлт маань ерөөсөө л төр данхайсных буюу төрийн алба, төрийн өмчит компани, орон нутгийн өмчит компаниуд тоо олширч данхайсны л үр дүн шүү дээ. Тэгэхээр энэ өсөлт өөрөө эргээд хувийн хэвшил дээр наалдахгүй, хувийн хэвшлээрээ дамжуулаад өрх гэрт орохгүй байгаа учраас ард иргэд маань бас бухимдаад байгаа юм. Тэгэхээр энэ төр өөрөө энэ бизнесийн салбараас ангид

байхгүй бол өнөөдөр энэ төсвийн хүндрэлтэй нөхцөл байдал, алдагдал, төсвийн орлого бүрдүүлэлт дээр муу байгаа хэсэг дээрээ ярьж байгаа хууль маань биржийн тухай хууль. Биржийн тухай хуулийг ярьж байгаа гэдэг асуудал нь өөрөө төр бизнес хийх тухай байхгүй юу. Төр яаж нүүрсний бизнесээ үүгээр явуулах тухайгаа яриад байдаг. Уг нь энэ бизнесүүдийг хувийн хэвшил хийдэг л баймаар байгаа юм. Тэгээд өнөөдөр яг энэ бусад хувийн хэвшил гэдэг юм уу, аж ахуйн нэгж байгууллагууд маань уул уурхайн салбарт орох асуудал бодлогын хувьд ерөөсөө тодорхойгүй болчихлоо. Тэгэхээр энэ зүйлүүд дээрээсээ л уг нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал маань их цэгцрээд, ямар ямар хуулиудыг яаралтай оруулж ирэх юм. Энийгээ л яримаар байна. Би ингээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эргээд энэ шат дараатай бүх юмнууд дээр энэ хуулиудыг тун удахгүй оруулж ирнэ гэдэг үгийг л маш олон удаа сонслоо. Тэгэхдээ одоогоор хаана яваа нь мэдэхгүй байна. Тийм учраас энэ дээрээ сайн анхаараач ээ гэж хүсэж байгаа юм.

Тэгээд энэ уул уурхайн салбар дээр маш олон тусгай зөвшөөрлүүдийг хувийн компаниуд эзэмшиж байгаа мөртөө бас эдийн засгийн эргэлтэд оруулж өгөхгүй байна. 1 талдаа дэд бүтцийн асуудал хомсдол байгаа. Дэд бүтцийн шийдэж өгөөгүй. Нөгөө талдаа бас нөөцлөөд байна. Өөрөөр хэлэх юм бол ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг буюу хайгуулын болон ашиглалтын зөвшөөрлийг эзэмших хугацааг бас тодорхой болгомоор байна. Магадгүй зүгээр яах вэ эхний 2, 3 жил дээрээ төлбөр хямд байгаа. Цаашаа өсөн нэмэгдээд явж байгаа боловч энийгээ яг тэр хуульд заасан буюу 12 жилдээ эдийн засгийн эргэлтэд оруулж чадаагүй бол төрд нь буцаагаад өгчихдөг. Төр энийгээ буцаагаад чаддаг этгээдэд нь нээлттэйгээр сонгон шалгаруулалтаар өгдөг баймаар байна. Тэгэхгүй эдийн засгийн эргэлтэд ордоггүй, 1 компанийн тэр лиценз нь сейфт нь хав дараастай байдаг. Бид нар тэрийг олгочихсон лицензээ болохоороо орлого талдаа бас төсөөлж бодоод байдаг. Тэгээд ерөөсөө ингээд уул уурхай гэхээр л нүүрснээс гарахгүй л байна шүү дээ. Тэгэхээр бид хэд энэ хаана хаанаа бодитой яримаар байна. Төр бас аль болохоор уул уурхайн бизнесийг ч гэсэн бага хийе. Хувийн хэвшил ч гэсэн энэ олон лицензүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй бол төрдөө буцааж өгдөг. Бид хэд чаддаг газарт нь бас оруулмаар байна. Ингэхгүй бол ерөөсөө бүх юм явахаа болилоо. Энэ зуурмагтаа, энэ намгаасаа гарахгүй нь. Тэгээд энэ дээр ерөөсөө бас1 харагдаад байгаа юм байна.

Уул уурхайн бус эдийн засгийн салбарууд болох аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбар дээр бодлогын юмнуудыг бас тун цөөхөн орж ирж байна. Тэгээд цагаан алт, ноолуур, мах сүү гээд дэмжинэ л гээд байна. Өмнөх эсвэл яг энэ асуудал дээр бүр бодлогын хүрээнд бүр нэг тултал нэг яваад үзмээр байна. Өнөөдөр яг энэ ХАА-н салбар аялал жуулчлалын салбар дээр л дундаж өрхүүд дундаж орлоготой өрхүүд бий болж босож ирнэ. Маш олон ажлын байрууд хадгалагдана. Тэгээд өнөөдөр Франкфурт дээр жишээ нь/минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформ гээд гоё гоё нэртэй байна. Нэрүүдтэй санал нийлж байгаа. Тэгээд төсвийн зардлын реформ дээр халамжийг багасгах талаар авч хэрэгжүүлэх ажил нь ерөөсөө байхгүй, харагдахгүй байгаа. Эдийн засгийн эрх чөлөөний реформ дээр ярих уу, төсвийн зардлын реформ дээр ярих уу. Нөгөө төсвөөс гадуур Эксим банкнаас авсан зээлийг төсөвтөө оруулаад, жил жилд нь бага багаар тусагнуулаад

аливаа том төслүүдийг 10, 20 жилээр нь гацаадаг санаатай ч юм шиг, санаандгүй ч юм шиг энэ үйлдлээ бид нар энэ удаа засах хэрэгтэй байх гэж бодож байна. Тэгэхгүй бол ийм л байх ёстой. Яг энэндээ захирагдана. Тэгэхгүй бол улс орон бараг гаднынханд эзлэгдэнэ гэж ярьдгаа хэдүүлээ болиод, энэ төсөв дээр бага багаар дусагнуулаад л том төслүүдийг гацаадагаа болих хэрэгтэй. Энийг ч гэсэн хамтад нь оруулж ирмээр санагдаад байгаа байхгүй юу. Жишээ нь манай Дорноговийн Алтанширээгийн Газрын тосны үйлдвэр яг энэ төсвийг чинь тэр Энэтхэгийн Эксим банкнаас авсан зээл чинь ороод явах юм бол 209 тэрбум. Үүгээр 15 жил, 20 жил барих байхгүй юу. Тэгэхээр болохгүй юм гэж байдаггүй. Хэдүүлээ жоохон тийм хэвшмэл сэтгэлгээнээсээ салчихмаар байгаад байгаа юм. Тэгээд манай говийн нөгөө усжуулах төсөл байна. Цагаан бургастай, Улаан нуурын. Энийг төсвөөс тавьдаг болчихсон байх юм. Тэгээд сая говийн бүсэд хуралдсан Засгийн газрынхаа шийдвэрүүдийг бүгдийг нь оруулж, би түрүүн асуулт асуух гээд чадсангүй. Бүгдийг нь оруулж чадсан эсэхэд эргэлзээтэй л байна. Зарим зүйл нь байна. Зарим нь алга. Жишээ нь Цогтцэций сумын асуудал алга. Эдийн засгийн чөлөөт бүс болно гэсэн нь алга байна. Цогтцэцийгээс Даланзадгад руу тавих төмөр зам нь алга байх юм. Тэгээд энэ мэт юмаа сүүлд нь оруулаад ирэх байлгүй дээ гэж найдаж байна. Тэгээд нэгэнт реформ гэж нэрлэж байгаа бол реформыг хийсэн шиг хийчихмээр санагдаж байна. Тэгээд энэ тал дээр Засгийн газар ажиллах байх. Дахиад ороод ирэхээр нь Байнгын хороод дээр, Их Хурал дээр нэлээн юутай санаачилгатай ажиллана. Ер нь тэгээд Улсын Их Хурлын босго давна Улсын Их Хурлаар энийгээ батлуулна гэдэг бол нэлээд том асуудалтай тулгарах байх гэж бодож байна. Одоо яагаад гэвэл бид нар бас нэг үеэ дуусгачихлаа. Тэгэхээр энийг мөрөөдлийн жагсаалт болгохгүйн төлөө түрүүн Гантөмөр сайд хэлсэн. Мөрөөдлийн жагсаалт болохгүй гэж. Мөрөөдлийн жагсаалт болохгүйн төлөө тал талаасаа хамтарч ажиллая.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн үг хэлье.

М.Ганхүлэг: Анхаарах 1 асуудал, зайлшгүй тусгах 2 саналыг бас онцолж хэлье. Ялангуяа хурдтай хөгжлийн төлөөх Засгийн газраас хурдтай байхыг шаардаж байна. Бүсчилсэн хөгжлийн тухай бид бүхэн яриад нэлээдгүй хугацаа бас өнгөрсөн. 2024 оны улсын төсөвт 2024 ондоо багтаад бид бүхэн бүс болгон дээр 10 орчим тэрбум төгрөгөөр тэргүүлэх чиглэлүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулах бүр тодорхой заалтуудыг тусгаж өгсөн. Өнөөдөр 2025 оны 6 сар луугаа бид бүхэн орох гэж байна. ТЭЗҮ-үүд зарлагдаагүй байгаа. ТЭЗҮ зарлагдаж байж тухайн бүс нутаг дээр тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд эдийн засгийн тооцоо судалгаатайгаар аль цэг дээр арьс ширний үйлдвэр, аж үйлдвэрийн паркууд нь байгуулагдах юм бэ. Аль цэгийг аль бүсийг ямар байдлаар хөгжүүлэх юм бэ гэдэг бид нар уриа лоозон биш тодорхой төлөвлөгөөтэй болох гээд байгаа юм. Тэгээд энэ байдал уг нь өмнөх ондоо зарлагдаад, өдийд эхний ТЭЗҮ-үүд нь бэлэн болоод, тодорхой дэд бүтэц төсвийн асуудлуудыг бид нар 2026 оны төсөвт суулгаад, ингээд бүсийн хэмжээний бүтээн байгуулалт гэдэг бол 23 жилийг зарцуулах томоохон бүтээн байгуулалтууд гэж ойлгоод байгаа. Тэгээд энэ асуудал 2028 оноос өмнө бас үр дүнгээ өгөөд явах ийм цаг хугацааны хуваарьтай байсан. Тэгэхээр бид нар ТЭЗҮ-ээ зарлаж чадахгүй жил алдаж байгаа энэ байдалдаа цаашдаа бас анхаарах хэрэгтэй байна. Хурдтай хөгжлийн төлөөх Засгийн газраас энэ мэт хурдыг бас шаардаж байгаа юм. Энийг бол цаашдаа бид анхаарах ёстой.

Зайлшгүй хөгжлийн төлөвлөгөөнд тусгах ёстой 2 асуудлыг би түрүүн тодруулсан. Би дахиад нэмээд хэлье. Залуучууд руугаа чиглэсэн энэ ажил асуудлуудыг бид нар ингээд тойроод яваад баймааргүй байна. Шинэ үеийн

залуучуудын хүлээлт олон зүйлүүд маш ухаалгаар бас удаа дараа бид бүхэнд бас хандаж байгаа энэ байдлуудыг их сайхан ул суурьтайгаар хүлээж аваад, тодорхой асуудлуудыг нь шийдэх 1, 2-оор нь эрэмбэлэх ажлуудыг бид нар ингэж тойруулаад, ерөнхий агуулгаараа бид бүхэн оруулсан байгаа гэдэг байдлаар хандалгүйгээр яг тодорхой энэ залуучуудын өмнө тулгамдсан асуудлуудыг тусгаад явмаар байгаа юм. Тэгэхээр энэ саналуудыг нэмэлтээр оруулах чиглэл дээр дараа дараагийн хэлэлцүүлгүүд дээр бас гол анхаарал хандуулаасай гэсэн ийм саналтай байна.

Гадагшаа явж сурдаг биш, гаднын боловсролыг Монголдоо эзэмшдэг болохыг залуучууд хүсэж байна. 100 залууг бид нар гадагшаа сургадаг байсан энэ бодлогоо дотооддоо дэлхийн хэмжээний багш, боловсон хүчнийг авчирч 1000, 1000 залуучуудыг бэлдэх чиглэл рүү анхаарлаа хандуулдаг болох хэрэгцээтэй байна. Тэгээд энэ чиглэл дээр маш тодорхой төсвийн хөрөнгө оруулалтуудыг оруулж, энэ урсгалыг дотооддоо авч үлдэх, дэлхийн хэмжээний боловсрол эзэмших энэ боломжийг бид бүхэн цаашдаа хэзээ яг тусгаж ингэж оруулах вэ. Гаднын ажиллах хүчин болж өдөр тутам гадагшаа явах хүсэл эрмэлзэлтэй болоод байгаа энэ залуучуудынхаа энэ урсгалыг зогсоох тал дээрээ бид нар яг тодорхой старт ап энэ компаниудыг дэмжих чиглэлийн ажлууд дээр бид нар яах ёстой вэ.

Ипотекийн энэ хөтөлбөртэй адилхан түрээсийн орон сууцын хөтөлбөрүүдийг 100 хувь залуучууд руугаа яг чиглүүлж ажиллах чиглэл дээр бид нар тодорхой бас ахиц дэвшлийг гаргамаар байна. Дахиад зайлшгүй тусах ёстой асуудал бол энэ шинэ хоршоо хөдөлгөөн байгаа шүү. Өнөөдөр нэг үг үсэг байхгүй орж ирж байгаад бол үнэхээрийн харамсалтай байна. Жилийн өмнө бид нар хамгийн их ярьсан асуудал. 7, 8 мянгаараа байгуулагдсан энэ хоршоонуудыг бид нар 2026 онд сургах хэрэгтэй байна. Дэмжих хэрэгтэй байна. Тодорхой түвшинд дараагийн шатны ийм хоршоонууд болгон хөгжүүлэх хэрэгтэй байна. Энэ чиглэлийн асуудлуудыг .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууя. Үг хэлнэ.

Г.Уянгахишиг: Ер нь бол гишүүд маань маш олон асуултууд асууж, тодруулга авлаа. Бас үг хэллээ. Тэгэхээр яах вэ, ер нь бол сая бид нар 3 сард 2024 оны хөгжлийн хөтөлбөрийн тайланг хэлэлцсэн. Энэ дээр бол үнэлгээний зарчмууд хоорондоо зөрөөтэй байна. Дүрэм, журмууд нь хоорондоо зөрчилтэй байна. Мөн түүнчлэн хэмжигдэхүүнүүд нь тодорхойгүй байна. Үүнээс үүдээд гүйцэтгэлийн үнэлгээ бага гарчихлаа гэдэг асуудал яригдсан.

Мөн түүнчлэн гадаад зээлээр болон гадаадын төсөл, хөтөлбөрөөр, эсвэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжилтийг нь шийднэ гэсэн төслүүдийн гүйцэтгэл бол маш бага байсан. Яг энэ асуудал маань 2027 онд дахиад давтагдаад яригдах нь уу даа гэж бас санаа зовж байна л даа. Яагаад гэхээр энэ хооронд яг энэ төлөвлөгөө дээр тусгагдаж байгаа хэмжигдэхүүнүүд үр дүнгийн үзүүлэлтүүд эд нарыгаа яг Эдийн засгийн яамнаас болон Засгийн газрын Хэрэг эрхлэх эрхлэх газар, Засгийн газрын хяналт шалгалтын сайд маань яг энэ хэсэг дээр нөгөө шинээр боловсруулж байгаа аргачлалаа бас хэрэглэж амжаагүй буюу яг энэ маань 2027 онд нөгөө 3 сард явсан яг тэр яриа үргэлжилж гарахаар тийм нөхцөл байдал харагдаад байна л даа. Тэгэхээр энийгээ бид нар ер нь яаж цаашдаа авч явах юм бэ. Яг ингээд 2025 оныхыг бид нар дараа жил хэлэлцэнэ. 2026 оныхыгоо 2027 онд хэлэлцэнэ. Гэтэл энэ жилийн хугацаанд яг энэ төлөвлөгөө юм чинь өнөөдөр бид нар засвараа хийж чадаагүй учраас нөгөө үнэлгээ дээр, хэмжигдэхүүн дээр дахиад л алдаа

гараад явчих юм шиг ийм асуудлууд бас харагдаад байна. Энийгээ бас хэдүүлээ Байнгын хороод дээр яг хувааж аваад, нарийн хэлэлцэх шаардлагатай гэж харж байна.

Мөн түүнчлэн одоо яг энэ дэлгэрэнгүй танилцуулга дээр жишээлбэл тоон хэмжигдэхүүнүүдийн хувьд бол 2024 оноор эцэслээд авахыг бол ойлгож байна. Гэтэл жишээлэх юм бол энэ яг хууль зүйн хүрээнд засаглал хүний эрхийн нөхцөл байдал гэдэг 1.4 дээр Монгол Улсын Их Хурал дараах хуулийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлээд байна гээд энэ дотор жишээлбэл Казиногийн хууль, Бооцоот морин уралдааны тухай хууль, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль гэх мэтчилэн нөгөө өмнөх парламентын үед өргөн баригдаад батлагдаж чадаагүй буцчихсан хуулийн төслүүдийг өнөөдөр өргөн мэдүүлээд явж байгаа юм шиг биччихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нөгөө бичиг цаасаа боловсруулахдаа ч гэсэн ингээд копи паст хийгээд явмааргүй байна. Яг энийгээ өнөөдрийн нөхцөл байдал ямар байгаа юм бэ гэдгийгээ нягталж харж явахгүй энэ гишүүд уншдаггүй юм чинь гэж байгаа юм шиг ийм алдаатай байдлаар бичээд байдгаа болимоор байна гэж бас хэлмээр байна. Тэгэхээр цааш цаашдаа энэ танилцуулгын юмнуудаа ч гэсэн бүр мөр мөрөөр нь, багана баганаар нь, үг үсгээр нь, яг одоогийн байгаа нөхцөл байдлуудыг, мэдээллүүдийг, тоонуудыг бодит нөхцөл байдлуудаа хармаар байна. Энэ чинь тайлан биш. Энэ чинь 2026 оны төлөвлөгөө яригдаж байгаа буюу өнөөдрийн нөхцөл байдлыг бид нар дурдаж байгаа гэдгийг бас анхаармаар байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн үг хэлье.

Б.Бейсен: Энэ хөгжлийн төлөвлөгөөтэй танилцаж байна. Сайн ч юм байна, дутагдалтай ч юмнууд байж байна. Тэгээд саналаа хэлээд, үг хэлье гэж бодож байна. Энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахын тулд ер нь хот руу ачаалал нь их байгаа. Орон нутгийн эмнэлгүүдийг дэмжээд, тэнд тоног төхөөрөмж, эмч, мэргэжилтнүүд ажлын байрны сургалт хийгээд ер нь дэмжчихвэл наашаа хүн ирэх нь цөөхөн болох болов уу гэж бодож байна. Нөгөө талаар зарим шаардлагатай тоног төхөөрөмжийг нь аваад өгчихвөл хотын эмнэлгүүдийн ачаалал буурах байх гэж бодож байна.

2 дугаарт энэ Баян-Өлгий аймагт энэ “Морин сувд констракшн” гээд компани том оношилгооны төвийн эмнэлэг барьсан. Үүний 3 тэрбум 700 сая төгрөг нь дутагдалтай юм байна. Сангийн сайд байхгүй байна. Энийг нь Сангийн яамныхан шийдээд өгвөл энэ цалингийн зөрүү л юм байна лээ шүү дээ. Энийг чинь бид нар хуулийн байгууллагад шалгуулна гэж байсан чинь яах аргагүй энэ Барилгын хөгжлийн төвийн дүгнэлт, Барилгын яамны дүгнэлт, нөгөө талаар Аудит 2 удаа шалгасан байна. Энийг нь энэ өгчихмөөр юм байна. Тэгж байгаад 6 сарын 23-нд гэхэд энэ дуусгачихмаар юм. Одоо дуусга гээд бид нар шаардаад байдаг. Эд нар болохоор чинь зээл авч шийдэхгүй бол бид нар ямар ч бололцоогүй гэдэг ийм асуудал тавьж байна. Маш том хэмжээний оношилгооны төв баригдчихсан асуудал байгаа.

Аялал жуулчлалын хувьд аялал жуулчлалын ажил нь яваад байдаг, хийж байгаа ажил нь байхгүй. Таван богдын аялал жуулчлалын тэр бүс нутаг, Хотон, Хурган нуурын байгалийн үзэсгэлэнт газраар жилд 30-40 мянган жуулчин очдог. Энэ Их Хурлын гишүүд ч ихээр явж байгаа. Гэтэл отоглох газар, ариун цэврийн байгууламж байхгүй. Гол горхи, ус, ой мод ихээр бохирдож байгаа. Тэгэхээр чинь

энийг бас тодорхой хэмжээнд тусгачихвал гадаад, дотоодын жуулчид явж байхад шаардлагатай нөхцөл байдлаа хангасан тийм байгууламж заавал шаардлагатай байна. Энийг бас тусгаж өгөхгүй бол Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон шүү дээ. Энэ дээр бас анхаарах шаардлагатай байна.

Малын түгээд боловсруулах асуудал дээр Энхбаяр сайд аа. Уг нь баруун 5 аймгийн ноос угаах үйлдвэр гээд байсан. Баян-Өлгийд. Баруун 5 аймгийн бүх ноосыг угааж гаргадаг байсан сүүлдээ самнах үйлдвэртэй байсан. Англи, Европын холбоо, Америк руу гаргаж байсан. Гэтэл энэ компани дампуураад банканд 2 тэрбум төгрөгийн барьцаанд байгаа юм байна. Энийг ер нь авчихвал баруун аймагтаа тэр хуучин баруун 5 аймгийн ноос угаах үйлдвэр 400, 500 ажилчинтай байсан. Энэ нь тэнд бас малын түүхий эд боловсруулах бас нэг том ажил болчих болов уу, дотоодын нөөцөө ашигличихвал яасан юм бэ гэдэг санал хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Би бол санал шүүмжлэл их хүлээж авдаг хүн л дээ. Цаашдаа бол юу яана. Гэхдээ Улсын Их Хурлыг Улсын Их Хурал шиг болгомоор байна. Амарбаясгалан дарга бол сайн генсек байсан Ардын намын. Одоо Их Хурлын сайн дарга болно гэдэгт эргэлзэхгүй байна л даа. Шинэ тутам хийж байгаа ажил болох байх. Гэхдээ бид нарт нэг ойлголтын зөрүү байгаа юм энэ дээр. Жишээлбэл, Баярмаа гэдэг хүн заавал хэн нэг даргын доромжлолыг хүлээж байх ёстой юм шиг тийм ойлголт өгөөд байгаа байхгүй юу. Үгүй шүү дээ. Доромжилж байх ёстой. Энэ чинь юу юм юу ч биш гэсэн ийм байж болохгүй ээ. Бид бүхэн бас ойлголтын зөрүү их байна. Хэрэв ингээд намууд нэгдээд, 1 Засгийн газраа ороод сайн сайхан болчихдог юм бол юу яамаар байгаа юм. Энэ 2 намаа ч гэсэн нийлүүлчихмээр байгаа юм. Тэгээд сайд нарын тоо олшроод, улс орон хөгждөг юм бол ахиад 2, 3 сайд нэмчихмээр байгаа юм.

Би бол эсрэг үзэл бодолтой л доо. Хэзээ ч ингээд төр засаг хувийн хэвшлийн хийчих бизнесийг өмнүүр нь ороод хийгээд байхаар улс орон хөгжинө гэж байхгүй. Тэр дампуурчихсан Аргентины араас, Венесуэлийн араас л яваад байгаа. Энэ бол бүгдээрээ өнөөдөр хөгжил ярьж байгаа боловч хөгжлийн л хүслийн жагсаалт л болно. Цаг хугацаа маш их алдаж байгаа байхгүй юу. Миний барьдаг үзэл баримтлал хувийн хэвшлээ дэмж. Хувийн хэвшлүүд ажлын байр бий болгоно. Тэр цалин цавуу олигтой яадаг техник инновац оруулж ирдэг тэр компаниудаа битгий үзэн яд. Одоо хар л даа. Эрдэнэтийн 51 хувийг авчраагүй байсан бол саяын ковидыг бид нар давахааргүй л байлаа шүү дээ. Одоо тэр 51 хувиа нөгөө компани нь буцаагаад оросууддаа өгчихвөл яах юм. Иймэрхүү л байдалтай байгаа шүү дээ ер нь бол.

Нөгөө талаараа одоо хил холбож байна гээд яриад байгаа. 1425 юутай тийм төмөр замыг үгүй ээ тийм төмөр замтай нь холбо л доо. Наана нь байгаа тэр 1500-тай нь холбож байна. Холбож байгаа биш, зүгээр хил давуулаад л яачхаж байгаа байхгүй юу. Тэр чинь ачиж буулгана гээд зардал байхгүй. Өчнөөн зардал гарна. Дээр нь нэмээд тэр Тяньжин далайн боомтод очих ямар ч боломжгүй болчихож байгаа байхгүй юу. Монголын коксжих нүүрс дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадваргүй болчихож байгаа юм. Тэгэхээр чинь ганцхан Чайна Энержигийн гарт л орчихож байгаа байхгүй юу. Тавантолгойноо талыг өгөөд, тэгээд иймэрхүү байдалтай ажил төрөл хийхээр бол цаашаа улс орон хөгжинө гэж байхгүй. Тэгээд

ийм байсангүй, тийм байсангүй ярина. Одоо миний хажууд 2 намын дарга сууж байна. Үгүй ээ энэ Доржхандыг, манай 2 даргыг бол төрсөн эх эцэг нь ч бараг ялгахгааргүй болсон байх. Энэ чинь овоо аятайхан юм ярьдаг байсан байхгүй юу. Одоо тэгээд Засгийн газрын улаан хамгаалагч нар шиг л байх юм. Ярьж байгаа юм нь өөр болчихсон. Бараг ээж нь ч мэдэхгүй болчихсон. Манай хүүхдүүд юу яриад байна гээд. Би лав мэдэхгүй байна. Ингээд үзэл бодол нь яадаг юм. Очоод солигдчихдог юм уу. Энэ Засгийн газрыг 9 сайдтай болгомоор байна. 9 яамтай болгомоор байна. Тэгж байж бид нар ярих гэж байна шүү дээ.

Үгүй ээ, манай ард иргэд ямар байна. Зүүн хойд Азидаа бол бид нар хамгийн ядуу улс нь байна шүү дээ. Үгүй ээ, иргэд маань тэгээд л бусад орны хил дээр очоод нохой, гахай шиг хөөгдөж байна шүү дээ. Өчнөөн мянгаараа бид нар хараар ажиллаж байна манай залуучууд. Олигтой байгаа ганц салбар байна уу. Байхгүй шүү дээ. Энийг л нэг арай өөрөөр өөрчилж явмаар байгаа юм. Ирэх жилээс бол гэрэл цахилгаан тасардаг хэвээрээ байна л гэж байгаа. Тэгсэн мөртөө үнээ нэмчихсэн. Тэгээд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлнэ. Байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65.6-д заасны дагуу жилийн төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-д заасан шаардлага хангасан эсэх талаар санал хураалт явуулна. Бүртгэлийн санал ирц бүртгэлийн санал хураалт нэг явуулагдахъя. Санал хураалт. 52 гишүүн байгаа юм байна шүү дээ. Тэгээд өнөөдрийн ирцийнхээ 50 хувь л даа.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл нь хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-д заасан шаардлагыг хангасан байна гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 48 гишүүн буюу 68,3 хувиар санал дэмжигдлээ. Протоколд Мөнхтулга гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн нарыг дэмжсэнээр, протоколд Сарнай гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад бүх Байнгын хороонд шилжүүллээ.

Бүх байнгын хороо уг асуудлыг ирэх 7 хоногт цаг алдахгүй хэлэлцэх ёстой. Яагаад гэхээр Улсын Их Хурал хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудлыг 6 сарын 1-ний дотор баталдаг хуультай. 1 дүгээрт.

2 дугаарт Засгийн газрын зүгээс анхаарах юм бол холбогдох Байнгын хороо болгон дээр салбар хариуцсан сайд нар орж асуудлаа танилцуулж явна. Тэгэхгүйгээр Байнгын хороо болгон нийт асуудлыг ярих биш, тухайн салбартай холбоотой асуудал дээрээ төвлөрч ярина гэдгийг аль аль талдаа ойлголцож зөв яваарай. Тэгэхгүй бол Гантөмөр сайд, Сангийн сайд гээд голлох асуултад хариулах сайд нар чинь бүх Байнгын хороогоор орно гэвэл амжихгүй шүү дээ. Тийм учраас салбар хариуцаж байгаа сайд болгон өөрсдийн харьяалагддаг Байнгын хороодод орж, асуултад хариулж, ирэх 7 хоногт ажил хэрэгчээр хандаарай.

Тэгээд Засгийн газрын зүгээс гадагшаагаа томилолтод 4 сайд явчихсан байгаа юм байна лээ. Энэ 7 хоногтоо ирчих байх гэж бодож байна. Ингээд ирэх 7 хоногийн ажилд амжилт хүсье.

Маргааш өглөө 8 цагаас Эдийн засгийн байнгын хороо хуралдаж, ажлын хэсэг бас гарах ёстой. Амралтын өдрүүдээр ажлын хэсэг ажиллаад, 1 дэх өдрөөс бүлгүүдэд болон Байнгын хороодод танилцуулах материал бэлтгэгдэнэ.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

16.54 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ